



# ОЮУНЛАГ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТӨЛӨӨ

## СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

### Ерөнхий эрхлэгч:

Хурандаа Б.Өлзийхуяг ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал, доктор (Sc.D), профессор

### Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Дэд хурандаа Д.Идэшноров ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацын хэлтсийн дарга, доктор (Ph.D), дэд профессор

### Редакцийн гишүүд:

Дэд хурандаа Л.Одмаа ЦНДС-ийн Цэргийн холбоо, кибер аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)

Б.Баатарсүрэн БХЭШХ-ийн Батлан хамгаалахын дүн шинжилгээний төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

Х.Орхончимэг БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

### Техник редакцийн гишүүд:

Д.Одгэрэл Редактор  
М.Даваасүрэн Дизайнер

### Редакцийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, БНМАУ-ын баатар Д.Нянтайсүрэнгийн гудамж, 16 дугаар хороо, Улаанхуаран

**Утас/факс:** 976 11 480172

**Шуудангийн хайрцаг:** 13300

**Веб хаяг:** [www.mndu.gov.mn](http://www.mndu.gov.mn)

**Цахим шуудан:** [tsats@mndu.gov.mn](mailto:tsats@mndu.gov.mn)

**Олон улсын индекс:** ISSN 2313-8076

**Эрхлэх байгууллага:** Монгол Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургууль

**Хэвлэх үйлдвэр:** ҮБХИС-ийн Хэвлэх үйлдвэр



## FOR INTELLECTUAL AND CREATIVE THINKING

---

### EDITORIAL BOARD

#### Editor-In-Chief

Colonel Ulziikhuyag.B Deputy Director for Research and cooperation, MNDU, Prof. (Sc.D)

#### Deputy Editor-In Chief

Lieutenant colonel Ideshnorov.D Chief of Division for Research and innovation, MNDU, Ph.D

#### Editorial Panel

Lieutenant colonel Odmaa.L Senior Lecturer of Military Signaling and cyber security Department of Joint Military School, MNDU, Ph.D

Baatarsuren.B Research fellow, Center of Defense Analyses, Institute of Defense Studies, MNDU, Ph.D

Orkhonchimeg.Kh Research fellow, Center of Security and Defense Studies, Institute for Defense Studies, MNDU, Ph.D

#### Technical Editor

Odgerel.D Technical editor  
Davaasuren.M Designer, Illustrator

#### Address:

Mongolian National Defense University  
Nyantaisuren Street, Bayanzurkh District, Ulaanbaatar, Mongolia, 13300

**Phone:** 976 11 480177

**Fax:** 976 11 480172

**Mail box:** 13300

**Website:** [www.mndu.gov.mn](http://www.mndu.gov.mn)

**E-mail:** [news@mndu.gov.mn](mailto:news@mndu.gov.mn)

**ISSN:** 2313-8076

**Host:** Mongolian National Defense University

**Published by:** Defense Press



ҮНДЭСНИЙ  
БАТЛАН ХАМГААЛАХЫН  
ИХ СУРГУУЛИАС  
ЭРХЛЭН ГАРГАВ.

2025

№30/53/

СУРГАЛТ, СУДАЛГАА,  
АРГА ЗҮЙН УЛИРАЛ  
ТУТМЫН СЭТГҮҮЛ

## ДУГААРЫН ТОВЧООН

### 1. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал

"Квантуны армийн 731 дүгээр отрядын талаарх зарим асуудал"	6
Монгол улс, БНХАУ-ын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа ба боломж	16
Хилийн боомтод үүсэх эрсдэл, түүнийг хэрхэн бууруулж буй олон улсын туршлага	22
Хүний хувийн халдашгүй байдлын олон улсын ба үндэсний эрх зүйн хамгаалалт салбарчилсан загвараас төвлөрсөн загварт	29
Цацраг, хими, биологийн орчин үеийн зарим техник, зэвсэглэлийн тухай	36
Монгол улсын үндэсний био аюулгүй байдалд тулгамдаж буй зарим асуудалд	41
Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд ашигт малтмалын олборлолт, борлуулалтын үзүүлж буй нөлөөллийн өнөөгийн байдал	44
"Артиллерийн байлдааны ажил" хичээдийг хиймэл оюун ухаан ашиглан заах боломж	52

### 2. Батлан хамгаалах боловсрол, цэргийн сургалт

Автомашинны резин дугуйн ашиглалтыг дээшлүүлэх арга зам	56
Цэргийн хөгжмийн политехник коллежийн хөгжмийн зэмсгийн шинэчлэлийн асуудалд	61
Монголчуудын цэрэг бие хүнийг сурган хүмүүжүүлж ирсэн үзэл санааны үндэс бүрэлдэн бий болсон зарим асуудалд	67

### 3. Цэргийн зэвсэглэл, техник, инноваци судлал

Цэргийн удирдлагыг зохион байгуулахад хиймэл оюун ухааныг ашиглах	70
Ухаалаг хотын концепц дахь жолоочгүй автомашины тухай ойлголт	76
Ухаалаг хотуудад зориулсан IoT-д суурилсан цахим зогсоолын систем	80

### 4. Судалгаа боловсруулалтын ажил

Багш тасралтгүй хөгжих хэрэгцээ шаардлага	87
Багш ажлын байрандаа өөрийгөө хөгжүүлэх нь	93
Нийгэм судлал хичээлийн амжилтад нөлөөлөх институтийн хүчин зүйлсийг судалсан нь	97
Захиргааны хэм хэмжээний актад тавих хяналтын тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам	104
"Гал" хэмээх толгой үгийн тайлбарыг харьцуулах нь	110
Монгол улсын иргэдийн эх оронч үндэсний үзэл хүмүүжлийн арга зүйн зарим асуудал	115
Хүүхдийн сурах орчны ойлголт, мөн чанар, үзэл баримтлал	123
Хүний аюулгүй байдлын тухай ойлголт, мөн чанар	130

### 5. Шинжлэх ухаан судлал, дайны туршлага сургамж

XIII-XIV зууны үеийн Монголын соёлын түүх бичлэгийн судалгааны товч тойм	142
Соёл иргэншлийн тухай асуудалд	147

## “КВАНТУНЫ АРМИЙН 731 ДҮГЭЭР ОТРЯДЫН ТАЛААРХ ЗАРИМ АСУУДАЛ”

**Г.АМАРТУВШИН** /Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль, Батлан Хамгаалахын Удирдлагын Академи, Аюулгүй байдал, стратегийн төвийн ахлах багш, Дэд хурандаа/  
Aagiartuvshin3@gmail.com

**Түлхүүр үг:** Иши Широ, "Банз", бактериологийн зэвсэг, биологийн туршилт .

**Key words:** Shiro Ishii, bacteriological weapon, bio experiment

**Abstract:** Arms race, in particular the race to acquire weapons of mass destruction still endures to this day in the world, in this article it is essential for scholars and researchers to collaborate and contribute to the efforts for peace and security through the study of the last war and ways to prevent it. Investigating the deployment of bacterio-chemical weapons 85 years ago at the battle near Khalkha river will re-emphasize the value of the historic victory at Khalkha river.

### Хураангуй

Дэлхий дахинд зэвсэглэл, тэр дундаа үй олноор хөнөөх зэвсгээр хөөцөлдөх явдал гарсаар байгаа өнөөгийн цаг үед өнгөрсөн дайны гашуун сургамжийг судлан түүнээс урьдчилан сэргийлэх замаар энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах ариун үйлсэд өөрсдийн хувь нэмрийг оруулах, энэ чиглэлээр эрдэмтэн судлаачид нягт хамтран ажиллах явдал нэн чухал байгааг харсаар байна. Чухам энэ үзэл санааны дор зүүн хойд азийн улс түмнүүд, эдгээр орны эрдэмтэн судлаачид хүн төрөлхтөнд өнгөрсөн дайны хол уршгийг дахин сануулж, өнөөгийн дайн зэвсэгт мөргөлдөөн, терроризмын аюул заналыг зайлуулахад зохих хувь нэмрээ оруулна гэдэг. Тэртээх 80 жилийн өмнө Чөлөөлөх дайны түүхэнд 731 дүгээр отрядын хими, бактериологийн туршилт-байлдааны ажиллагааны мөрөөр мөшгөн судлах нь МАХЦ-ийн түүхт ялалтын үнэ цэнийг улам тодотгож буй хэрэг билээ.

### Удиртгал

Дэлхийн II дайны жилүүдэд зүүн хойт Хятадад хими, бактериологийн зэвсгийн туршилт, үйлдвэрлэл явуулж байсан Японы 731 дүгээр отрядын асуудал эрдэмтэн судлаачдын анхаарлыг татсаар, энэ чиглэлээр судалгааны ажил багагүй хийгдэх болсон байна. Энэ нь хүн төрөлхтөнд дайн, алан хядлага, үй олноор хөнөөх зэвсгийн аюул заналхийлсээр байгаа өнөө үед өнгөрсөн дайны түүхийг нягтлан

судалж, түүхэн сургамжийг хүн төрөлхтөнд ухааруулан сануулж, дэлхий ертөнцөд энх тайван байдлыг тогтоох, дайн, зэвсэглэлийн аюулыг зайлуулахад чухал ач холбогдолтой юм. Халхын голын байлдааны болон чөлөөлөх дайны түүхт ойнуудыг тохиолдуулан Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ, Япон улсын эрдэмтэн судлаачдын хамтран зохион байгуулж ирсэн олон удаагийн хурлын илтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэлүүдэд дурдагдаж иржээ.

Монгол Улсад өгүүлэн буй сэдэвт холбогдох эх сурвалж нэн ховор, судалгааны ажил төдий л далайцтай өрнөөгүй байна. Энэ нь Нэгдүгээрт: дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлд Япончууд нотлох баримтуудыг сайтар устгасан, Хоёрдугаарт: төсөл анхнаасаа маш нууцаар хэрэгжүүлж байсан, Гуравдугаарт: Японы зүгээс 731 дүгээр отрядын үйл ажиллагаа, зорилгыг өнөөг хүртэл албан ёсоор хүлээн зөвшөөрдөггүйд оршино. Дэлхийн дайн дууссаны дараа Азийн орнуудад тус отрядын талаар мэдлэг, мэдээлэл хомс байжээ.

Японы Коммунист намын эрхлэн гаргадаг байсан "Улаан туг" сонинд 1981 онд "Чөтгөрийн махчин" хэмээх 731 дүгээр отрядын тухай цуврал материал дуулиан тарьжээ. Энэ нь тухайн үеийн "Улаан туг" сэтгүүлийн сурвалжлагч Масаки Шимосатогийн "Хабаровскийн шүүх хурал" нэртэй нийтлэл болон Японы армийн биологийн туршилтуудын тухай өгүүлсэн зохиолоос сэдэвлэн Сэйчи Моримурагийн гаргасан цуврал нийтлэл байжээ. Энэхүү нийтлэлээс улбаалж 731 дүгээр ангийн талаар Японы коммунист намын гишүүдээс парламентад асуудал хөндөхөд нийгэм даяар дахин дуулиан дэгдээсэн байдаг.

Солонгосчууд 731 дүгээр отрядын талаар "Үүрийн мэлмий" (여명의눈동자) романыг 1970-аад оны сүүлээр хэвлэгдэх үед л олон нийтээр анзаарсан байна. Арай сүүлээр өмнөд Солонгост "Dong-A Ilbo" (동아일보) сонинд



1982 оны 4 дугаар сарын 13, “Kyunghyang Shinmun”(고향신문) сонинд 8 дугаар сарын 4–ний дугаарт дээрх номтой холбогдох нийтлэлүүд хэвлэгдсэн байна. Харамсалтай нь тухайн номонд орсон 35 зургийн 20 нь бодит түүхэн зураг биш байсан гэдэг. Эдгээр нь 731 дүгээр отрядад зочилсон гэгдэх тайлбартай Герман офицеруудын зураг, Хятад дахь цэргийн эмнэлэгт авсан гэгдэх зурагт эргэлзээтэй хандах тал бий.

Япончууд 731 дүгээр отрядаас гадна 1936 онд Манжийн 100 дугаар анги, 1938 онд Цицикарын орчимд 516 дугаар хорт хийн анги, Манж Гогийн 525 дугаар анги (Химийн зэвсгийг хэрэглэн байлдах миномётын 2 дугаар анги), Сонго дахь 773 дугаар анги, 1939 онд Бээжингийн орчимд “Бей Хи Жианы 1855 дугаар анги” буюу бактерийн зэвсгийг судлах газар, Чанчун дахь 200 дугаар анги, 1939 онд Нанжинд байгуулсан 1644 дүгээр анги, Гуанжоуд байгуулсан 8604 дүгээр анги, Сингапур дахь 942 дугаар анги гэх мэтчилэн амьд олзлогдогсдоор биологийн туршилт хийсэн гэж үздэг ч баримтаар нотлогдоогүй байсаар байна. Өгүүлэн буй отрядын үүрэг зориулалт, онцлогоос шалтгаалаад Японы эзэн хааны армийн дээд удирдлагуудын төдийлөн мэддэггүй, байлдааны туггүй цорын ганц нэгж нь 731 дүгээр тусгай отряд юм. Тиймээс тус отрядыг аюулгүй байдлын үүднээс үндэслэн байгуулагч Иши Широ болон маш цөөн тооны өндөр албан тушаалтнуудаас өөр хэн ч мэдэхгүй болтол сайтар хамгаалагдсан. Үүрэг зорилго ижил бусад тусгай анги салбаруудын хооронд тодорхой хэмжээний боловсон хүчний солилцоо явагддаг байсан. Эдгээр ангиуд бие даан үйл ажиллагаа явуулахгүй, харин ч 731 дүгээр отрядаас тушаал, мэргэжлийн удирдлагаар хангагдаж байсан нь зүйн хэрэг.

Хэдийгээр Халхын голд явагдсан дайн байлдааны ажиллагааны талаар олон арван судалгааны бүтээл, эрдэм шинжилгээний өгүүллүүд туурвигдсан ч Япончуудын зүгээс бактерийн зэвсэг хэрэглэсний тухайд яг таг баримтаар нотлогдсон бүтээлүүд хомс байна. Зарим судлаачдын үздэгээр 731 дүгээр отрядын бие даасан үйл ажиллагааг 1940 оноос эхэлсэн, түүнээс өмнө зөвхөн судалгааны түвшинд хөгжиж байсан болох, 1939 оны Халхын голд явагдсан байлдааны ажиллагааны театрт Квантуны армийн 23 дугаар явган дивизийн

хавсрагдсан салбар болж, ундны усыг тунгаан цэвэршүүлэх төдий үүрэгтэйгээр оролцсон мэтээр өгүүлсэн байдаг. Энэхүү өгүүллээр Халхын голын орчимд болон Чөлөөлөх дайны үеийн 731 дүгээр отрядын хими–бактерийн зэвсэг хэрэглэсэн байлдааны ажиллагааг тодруулахыг зорьсон билээ.

Квантуны армийн 731 дүгээр отрядын үүсэл

Отрядын бүхий л түүх түүнийг үндэслэгч, цэргийн микробиологич Иши Широ<sup>1</sup> –той салшгүй холбоотой юм. Японд биологийн зэвсэг хөгжүүлэх санаа цэргийн эмч Исийд 1920–иод оны эцсээр Европт шинжлэх ухааны томилолтоор яваад ирсний дараа төржээ. Түүний европ дахь аялалын зорилго нь эмч хүний хувиар мэргэжлийн дадлага туршлагаа нэмэгдүүлэх байсан гэдэг ч үнэн хэрэгтээ дуусаад удаагүй байсан дэлхийн нэгдүгээр дайнд хими–биологийн зэвсгийг ашигласан туршлага сургамжийн талаар судлагааны зорилготой явсан гэж үздэг.

Тэрбээр 1921 оноос Японы Эзэн хааны армид алба хааж эхлэхдээ байгалийн баялаг муутай Япон гүрнийг ирээдүйд үйлдвэрлэл хөгжсөн барууныхантай хийх дайнд эн зэрэгцэхийн тулд хямд бөгөөд үй олноор нь устгах зэвсэг бүтээх шаардлагатай болно хэмээн үзэж байсан юм. Энэ санаагаа цэргийн дээд удирдлагад уламжилж, цэргийн яамны сайд Садао Араки, эзэн хааны армийн хуурай замын цэргийн командлагч хошууч генерал Нагата Тэцузагийн зүгээс хүчтэй дэмжлэг авчээ. Нагатагийн заавраар 1931 онд цэргийн ахлах эмч, хошууч Исий биологийн зэвсэг бүтээж, түүнийг байлдаанд ашиглах цэргийн тусгай хэлтэс байгуулахаар болж, удирдах үүргийг Исийд өгчөө. Эхлээд 1932 оны наймдугаар сард Токио дахь Цэргийн анагаахын академийн дэргэд “Эзэн хааны армид халдварт өвчин

<sup>1</sup> Иши Широ(1892–1959) Чинээлэг газрын эзний гэр бүлээс гаралтай. Киото хотын анагаахын их сургууль төгссөн. 1936.8.1–1942.8.1 хүртэл 731 дүгээр отрядын дарга, 1942.8.1–ээс Нанжин дахь цэргийн эмнэлэгийн, 1943 оны 8 сараас Токиогийн явган цэргийн анагаах ухааны сургуулийн захиралаар ажиллаж байгаад 1945.3.1–нд дахин 731 дүгээр отрядын даргаар томилогджээ. Америкийн баруун эрэг дагуу тахлаар халдварласан бөөс тархах “Сакура цэцэглэлтийн шөнө”(Operation Cherry Blossom Night) ажиллагааг төлөвлөж байсан ч 1945.8.15–нд Япон үг дуугүй бууж өгснөөр энэ нь хэрэгжээгүй гэдэг.



тархахаас урьдчилан сэргийлэх лаборатори" гээчийг Исийг оролцуулаад зургаан хүний бүрэлдэхүүнтэй байгуулав. Мөн оны эцсээр уг лабораторийг эзлэн аваад удаагүй байсан Манжуурт илгээжээ. Тус лаборатори Харбинаас өмнөд хэсэгт байх Эрбэй мужийн Жонгма цайзад байрласан аж. Лабораторийг нууцлах үүднээс "Камогийн отряд" буюу японоор "Камо бутай" хэмээн нэрлэж байв. 1935 онд Камогийн отряд зүүн хойт хятдын Пинфаньд шилжин байрлажээ. Нийт 2600 хүний бие бүрэлдэхүүнтэй, мөн 100 хоригдол хорих шорон, тусгай туршилтын полигон зэргээс багтаж байлаа. Энд хоригдол, олзны хүмүүст онц халдварт өвчин халдааж туршилт хийхийн зэрэгцээ нохой бөөснөөс авахуулаад хулгана, харх үржүүлэн гоц халдварт өвчний бактери гарган авч байжээ.

Ишигийн боловсруулсан үзэл баримтлалаар Япон Улс бактерилогийн дайн хийснээр ялалтанд хүрэх бөгөөд энэхүү бактерилогийн зэвсгийг турших, үйлдвэрлэхэд нүсэр их зардал мөнгө, тоног төхөөрөмж шаардагдахгүй, түүнчлэн богино хугацаанд эсрэг этгээдийнхээ хүн ам, цэргийг олноор нь халдварлуулан амьд хүчний ихээхэн хохирлыг үзүүлж байлдах чадварыг нь алдагдуулах боломжтой гэж үзжээ. Бүх ажлыг эмнэлгийн судалгаагааны дор халхавчлан нууцлах боломжтой зэргээрээ давуу бөгөөд энэ чанараараа ашигт малтмалын нөөц хомс Япон улсын хувьд хими, бактерилогийн зэвсэг нь маш ашигтай хэмээн үзсэн байна. Харбин хотын Нань Гань тойрогт 1933 оны 08 дугаар сард "Хижгээс сэргийлж ус түгээх анги" (關東軍防疫給水本部) гэгч бактерийн туршилтын ангийг нууцаар байгуулжээ. Улмаар 1936 онд Японы эзэн хааны зарлигаар зүүн хойт хятадад Японы хуурай замын цэргийн бактерийн зэвсгийг бэлтгэх болон дэлгэрүүлэх 2 нууц ангийг байгуулжээ. Үүний нэг нь Харбин хотод байгуулсан "Хижгээс сэргийлэх, ус хүргэх Квантуны цэргийн хэлтэс", нөгөөх нь Чанчунь хотын "Малын хижгээс сэргийлэх Квантуны хэлтэс" юм. Эдгээр нь хэдийгээр хижгээс сэргийлэх, "ус хүргэх" гэсэн нэршилтэй боловч үнэн хэрэгтээ бактериологийн зэвсгийн нууц туршилт явуулах онцгой объектууд байв. "Хижгээс хамгаалж, ус түгээх анги"-ийг 1938 онд өргөтгөн 2000 хүн, 8 хэсэгтэй болгосон бөгөөд 1938 оны 06 дугаар сард Квантуны армийн удирдлагын шийдвэрээр Харбинд

цэргийн онцгой бүс байгуулж бактерилогийн туршилтын төвийг тус хотоос 20 км зайтай газар шилжүүлэн байрлуулж, "Манжуурын 659 дүгээр цэргийн анги" (滿洲第659 部隊關東軍防疫給水部本部) гэж нэрлэж байгаад 1941 оноос "Манжийн 731 дүгээр цэргийн анги", 1945 оны 5 дугаар сард "Манжийн 25202 дугаар цэргийн анги" гэж өөрчилжээ.

Зүүн хойт хятад нь бактери судлах тусгай анги байгуулахад хамгийн тохиромжтой газар болохыг Квантуны армийн удирдлага сайтар тооцоолсон байна. Учир нь тухайн газар орноос бактерийн туршилт явуулах "Банз"<sup>2</sup> (丸太) амьд хүн, амьтан амархан олдох боломжтой, мөн ЗХУ-тай хил залгаа, цаг агаарын хувьд адилавар, цаашид ЗХУ-тай дайн хийхэд хүрвэл бактерийн зэвсэг хэрэглэхэд дөхөмтэй гэж тооцжээ.

Улмаар 1940 оны 12 дугаар сарын 02-нд Японы эзэн хаан Хирохитогийн гаргасан зарлигийг үндэслэн 731 дүгээр отрядын харьяанд 4 салбар ангийг зүүн Хятадад байгуулжээ. Үүнд Хайлаар дахь 543 дугаар, Сун вуй дахь 673 дугаар, Мин Куа дахь 162 дугаар, Муданжан дахь 643 дугаар салбарууд багтана.

Япончууд бактерийн зэвсэг үйлдвэрлэх томоохон бааз, төвүүдийг Чанчунь, Бээжин, Нанжин, Гуанжоу хотуудад байгуулсан. Ийнхүү Японы цэргийн удирдлага дэлхийн II дайны жилүүдэд зүүн хойт хятадад хими, бактерийн зэвсгийн судалгаа, туршилт, үйлдвэрлэлийн бүхэл бүтэн систем байгуулан, томоохон хэмжээний бактерийн дайн явуулах бэлтгэлийг хангаж байв. Японы армийн 731 дүгээр отрядад хими, бактерийн зэвсэг, түүний нянг судлах, өсгөн үржүүлэх, хадгалан нөөцлөх, эмчлэх туршилт судалгааг явуулж, бактерийн зэвсгийн гол түүхий эд болох халдварт өвчний нянг

<sup>2</sup> Японоор Марута гэсэн(丸太) ханз нь банз, дүнс, гуалин гэсэн утгатай. Тус отрядын биологийн туршилтанд хэрэглэсэн амьд "Материал"-уудыг нэрлэсэн нууц нэршил. Квантуны армийн штабын дарга Уэда Киничи, тус армийн Цэргийн цагдаагийн дарга Танака Шизучи, Сэргийлэн хамгаалах хэлтсийн дарга Кажией Жиро, 731 дүгээр отрядын дарга Иши Широ нар зөвлөлдөн, "Тусгайлан хүргэх" төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, нууц тушаал гаргажээ. Тушаал ёсоор Квантуны армийн сөрөх тагнуулын газар, Манж-Го улсын цагдаагийн захиргаанаас Манжуур дахь ХКН-ын партизан, Солонгосын тусгаар тогтнолын хөдөлгөөн, Монгол, Зөвлөлтийн олзныхоноос бүрдсэн олон тооны "Банз"-ыг тусгайлан хүргэжээ.



гарган авч дайны зорилгоор ашиглахаар их хэмжээгээр нөөцлөн бэлтгэж байжээ.

Бактериологийн дайны цэргийн ач холбогдлын талаар генералын үгийг сийрүүлбэл: “Бактериологийн зэвсэг хэрэглэснээр халдлага нь өндөр үр ашигтай. Артиллерийн буудлагын үед энгийн металл нь тодорхой хэсэгт тодорхой объектыг л зөвхөн устгах бөгөөд шархагдахад түргэн илааршиж, эргэн жагсаалдаа орно. Харин амьд нян бол өөр хэрэг. Хүнээс хүнд, хөдөөнөөс хотод халдсанаар өсөн нэмэгдэж байж болох бүх хохирлыг учруулна. Түүнээс гадна нян бол хүний бие эрхтэнд нэвтрэн шингэснээр удаан хугацаанд үйлчилж, үхлийн хувь нь өндөр байх болно. Нянгийн халдвар авсан хүн эдгэрэх нь ховор. Мөн ашигт малтмалын нөөц хомс Япон улсын хувьд бактерийн зэвсэг нилээд ашигтай. Энэ зэвсэг бол томоохон цар хүрээтэй туршилт боловсруулах, үйлдвэрлэхэд нүсэр тоног төхөөрөмж шаардагдахгүй. Бүх ажлыг эмнэлгийн судалгаагаар халхавчлах боломжтой. Тиймээс зардал их гарахгүй...”, “Артиллерийн сумнаас бактериин зэвсгийн ялгаа нь амьд хүчийг эгшин зуур хөнөөх чадваргүй, гэхдээ энэ нян дүүргэсэн сум “дэлбэрдэггүй бөмбөг” нь чимээ шуугиангүй хүн амьтаны бие бялдрыг удаанаар тарчлаан хөнөөж чадна. Сумыг заавал үйлдвэрлэх шаардлагагүй, зүгээр энгийн эд зүйлс болох хувцас хунар, гоо сайхны хэрэглэл, хүнсний зүйл ундаа, мал амьтадад халдвар тараах, түүнчлэн агаараас ч нян цацаж болно. Эхний довтолгоо заавал бөөгнөрүүлсэн байх шаардлагагүй, ялгаагүй дараа нь нян үржсэнээр зорилогдоо хүрэх болно”<sup>3</sup> хэмээн генерал Иши Широ санал болгож байжээ.

Энэ отрядын лабораториудад хижиг, булчин задрах тахал, хамуу, цусан суулга, татран, боом, сүрьеэ зэрэг халдварт өвчний нянг үржүүлэн судалж байжээ.

Японы 731 дүгээр отрядын гэмт хэргийн эд зүйлсийн музей нь бактериологийн дайнд тарчлан зовсон болон амь үрэгдэсдэд зориулсан гэрэлт хөшөө БНХАУ-ын нутагт бий бөгөөд 23 балгас анхны байдлаараа хадгалагдаж байдаг ба орон

<sup>3</sup> (고 기요노 겐지 선생 기념논문집 제3집). <https://blog.naver.com/ilamjcyong/2456928581> (таталт:2024.03.28). 1955 оны 12-р сард Киотогийн их сургуулийн анагаах ухааны зөвлөх профессор Кэнжи Киёног оршуулах ёслолын үеэр Широ Иши “Тахлаас сэргийлэх, ус хангалтын төв”-ийг байгуулахад хүргэсэн нөхцөл байдал, түүний цар хүрээ, зорилгын талаар ярьжээ.

нутгийн чанартай хамгаалалтанд байдаг дурсгал юм. Гэмт хэргийн эд зүйлсийн үзүүлэгийн танхим нь 418 кв.м бөгөөд энд 160 гаруй гэрэл зураг, 70 гаруй бодит эд өлгийн зүйлс, тэрхүү аймшигт үйл явдлын нотолгоо болох гэрчүүдийн дуртатгал их хэмжээгээр байдаг. Эдгээр баримтууд нь японы милитаризмийн үйлдсэн бактериологийн дайны хор уршгийн талаарх нотолгоо болдог.

Зүүн хойт азид явуулсан 731 дүгээр отрядын үйл ажиллагаа

Бактерийн дайны стратегийн эн тэргүүний зорилт нь сөргөлдөгч талуудын амьд хүчийг устгаж, газар нутгийг нь эзэгнэн захирах хэрэгсэл болгоход оршдог. Зардал багатай, амьд биетийг үй түмээр нь хөнөөж чадах аймшигт хэрэгсэл болох бактериологийн зэвсгийг Япончууд сонгон авчээ. Энэ зорилгоор биологич эрдэмтдээр удирдуулсан 731 дүгээр отряд үүссэн юм. Отрядын онцлог нь судлаач эрдэмтдээс бүрдэж, маш нууц байдлаар үйл ажилгаагаа явуулж байснаас гадна Японд биш Манжуурт байрлаж байв. Учир нь ямарваа нэгэн халдвар тарлаа гэхэд зөвхөн Япон бус иргэд л хохирхоор байв. Тэд туршилтандаа олзны хүмүүсийг ашигладаг бөгөөд Хятад, Монгол, Орос, Солонгос үндэстнүүд байв.

Хэрвээ дайны явцад өрсдийн цэргийн байдал хүндэрсэн тохиолдолд дараах 3 аргаар бактериологийн зэрсэг хэрэглэхээр төлөвлөсөн нь:

1. Бактери, нян агуулсан их бууны сумаар дайсны фронтын шугам болон гүнд буудаж нян тараах,

2. Халдварт өвчний нян бүхий нохой бөөс агуулсан бөмбөгийг байлдааны онгоцоор Халхын голын баруун эрэгт хаяж нян тархах

3. Амиа золиослох бүлгийг нууцаар илгээж Халхын голын баруун эрэг гаталган худаг, гол усны эхийг нянгаар хордуулах, энэ зорилгоор үйлдсэн газрын зурагт бактериар хордуулах гол усны эх, худаг, нуур, цөөрмийн нэг бүрчлэн тэмдэглэсэн байжээ.

Дайны сүүл үед 731 дүгээр отрядад дэлхий даяар гамшиг тарих хэмжээний нянгийн идэвхжүүлсэн өсгөвөр байсан ч хэрэглээгүй болно. Учир нь Япон дайнд ялагдах нь тодорхой болсноос гадна хэрвээ үй олноор нь устгах хэрэг үйлдвэл эргээд Японы эзэн хаан, түүний армийн нэр төрд гутаамшигт нэр үлдэх, цаашлаад ард түмнийг өршөөлгүй хядаж хариу барих болно



гэдгийг дээд тушаалын генерал офицерууд ухамсарлаж байв. Зөвлөлтийн Арми өргөн далайцтай, гэнэтийн давшилт 1945 онд хийсэн тул отрядын бүх баримт болох зүйлийг устгаж булсан байна. Амьд байсан туршилтын хүмүүс болон хүмүүсийн эд эрхтнүүдийг устгасан. Чухал баримт материалуудыг Широ Иши болон бусад эрдэмтэд, отрядын толгойлогчид америкчуудад нууцаар шилжүүлэн өгч эрх чөлөө олж авсан тухай Орос, Хятдын судлаачид жигшин бичдэг.

Зөвлөлтийн улаан арми дөрвөн жил мэдээлэл цуглуулж, бэлтгэсний дараа 1949 оны 12–р сарын 25–наас 30–ны хооронд ЗХУ–ын Хабаровск хотын офицеруудын соёлын ордонд болсон Японы дайны гэмт хэрэгтнүүдийн эсрэг зургаан өдрийн турш үргэлжилсэн цэргийн шүүх хурал болсон юм. Шүүх хуралд татагдсан Японы шүүгдэгчид нь Зөвлөлтийн армид олзлогдсон Квантуны армийн удирдлага, биологийн туршилт, бактерийн дайнд оролцсон хүмүүс байв. Шүүгдэгчид бүгд албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлж, Сибирь, алс дорнодын засан хүмүүжлийн лагерьт ял эдэлж байгаад 1956 онд Зөвлөлт–Японы хамтарсан тунхаглалд гарын үсэг зурснаар хоёр улсын хооронд дипломат харилцаа сэргэснээр суллагджээ.<sup>4</sup>

ЗХУ–ын армид олзлогдсон 731 дүгээр отрядтай холбогдох 12 цэргийн алба хаагчид оноосон ялыг хүснэгтээр үзүүлбэл

д/д	Цол	Овог нэр	Албан тушаал	Цэргийн шүүхээс оноосон ял	Тайлбар
1	Хурандаа генерал	Ямада Отозо (山田 乙三)	Квантуны армийн ерөнхий командлагч	25 жил албадан ажил хийлгэх	1956 онд өршөөл
2	Дэслэгч генерал	Кажизука Рюжи (梶塚 隆二)	Квантуны армийн Цэргийн эмнэлгийн газрын дарга	25 жил албадан ажил хийлгэх	1956 онд өршөөл
3	Дэслэгч генерал	Такацу Такахаши (高橋隆 篤)	Квантуны армийн мал эмнэлгийн газрын дарга	25 жил албадан ажил хийлгэх	1952 онд тархины цус харвалтын улмаас нас барсан
4	Хошууч генерал	Сато Шунжи (佐藤 俊二)	Квантуны 5 дугаар армийн Цэргийн эмнэлгийн дарга	20 жил албадан ажил хийлгэх	1956 онд өршөөл

<sup>4</sup> 1956 оны 10 сарын 19–нд Япон–Зөвлөлтийн хамтарсан тунхаглалын дагуу өршөөл үзүүлэх тухай зарласан боловч 10 сарын 20–нд тэрээр ЗХУ–ын 48–р хуарангийн офицеруудын угаалгын газар баганаас өөрийгөө дүүжлэн амиа хорложээ.

5	Хошууч генерал	Киёоши Кавашима (川島 清)	Бактери үйлдвэрлэлийн 4 дүгээр хэлтсийн дарга	25 жил албадан ажил хийлгэх	1956 онд өршөөл
6	Хошууч	Томио Карасава (柄澤 十三夫)	Бактери үйлдвэрлэлийн 4 дүгээр хэлтсийн орлогч	20 жил албадан ажил хийлгэх	1956 онд амиа хоролсон
7	Хошууч	Тошихидэ Ниши (西 俊英)	Бактери үйлдвэрлэлийн 4 дүгээр хэлтсийн ахлах эмч	18 жил албадан ажил	1956 онд өршөөл
8	Хошууч	Онүэ Масао (尾上 正男)	Муданжан 643 дугаар ангийн дарга	12 жил албадан ажил хийлгэх	1956 онд өршөөл
9	Ахлах дэслэгч	Зенсаку Хиразакура (平桜 全作)	100 дугаар ангийн судлаач малын эмч	10 жил албадан ажил хийлгэх	1956 онд өршөөл
10	Ахлах түрүүч	Каэу Митомо (三友 一男)	100 дугаар ангийн хорих хэсгийн харуул	15 жил албадан ажил хийлгэх	1956 онд өршөөл
11	Энгийн	Норимицу Кикичи (菊地 則光)	Муданжан 643 дугаар ангийн эмч	2 жил албадан ажил хийлгэх	1951 онд суллагдсан
12	Энгийн	Куружима Южи (久留島 祐吉)	Минкуа 162 дугаар ангийн эмч	3 жил албадан хөдөлмөр	1951 онд суллагдсан

Үнэндээ отрядын зарим эрдэмтэд америкчуудын ачаар ялнаас мултарч эх орондоо очиж их сургууль, анагаах эмнэлэг, эрдэм шинжилгээний байгууллагад ажиллах болсон байна. Тухайлбал Япон бууж өгсний дараа баривчлагдсан Иши Широг АНУ–ын генерал Дуглас Маккартурын батлан даалтаар цэргийн шүүхээс чөлөөлжээ<sup>5</sup>. Энэ нь олзлогдогсод дээр явуулсан биологийн туршилтын материалуудыг Зөвлөлтийн талд алдалгүй нууцаар шилжүүлж өгсөний хариу шан байв. Хожим нь Японы анагаах ухааны нийгэмлэг 731 дүгээр ангийн зарим мэргэжилтнүүдэд докторын зэрэг олгожээ. Тэдний бичсэн хэд хэдэн диссертаци байдгийн дотор тус отрядын туршилт, судалгааны тайлан болгон хэвлүүлсэн илтгэлийг ашиглан эрдмийн зэрэг хамгаалсан нь бий.<sup>6</sup> Эдгээр эрдэмтдийг дурдвал

- Эд эсийн өнгийг өөрчлөх бактерийн судалгаа (Кэйо, 1946)
- Сахуу ба Татран өвчнөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн тухай (Кумамото, 1946)
- Цусан суулгын нянгийн ангилалын тухай (Кумамото, 1946)

<sup>5</sup> Hal Gold, Unit–731. Testimony, 2003, p.109

<sup>6</sup> 관동군 방역급수부 본부 <https://namu.wiki/w/731> (таталт :2024.03.28)



– Дотор эрхтэн гэмтлийн дараах үр нөлөөний тухай (Токю, 1947)

– Тархи нугасны шингэний эквивалент дахь өөрчлөлтийн судалгаа (Нигата, 1949)

Японы Шигагийн анагаах ухааны их сургуулийн профессор Кацуо Нишиямагийн ахалсан эрдэмтдийн баг 2018 онд нэгэн харгис туршилтын үр дүнд авсан эрдмийн зэрэг цолыг хүчингүй болгох шаардлагыг тавьж байжээ. Энэ нь 731 дүгээр ангийн офицерийн 1945 оны тавдугаар сарын 31–нд Киотогийн их сургуульд илгээсэн судалгааны ажлыг жишээ болгон дурдсан юм. Тухайн үед Киотогийн Эзэн хааны их сургууль нэртэй байсан тус сургуульд ирүүлсэн материал нь: “Тахал өвчин нохой бөөсөөр дамжиж тарах боломж” гэсэн нэршилтэй байжээ. Энэхүү судалгааны тайланд туршилтыг сармагчин дээр хийсэн бөгөөд нохой бөөсөөр халдварлуулснаас 6–8 хоногийн дараа “сармагчингуудын” толгой өвдөж, халуурч, хоолны дуршил нь буурч байгааг өгүүлсэн байдаг. Цааш нь бичихдээ нэг сармагчин “таван өдөр дараалан 39 хэмээс дээш халуурч, зургаа дахь өдрөө үхсэн” гэсэн байна. Нишиямагийн багийнхан уг туршилтыг үнэндээ сармагчин дээр биш хүн дээр хийсэн гэж дүгнэжээ. Учир нь сармагчингууд толгой өвдөж байгаагаа илэрхийлж чадахгүй, мөн сармагчингууд ямар төрөл зүйлийнх байсныг дурдаагүй, сармагчингуудын хувьд 39 хэм нь өндөр халуунд тооцогдохгүй зэргээр тэд үндэслэлээ тайлбарласан байна. Тус ангийг удирдаж байсан Широ Иши нь Киотогийн их сургуулийг төгсөгч байсан юм. Нишияма профессор: “Энэ бүх туршилтыг ганц мэргэжилтэн өөрийн сонирхлоор хийж чадахгүй. Японы анагаах ухааны салбар бүхлээрээ оролцсон байж таарна. 731 дүгээр анги бол ердөө мөсөн уулын орой юм<sup>7</sup>” хэмээн ярьжээ.

Квантуны армийн 731 дүгээр отрядын алба хаагчид, тэдэнтэй холбоотой 3607 хүний нэрсийг Японы үндэсний архивын газар 2018 онд ил болгожээ.<sup>8</sup> Үүнд 1945 оны 01 дүгээр сарын 01–нээр огноолсон уг баримт бичигт 52 мэс засалч, 49 инженер, 38 сувилагч, 1117 цэрэг байлдагч, ажилтнуудын жинхэнэ нэр, албан тушаал, гэрийн хаяг зэрэг мэдээлэл

<sup>7</sup> “Японы эрдэмтэд тэмцэж байна”. <https://tug.mn/n/20/show/26631>(татсан:2024.03.28)

<sup>8</sup> 731部隊侵攻日本軍の第 (東京都市大学名誉教授) <https://eritokyo.jp/independent/Bidu-731-a0731.htm> (татсан:2024.03.30)

багтжээ.

Халхын голын байлдаанд 731 дүгээр отрядын оролцооны тухайд

Квантуны арми 1939 онд БНМАУ–ын зүүн хил хязгаарт Монгол–Зөвлөлтийн армийн эсрэг бактерийн зэвсэг хэрэглэхийг санаархаж, энэ талаар тодорхой төлөвлөгөө боловсруулан, түүнийгээ гүйцэлдүүлэх оролдлого хийж байжээ гэж үзэх үндэстэй.

Халхын голын байлдааны явцад Монгол–Зөвлөлтийн цэргийн эсрэг бактерлогийн зэвсэг хэрэглэсэн болохыг баталсан баримт сэлт нэлээд бий. Эдгээр нь ихэвчлэн Орос, Хятдын судлаачдын бүтээл болон МАХЦ–ийн ахмад дайчдын дурдатгалаар дамжин илэрч байдаг. Он цагийн хувьд Халхын голын байлдаан эхлэхээс өмнө 1931–1934 онд Хөлөнбуйрт тагнуулаар ажиллаж байсан нэрт тагнуулч Г.Гончигдоо 1935 онд шоронд байх үедээ: “1933–1934 оны үед шинээр цэргийн албанаа татагдсан цэргүүд ба Хайлаар хотын харьяат нарыг халуун өвчнөөс хамгаалах тарилга явуулсан бөгөөд түүнийг зарим хүн нь үл даан үздэг байсан. Энэхүү тарилга юуны учир хийж буй хэмээн миний бие Японы Инэгүчигээс асуусанд түүний хэлсэн нь, Монгол ба СССР хоёр улс лугаа ирээдүйд дайн байлдаан хийх үед дайсан этгээдийн зүг халдварт өвчний зүйлсийг бөмбөг их бууны сум зэргийн дотор агуулан Монгол, СССР хоёрын (нутаг)дэвсгэрт хаях болно. Учир иймээс өөрийн цэргийг тэрхүү өвчний халдвараас хамгаалахын тулд энэхүү тарилга үйлдэж буй хэмээсэн. Тэрхүү бөмбөгүүдийг “Чондон” хэмээн нэрлэж байсан бөгөөд тэдгээрийн хэмжээ нь тахианы өндөгний хир бөгөөд харавтар өнгөтэй байсан. Тэдгээр бөмбөгүүдийг 1934 оны намар цаг Халуун рашаан дайруулан Японы Инэгүчигийн сууж буй газар унаа хөсөг хэрэглэн тээж байсан болох тул миний бие өөрийн нүдээр үзсэн бөлгөө<sup>9</sup> хэмээн мэдүүлсэн байдаг.

Монгол–Зөвлөлтийн цэргийн бие бүрэлдэхүүнийг урьдчилан сэргийлэх, ус, хоол хүнсээр хангахын зэрэгцээ буудалласан газрыг ариутгаж, ялангуяа усны эх үүсвэрийг ариутгах талаар ихэд анхаарч байлаа. Зөвлөлтийн улаан армийн жанжин штабын дарга Б.М.Шапошниковоос 57 дугаар Онцгой корпусын командлалд эсрэг этгээдээс бактериологийн хэрэгсэл хэрэглэж болзошгүйтэй холбогдуулан сэрэмжлэх арга

<sup>9</sup> ТЕГ–ын Тусгай архив. Ц1633. т.163–164



хэмжээ авах талаар 1939 оны долдугаар сарын 14-нд шуурхай захирамж ирүүлсэн байдаг. Уг захирамжид: "...Ундны усыг хэрэглэхдээ онцгой анхаарал болгоомжтой байхыг цэргүүдээс шаардах хэрэгтэй. Бүхий л тохиолдолд усыг хэрэглэхээс өмнө сайтар шинжлэн, худаг дээр харуул гаргах шаардлагатай. Авсан арга хэмжээний талаар илтгэ."<sup>10</sup> гэжээ. Үүнээс үзвэл Зөвлөлтийн цэргийн дээд командлал Японы зүгээс х

Хятдын зарим судлаачдын орон нутгийн чанартай хэвлэлд гарсан нийтлэлүүдээс харахад Японы 6 дугаар армийн хувьд өвчний тархалт эсэргүүцэх ажиллагаа сул хийгдэж байснаас 1340 цэрэг, офицерууд өөрсдийнхөө биологийн зэвсэгт өртөж, булчин задрах тахал, цусан суулга, боомоор өвчилж, олонх нь үхсэн тухай, Хайлаарт байх Японы армийн цэргийн эмнэлэг өвчлөгсдөөр дүүрч, 8500 цэрэг халдвар авсан тухай, ахмад Ямасити Кэнжигээр толгойлуулсан халдвар судлалын тусгай комисс цэрэг, офицерууд "Исигийн отряд"-ын үйл ажиллагаанаас болсон гэсэн дүгнэлтэд хүрсэн тухай яг таг баримтгүй бичвэр нэлээд дайралддаг нь судалгааны өгүүлэлд эшлэмгүй байдаг.

Япон дайнд ялагдсаны дараа эх орондоо буцаж ирсэн 731 дүгээр отрядын албан хаагч Камата өгүүлсэн нь: "Нэг өдөр манай 3 хүнтэй хэсэгт Хулстай голд бактери цацах тушаал өгч, бид тахлын ба хулганы хижгийн бактериар, шингэн агуулсан сав болон хижиг халдварлуулсан хулгана, хор цацах багажийг машинд ачиж Жанжин сүмээс хөдлөв. Бид яарч тэвдсэнээс болгоомж алдаж манай тасгийн дарга халдвар авч, өвчин тусч Хайлаарын эмнэлэгт очиж эмчлүүлсэн боловч удалгүй үхсэнийг би сүүлд сонссон. Тэр голд бактери цацах гэж үдийн хойно Жанжин сүмээс гарахдаа замдаа нэг тариачин айлд орж зам өнгөрч байгаа жирийн япон хүн гэж худал хэлж түр амарсан. Тэр айл халиараар банш хийж биднийг дайлав. Тэднийхээс явах үедээ гэрийнхний анхаарамжгүй байдлыг ашиглан биедээ авч явсан хулганы хижгийн хатаасан бактери гэрт нь хаяж орхисон. Бид Халхын голд бактери хаях үүргээ биелүүлээд буцахдаа энэ айлд ирэхэд тэр өрхийн 3 хүн бүгд үхсэнийг

мэдсэн"<sup>11</sup> гэжээ.

Квантуны армийн 731 дүгээр отряд зохих хэмжээний бактери үйлдвэрлэх чадалтай, бактерийн зэвсэг хэрэглэх арга барилаа олсон, дайны үед өөрийн цэргийг хамгаалах ус шүүн тунгаах машиныг зохион бүтээсэн байжээ. Энэ нь Японы армийн дээд командлалын итгэл найдварыг төрүүлж, Иши Широ ч отрядынхаа хүч боломжийг дээд удирдлагадаа харуулахын тулд түр цагийн дэлгэн үзүүлэх байрыг бэлдэж, бактери үржүүлэх сав, хайрцаг, бактери тээгч сумны хонгио, ус шүүх машин зэрэг бактерийн дайнд хэрэглэх багаж, тоног төхөөрөмж, өмнө нь туршилт хийж буйг харуулсан гэрэл зураг, зүүн хойт Хятадын газрын гадарга, уур амьсгалын газрын зураг зэргийг дэлгэн үзүүлж, Квантуны армийн удирдлага эдгээрийг үзээд Иши Широ Халхын голын байлдаанд оролцох төлөвлөгөө, төсөв хийх үүрэг өгчээ. Квантуны армийн удирдлагын энэ шийдвэрийн дагуу 731 дүгээр отряд уг дайнд оролцох төлөвлөгөө боловсруулав.<sup>12</sup> Тэд дайны үед бактерийн зэвсгийг хэрэглэх хэд хэдэн арга боловсруулсан бололтой байдаг. Үүнд:

Нэгд, боомын бактерийг их бууны сумны хонгионд хийж, их буугаар Зөвлөлт, Монголын цэргийн зүг буудаж дайсны фронтын гүнд бактери тараах.

Хоёрт, их бууны сум мэт шавар, шаазан бөмбөг хийж, дотор нь бактери халдварлуулсан жижиг амьтан, бодис, хүнсний зүйл хийж Халхын голын баруун эрэгт нисэх онгоцоор хаях. Нэг онгоц хэдэн арван бактериар бөмбөг тээх бөгөөд нэг бөмбөгөнд л гэхэд 5000 орчим хулганы хижиг халдварлуулсан нохой бөөс тээж дайны гүнд хаяна. Бөмбөг газарт унаж хагарахад бактери халдварлуулсан нохой бөөс газарт цацагдан богино хугацаанд үлэмж талбайд тарж, улмаар хүнийг хазаж цусаар дамжуулан бактери тарааж хулганы хижиг өвчнийг халдварлуулна.

Гуравт, тусгайлан бэлтгэсэн нэг салаа буюу амиа золиослох анги Халхын голын баруун эргийн гүнд оруулж гол мөрөн, худаг зэрэг ундны усны эх булагт бактери ба хорт бодисыг тавьж Зөвлөлт, Монголын цэргийг хордуулах. Японы 731 дүгээр отрядын удирдлага дээрх 3 арга замаар дайны явцад бактерийн зэвсэг

<sup>10</sup> Халхын голын орчим дахь зэвсэгт мөргөлдөөн. 1939.5-9 сар. Баримт материалууд. УБ, 2019 он. т.217-218 /Орос эх: ОТЦА. Ф.37977. оп. 1. Д.54. Л.122./

<sup>11</sup> Хан Шияо, Шин Пэй Лин. "Японы армийн 731 дүгээр ангийн ялт хэргийн түүх". Хэйлинжиан мужийн ардын хэвлэлийн хороо. 1991 он. т.252-253

<sup>12</sup> Мөн тэнд. т.258-259



хэрэглэх боломжтой гэж үзжээ.

Гэвч тэд хулганы хижгийн бактери, боомын бактерийг халдварлуулах арга чадвар дутмаг, харин булчин задрах тахал, цусан суулгын бактери болон бусад тахлын халдварлах арга замыг тодорхой мэдэж байсан юм. Иймд Иши Широ хулганы хижиг, боомын бактерийг туршилтын журмаар хэрэглэж, булчин задлах тахлын ба цусан суулгын бактерийг голлон хэрэглэхээр шийдвэрлэжээ. Ингээд тусгай тасаг Халхын голын баруун эргийг судлан зургийг нь зурж, бактериар хордуулж болох гол, булаг, шанд, нуур, худаг зэргийг тусгайлан тэмдэглэсэн байна. Японы талаас Квантуны армийн 23 дугаар явган дивизийн командлагч, дэслэгч генерал М.Комацубара<sup>13</sup> олон жил цэрэг захирч, тагнуулын ажиллагаа удирдсан туршлагаараа 731 дүгээр отрядын боловсруулсан дээрх 3 төслийг хэрэгжүүлэхэд гарч болох хохирол, сөрөг талыг урьдчилан сайтар хянаж үзсэн нь дамжиггүй. Магадгүй түүний тооцоолсноор хэрвээ их буу, миномётоор бактерийг харвахаар бэлтгэсэн тохиолдолд их хэмжээний бактери агуулсан их бууны сумнууд нь буудаж амжаагүй байхад Зөвлөлтийн цэргийн их бууны галд өртөж болзошгүй юм. Энэ тохиолдолд бактерийн сум өөрийн цэргийн дотор дэлбэрч, өөрсдөө бактерийн хорыг амсаж болзошгүй гэж Комацубара болгоомжилсон байх магадлал өндөр. Мөн нисэх онгоцоор бактериар бөмбөг хаях тохиолдолд онгоц нь нам өндөрт нисч байхдаа дайсан этгээдийн галд өртөж, Халхын голын зүүн талд унавал мөн л өөрийн талд бактерийн аюул тарина. Харин тусгай анги дайсны фронтын гүнд орж ундны усны эх булагт бактери цацахад Монгол, Зөвлөлтийн цэрэг усны эх булгийг сайн хамгаалж байгаа тул баригдах аюултай гэж үзжээ. Хамгийн гол нь Квантуны арми Халхын голын баруун эрэгт гарахаас өмнө бактерийн зэвсэг хэрэглэвэл өөрсдөө голын баруун талыг эзэлсний дараа хор аюулыг амсч болзошгүй хэмээн дэслэгч генерал Комацубара ихэд болгоомжилсон байх талтай. Тэрээр гарч болзошгүй эрсдлийг зайлшгүй харгалзан үзэх нь чухал гэж шийдвэрлэжээ. Японы 23 дугаар

<sup>13</sup> Комацубара Мичитаро. Японы цэргийн академийг 1906 онд төгссөн бөгөөд 1919–1920, 1927–1930 онд ЗХУ–д цэргийн атташе, 1932–1935 онд Харбинд тагнуулын тусгай ангийн дарга, улмаар Гирин мужийн цэргийн гарнизоны командлагчаар ажиллаж байгаад 23 дугаар явган дивизийн командлагчаар томилогджээ.

явган дивизийн удирдлага эдгээрийг нарийн нягт судлан эргэцүүлсний эцэст бактерийн зэвсгийг зөвхөн өөрсдөө “Чиглэл ээ өөрчлөх” / ялагдаж ухрах–зох/ үед л хэрэглэвэл зохистой гэж үзсэн бололтой. Тэд дайны байдал өөрсдөд нь ашиггүй болбол Халхын голын дээд урсгалд бактери хийж урсгалын доор байгаа Монгол, Зөвлөлтийн цэргийг хордуулах замаар давшилтыг нь зогсоох, мөн дайнд ялагдвал нууц байдлаар бактерийн сум харвахаар тооцоолсон байна.

Халхын голын байлдаанд Иши Широ 731 дүгээр отрядын бактери судлаач 400 гаруй хүнийхээ бараг хагасыг нь байлдааны талбарт татан ирүүлж “Квантуны армийн хижгээс сэргийлэх тасаг” гэсэн нэрээр оролцуулжээ. Тэрээр “Квантуны армийн хижгийг сэргийлэх тасаг”–т дайнд хоёр чухал үүрэг гүйцэтгэхийг даалгажээ. Үүнд: Нэгд, бага дэслэгч Сасакийн удирдлага дор 3 хэлтсийн арав гаруй бага түрүүч, сурган хүмүүжүүлэх хэлтэст суралцуулсан хүмүүсийг оролцуулж, бактерийн хижгийг сэргийлэх, ус хангах тасаг ба тохируулах тасгийг зохион байгуулж ажиллуулахаар шийдвэрлэжээ. Энэ тасаг нь голын усыг шүүн тунгааж, өөрсдийн цэргийг цэвэр усаар хангах үүрэгтэй юм. Энэ тасгийн хэрэглэх ус тунгаах багаж 20, ус шүүн тунгаах багаж 100 болон бусад хэрэгцээтэй багаж хэрэгслийг 6 дугаар сарын сүүлчээр галт тэргээр Хайлаарт авчирсан байна. Харин хүмүүс нь 731 дүгээр отрядын тусгай машинаар өдөр, шөнөгүй явсаар шууд Номунханы дайны талбарт хүрч иржээ. Дайны үед хижгийг сэргийлэх тасаг бүрд ус тунгаах машин нэгийг өгсөн бөгөөд энэ нь нэг суман цэргийн нэг долоо хоног хэрэглэх усыг шүүн цэвэрлэх чадалтай байжээ. Энэ машины усны сав нь модоор хийсэн тул дайсанд олзлогдоход хүрвэл шатааж орхино. Ийм төхөөрөмжийг тэр үед Зөвлөлтийнхөн судлан бүтээж чадаагүй байжээ. Хоёрт, тусгай тасаг зохион байгуулж бактерийн зэвсгийг туршин хэрэглэнэ. Зургаадугаар сарын сүүлчээр Иши Широ хошууч Дейчүгээр удирдуулсан амиа золиослох анги байгуулжээ. Хошууч Дейчү тушаал аван Харбины 731 дүгээр отрядаас Хайлаарын зүг явахын өмнө Иши Широгийн өмнө хуруугаа тас хазаж, Японы туган дээр цусаараа нэрээ бичиж самурайн ёслол хийсэн бөгөөд түүний удирдсан үхэн байлдах ангийн дайчид ч мөн адил тангараг өргөжээ. Тэд Их Наран улсын



зээн хаанд үнэнч шударга зүтгэн, 731 дүгээр отрядын нууцыг задлахгүй байхаа андгайлан тангарагласан байна. Энэ тасаг нь Халхын голын усанд бактери цацаж дайсны цэргийг халдварт өвчнөөр өвчлүүлэн хохирол учруулах үүрэгтэй байжээ. "...7 дугаар сарын 12-ны өдөр амиа золиослох бүлэг Халхын голын хөвөөний нарсан модон дотор орлоо. Тэд бүгд мөрдэс, малгайн тэмдэгтэй, япон цэргийн шар хувцас өмссөн нь хүмүүс тэднийг Квантуны армийн бактерийн анги гэж мэдэхээс сэргийлжээ. Хийлдэг завинд арван хэдэн том төмөр торх, нэг хэсэг шилэн сав, усны төмөр сав суулга, урт бариултай шанага зэргийг тээж, онцгой багаж материалаа хуваан үүрчээ. Тэд хошууч Дей Чүгийн удирдлагаар нарсан ойн захаар нуугдан явсаар Халхын голын хөвөөнд ойртов"<sup>14</sup> гэжээ.

Хожим нь усанд нян хийж байгаа дүрс бичлэг бүхий энэхүү киног 731 дүгээр ангийн сургалтын багийнхан олон удаа үзжээ.<sup>15</sup> 1939 оны 7 дугаар сарын 13-ны өдрийн 1 цаг 30 минутад 731 дүгээр отрядын дарга Иши Широ Хулстай голын өмнө хөвөөнд байсан Квантуны 71 дүгээр батальоны дарга, байлдагч нарт "Халхын голын усыг хэрэглэж болохгүй. Голын ус нэгэнтээ хордсон" гэж мэдэгджээ. Ийм учраас Номунханы дайны өмнө фронт дахь Япон болон Манж Гогийн цэрэг ус тунгаах машинаар усаа шүүн хэрэглэх болов. Хайлаарт 1939 оны 8 дугаар сарын дундуур 731 дүгээр отрядын Ямашитагийн удирдсан халдварт өвчин тархалтыг судлах тасаг 10 гаруй мэргэжилтэн цугларч өвчний тархалт, бактерийн үйлчилгээг судалжээ. Тэд 7 хоногийн дотор дарга, байлдагчдад үзлэг хийж шалгахад 8500 хүн өвчилсөн байсан бөгөөд өвчин нь өөрсдийн тавьсан бактериас үүсэлтэй болохыг тогтоожээ. 731 дүгээр отрядын 2 дугаар эмнэлгийн цэргийн эмч, дэслэгч Катами, цэргийн эмч, хошууч Мияа Путадо, Инодия, Биба, Кураками нарт тахлын нян халдварлаж нас баржээ. Тус отрядын алба хаагчдыг 1939 оны 10 сард Халхын голоос татаж Харбинд буцаажээ. Тус отрядын албан хаагч Цурата мэдүүлэхдээ "Дайны талбараас буухад нэгэн тасгийн дарга тахлын халдвар авснаас Хайлаарын хуурай замын цэргийн

эмнэлгийн хороонд үхлээ гэж сонссон"<sup>16</sup> гэсэн бол өөр нэгэн Кимата мэдүүлэхдээ "Бактерийг Номон ханы дайнд хэрэглэсэн гэж лавтай сонссон. Гэвч цэргийн эмч Кохи зэрэг хэдэн арван хүн бактери халдварласнаас үхсэн"<sup>17</sup> гэж мэдүүлжээ.

Хожим 1954 оны 8 дугаар сарын 21-ний өдөр Мүгдэнд болсон Японы цэргийн гэмт хэрэгтнүүдийн шүүх хурал дээр цэргийн эмнэлгийн дэслэгч Такуйчи мэдүүлэхдээ "Иши Широ бактерийн судалгааны ажлыг эрчимжүүлэхийн төлөө бүхий л хүч чадлаа дайчлан ажиллаж, бактерийг их хэмжээгээр үржүүлж байсан. Тэрээр Квантуны армийн цэргийн эмнэлгийн хэлтсийн дарга, дэслэгч генерал Озикатай биечлэн харилцаж Хайлаарын хуурай замын цэргийн эмнэлэгт том хэлбэрийн өндөг дарах машин (бактери үржүүлэх багаж) хуурайгаар бактери устгах багаж 2, бактерийн өвчний үүсэлт, шинж байдлыг хянан шалгах багаж 2, тодотгогч шил 2 суурь болон өвчний зүйн туршилтын төхөөрөмжийг нэмэн өгч, барилга байгууламжийг нь ч хоёр дахин өргөтгөсөн" гэжээ.

Квантуны армийн 6 дугаар армийн штабын дарга дэслэгч генерал Укишидагийн 1939 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн гардуулсан шагналын бичигт "Шагнал, зургаадугаар армийн хижгийг сэргийлэх, ус хангах түр цагийн хэлтэст. Тус хэлтэс нь цэргийн ахлах эмч, хурандаа Иши Широгийн удирдлагаар "Номун ханы хэрэг явдал"-д оролцож хижиг сэргийлэх, ус хангах үүргийг гүйцэтгэв. Нэн ялангуяа 8 дугаар сарын сүүлчээр дайсны цэрэг довтлох үеэр тус анги Халхын гол хавьд үлдэж, усны эхийг сахин сэргийлэн, цэргийн эмч Ияама зэрэг хэдэн хүн амь үрэгдэж, байлдааны хүнд нөхцөлд олон өдрийн турш эрүүлийг хамгаалах амжилттай биелүүлж, цэрэг дайны хэрэгт дэмжлэг үзүүлэв" гэжээ.

Япончууд 1939 оны 7 дугаар сарын 13-нд Халхын голын усанд хийж халдварлуулан бохирдуулсан биологийн агент-бактери нь олон улсын өвчний 10 дугаар ангилалд багтдаг бөгөөд одоо нийтээр хэрэглэж буй өвчний нэр нь дээр заасан эх үүсвэрүүдээс ихээхэн зөрөөтэй байгаа тохиолдолд Анагаах ухааны олон улсын байгууллагуудын зөвлөлөөс зөвлөмж болгосон

<sup>14</sup> Ли Чүн Пен., нар. "Номун ханы дайн". Жилин мужийн соёл, түүхийн хэвлэлийн хороо. 1988, т.48

<sup>15</sup> Шу Жэнь Жян., нар. "Японы армийн Номон ханд хийсэн бактериологийн байлдаан". Халхын голын дайн-80 жил. ОУЭШХ-ийн эмхэтгэл. 2019. т.55-57

<sup>16</sup> Хан Шияо, Шин Пэй Лин. "Японы армийн 731 дүгээр ангийн ялт хэргийн түүх". Хэйлинжиан мужийн ардын хэвлэлийн хороо. 1991 он. т.20

<sup>17</sup> Мөн тэнд. т.54



боом, холер, цусан суулга зэргийг ашигласан байдаг.

### Дүгнэлт

Японы эзэн хааны армийн дээд командлал нь 731 дүгээр отрядын бүрэлдэхүүнээр хими, бактерийн зэвсэг бүтээх, турших бүхий л ажиллагааг эрхлэн явуулж байсан бөгөөд түүнийгээ Халхын голын байлдааны театрт бодитоор турших боломж олджээ. Ингэхдээ өөрсдийн бүтээсэн бактерийн зэвсэг нь өөрсөдөд нь халтай гэдгийг зарим туршлага бүхий генерал офицерууд сайтар ойлгож байж. Нөгөөтэйгүүр Монголын цэргийн тагнуулчдын олзворлосон мэдээлэл, Зөвлөлтийн улаан армийн дээд командлалаас ирүүлсэн захирамжуудаас харахад эсрэг талын бактерийн зэвсгийн хор хөнөөлийг эртнээс мэдэж сэрэмжилж байсан нь анзаарагдана. Мөнөөх 731 дүгээр отряд цөөнгүй жил элдэв халдварт өвчний бактерийг өсгөн үржүүлэх, хадгалан нөөцлөх, дайнд хэрэглэх талаар туршилт явуулсан боловч дайнд хэрэглэх бодит практик туршлага байсангүй. Өмнөх бүлэгт дурдсан баримтууд нь Халхын голын байлдаанд хэрэглэсэн 731 дүгээр отрядын бэлтгэсэн халдварт өвчний бактерийн үр дүн ямаршуу болсныг гэрчилж байна. Туршилт, байлдааны ажиллагаа нь үр дүнгүй болж, өөрсдийн цөөнгүй алба хаагчид хордож амь үрэгдсэн мэдээ байна.

Халхын голын байлдаанд бактериологийн зэвсэг хэрэглэсэн нь эдүгээ хүртэл яг таг хөдлөшгүй баримтаар нотлогдоогүй, харин Хятадын тал, үүнээс үүдэн Японы зүүний хүчнийхэн, зарим Оросын судлаачид “хэрэглэсэн” гэж үздэг болно, энэхүү байдлыг харгалзан алив дүгнэлт гаргахдаа догматикаар хандахгүй байх нь зүйтэй юм.

Гэвч Япончуудын хувьд Халхын голд болж өнгөрсөн “Хижгээс сэргийлж, ус цэвэршүүлэх” ажиллагаа нь хэдийгээр өөрсдийн хүн хүчний хохиролтой ч гэсэн практик туршилтын талаасаа ач холбогдолтой байсан нь илэрхий.

Халхын голд явагдсан байлдааны ажиллагааны дараа “Номун ханы хэрэг явдал”-д оролцсон Квантуны армийн зарим дээд тушаалын бүрэлдэхүүнийг албан тушаал бууруулах, эгүүлэн татах, сэлгэн томилсон байдаг. Харин 731 дүгээр отрядын бүтэц, орон тоог нэмэгдүүлж, түүний бүрэлдэхүүнд салбар ангиудыг шинээр байгуулан өргөтгөн зохион байгуулжээ. Отрядын дарга Иши Широод хошууч генерал цол олгогдсон билээ.

### Ашигласан материал:

1. ТЕГ-ын Тусгай архив. Ц1633. т.163-164
2. Халхын голын орчим дахь зэвсэгт мөргөлдөөн. 1939.5-9 сар. Баримт материалууд. УБ, 2019 он. т.217-218 /Орос эх хувь:ОТЦА. Ф.37977. оп. 1. Д.54. Л.122./
3. Hal Gold, Unit-731. Testimony, 2003, p,109
4. Хан Шияо, Шин Пэй Лин. “Японы армийн 731 дүгээр ангийн ялт хэргийн түүх”. Хэйлинжиан мужийн ардын хэвлэлийн хороо. 1991 он. т.252-253
5. Ли Чүн Пен, Сю Жанг Зиан, Авид нар. “Номун ханы дайн”. Жилин мужийн соёл, түүхийн хэвлэлийн хороо. 1988, т.48
6. Шү Жаны Жян, Вү Сеньхуа, Лю Тунчянь нар. “Японы армийн Номон ханд хийсэн бактериологийн байлдаан”. Халхын голын дайн-80 жил. ОУЭШХ-ийн эмхэтгэл. 2019. т.55-57

### Цахим сурвалж:

1. (고 기요노 겐지 선생 기념논문집 제3집). <https://blog.naver.com/ilamjcyong/24928581> (таталт:2024.03.28).
2. 관동군 방역급수부 본부 <https://namu.wiki/w/731> (татсан :2024.03.28)
3. “Японы эрдэмтэд тэмцэж байна”. <https://tug.mn/n/20/show/26631> (татсан:2024.03.28)
4. 731部隊侵攻日本軍の第 (東京都市大学名誉教授) <https://eritokyo.jp/independent/Bidu-731-a0731.htm> (татсан:2024.03.30)

## МОНГОЛ УЛС, БНХАУ–ЫН БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА БА БОЛОМЖ

**Б.АМАРТӨР** /БХЭШХ-ийн БХСТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан докторант, дэслэгч/

**Key words:** defense cooperation, defense policy, border protection, security

### Хураангуй:

Энэхүү нийтлэлд Монгол, Хятадын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хөгжлийн төлөв байдлыг судалж, түүхэн нөхцөл байдал болон стратегийн хамтын ажиллагааны шинэ боломжуудыг онцолсон болно. Дипломат харилцааны гүн гүнзгий харилцаатай орнуудын хувьд Монгол, Хятад хоёр улс хамтарсан сургуулалт, өндөр түвшний яриа хэлэлцээ, батлан хамгаалахын дипломат харилцаа зэргээр дамжуулан батлан хамгаалах салбарын харилцаагаа аажмаар өргөжүүлж байна. Энэхүү судалгаанд энхийг сахиулах, хилийн аюулгүй байдал, чадавхыг бэхжүүлэх, хүмүүнлэгийн тусламж зэрэг хамтын ажиллагааны гол салбаруудыг судалж, хоёр улсын батлан хамгаалахын харилцаанд нөлөөлж буй улс төр, эдийн засаг, геополитикийн хүчин зүйлсийг үнэллээ. Энэхүү нийтлэл нь хоёр талын ашиг сонирхол, цаашдын хамтын ажиллагааны боломжит гарцуудыг тодорхойлсноор Монгол, Хятад хоёр бүс нутгийн тогтвортой байдал, харилцан аюулгүй байдлын зорилтуудыг хангах үүднээс батлан хамгаалахын харилцаагаа хэрхэн бэхжүүлэх талаар илүү сайн ойлголттой болоход хувь нэмэр оруулах зорилготой юм.

### Abstract:

This article examines the development of defense cooperation between Mongolia and China, highlighting the historical context and new opportunities for strategic cooperation. As countries with deep diplomatic ties, Mongolia and China have been gradually expanding their defense cooperation through joint exercises, high-level dialogues, and defense diplomacy. This study examines key areas of cooperation, including peacekeeping, border security, capacity building, and humanitarian assistance, and assesses the political, economic, and geopolitical factors affecting the defense relationship between the two countries. This article aims to contribute to a better understanding of how Mongolia and China can strengthen their defense relations to ensure regional stability and mutual

security goals by identifying the interests of both sides and potential avenues for future cooperation.

### Оршил.

Монгол, Хятад хоёр орон газар зүй, түүх, хувьсан өөрчлөгдөж буй геополитикийн динамикаас үүдэлтэй өвөрмөц харилцаатай. Хоёр улс 4700 км урт хилийн шугамтай хөршүүдийн хувьд улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын чиглэлээр олон төрлийн хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн. Эдгээрийн дотроос батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа хоёр талын харилцааг тодотгож буй чухал салбар болж байна. Хятад, Орос хоёр их гүрнүүдийн дунд оршдог Монгол Улс үндэсний аюулгүй байдал, бүс нутгийн тогтвортой байдлыг хангасан бүтээлч түншлэлийн харилцааг хөгжүүлэхийн зэрэгцээ тусгаар тогтнолоо хадгалах давхар сорилттой тулгарч байна.

Хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа нь батлан хамгаалахын дээд түвшний яриа хэлэлцээ, цэргийн хамтарсан сургалт дадлага, боловсон хүчнийг бэлтгэх хөтөлбөр, зэвсэглэл, техник, материал хэрэгслийн тусламж үзүүлэх зэрэг чиглэлээр амжилттай хөгжиж байна. Хоёр орны харилцаа нь ашигтай байхын зэрэгцээ тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх өргөн хүрээг хамардаг. Монгол Улс "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд дэлхийн бусад орнуудтай найрсаг харилцаатай, хамтран ажиллахыг эрэлхийлж байгаа нь ойрын хөршүүдтэйгээ тогтвортой, ашигтай харилцаа тогтоох прагматик хэрэгцээг тэнцвэржүүлэх хүчин чармайлтын илрэл юм.

Энэхүү өгүүлэлд Монгол–Хятадын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж болон цэргийн хамтын ажиллагаагаа шинэ хэлбэрээр хөгжүүлэх талаар судалсан ба судалгааны хүрээнд хоёр орны харилцааны түүхэн нөхцөл байдлыг авч үзэн, өнөөгийн харилцаанд дүн шинжилгээ хийж, Монгол Улсын гадаад бодлого, бүс нутгийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөг судаллаа.



Хоёр орны түншлэлийн батлан хамгаалахын харилцааны талаар судалснаар Зүүн Хойд Азийн орнуудын батлан хамгаалах, цэрэг–дипломатын харилцааны талаарх өргөн хүрээний судалгаанд хувь нэмэр оруулахыг зорисон болно.

### **Хоёр орны батлан хамгаалах салбарын харилцааны хөгжил**

БНМАУ 1949 онд БНХАУ–тай дипломат харилцаа тогтоосноос хойш 70 гаруй жилийн түүхэнд бүхий л салбарт нэн ялангуяа аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа өгсөж уруудсан үе байсан боловч үндсэндээ идэвхтэй өргөжин хөгжиж иржээ. Үүний тод жишээ бол хоёр орны хамтарсан хээрийн сургууль болох “Талын түнш–2024”<sup>1</sup> бөгөөд хоёр орны цэргийн хамтын ажиллагаанд томоохон ахиц гарсныг олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл мөн онцолсон юм.

Манай урд хөрш БНХАУ сүүлийн жилүүдэд үсрэнгүй хөгжиж бүс нутаг болон дэлхийн олон улс оронд төрөл бүрийн салбарт хамтын ажиллагааны хүрээгээ тэлсээр байна. Хятадын Коммунист Нам (ХКН) 2024 оны 7–р сарын 21–ий өдөр гаргасан тогтоолдоо улс орны эдийн засгийг эрчимжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх томоохон төлөвлөгөөний хүрээнд Ардын Чөлөөлөх Арми (ХАЧА)–ийн тасралтгүй хөгжлийг дэмжих зорилгоор цэргийн шинэчлэлийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхийг уриалсан. Энэхүү шинэчлэлийн үр дүнд ХАЧА 2027 он буюу 100 жилийн ойгоороо Бээжингээс дэвшүүлсэн “Бүрэн шинэчлэгдсэн”<sup>2</sup> эмээн нэрлэсэн зорилтдоо хүрнэ хэмээн ХКН мэдэгдсэн. “Бүрэн шинэчлэгдсэн ХАЧА” гэсэн зорилт нь БНХАУ–ын Зэвсэгт хүчний шинэ зууны дунд үеийн шинэчлэлийн зорилтуудад хүрэх чухал үе шат ажээ. Олон улсын судлаачид цэргийн хүрээний энэхүү шинэчлэлийн арга хэмжээг ХКН–ын ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд БНХАУ–ын дарга Ши Жинпиний ХАЧА дахь авлигыг устгахад чиглэсэн үйл ажиллагааны нэг хэсэг хэмээн үзэж байна.

Хоёр улсын хооронд хөгжүүлж буй батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа нь аюулгүй тогтвортой байдлыг хангах, бүс нутгийн энх тайвныг хамгаалж бэхжүүлэх болон бусад болзошгүй эрсдэл, эмзэг асуудлуудаас урьдчилан сэргийлэх талаар хамтран ажиллахад чиглэж байна. Энэхүү харилцаа нь Монгол, Хятадын төр, эдийн засгийн харилцан ашигтай

хамтын ажиллагаа, аюулгүй байдлын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн стратегийн түншлэлийг бататгах олон талт арга хэмжээнүүдээс бүрдэх юм.

Хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа дараах арга хэмжээний хүрээнд хөгжиж байна. Үүнд:

1. Хил хамгаалалт. Хоёр улсын хил хамгаалалтыг сайжруулах, хууль бус цагаачлал, хилийн зөрчил, хууль бус бараа бүтээгдэхүүний худалдаатай тэмцэх чиглэлээр хамтарсан ажлыг зохион байгуулах болон хил орчмын газар нутаг, бүсэд тогтвортой байдлыг хадгалахын тулд мэдээлэл солилцох, хяналтыг сайжруулахад харилцан дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;

2. Терроризм болон хил дамнансан гэмт хэрэгтэй тэмцэх, олон улсын терроризмын эсрэг хамтран тэмцэх, хил дамнансан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бүс нутгийн аюулгүй байдлыг хамгаалах, мэдээлэл солилцох, цагдаагийн тусгай сургалт, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах хамтын ажиллагааг дэмжих;

3. Олон улсын аюулгүй байдлыг хангах. Бүс нутгийн аюулгүй байдлын тогтвортой байдлыг бэхжүүлэх Монгол улс, БНХАУ, ОХУ–ын аюулгүй байдлын талаарх хамтын ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах замаар олон улсын аюулгүй байдлыг хангах, энх тайван байдлыг хамгаалахад хувь нэмрээ оруулах;

4. Байгаль орчны аюулгүй байдлыг хамгаалах. Хүрээлэн буй орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдол зэрэг байгаль орчны аюулгүй байдлын асуудлуудад чиглэсэн хамтын ажиллагааны арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж, ажиллах;

5. Цэрэг, батлан хамгаалахын хамтын ажиллагаа. Хоёр улсын Батлан хамгаалах яам, зэвсэгт хүчин хамтын ажиллагааны хүрээнд хамтарсан сургалт, дадлага хийх, энхийг сахиулах, цэрэг–техникийн тусламж болон цэргийн сургалтын хөтөлбөрүүдэд хамруулах замаар батлан хамгаалахын харилцааг дэмжих, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхээр чармайн ажиллаж байна.

Монгол, Хятадын батлан хамгаалах, цэргийн хамтын ажиллагаа нь хоёр улсын стратегийн түншлэл, хамтын ажиллагааг дэмжих, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах, итгэлцлийг бэхжүүлэхэд чиглэж байна.

Тус хоёр улсын батлан хамгаалахын хамтын ажиллагаа амжилттай хөгжиж байгаа нь олон

<sup>1</sup> <https://www.globaltimes.cn/page/202405/1312674.shtml>

<sup>2</sup> [https://www.gov.cn/zhengce/202407/content\\_6963770.htm](https://www.gov.cn/zhengce/202407/content_6963770.htm)



боломжийг бий болгож байгаагийн зэрэгцээ хоёр орны геополитик, улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын ашиг сонирхлоос улбаатай зарим эрсдэлийг бас дагуулж байдаг.

Одоо хоёр орны хамтын ажиллагааны цаашдын боломжуудыг авч үзье. Монгол, Хятадын хамтын ажиллагаа улсын хилийн аюулгүй тайван байдлыг бэхжүүлж, хилийн зөрчлийг бууруулан улмаар бүс нутгийн тогтвортой байдал, итгэлцлийг бий болгоход эргээр нөлөөлөх нь дамжиггүй юм.

Хоёр орны батлан хамгаалах хамтын ажиллагааны хүрээнд эдийн засгийн болон дэд бүтцийн хөрөнгө оруулалтын боломжийг бий болгож Монголын дэд бүтцэд хөрөнгө оруулснаар батлан хамгаалах хөгжилд шаардлагатай тээвэр, логикийн нөхцөлийг сайжруулаад зогсохгүй цаашлаад Монгол улсын эдийн засаг, худалдаа, бараа, үйлчилгээний тээвэрлэлт, хүртээмжийг ч нэмэгдүүлэхэд эерэг үр дүн үзүүлэх боломжтой.

Мөн батлан хамгаалах хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын цэргийн сургалт, дэвшилтэт технологийн салбарт хүрсэн ололт амжилтаас суралцсанаар Зэвсэгт хүчний шинэчлэлийг эрчимжүүлэн, зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэх, олон улсын терроризмтой тэмцэх болон зэвсэгт хүчний шинжлэх ухаан технологийн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах боломж бүрдэнэ.

Монгол улсын БХЯ, Зэвсэгт хүчин болон БНХАУ-ын Ардын Чөлөөлөх Арми нь бүс нутгийн аюулгүй байдлын орчинг харгалзан хэд хэдэн чиглэлээр хамтран ажиллаж, өргөжүүлэх боломжтой. Үүнд:

#### **Цэргийн хамтарсан сургуулилт, сургалт**

- Монгол Улс олон улсын энхийг сахиулах ажиллагаанд өндөр амжилт үзүүлж байгаа бөгөөд хамтарсан сургуулилт хийснээр гамшгийн үед хариу арга хэмжээ авах, эрэн хайх, аврах ажиллагаа, хүмүүнлэгийн үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх боломжтой.

- Хоёр улс бүс нутгийн аюулгүй байдлын асуудал, тэр дундаа терроризм, хэт даврагч үзэлтэй тулгардаг. Терроризмын эсрэг тактик, тагнуулын мэдээлэл солилцох, хилийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хамтарсан сургуулилт нь талуудад үр өгөөжтэй байх болно.

#### **Хил хамгаалалт ба менежмент**

- Хоёр улс хил хамгаалах чиглэлээр хамтран ажиллах нь хилийн зөрчил, хил дамнасан бусад хууль бус үйлдлээс урьдчилан

сэргийлэхэд тусална.

- Хил дамнасан гэмт хэрэг, болзошгүй аюул эрсдэлийн талаарх мэдээлэл солилцох нь хилийн удирдлагын үр нөлөөг нэмэгдүүлэх юм.

#### **Цэргийн боловсрол, сургалтын солилцооны хөтөлбөрүүд**

- Офицер бэлтгэх хөтөлбөрөөр цэргийн сургууль эсвэл тусгай сургалтад хамрагдаж мэргэжлийн ажил төрлийн холбоо тогтоох, хоёр орны уламжлалт ёс заншлаас суралцах нь харилцан ойлголцол болон ирээдүйн харилцаа хамтын ажиллагааг бэхжүүлэх юм.

- Техникийн сургалт, инженер, логистик, эмнэлгийн тусламж зэрэг цэрэг-техникийн салбарт хамтран ажиллах нь манай орны цэргийн хүчний үйл ажиллагааны чадавхыг сайжруулах, туршлага судлах боломжийг нээх юм.

#### **Цэргийн зэвсэглэл, техник, технологийн чиглэлээр**

- Монгол Улс Хятадын батлан хамгаалах салбарын дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж, цэргийн техник хэрэгслийг хамтран хөгжүүлэх замаар түүнээс суралцан манай орны зэвсэгт хүчний хэрэглээнд шинэ техник технологийг нэвтрүүлэх боломжтой.

- Нөөц ба дэд бүтцийг, ялангуяа логикийн салбарт туршлага солилцож, тусламж дэмжлэг авснаар ЗХ-ны бэлэн байдал, үйл ажиллагааны, үр дүнг дээшлүүлэх боломжтой.

#### **Бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх**

- Хоёр улс аюулгүй байдлын нийтлэг сорилтуудыг шийдвэрлэхийн тулд бүс нутгийн аюулгүй байдлын форумуудад өргөн хүрээтэй оролцож, хамтран ажиллах боломжтой.

- Монгол, Хятад хоёр улс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох талаар хамтран ажиллаж, Монголын туршлага, Хятадын нөөц бололцоог ашиглан олон улсын энх тайван, аюулгүй байдалд оруулах хувь нэмрээ нэмэгдүүлж болно.

#### **Соёл, спортын солилцоо**

- Зэвсэгт хүчний хооронд соёл урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах нь харилцан итгэлцэл, нөхөрлөлийг бэхжүүлэх нөхцөлийг бий болгоно.

- Хэлний сургалт, хөтөлбөр нь хамтарсан ажиллагаа болон хамтарсан сургуулилын үеэр илүү сайн харилцаа холбоог бий болгох, өв соёлоо хүндэтгэж, харилцан итгэлцэл ойлголцлыг бий



болгоход дэмжлэг болно.

Хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг дээрх дурдсан аргуудаар өргөжүүлэх боломжтой ба аюулгүй байдал, батлан хамгаалахын орчин хурдацтай хөгжиж буй эрин үед уламжлалт цэргийн стратеги хангалтгүй болсон. Кибер дайн, цахим дайн (EW), сансрын аюулгүй байдал, хиймэл оюун ухаан (AI)–д суурилсан цэргийн хэрэглээний програмуудыг багтаасан шинэ хэмжээст дайн бий болсон нь улс орнууд батлан хамгаалах, аюулгүй байдалд хэрхэн хандах хандлагыг мөн өөрчилж байна.

Шинэ хэмжээст дайны нөхцөл дэх Монгол, Хятадын цэргийн хамтын ажиллагаа бол болгоомжтой хандах шаардлагатай нарийн төвөгтэй, эмзэг сэдэв юм. Хоёр улс цэргийн салбарт тодорхой хамтын ажиллагаатай хэдий ч ийм хамтын ажиллагаа нь энх тайван, найрамдал, харилцан хүндэтгэх зарчимд тулгуурлан, аль нэг гуравдагч этгээдийг онилсон бус бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хадгалахад чиглэгдэх ёстой.

### **1. Кибер аюулгүй байдал ба кибер дайны хамтын ажиллагаа**

Кибер аюул улам боловсронгуй болж байгаа бөгөөд улс орнууд кибер аюулгүй байдлын чадавхыг бэхжүүлэх тал дээр анхаарлаа хандуулж байна. Дижитал дэд бүтцээс улам бүр хамааралтай болж байгаа нөхцөлд кибер эмзэг байдал нь асар том үр дагаварт хүргэж болзошгүй тул Монгол, Хятадын кибер аюулгүй байдлын хамтын ажиллагааг үндэсний батлан хамгаалахын чухал хэсэг болгож дараах чиглэлээр хамтын ажиллагааг хэрэгжүүлж болно. Үүнд:

- Кибер аюулгүй байдлын хамтарсан сургалт: Кибер хамгаалалтын стратеги, тагнуулын мэдээлэл солилцох, кибер халдлагын эсрэг тэсвэрлэх чадварыг сайжруулах хоёр талын дасгал сургуулилт хийх.

- Кибер аюулын тагнуулын солилцоо: Кибер аюул занал, ялангуяа кибер терроризм, төрийн дэмжлэгтэй халдлагын талаар мэдээлэл солилцох аюулгүй механизмыг бий болгох.

- Хиймэл оюун ухаанд суурилсан кибер хамгаалалтын системийг хөгжүүлэх: Бодит цаг хугацаанд кибер аюулыг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, бууруулах зорилгоор хиймэл оюун ухааны чиглэлээр хамтран ажиллах судалгаа.

- Дэд бүтцийн чухал хамгаалалт: Кибер тагнуул, кибер хорлон сүйтгэх ажиллагаанаас урьдчилан сэргийлэхийн тулд эрчим хүч, харилцаа холбоо, санхүүгийн сүлжээний кибер аюулгүй байдлын арга хэмжээг бэхжүүлэх.

### **2. Электроник дайн (EW) ба хиймэл оюун ухаанд суурилсан дайн**

Дайсны харилцаа холбоог гацааж, сөргөлдөөний радар болон хяналтын системийг тасалдуулахыг багтаасан электроник дайн нь орчин үеийн цэргийн стратегийн чухал элемент болжээ. Хиймэл оюун ухаан, автоматжуулалтын хурдацтай дэвшлийн ачаар Монгол, Хятад хоёр энэ чиглэлээр хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх боломжтой.

- Электроник сөрөх арга хэмжээний хөгжил: Түгжрэлийн технологи, радарын хөндлөнгийн оролцоо, цахим тандалт зэрэгт хамтарсан судалгаа, хөгжил (R&D).

- Хиймэл оюун ухаанд суурилсан цэргийн шийдвэр гаргалт: Монгол улс байлдааны талбарт шийдвэр гаргах болон автоматжуулсан хамгаалалтын системд хиймэл оюун ухаан дахь Хятадын туршлагаас ашиглах боломжтой.

- Электроник дайны хамтарсан сургуулилт: Цахим аюулыг эсэргүүцэх, цахим дайны дэвшилтэт стратеги боловсруулах загварчлалд суурилсан сургалт явуулах.

- Цэргийн систем дэх квант харилцаа холбооны интеграцчлал: Электрон саатуулга, хакердахаас сэргийлэхийн тулд квант шифрлэлт, аюулгүй харилцааны сүлжээг ашиглах талаар судалгааг явуулах.

### **3. Сансрын аюулгүй байдал ба хиймэл дагуулын хамтын ажиллагаа**

Сансар огторгуй нь цэргийн ажиллагааны чухал салбар болж, хиймэл дагуулын технологийн хамтын ажиллагаа хоёр орны батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх боломжтой. Монгол Улс хиймэл дагуулд суурилсан харилцаа холбоо, навигацийн системд тулгуурлаж байгаа нь дараах хамтын ажиллагааны боломжуудыг бүрдүүлж байна.

- Хиймэл дагуулын тандалт, харилцаа холбооны систем: Монгол Улс тагнуулын мэдээлэл цуглуулах, цэргийн харилцаа холбооны аюулгүй байдлыг хангах зорилгоор Хятадын хиймэл дагуулын дэвшилтэт технологиос ашиг тус хүртэх боломжтой.

- Сансрын хог хаягдал ба аюулгүй байдлын санаачилгауд: Сансрын хог хаягдал



болон сансарт суурилсан зэвсгийн болзошгүй аюулыг хянах зэрэг сансрын аюулгүй байдлын хүчин чармайлтад хамтран ажиллах.

- Сансрын судалгааны хамтарсан төслүүд: Эрт сэрэмжлүүлэх систем, пуужингийн ажиглалт зэрэг сансарт суурилсан цэргийн хэрэглээний талаар хамтарсан шинжлэх ухааны судалгаа хийх.

- Хилийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хиймэл дагуулын дүрсийг ашиглах: Хил дамнасан хөдөлгөөн, зөвшөөрөлгүй халдлагыг хянах зорилгоор хиймэл дагуулын бодит цагийн хяналтыг сайжруулах.

#### 4. Терроризмын эсрэг ажиллагаа болон хосолмол дайны бэлэн байдал

Кибер, эдийн засаг, мэдээллийн дайны холимог хосолмол дайн нь улс орнуудын санааг зовоосон асуудал болоод байна. Монгол, Хятад хоёр улс аюулгүй байдлын хурдацтай хөгжиж буй орчныг чиглүүлэхийн хэрээр дараах байдлаар бэлэн байдлаа бэхжүүлэх боломжтой. Үүнд:

- Хилийн хамгаалалтыг хиймэл оюун ухаанд суурилсан технологиор бэхжүүлэх: Монгол-Хятадын хилийн хамгаалалтад хиймэл оюун ухаанаар ажилладаг хяналтын дрон, хяналтын системийг ашиглах.

- Хамтарсан эрлийз дайны сургалт: Мэдээллийн кампанит операци, эдийн засгийн дайн, уламжлалт бус цэргийн тактик зэрэг эрлийз аюулыг дуурайлган сургуулилт хийх.

- Хэт даврагч үзэл ба үндэстэн дамнасан аюул заналхийлэлтэй тэмцэх: Бүс нутгийн терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор тагнуулын мэдээлэл солилцох чиглэлээр хамтран ажиллах.

- Сэтгэл зүйн операцийн (PSYOPS) хамтын ажиллагаа: Үндэсний аюулгүй байдлыг тогтворгүй болгож болзошгүй хуурамч мэдээллийн кампанит ажил, гадны нөлөөллийн үйл ажиллагаатай тэмцэх чадавхыг сайжруулах тал дээр сургалт зохион байгуулах.

#### 5. Цэргийн ложистик ба стратегийн түншлэл

Үр дүнтэй ложистик, стратегийн дэд бүтэц нь орчин үеийн дайн байлдаанд нэн чухал юм. Монгол, Хятад хоёр цэргийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ложистик, технологи дамжуулах чиглэлээр үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой.

- Технологи дамжуулах гэрээ: Монгол

Улс Хятадын дэвшилтэт кибер хамгаалалт, цахим дайн, хиймэл оюун ухаанд суурилсан цэргийн технологийг нэвтрүүлэх боломжтой.

- Хамтарсан судалгаа, хөгжлийн санаачилгууд: Нисгэгчгүй нисэх хэрэгсэл (UAV), автоматжуулсан цэргийн ложистик, хиймэл оюун ухаанаар удирддаг хяналтын системүүдийн инноваци дээр хамтран ажиллах.

- Цэргийн солилцооны хөтөлбөрүүд: Тактикийн болон үйл ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлэхийн тулд Монгол, Хятадын зэвсэгт хүчний хоорондын сургалтын солилцоог өргөжүүлэх.

- Нийлүүлэлтийн гинжин хэлхээний уян хатан байдал ба батлан хамгаалах дэд бүтцийн хөгжил: Зэвсэгт хүчний хангамжийн сүлжээний логистикийг бэхжүүлж, хямрал үүссэн үед чухал нөөцийг хүртээмжтэй байлгах.

Дайны шинэ хэмжээс үргэлжлэн хөгжиж байгаа энэ үед Монгол, Хятад хоёр бүс нутгийн аюулгүй байдлыг сайжруулахын зэрэгцээ Монгол Улсын стратегийн бие даасан байдлыг хүндэтгэн хамтран ажиллах боломж нээгдэж байна. Кибер дайн, цахим дайн, сансрын аюулгүй байдал, хиймэл оюун ухаанд суурилсан цэргийн хэрэглээнд анхаарлаа хандуулснаар хоёр улс илүү уян хатан, технологийн дэвшилтэт батлан хамгаалахын түншлэлийг бий болгож чадна. Нэмж дурдахад итгэлцэл, стратегийн тэнцвэрт байдал, зохицуулалтын хамгаалалттай холбоотой сорилтуудыг шийдвэрлэснээр энэхүү хамтын ажиллагаа харилцан ашигтай, тогтвортой байж чадна.

Монгол Улс зөвхөн өөрийгөө хамгаалахад чиглэсэн энх тайванч үзэл баримтлалд тулгуурласан батлан хамгаалах стратегийг баримталж, хоёр хөрш болон гуравдагч орны түншүүдтэйгээ батлан хамгаалах хамтын ажиллагаагаа тэнцвэржүүлэн хөгжүүлэх нь манай улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын гол баталгаа байх болно. Ийм ч учраас манай улс хоёр хөрш төдийгүй дэлхийн бусад улсуудтай цэргийн олон талт хамтарсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд энхийг сахиулах ажиллагааны сургалт, дадлагад оролцох, өөрийн оронд зохион байгуулах зэргээр цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд чиглэсэн идэвхтэй бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

#### Дүгнэлт

Монгол, Хятадын батлан хамгаалах



салбарын хамтын ажиллагаа нь сорилт, эрсдэлийг тэнцвэржүүлсэн олон талт харилцаа юм. Нэг талаас БНХАУ-тай цэргийн харилцаагаа гүнзгийрүүлэх нь Монгол Улсын батлан хамгаалах чадавхыг дээшлүүлж, бүс нутгийн тогтвортой байдлыг хангаж, эдийн засаг, улс төрийн түншлэлийн харилцааг бэхжүүлнэ. Цэргийн хамтарсан сургуулилт, бие бүрэлдэхүүний солилцоо, өндөр түвшний яриа хэлцэл нь Монгол Улсад зэвсэгт хүчнийг шинэчлэх, Зүүн хойд Ази дахь стратегийн байр сууриа бэхжүүлэх үнэтэй боломжийг олгож байгаа юм.

Мөн түүнчлэн Монгол Улсын “гуравдагч хөршүүд”, тэр дундаа АНУ, Япон, Европын түншүүдийн дунд эргэлзээ бий болгон, түүний өргөн хүрээний дипломат бодлогод сөргөөр нөлөөлж болзошгүй.

Дүгнэж хэлэхэд, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа болон шинэ хэмжээст дайны нөхцөл дэх Монгол, Хятадын цэргийн хамтын ажиллагаа нь энх тайван, найрамдал, харилцан хүндэтгэх үндсэн дээр, бүс нутгийн

энх тайван, тогтвортой байдлыг хадгалахад чиглэгдэх ёстой. Монгол Улс батлан хамгаалах салбарын түншлэлээ төрөлжүүлж, олон талт үзлийг баримталснаар эрсдэлийг бууруулж, хамтын ажиллагааны боломжуудыг ашиглах боломжтой. Манай улсын геополитикийн өвөрмөц байр суурь, энх тайвны төлөөх дипломат үйл ажиллагааны тууштай байдалд тулгуурлан Хятад улстай батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг урт хугацааны үндэсний ашиг сонирхолд нийцүүлснээр өөрийн орны батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэн мөн бүс нутгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулахад чухал ач холбогдолтой бөгөөд талууд харилцаа холбоо, солилцоогоо эрчимжүүлж, харилцан итгэлцлээ нэмэгдүүлж, аюулгүй байдлын янз бүрийн сорилтод хамтаар хариулж, бүс нутаг болон дэлхийн энх тайван, хөгжлийг ахиулахад нааштай хувь нэмэр оруулах ёстой. Үүний зэрэгцээ бид цэргийн хамтын ажиллагаа бол бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хадгалах нэн чухал арга зам гэдгийг ухамсарлах ёстой.

#### Ашигласан материал:

1. <https://www.iiss.org/online-analysis/online-analysis/2024/05/chinas-new-information-support-force/>
2. 2023 Report on the Military and Security Developments Involving the People's Republic of China
3. [https://en.wikipedia.org/wiki/Modernization\\_of\\_the\\_People%27s\\_Liberation\\_Army](https://en.wikipedia.org/wiki/Modernization_of_the_People%27s_Liberation_Army)
4. 中国人民解放军是世界和平与安全的坚定守护者- 中国人民共和国驻蒙古国大使馆
5. <https://www.chinanews.com.cn/mil/2012/07-16/4034949.shtml>
6. <https://baijiahao.baidu.com/s?id=1800467346096446943&wfr=spider&for=pc>
7. <https://www.specialeurasia.com/2024/11/24/geopolitics-cmrec-asia/>
8. <https://thedi diplomat.com/2024/10/mongolias-strategic-shift-in-a-changing-geopolitical-landscape/>

## ХИЛИЙН БООМТОД ҮҮСЭХ ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ХЭРХЭН БУУРУУЛЖ БҮЙ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

**Б.ГАНСҮХ** /ДХИС-ийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн ахлах багш, докторант, дэд хурандаа

**Түлхүүр үг:** Хилийн боомт, эрсдэл, хилийн аюулгүй байдал, үйл ажиллагаа, олон улсын туршлага

**Key words:** Border checkpoint, risk, border security, operations, international experience

### Оршил

Глобалчлалын өнөө үед улс орнуудын хоорондын худалдаа, эдийн засгийн харилцаа улам бүр өргөжин тэлж, хилийн боомтуудын үүрэг, ач холбогдол өдрөөс өдөрт нэмэгдсээр байна. Хилийн боомтууд нь зөвхөн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний урсгалыг зохицуулах төдийгүй, улс үндэстнүүдийн соёл, нийгмийн харилцааны гүүр болж, эдийн засгийн хөгжлийн чухал хөшүүрэг болдог. Гэвч энэхүү өргөжин тэлж буй үйл ажиллагаатай зэрэгцэн олон төрлийн эрсдэлүүд бий болж, тэдгээрийг үр дүнтэй удирдах, бууруулах асуудал улам бүр тулгамдсан асуудал болж байна.

Хилийн боомтод үүсэх эрсдэлүүд нь хоорондоо нягт уялдаа холбоотой, олон талт шинж чанартай бөгөөд хууль бус наймаа, терроризм, үндэстэн дамнасан гэмт хэрэг зэрэг аюулгүй байдлын эрсдэлүүд; дэд бүтцийн хүчин чадал, ажиллах хүчний дутагдал зэрэг үйл ажиллагааны эрсдэлүүд; мөн гаалийн орлогын алдагдал, валютын ханшийн хэлбэлзэл зэрэг санхүү, эдийн засгийн эрсдэлүүд багтдаг. Эдгээр нь зөвхөн тухайн улсын төдийгүй, бүс нутгийн болон дэлхийн хэмжээний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй.

Хилийн боомтод тулгарч буй эрсдэлүүдийг тодорхойлж, тэдгээрийг бууруулахад чиглэсэн олон улсын практик, туршлагыг судлан, Монгол Улсад хэрэгжүүлэх боломжит шийдлүүдийг санал болгосноор хилийн боомтын эрсдэлийн удирдлагыг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг дээшлүүлэх, улмаар үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмэр оруулах боломжтой юм.

Аливаа улс орон руу орох, гарахад улсын хилийн шалган нэвтрүүлэх цэг болсон хилийн боомтоор дамжин өнгөрдөг билээ. Улсын

хилийг хамгаалж буй хилийн цэрэг нь зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг зохих журмын дагуу нэвтрүүлж, хилийн шалган нэвтрүүлэх байранд хяналт шалгалтыг явуулна. Иймд улсын хилийн шалган нэвтрүүлэх цэг (гарц) буюу боомт гэдэг нь улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа таваар нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг газар болохыг харуулж байна.

Манай улсад өнөөгийн мөрдөж буй эрх зүйн баримт бичгүүдэд хилийн боомтыг дараах байдлаар томъёолсон байна. Монгол Улсын "Хилийн тухай хууль"–д "хилийн боомт" гэж улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хилийн хяналтын байгууллага хяналт шалгалт хийх зориулалтаар төхөөрөмжилсөн, тусгайлан тогтоосон газрыг хэлнэ<sup>1</sup> гэжээ.

Хилийн боомт гэдэг нь улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, барааг нэвтрүүлэхээр тусгайлан тогтоож төхөөрөмжилсөн, хилийн хяналтын байгууллага хяналт, шалгалт явуулдаг газар гэж ойлгож болно. Хилийн боомтууд нь дэлхийн худалдаа, аялал жуулчлалын чухал цэгүүд бөгөөд эрсдэлийн менежмент нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, хууль ёсны худалдааг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Сүүлийн жилүүдэд эдгээр нэвтрэх цэгүүд хууль бус наймаа, хүний наймаанаас эхлээд дэлхийн эрүүл мэндийн хямралаас үүдэлтэй урьдчилан таамаглаагүй аюул заналхийлэл зэрэг олон тооны сорилтуудтай тулгарч байна.

Орчин үед дэлхий нийтийг хамарсан үйл явц болох даяарчлалын үр нөлөөгөөр улс дамнасан терроризм, халдварт өвчний тархалт, байгалийн гамшиг, улсын хил давуулан хар

<sup>1</sup> Монгол улсын Хилийн тухай хууль. (2016). 3.1.12–р заалт, <https://legalinfo.mn/mn/detail/12418>



тамхи, цөмийн болон химийн зэвсгийн түүхий эд, зэвсэг, хүн наймаалах, бохир мөнгө угаах, хил дамнасан гэмт хэргийн элементүүд нарийн зохион байгуулалттай болж улс орнуудад аюул занал учруулж байгаагаар илэрдэг.

#### **Хилийн боомтод үүсэх эрсдэл**

Эрсдэл гэдэг нь тодорхой бус байдал буюу урьдчилан тооцоолоогүй зүйл. Өөрөөр хэлбэл эрсдэл гэдэг нь гадаад, дотоод орчны зүгээс хувь хүн, байгууллага, улс оронд үзүүлэх тааламжгүй нөлөөлөл мөн.

Хилийн боомт нь улсуудын хоорондын худалдаа, аялал жуулчлал, хүнсний ачаа, болон бусад бараануудыг зөөвөрлөх гол цэгүүдийн нэг бөгөөд эдийн засгийн эргэлтэд чухал үүрэгтэйгээс гадна нь янз бүрийн эрсдэлд өртөмтгий байдаг.

Эдгээр боомтууд аюулгүй байдал, иргэдийн эрүүл мэнд, дэд бүтцийн асуудал зэрэг олон эрсдэл үүсэхээс гадна мөн хилийн боомтуудын дэд бүтэц муу, авлига, хил дамнасан гэмт хэрэг зэрэг дараах олон эрсдэлтэй тулгардаг.

**Аюулгүй байдлын эрсдэл.** Үндэстэн дамнасан гэмт хэрэг

– Хууль бус бараа бүтээгдэхүүний наймаа нь зэвсэг, галт зэвсгийн хууль бус худалдаа, хар тамхи, мансууруулах бодисын наймаа, зэрлэг амьтдын хууль бус бараа бүтээгдэхүүн зэрэг хилийн боомтуудад хууль бусаар хил нэвтрүүлэх эрсдэлтэй байдаг.

– Хүний наймаа буюу хүн худалдаалах гэм хэрэг: Хилийн боомтуудад хүн худалдаалах эрсдэлтэй. Хил зөрчигчид байж болно.

– Хууль бус цагаачид: Цагаачид нь хүн хулгайлах, дээрэмдэх, хувийн аюулгүй байдалд нь заналхийлэх зэрэг олон эрсдэлтэй тулгардаг.

– Терроризм болон үндэстэн дамнасан гэмт хэрэг нь хил, боомтын хамгаалалтын агентлагууд улс орноо террористуудаас хамгаалахын тулд ажилладаг.

– Хууль бусаар хил нэвтрүүлэх: Гэмт хэргийн сүлжээ нь хар тамхи, галт зэвсэг, хүн зэрэг хууль бус барааг хууль бусаар нэвтрүүлж болно.

#### **Эдийн засгийн эрсдэл**

Энэ нь гаалийн хууль бус үйл ажиллагаа, татвар, хураамж төлөхөөс зайлсхийх, хууль бус валютын гүйлгээ, мөнгө угаах үйл ажиллагаа, авилга хээл хахууль зэрэг зөрчлүүд гарч болно. Авлига хээл хахууль нь тарифын орлогыг бууруулж, бүс нутгийн тээврийн сүлжээнд

тэнцвэргүй байдлыг бий болгоно.

#### **3. Үйл ажиллагааны эрсдэлүүд**

– Дэд бүтцийн асуудал: Дэд бүтцийн хүчин чадал хүрэлцээгүй байх нь тохиромжгүй барилга байгууламж, өөрөөр хэлбэл хилийн боомтуудад хяналт шалгалтын байгууламж, техник, тоног төхөөрөмжийн гэмтэл, зам талбай хангалттай байхгүй байж болно.

– Түгжрэл буюу ачаалал ихсэх, саатал үүсэх: Боомтын түгжрэл нь нарийн төвөгтэй асуудал бөгөөд зам, талбайн хүчин чадал хүрэлцээгүйгээс хязгаарлагдмал тээврийн хэрэгслийн эгнээ үүсч, хилийн боомтуудад тээврийн хэрэгслүүдийн бөөгнөрөл үүсч болно.

– Тохиромжгүй байдал: Агуулах, терминалын багтаамж дутмаг, техник, тоног төхөөрөмжийн элэгдэл хорогдол, цахилгаан, усан хангамжийн тасалдал, харилцаа холбооны сүлжээний доголдол гэх зэргээр үйл ажиллагаанд доголдол гарч болно.

#### **4. Хүний нөөцийн эрсдэлүүд**

Мэргэжилтэй ажиллах хүчний дутмаг байдал нь мөн хилийн боомтын үйл ажиллагааны эрсдлийн нэг юм.

#### **5. Нийгмийн эрүүл мэндийн эрсдэл**

– Өвчний олон улсын тархалт: Олон улсын аялал, худалдаа, тээвэр нь хүмүүс, бараа, тээврийн хэрэгслээр өвчний тархалт ихсэж эрсдэлд оруулдаг.

– Зоонозын өвчин: Өргөтгөсөн худалдаа нь хүн ба амьтны хоорондын харилцан үйлчлэлийг нэмэгдүүлж, улмаар зоонозын халдвар дамжих эрсдэлтэй.

#### **6. Гадаад хүчин зүйлсийн эрсдэлүүд**

Хилийн боомтууд үйл ажиллагааг үндсээр нь тасалдуулж, аюулгүй байдлыг алдагдуулах олон эрсдэлийн нэг бол геополитикийн хурцадмал байдал бөгөөд энэ нь хяналт шалгалтыг өндөрсгөж, ачаа боловсруулалтыг удаашруулж, эдийн засгийн алдагдал, логистикийн тасалдал үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Эдгээр эрсдэлүүдийн харилцан хамаарал нь хилийн боомтын менежментийн нарийн төвөгтэй байдлыг онцолж байгаа бөгөөд бидэнд аюулгүй байдлын яаралтай асуудлыг шийдвэрлэх төдийгүй олон янзын сорилтыг даван туулах урт хугацааны цогц тогтолцоог сайжруулах зайлшгүй шаардлагатай болгож байна. Хилийн боомтууд олон улсын туршлагаас сургамж авснаар эдгээр олон талт эрсдэлд илүү

сайн бэлтгэж, бууруулж чадна.

Хилийн боомтын эрсдэл нь улс орон, үндэсний аюулгүй байдал, нийгэм, байгууллага, хувь хүнд хүртэл шууд болон шууд бус нөлөөллийг үзүүлдэг байна. Тиймээс хилийн боомтод үүсэх эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг олон төрлийн арга хэлбэрээр байнга сайжруулах нь чухал юм. Хилийн боомтын эрсдэлийг бууруулж байгаа гадаад орнуудын туршлагыг судлан гол дэвшилтэт санаануудыг дэвшүүлээ.

### **Хилийн боомтод үүсэх эрсдэлийг бууруулах олон улсын туршлага**

Сингапур улсын туршлага

Сингапурын **"Single Window"** (Нэг цонх) систем нь худалдаа, импорт, экспортын үйл явцыг хялбарчлах, хурдасгах зорилгоор бий болгосон мэдээллийн технологид суурилсан платформ бөгөөд бизнес эрхлэгчдэд дэд бүтэц, мэдээлэл, үйлчилгээ зэрэг мэдээллийг нэг цонхоор авах боломжийг олгодог олон төрлийн дэд системүүдийг нэгтгэсэн цахим платформоор үйлчилдэг мэдээллийн нэгдсэн платформ юм. Уг систем нь бусад платформ болон үйлчилгээтэй холбоход API (Application Programming Interface) ашиглан интеграци хийх боломжийг олгодог.

Импорт, экспортын бүх бичиг баримтыг цахимаар боловсруулж, бичиг баримтын боловсруулалт хийн илгээх боломжтой систем бөгөөд үүнийг нэвтрүүлснээр үйл явц хурдасч, худалдааны процесс богиносж, цаг хугацаа, зардлыг бууруулдаг. Мэдээлэл нэгтгэгдсэнээр эрх зүйн, төсвийн, хилийн хяналтын байгууллагууд илүү ил тод, хариуцлагатай ажилладаг.

Сингапурын автоматжуулсан гаалийн бүрдүүлэлт нь улс орны худалдааны процессийг шинэчлэн сайжруулах, гаалийн бүрдүүлэлтийг хурдан, зардал багатай, ил тод болгоход чиглэгддэг, үйлчлүүлэгчдэд бүх шаардлагатай бичиг баримтуудыг цахим хэлбэрээр нэгэн зэрэг илгээж гаалийн бүрдүүлэлтийн автомат систем бөгөөд программ хангамжийн автоматжуулалтын тусламжтайгаар гаалийн бүрдүүлэлтийг хурдан явагдах боломжийг олгодог.

Сингапурын хилийн боомт, нисэх онгоцны буудал нь олон улсын стандартад нийцсэн, өндөр хүчин чадалтай, хурдан үйлчилгээ үзүүлдэг бөгөөд хилийн боомтоор дамжин өнгөрөх ачааны хэмжээ нь дэлхийд тэргүүлэх

байр эзэлж байна.

### **Нидерланд улсын туршлага**

**Smart Border** төсөл нь Нидерландад хэрэгжиж байгаа инновацийн нэг хэсэг бөгөөд гурван үндсэн зорилготой бөгөөд хил дамнасан гаалийн ажиллагаа төсөл нь хил дээрх гаалийн бүртгэлийг автоматжуулах, хурдасгах зорилготой бөгөөд импорт, экспортын үйл явцыг илүү үр дүнтэй болгоно. Ногоон гарц систем нь ачаа тээврийн хэрэгслийг хурдан, саадгүй хил давуулахад туслах шийдэл бөгөөд хурдан, найдвартай, чирэгдэл багатай үйл явцтай байх боломжийг хангана.

Харин **блокчэйн технологи** нь мэдээллийг хамгаалах, аюулгүй, хяналттай байдлаар хуваалцахад ашиглагддаг. Үүний тусламжтайгаар хил дамнасан мэдээллийн сүлжээ нь илүү ил тод, найдвартай болдог. Энэ төслийн үр дүнд эдийн засгийн өсөлт сайжирч хилийн боомтын үйл явцыг хурдасгаж, ачаа тээврийн системийг сайжруулснаар гадаад худалдаа нэмэгдэнэ.

Нидерландын гаалийн байгууллагууд блокчэйн технологийг ашиглан импорт, экспортын хэрэгслүүдийн мэдээллийг бүртгэх, хянах, хуваалцах үйл явцыг автоматжуулах зорилготой бөгөөд энэ нь мэдээллийг ил тод, аюулгүй байлгах боломжийг олгоно.

**Ногоон гарц систем** нь Нидерландын гаалийн зохицуулалтыг сайжруулах зорилготой инноваци бөгөөд элдэв чирэгдэл, удаашралгүйгээр ачаа тээврийн хэрэгслийг хил давуулахад чиглэгддэг. Ногоон гарц системийн гол чиг үүрэг нь хилийн боомтын процессыг хурдасган ачаа тээврийн хэрэгслийг хурдан, хялбараар хилээр нэвтрэх боломжийг олгодог.

**Хил дамнасан мэдээллийн сүлжээ** нь Нидерландын эдийн засагт чухал үүрэгтэй бөгөөд, хил дамнасан худалдаа, логистикийг хөнгөвчлөх, аюулгүй байдал, ижил төстэй үйл ажиллагааг сайжруулахад чухал нөлөө үзүүлж байна.

Өмнөд Солонгос улсын туршлага

**UNI-PASS** систем нь гаалийн бүртгэлийн, худалдааны системд өргөн хэрэгждэг үйл явц бөгөөд энэ нь шууд бус, автоматжуулсан, сайжруулсан гаалийн үйлчилгээ авахад чиглэгдсэн систем юм. UNI-PASS нь гаалийн бичиг баримтуудыг боловсруулж, илгээх үйл явцыг автоматжуулдаг ба хил дамнасан үйл ажиллагааны үйл явцыг хурдан бөгөөд чирэгдэл багатай явуулах боломжийг олгодог болно.



UNI-PASS систем нь интернетийн дамжуулалтаар ажилладаг бөгөөд худалдаачид, тээвэрлэгчид, гаалийн алба бүрдүүлэх ажиллагааг хялбар болгодог ба хил дамжин нэвтрэх ачаа тээврийн хугацааг богиносгож худалдааны үйл ажиллагааг хурдасгах боломжтой.

Өмнөд Солонгосын олон улсын хамтын ажиллагааны платформ нь улс төрийн, эдийн засгийн, олон соёлт харилцааг дэмжиж, дэлхийн хэмжээнд хамтын ажиллагааг өргөжүүлэх, улс орнуудын хамтын ажиллагаа, стратегийн түншлэл, нийгмийн хэрэгцээг хангах зорилготой.

### **Холбооны Бүгд Найрамдах Герман улсын туршлага**

**E-Customs систем** буюу цахим гаалийн систем нь бизнес эрхлэгчид, гаалийн албан тушаалтнууд, тээврийн компаниудад мэдээлэл солилцох, гаалийн бичиг баримт бүрдүүлэх, процессын явцыг хянахад зориулсан цахим платформ юм. Систем нь улс хоорондын арилжааны төлбөр, гаалийн тайлангийн мэдээллийг төвлөрүүлэх бөгөөд автоматжуулалт, стандартчилах боломжийг олгодог.

E-Customs систем нь тээврийн компанид, гаалийн бараануудын чирэгдэл, тайлангийн явцыг хянахад тусалдаг ба аж ахуйн нэгжүүдэд шаардлагатай мэдээллийг хялбархан авах, хэрэгтэй үед нотлох баримт, тайланг шууд гарган авах боломж олгодог. Гаалийн нээлтийг хугацаанд хурдан гүйцэтгэх, асуудал гарсан тохиолдолд засварлах бүтээлтэй ажиллагааг автоматжуулах систем юм.

E-Customs системийг хянах, хамгаалах технологиуд (шифрлэх, аюулгүй сүлжээ гэх мэт) нэвтрүүлсэн ба хэрэглэгчийн өгөгдлийг хамгаалах, гаалийн мэдээллийг нууцлахтай холбоотой хууль дүрмийг баримталж мэдээллийн нууцлал сайтай систем юм.

### **Канад улсын туршлага**

Канадын аюулгүй байдлын систем нь үндэсний аюулгүй байдал, хилийн аюулгүй байдал, иргэдийн аюулгүй байдлыг хангах олон төрлийн механизмууд, хууль тогтоомжууд, байгууллагуудаас бүрдэх бөгөөд энэ систем нь терроризм, гэмт хэргээс хамгаалах, улсын аюулгүй байдлыг сайжруулах зорилготой.

**Канадын биометрийн хяналтын систем** нь аюулгүй байдал, хилийн хяналт, хилийн боомтын хяналт, хүн амын мэдээллийг

удирдах зорилгоор биометрийн мэдээллийг ашигладаг. Энэ систем нь биометрийн өгөгдлийг, тухайлбал, хурууны хээ, нүүрний таних технологийг ашиглан иргэдийн болон зорчигчдын мэдээлэл, гэрчилгээжүүлэх, хяналт тавихад чиглэгдсэн байдаг.

Хилийн боомтын хяналтад болон иргэдэд оршин суух зөвшөөрөл олголтыг хялбарчлахад биометрийн системийг ашигладаг ба энэ нь илүү аюулгүй, хурдацтай үйлчилгээг бий болгодог. Гадаадын ажилчдын биометрийн мэдээллийг ашиглан асуулгын процессыг хөнгөвчлөх, хязгаарлалт хяналтын мэдээллийг хурдан үнэлэхэд ашигладаг.

Канадын терроризмтой тэмцэх тусгай хөтөлбөр нь улс орны аюулгүй байдлыг хангах, терроризмыг урьдчилан сэргийлэх, түүний нөлөөллийг бууруулахад чиглэгдсэн олон төрлийн арга хэмжээ, стратеги, хөтөлбөрүүдийг агуулдаг. Энэхүү хөтөлбөр нь төрийн болон засгийн газрын байгууллагууд, хууль зүйн байгууллагууд, тагнуулын албад, олон улсын хамтын ажиллагааны платформуудтай хамтран ажиллахад хариуцдаг.

Канадын олон улсын хамтын ажиллагааны механизм нь улс орнуудтай хамтын ажиллагааг дэмжих, хилийн чанад дахь аюулгүй байдал, хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэх, олон улсын аюулгүй байдлын төрлүүд, энхтайвны үйл ажиллагаанд оролцох зорилгоор байгуулагдсан ба Этиоп, Африк, Европ, Ази, Латин Америк зэрэг бүс нутгуудад Канад улс санхүүгийн дэмжлэг, боловсрол, мэргэжилтний сургалт, техникийн туслалцаа зэрэг арга хэмжээнүүдийг явуулж байна.

### **Европын Холбооны улсуудын туршлага**

**Ухаалаг хилийн санаачилга /Smart Border/** нь Шенгений бүсийн хилийн боомтын удирдлагын тогтолцоог шинэчлэхэд чиглэгдсэн ба Европын Холбооноос (ЕХ) боловсруулсан стратегийн тогтолцоо бөгөөд хилийн боомтын тээврийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлын асуудал, хил дамнасан хөдөлгөөний үр ашгийг дээшлүүлэх хэрэгцээ зэргээс үүдэлтэй сорилтуудыг шийдвэрлэх зорилготой юм.

Хилийн боомтыг хөнгөвчлөх стратеги нь зорчигчдын хилийн шалгалтын үр ашгийг дээшлүүлж, аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ саадгүй нэвтрэх боломжийг бүрдүүлнэ. Технологийн интеграцлалт стратеги нь хилийн боомтын удирдлагын үйл явцыг оновчтой болгохын тулд биометрийн мэдээлэл, мэдээлэл



солилцох систем зэрэг дэвшилтэт технологийг ашиглах стратеги юм.

Орох/Гарах систем (**EES**) нь Шенгений орнуудын гадаад хил дээр гуравдагч орны иргэдийг нэвтрэх, гарахыг бүртгэх систем юм. Биометрийн мэдээлэл (хурууны хээ, нүүрний зураг) цуглуулах ажлыг автоматжуулж, хэн болохыг баталгаажуулж, хилийн гарцыг үр дүнтэй бүртгэдэг.

Европын аялал жуулчлалын мэдээлэл ба зөвшөөрлийн систем (**ETIAS**) нь визээс чөлөөлөгдсөн аялагчдад зориулсан аялалын өмнөх шалгалтын систем бөгөөд жуулчдыг Европын холбооны орнуудад ирэхээс өмнө эрсдэлийг үнэлж, аялал жуулчлалын явцад саад учруулахгүйгээр аюулгүй байдлыг сайжруулдаг.

Ухаалаг хилийн хяналтын байгууламжууд нь эрх бүхий зорчигчдын паспортын шалгалтын хугацааг хурдасгах зорилгоор хилийн боомтын хяналтын автоматжуулсан ТҮЦ машиныг нэвтрүүлсэн бөгөөд энэ нь хүлээлгийн хугацааг багасгаж, зорчигчдыг зөв таних боломжийг баталгаажуулахын тулд нэвтрэх цэг дээр биометрийн баталгаажуулалтыг хийдэг төхөөрөмж юм.

Хилийн боомтод үүсэх эрсдэлийг бууруулах олон улсын туршлага<sup>2</sup>

1 дүгээр хүснэгт.

КАНАД			
1	Аюулгүй байдлын систем	Логистикийн шийдэл	Үр дүн
	Биометрийн хяналтын систем	Ухаалаг контейнерийн систем	Аюулгүй байдлын зөрчил 65% буурсан
	Терроризмтой тэмцэх тусгай хөтөлбөр	GPS хяналтын систем	Логистикийн үр ашиг 45% дээшилсэн
	Олон улсын хамтын ажиллагааны механизм	Автомат мэдээллийн солилцоо	Олон улсын худалдаа 30% өссөн
МЕКСИК			
2	Бүс нутгийн интеграци	Дэд бүтцийн хөгжил	Үр дүн
	АНУ-тай хамтарсан хяналтын систем	Орчин үеийн боомтын барилга байгууламж	Хилийн худалдаа 40% өссөн
	Худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр	Автомат хяналтын систем	Ажлын байр 25% нэмэгдсэн
	Хил орчмын эдийн засгийн бүс	Логистикийн төвүүдийн сүлжээ	Бүс нутгийн эдийн засаг 35% өссөн
НИДЕРЛАНД <sup>3</sup>			

<sup>2</sup> Organization for Security and Co-operation in Europe. (2024). Handbook of Best Practices at Border Crossings – A Trade and Transport Facilitation Perspective. [https://etir.org/sites/default/files/2021-04/OSCE-UNECE\\_Handbook.pdf](https://etir.org/sites/default/files/2021-04/OSCE-UNECE_Handbook.pdf)

<sup>3</sup> European Commission. (2024). Smart borders. <https://home-affairs.ec.europa.eu/policies/schengen-borders-and->

3	"Smart Border" төсөл	Ногоон технологи	Үр дүн
	Хиймэл оюун ухаанд суурилсан хяналт	Байгаль орчинд ээлтэй дэд бүтэц	Нүүрстөрөгчийн ялгарал 40% буурсан
	Дрон, роботын хэрэглээ	Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний зардал 25% буурсан
	Автомат скан систем	Хаягдлын менежментийн систем	Үйл ажиллагааны үр ашиг 60% дээшилсэн
СИНГАПУР			
4	Технологийн шийдлүүд	Хууль эрх зүйн шинэчлэл	Үр дүн
	"Single Window" системийн нэвтрүүлэлт	Гаалийн тухай хуулийн шинэчлэл	Бүрдүүлэлтийн хугацаа 90% буурсан
	24/7 үйлчилгээ	Олон улсын гэрээ, конвенцид нэгдсэн	Гаалийн орлого 30% өссөн
	Smart Gate системийн хэрэгжилт	Эрсдэлийн удирдлагын журам боловсруулсан	Хууль бус үйл ажиллагаа 45% буурсан
БНСУ			
5	UNI-PASS системийн хэрэгжилт	Дэд бүтцийн хөгжил	Үр дүн
	Бүрэн автоматжуулсан гаалийн систем	Орчин үеийн терминал, агуулахын систем	Ачаа боловсруулах хугацаа 70% буурсан
	Блокчэйн технологийн хэрэглээ	Ухаалаг тээврийн удирдлага	Үйл ажиллагааны зардал 35% буурсан
	Ухаалаг хяналтын систем	– Логистикийн төвүүдийн сүлжээ	Хилийн боомтын хүчин чадал 50% нэмэгдсэн
ХБНГУ <sup>4</sup>			
6	Дижитал шилжилт	Хүний нөөцийн хөгжил	Үр дүн
	E-Customs системийн хэрэгжилт	Тасралтгүй сургалтын систем	Алдаа, зөрчил 55% буурсан
	Автомат баримт бичгийн систем	Олон улсын туршлага солилцох хөтөлбөр	Ажилтнуудын бүтээмж 40% өссөн
	Цахим гарын үсгийн хэрэглээ	Мэргэшсэн боловсон хүчний бэлтгэл	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 85% хүрсэн

Олон улсын туршлагаас харахад хилийн боомтын эрсдэлүүдийг бууруулахад технологийн дэвшил, хууль эрх зүйн зохицуулалт, хүний нөөцийн чадавхыг нэгэн зэрэг хөгжүүлэх шаардлагатай ба өөр үндсэн зүйл нь системтэй төлөвлөлт, тууштай хэрэгжилт, олон талын оролцоо чухал байдаг байна.

Аюулгүй байдлын олон давхаргат арга барил нь биометр, тандалтын систем зэрэг технологийг уламжлалт аргуудтай хослуулан үр ашгийг дээшлүүлэх нь чухал юм. Мэдээлэл солилцох, эмзэг байдлыг бууруулахад үндэсний болон олон улсын агентлагуудын хамтын ажиллагаа хэрэгтэй нь харагдаж байна. Боомтын ажилтнуудыг тогтмол сургаж

visa/smart-borders\_en

<sup>4</sup> Frontex. (2023). Frontex Risk Analysis 2023/2024 discusses challenges at EU external borders. [https://www.frontex.europa.eu/assets/Publications/Risk\\_Analysis/Risk\\_Analysis/ARA\\_2023.pdf](https://www.frontex.europa.eu/assets/Publications/Risk_Analysis/Risk_Analysis/ARA_2023.pdf)



чадавхижуулах нь тэднийг шинээр гарч ирж буй аюулд бэлтгэхэд гол ач холбогдолтой. Төрөл бүрийн эрсдэлийг даван туулах, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахын тулд уян хатан дэд бүтцэд хөрөнгө оруулж сайжруулах хэрэгтэй нь харагдаж байна.

Эрсдэлийн удирдлагын стратегийн үе үе үнэлгээ хийж байх нь хувьсан өөрчлөгдөж буй сорилтод дасан зохицоход чухал үүрэгтэй. Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлснээр хилийн боомтуудын аюулгүй байдлыг бэхжүүлж, худалдааны саадгүй урсгалыг хангаж, бүх оролцогч талуудын аюулгүй байдлыг нэмэгдүүлэх боломжтой.

### **Дүгнэлт**

Хилийн боомтод тулгардаг эрсдэлүүд, тэдгээрийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй олон улсын туршлага, мөн Монгол Улсын хувьд авч хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээнүүдийг судлан үзлээ. Үүний үр дүнд дараах гол дүгнэлтүүдийг хийж байна:

Хилийн боомтын эрсдэлүүд нь өөр хоорондоо нягт уялдаа холбоотой, олон талт шинж чанартай байна. Аюулгүй байдал, үйл ажиллагаа, эдийн засгийн эрсдэлүүд нь нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлж, улмаар системийн шинжтэй асуудлуудыг үүсгэдэг болох нь харагдлаа. Иймд эдгээр эрсдэлүүдийг тусгаарлан авч үзэх бус, цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай юм.

Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад, эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээнүүд нь дараах гурван үндсэн чиглэлд төвлөрч байна:

– Технологийн шийдлүүд: Ухаалаг систем, хиймэл оюун ухаан, блокчэйн зэрэг дэвшилтэт технологиудын хэрэглээг нэмэгдүүлэх

– Хууль эрх зүйн орчин: Олон улсын стандарт, хэм хэмжээнд нийцсэн үндэсний хууль тогтоомж, дүрэм журам боловсруулах

– Хүний нөөцийн чадавх: Мэргэшсэн боловсон хүчин, тасралтгүй сургалт, олон улсын туршлага солилцох хөтөлбөрүүд хэрэгжүүлэх

Сингапур, Нидерланд, Өмнөд Солонгос зэрэг гадаад орнуудын туршлагаас харахад, эрсдэлийг бууруулах арга хэмжээг үе шаттайгаар, системтэй хэрэгжүүлэх нь чухал болохыг харуулж байна. Эдгээр улсууд эхлээд үндсэн дэд бүтэц, хууль эрх зүйн орчноо бүрдүүлж, дараа нь технологийн дэвшилтэт шийдлүүдийг үе шаттайгаар нэвтрүүлсэн байна.

Монгол Улсын хувьд эрсдэлийг бууруулах арга хэмжээг дараах үе шаттайгаар хэрэгжүүлэх нь зүйтэй гэж САНАЛ оруулж байна. Үүнд:

– Одоо байгаа системүүдийн үр ашгийг дээшлүүлэх

– Ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг сайжруулах

– Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх

– Дэд бүтцийн хөгжлийг эрчимжүүлэх

– Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох

– Технологийн шинэчлэлийг үе шаттайгаар хийх

– Бүрэн автоматжуулсан систем нэвтрүүлэх

– Бүс нутгийн интеграцид гүнзгий нэгдэх

– Олон улсын стандартад бүрэн нийцсэн үйлчилгээ үзүүлэх

Эцэст нь дүгнээд хэлэхэд, хилийн боомтын эрсдэлүүдийг бууруулах нь нэг удаагийн арга хэмжээ бус, тасралтгүй үргэлжлэх, олон талт оролцоо шаардсан цогц үйл явц юм. Монгол Улсын хувьд өөрийн онцлог нөхцөл байдалд тулгуурлан, олон улсын туршлагыг зөв түвшинд нутагшуулж, үе шаттайгаар хэрэгжүүлснээр эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог бий болгох боломжтой юм.

Ингэснээр үндэсний аюулгүй байдлыг хангах, хөрш орнуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, хил орчмын дэд бүтцийг хөгжүүлэх, гадаад худалдааг хөнгөвчлөх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, улмаар хил хамгаалалтын боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх боломжтой болно.

**Ашигласан материал:**

1. Asian Development Bank. (2023). Border management modernization. Mongolia: Cross Border Facilitation and Ports Coordination and Integration. Sovereign Project I 55044-003, <https://www.adb.org/projects/55044-003/main>
2. European Commission. (2024). Smart borders. [https://home-affairs.ec.europa.eu/policies/schengen-borders-and-visa/smart-borders\\_en](https://home-affairs.ec.europa.eu/policies/schengen-borders-and-visa/smart-borders_en)
3. Frontex. (2023). Frontex Risk Analysis 2023/2024 discusses challenges at EU external borders. [https://www.frontex.europa.eu/assets/Publications/Risk\\_Analysis/Risk\\_Analysis/ARA\\_2023.pdf](https://www.frontex.europa.eu/assets/Publications/Risk_Analysis/Risk_Analysis/ARA_2023.pdf)
4. International Chamber of Commerce. (2024). Global trade report. <https://iccwbo.org/global-insights/global-trade/>
5. International Maritime Organization. (2023). Port security project. <https://www.imo.org/en/OurWork/Security/Pages/Port-Security-Project.aspx>
6. International Organization for Migration. (2023). Border and migration management assessment. <https://www.iom.int/sites/g/files/tmzbdl2616/files/documents/border-and-migration-management-assessments.pdf>
7. Монгол улсын Хилийн тухай хууль. (2016). 3.1.12-р заалт. <https://legalinfo.mn/mn/detail/12418>
8. Doyle, Tom; Fanta Ivanovic, Enrique Guillermo; Mclinden, Gerard; Widdowson, David Charles. (2011). Border management modernization. Washington, DC: World Bank 20433. <https://documents.worldbank.org/en/publication/documents-reports/documentdetail/986291468192549495/border-management-modernization>
9. Organization for Security and Co-operation in Europe. (2024). Handbook of Best Practices at Border Crossings – A Trade and Transport Facilitation Perspective. [https://etir.org/sites/default/files/2021-04/OSCE-UNECE\\_Handbook.pdf](https://etir.org/sites/default/files/2021-04/OSCE-UNECE_Handbook.pdf)
10. Баасандулам, Д. Хадбаатар, Б. Чулуун-Эрдэнэ, Ш. (2021). Хилийн боомтын аюулгүй байдлыг хангахад анхаарах асуудал, хилийн боомтын үйл ажиллагаанд баримталж буй бодлого, эрх зүйн хэм хэмжээ. (Илтгэл) Гадаадын иргэн, харьяатын газар. [https://immigration.gov.mn/media/filer\\_public/98/72/98726f51-2c0c-4303-ab25-f6603a161cc6/khiliin\\_boomтын\\_айуулгуй\\_baidlyg\\_khangakhad\\_ankhaarakh\\_asuudal.pdf](https://immigration.gov.mn/media/filer_public/98/72/98726f51-2c0c-4303-ab25-f6603a161cc6/khiliin_boomтын_айуулгуй_baidlyg_khangakhad_ankhaarakh_asuudal.pdf)
11. Баярсайхан, Д. (2018). Хилийн боомтын аюулгүй байдал, хилийн хяналтын үйл ажиллагааг боловсронгуй болгоход эрсдэл тооцох арга зүйг хэрэглэх арга зам. Хууль сахиулахуй сэтгүүл. №13, дугаар 17. хуудас 26. <https://www.uia.gov.mn/uploads/trans/attach/20183.pdf>
12. Монгол банк. (2023). Эрсдэл ба хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалалт. [www.sankhuuginbolovsrol.mn](http://www.sankhuuginbolovsrol.mn)
13. Энхбаяр, Ж. (2007). Аюулгүй байдлын олон талт асуудал. Судалгаа, сурталчилгааны материалуудын түүвэр эмхтгэл. Стратеги судлал сэтгүүл. (Vol. 1). УБ. Соёмбо хэвлэлийн газар



# ХҮНИЙ ХУВИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ: САЛБАРЧИЛСАН ЗАГВАРААС ТӨВЛӨРСӨН ЗАГВАРТ

**М.ХАТАНЗОРИГ** /Шихихутуг их сургуулийн Хувийн эрх зүйн  
тэнхимийн ахлах багш, хууль зүйн доктор (Ph.D.), дэд профессор

**Түлхүүр үг:** Хувийн халдашгүй байдал, хувийн мэдээллийн хамгаалалт, салбарчилсан загвар, төвлөрсөн загвар, эрх зүй ба аюулгүй байдал

**Key words:** privacy, personal data protection, decentralized model, centralized model, law and security

Цахим эринд хувийн халдашгүй байдлыг аюулгүй байдал судлалын үүднээс авч үздэг байх, аюулгүй байдлын чиглэлээрх албан хаагчдын энэ талын боловсролыг дээшлүүлэх шаардлага нэмэгдэж байна. Иргэдийн халдашгүй байдлыг зөрчих замаар мэдээлэл цуглуулж суртал ухуулга хийх, улмаар үндэсний эв нэгдэлд сөргөөр нөлөөлөх, улс төрийн шийдвэр гаргуулах зэрэг аюулын жишээ олон улсад цөөнгүй гарлаа. Нөгөөтээгүүр, албан хаагчид үйл ажиллагааныхаа хүрээнд эрх хэмжээгээ хэтрүүлэлгүй хэрэгжүүлдэг байх шаардлагатай. Хувийн халдашгүй байдал, тэр дундаа мэдээллийн эрх зүйн хамгаалалт өргөжсөн энэ үед олон улсын ба үндэсний эрх зүйн орчны судалгааны хэрэгцээ нэмэгдсэн тул энэхүү өгүүлэлд уг эрхийн ойлголт, эрх зүйн хамгаалалт, олон улсын байгууллагуудын үйл ажиллагааны талаар хөндлөө. Ялангуяа мэдээллийн орчин дахь хэрэглэгчийн боловсрол багатай<sup>1</sup> манай улсад мэдээллийн орчин дахь эрсдэлийн сэрэмж өндөртэй байх, энхийн цагт хууль тогтоомжийн оновчтой зохицуулалтаар эрсдэлийг бууруулахад эрх зүйн хувьд халдашгүй байх эрх гол үндэслэл болно.

## Нэг. Хүний халдашгүй байдлын ерөнхий ойлголт

Халдашгүй байдлыг ерөнхийдөө хүний бие махбод, орон байр, эд хөрөнгө халдашгүй байх буюу бусад этгээд (төрийн болон хувийн хэвшлийн, бусад байгууллага, хувь хүмүүс) тэдгээрт дур мэдэн халдахыг хориглох; хүний хувийн болон гэр бүлийн амьдрал, захидал

<sup>1</sup> Эцэг эхчүүдийн дийлэнх буюу 94 хувь, багш нарын 96.8 хувь нь интернэт орчны шүүлтүүрийн программ хангамжийг ашиглах чадваргүй; Хүүхэд болон эцэг эхчүүдийн гурван хүн тутмын нэг нь цахим орчинд хувийн нууц мэдээллээ хамгаалах тохиргоо хийх талаар ямар ч ойлголтгүй байв (эх сурвалж: Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар. Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал” судалгааны тайлан. 2018).

харилцаа халдашгүй байх; хүүхэдтэй болох эсэх, гэр бүл төлөвлөх, сонгуулиар хэнд санал өгөх хийгээд өмсөх хувцас, хоолны сонголт гэх мэт хувийн шийдвэрээ бусдаас хараат бусаар, бие даан гаргах гэсэн хүрээнд ойлгож болно. Уг ойлголт англи хэлний “privacy” гэх үгээр олон улсад түгээмэл танигдсан бөгөөд Монгол хэлнээ “халдашгүй байдал” хэмээх нэр томъёогоор оноон хэрэглэж байна. Ж.Цэвээн Монгол хэлээр анхлан “иргэний хувийн эрх” хэмээн нэрлэсэн бол хожим “хувийн халдашгүй байдал, халдашгүй байдал” гэх нэршлээр түгээмэл хэрэглэж буй. “Privacy” хэмээх үг нь латин хэлний “privatus” буюу “олон нийтийн амьдралаас тусгаарлагдах, өөртөө төвлөрөх” гэсэн үгнээс гаралтай гэж болно.<sup>2</sup>

Хүний эрх болохын хувьд зарим судлаач бусад эрхээс урган гардаг буюу агуулгад нь хамаардаг гэж үздэг боловч дийлэнхдээ бие даасан эрх мөн хэмээн хүлээн зөвшөөрөгддөг.<sup>3</sup>

Халдашгүй байдлыг түгээмэл хэрэглэгддэг толь бичгүүдэд хувийн мэдээлэл, орой зай, бие махбод, үйл ажиллагааг бусдын ажиглалт, халдлагаас ангид байх агуулгаар тодорхойлох нь нийтлэг. Халдашгүй байдлыг тодорхойлох талаар олон улсад түгээмэл эшлэгддэг хэд хэдэн онол бий.<sup>4</sup>

Мэдээллийн технологийн хэрэглээнээс шалтгаалан эл ойлголт нийгмийн уламжлалт ёс зүй, заншлын хэм хэмжээгээр зохицуулагдаагүй хэлбэрээр, тухайлбал цахим хэлбэрээр

<sup>2</sup> Зарим эх сурвалжид (A History of Private Life. Paul Veune, Georges Duby нарын хамтын бүтээл) латин хэлнээ уг ойлголттой дүйх нэр томъёо байгаагүй (“privatio” гэдэг нь “алслагдах” гэсэн утгатай) хэмээн тэмдэглэсэн. Хэдий орчин үеийн ойлголтоор шууд оноох боломжгүй ч дурдсан нэр томъёо агуулгын хувьд ижил утгыг илэрхийлдэг.

<sup>3</sup> Редуктив, редуктив бус онолууд хэсгээс дэлгэрүүлэх.

<sup>4</sup> Дэлгэрэнгүйг: М.Хатанзориг. Хувийн халдашгүй байх эрхийн орчин үеийн үзэл баримтлал.2024. Хүний эрх сэтгүүлийн 2024/2 дугаар



зөрчигдөх болсон нь олон улсын анхаарлыг хүчтэй татсан ба дэлхий даяар улс орнууд хамтарсан буюу бие даасан хэлбэрээр төстэй буюу ялгаатай зохицуулалт тогтоож байна.

**Хоёр. Халдашгүй байдал, хувийн мэдээллийн олон улсын эрх зүйн зохицуулалт ба хамгаалалт:**

Дэлхийн 137 улс халдашгүй байх эрхийн талаар буюу хүний хувийн мэдээллийг хамгаалах хууль тогтоомжийг тодорхой хэмжээнд нэвтрүүлсэн байна. Африк болон Ази тивийн улсууд 61 болон 57 хувь нь энэ төрлийн зохицуулалт тогтоосон бол буурай улсуудын 48 хувь нь хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомж баталжээ.<sup>5</sup>

### 1. Олон улсын эрх зүйн зохицуулалт

Олон улсын голлох эрх зүйн эх сурвалжуудад халдашгүй байдал, хувийн мэдээлэл хамгаалах тухай цөөнгүй зохицуулалт тусгасан байдаг. Халдашгүй байх эрхийн ерөнхий үзэл баримтлалын дагуу хүний эрхэм чанар, язгуур эрх чөлөөнд халдашгүй байх эрх салшгүй холбоотой гэж үзсэн үзэл хандлага эдгээр зохицуулалтад түгээмэл ажиглагдаж байна. Тухайлбал:

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 12 дугаар зүйл;<sup>6</sup>

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйл;<sup>7</sup>

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 16 дугаар зүйл;<sup>8</sup>

Компьютержуулсан хувийн өгөгдлийн файлуудын зохицуулалтын талаарх НҮБ-ын зааварчилгаа (1990);

<sup>5</sup> Нэгдсэн Үндэсний Байгууллагын (UNCTAD) статистик. (<https://unctad.org/data-protection-and-privacy-legislation-worldwide>)

<sup>6</sup> Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч байхуулиар хамгаалуулах эрхтэй.

<sup>7</sup> 1. Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.

2. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.

<sup>8</sup> 1. Нэг ч хүүхдийн хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байрны халдашгүй байдал болон захидал харилцааны нууцад хөндлөнгөөс, хууль бусаар буюу дур мэдэн оролцох, эсхүл түүний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй.

2. Хүүхэд хөндлөнгийн ийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.

Нууцлал болон хувийн өгөгдлийн хил дамжсан урсгалын талаарх Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зааварчилгаа (1981).

Цагаач ажилчид ба тэдгээрийн гэр бүлийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенцын (1990) 14-р зүйл.<sup>9</sup>

### Бүс нутгийн шинжтэй зохицуулалт:

Ерөнхий өгөгдөл хамгаалах зохицуулалт (Европын холбоо 2016) –GDPR;<sup>10</sup>

Европын хүний эрхийн конвенцын 8-р зүйл;<sup>11</sup>

Европын Хүний Үндсэн Эрхийн Дүрмийн 7 дугаар зүйл;<sup>12</sup>

Исламын улсуудын хүний эрхийн Кайрогийн тунхаглалын 18-р зүйл;

Арабын хүний эрхийн дүрмийн 16, 21 дүгээр зүйл;

Африкийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зарчмын тунхаглалын 4.3 дугаар зүйл<sup>13</sup>

Африкийн хүүхдийн эрх, сайн сайхны дүрмийн 19 дүгээр зүйл;

Зүүн өмнөд Азийн улсуудын хүний эрхийн тунхаглалын 21 дүгээр зүйл;

Исламын орнуудын хүний эрхийн Кайрогийн тунхаглалын 18 дугаар зүйл;<sup>14</sup>

Бүсийн онцлох зохицуулалт – Өгөгдөл

<sup>9</sup> Цагаач ажилчид ба тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн халдашгүй байдал, гэр бүл, орон гэр, захидал харилцаанд хууль бусаар халдахыг хориглох ба нэр төр, алдар хүндийг нь хууль бус халдлагаас хамгаална.

<sup>10</sup> 2018 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн, олон улсад түгээмэл жишигдэг зохицуулалт.

<sup>11</sup> Хүн бүр өөрийн хувийн болон гэр бүлийн амьдрал, орон гэр болон захидал харилцааг хүндэтгүүлэх эрхтэй.

<sup>12</sup> (Хувийн болон гэр бүлийн амьдралд хүндэтгэлтэй хандах) “Хүний хувийн болон гэр бүлийн амьдрал, орон гэр ба захидалд харилцаанд хүндэтгэлтэй хандана” гэж; 8 дугаар зүйлийн (Хувийн өгөгдөл хамгаалах) §1-д “Хүн бүр хувийн өгөгдлөө хамгаалуулах эрхтэй”, §2-т “Хүний хувийн өгөгдлийг мэдээллийн эзний зөвшөөрөл буюу хуульд заасан үндэслэлээр, тодорхой зорилгын дагуу шударгаар ашиглана. Хүн бүр өөрийнх нь талаар цуглуулсан мэдээлэлтэй танилцах, түүнийг зөвтгөх эрхтэй”, §3-т “Эдгээр дүрмийг хэрэгжүүлэхэд бие даасан эрх бүхий этгээд хяналт тавьж ажиллана”.

<sup>13</sup> “Мэдээллийн эрх чөлөө”. Хүн бүр төрийн буюу нийтийн эсвэл хувийн байгууллагад хадгалагдаж байгаагаас үл шалтгаалаад тус мэдээлэлдээ хандах, өөрчлөх буюу зөвтгөх эрхтэй.

<sup>14</sup> 2 дахь хэсэг. Хүн бүрийн хувийн амьдрал, орон гэр, гэр бүл, өмч, харилцаа халдашгүй байна. Хүнийг тагнах, хянах (surveillance), нэр төрийг нь гутаахыг хориглох ба төрөөс хүнийг аливаа халдлагаас хамгаална. 3 дахь хэсэг. Хувийн орон байр ямар ч тохиолдолд халдашгүй байна. Хуульд заасан, эсвэл эздийн зөвшөөрөлгүйгээр үүнд халдахыг хориглоно.



хамгаалах ерөнхий зохицуулалт<sup>15</sup>: 2018 оноос үйлчилж эхэлсэн Европын холбооны эл зохицуулалт Монгол Улс, БНХАУ, АНУ-ын Калифорн муж зэрэг олон газрын хувийн мэдээлэл хамгаалах зохицуулалтад жишиг болсон байна. Зохицуулах харилцаа нь “Хүний хувийн мэдээллийг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах замаар хүний тулгуур эрхүүд, тэр дундаа хувийн мэдээллээ хамгаалуулах эрхийг хамгаалах” ажээ. Хүний хувийн мэдээллийг ашиглах автоматжуулсан болон хэсэгчлэн автоматжуулсан, автомат бус ажиллагаатай холбоотой харилцаанд үйлчлэх ба хүн өөрөө мэдээллээ ашиглах зэрэг тодорхой харилцаануудад үйлчлэхгүй.

Тус зохицуулалтаар хувийн мэдээлэл; мэдээлэл ашиглах, боловсруулах; мэдээлэл ашиглахад тавигдах хориг; профайлинг; мэдээлэл ашиглагч; генийн мэдээлэл; биометр мэдээлэл; мэдээллийн халдлага гэх мэт 26 нэр томъёог тодорхойлсныг цөөнгүй улс жишиглэн тогтоосон. Тухайлбал Монгол Улсын Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд “хувийн мэдээлэл”-ийг тодорхойлохдоо<sup>16</sup> уг хуулиас хөрвүүлж авсан байна. Мөн энэхүү зохицуулалтын нэг онцлог нь Европын холбооны нутаг дэвсгэрээр гадуур үйл ажиллагаа явуулж буй этгээдэд үйлчлэх боломжтой (extraterritorial). Зохицуулалтад зааснаар (1) Европын холбоонд байрлах хувийн мэдээлэл ашиглагч бүх этгээдэд; (2) Мэдээлэл ашиглагч нь европын холбоонд байрлахгүй боловч тус бүсэд байрлаж буй этгээдийн талаар хувийн мэдээлэл ашиглах бол (Тухайн этгээдэд бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зан байдал тогтоох үйл ажиллагаа); (3) Мэдээлэл ашиглагч Европын холбоонд байрлаагүй боловч олон улсын эрх зүйн хүрээнд гишүүн улсын хууль тогтоомж үйлчлэх газар байрлаж буй бол зохицуулалт үйлчилнэ гэжээ.

### **Олон улсын байгууллагуудын хүний халдашгүй байдлыг хамгаалах ажиллагаа**

Нэгдсэн үндэстний байгууллага. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан Хүний

эрхийн түгээмэл тунхаглал заавал дагаж мөрдөх шинжийг агуулдаггүй ч олон улсад хүний язгуур эрхийн чиг баримжааг тодорхойлох явдалд чухал нөлөө үзүүлсэн. Тус баримтын 12-р зүйлд халдашгүй байдлын талаар зохицуулснаас гадна Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пактын 17-р зүйлд тусгасныг дээр дурдсан. Эл пакт Монгол Улсыг оролцуулаад дэлхийн 169 улсад хүний халдашгүй байх эрхийг хамгаалах гэрээний үүргийг хүлээлгэж буй. 2013 онд Ерөнхий асемблей “Дижитал эрин дэх халдашгүй байх эрх”-ийн тогтоол гаргаж хүний халдашгүй байх эрхийг зөрчих явдлыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн үндэсний хууль тогтоомж баталж мөрдүүлэх талаар тусгажээ. Зарим эх сурвалжид энэ тогтоолын талаар хүний халдашгүй байдал ба олон нийтийг тагнах, чагнах ажиллагааны талаарх хүчтэй мэтгэлцээнийг эхлүүлсэн ач холбогдолтой талаар тэмдэглэсэн байна.<sup>17</sup> 2013 оны тогтоолд халдашгүй байдлын зөрчлийн талаар цохон тэмдэглэсэн бол, тус тогтоолын 2016, 2017 оны шинэчилсэн хувилбарт олон нийтийг тагнах төрийн байгууллагын эрх хэмжээг хязгаарлах талаар, 2020 оны хувилбарт боловсролын агуулгад халдашгүй байдлаа хамгаалах тухай тусгах, хувийн байгууллагуудаас халдашгүй байх эрхийг хүндэтгэх нөхцөл бүрдүүлэх тухай тусгажээ.

Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD). Тус байгууллагаас халдашгүй байдлыг, тэр тусмаа мэдээллийн халдашгүй байдлыг хамгаалах талаар гол хүчин чармайлт нь “Халдашгүй байдлын заавар” буюу “Хил дамнансан хувийн өгөгдлийн урсгал ба халдашгүй байдлыг хамгаалах тухай заавар (Guidelines Governing the Protection of Privacy and Transborder Flows of Personal Data)” батлах, улмаар гишүүн улсуудад халдашгүй байдлыг хамгаалах анхан шатны стандарт мөрдүүлэх явдал болно. 1980 онд анх батлагдаж, 2013 онд шинэчлэгдсэн тус заавар мэдээлэл хамгаалах зохицуулалтад тодорхой хувь нэмэр оруулсан ба тухайлбал мэдээлэл хамгааллын суурь зарчмуудыг тогтоосон байна.

Үүнд: Мэдээлэл цуглуулах хязгаарлалтын зарчим<sup>18</sup>; Өгөгдлийн чанарын зарчим<sup>19</sup>;

<sup>17</sup> Handbook on European data protection law 2018.

<sup>18</sup> Хувийн мэдээлэл цуглуулах ажиллагаа хууль ёсны, шударга, мэдээллийн эзний зөвшөөрөлтэй байхаас гадна зохих ёсны хязгаарлагдвал зохино.

<sup>19</sup> Цуглуулсан хувийн өгөгдлийн агуулга цуглуулж

<sup>15</sup> General data protection regulation (GDPR).

<sup>16</sup> §4.1.11–т: “хүний хувийн мэдээлэл” гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг хэлнэ.



Зорилгын тухайлсан байдлын зарчим<sup>20</sup>; Хэрэглээний хязгаарлалтын зарчим<sup>21</sup>; Аюулгүй байдлын зарчим<sup>22</sup>; Нээлттэй байдлын зарчим<sup>23</sup>; Хувь хүний оролцооны зарчим<sup>24</sup>; Бүртгэл хариуцлагын зарчим<sup>25</sup> хамаарна. Тус байгууллага мөн ковид-19 цар тахлын үеэрх өгөгдлийн ашиглалттай холбоотойгоор халдашгүй байдлын хамгаалах арга хэмжээг<sup>26</sup> үйл ажиллагааныхаа зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн аж.<sup>27</sup>

Европын зөвлөл (Council of Europe). 1950 онд Европын зөвлөлөөс гаргасан Европын хүний эрхийн конвенц өдгөө ч Беларус, Косовогоос бусад европын улсуудад хүчин төгөлдөр үйлчилж буй. Уг конвенцын 8 дугаар зүйлд хүний хувийн амьдралыг хүндэтгэх агуулгаар: “Хүн бүр өөрийн хувийн болон гэр бүлийн амьдрал, харилцаагаа бусдаар хүндэтгүүлэх эрхтэй” хэмээн заажээ. Мөн 1981 онд “Хувийн мэдээллийн автомат боловсруулалттай хамаатайгаар хувь хүмүүсийг хамгаалах тухай (The Convention for the Protection of Individuals with regard to Automatic Processing of Personal Data)” конвенцыг баталсан. 2018

буй зорилгод нийцсэн байхаас гадна үнэн зөв байхыг (хуучирсан бус) шаардана.

<sup>20</sup> Зөвхөн тодорхой зорилгын хүрээнд, түүнээс хэтрүүлэлгүйгээр хувийн мэдээллийг цуглуулах ба цуглуулсны дараа бус цуглуулах үед тодорхойлогдсон байвал зохино.

<sup>21</sup> Хувийн мэдээллийг хуульд заасан тохиолдол, эсвэл мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр цуглуулсан зорилгоос өөрөөр ил болгохыг хориглоно.

<sup>22</sup> Хувийн мэдээллийг устах, халдлагад өртөх, ил болгох зэрэг аюулаас зохих ёсоор хамгаалсан байхыг шаардана.

<sup>23</sup> Хувийн мэдээллийг хамгаалах бодлого, практик, хөгжүүлэлтийн нээлттэй байдлыг талаар нийтлэг бодлого хэрэгжүүлэх шаардлагатай.

<sup>24</sup> Мэдээллийн эзэн (1) өөрийн мэдээлэлтэй танилцах, эсвэл түүний мэдээллийг хадгалж байгаа эсэхийг лавлах; (2) үндэслэл бүхий хугацаанд, төлбөргүй эсвэл өндөр биш төлбөрөөр, зохих хэлбэрээр зэрэг шаардлагыг хангасан нөхцөлөөр өөрийн буюу өөрт хамааралтай өгөгдөлтэй танилцах; (3) дурдсан нөхцөлөөр түүнд мэдээллийг нь олгохоос татгалзсан шалтгаантай танилцах, давж заалдах; (4) өөрт хамааралтай өгөгдлийг шалгах (үнэн зөв эсэх, хууль ёсоор цуглуулсан эсэх гэх мэт), шалгалтад үл нийцвэл өгөгдлийг устгуулах, өөрчлөх, засварлах гэх мэт эрхүүдтэй байна.

<sup>25</sup> Өгөгдөл хадгалагч бусад зарчмуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй.

<sup>26</sup> Тухайлбал цар тахлын үеэрх дижитал арга зүйн хүрээнд халдашгүй байдлын зөрчил үүсэх эрсдэл, нөхцөл байдал, даван туулах арга замын талаар судалгааны материал нийтэлсэн байна: “Ensuring data privacy as we battle COVID-19”; “Tracking and tracing COVID: Protecting privacy and data while using apps and biometrics”; “Using artificial intelligence to help combat COVID-19.”

<sup>27</sup> <https://www.oecd.org/sti/ieconomy/privacy.htm>

онд шинэчлэгдсэн тус конвенцод 55 улс нэгдэн орсон, 25 улс ажиглагчаар орсон нь олон улсын баримтуудаас хамгийн түгээмэл хүлээн зөвшөөрөгдсөнд тооцогдож байна.

Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (Asia-Pacific Economic Cooperation – APEC): 2004 онд Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас ерөнхий мэдээлэл хамгаалах болон хил дамнанас мэдээлэл хамгаалалтын тогтолцооны загвар (APEC privacy framework) боловсруулсныг (сүүлийн хувилбар 2015 онд) 21 гишүүн улс нь бүгд сайн дураар хүлээн зөвшөөрч ашиглахаар болжээ.<sup>28</sup> Уг зохицуулалтаар хамгаалалтын дараах 9 зарчмыг стандартын доод шалгуур болгон тогтоожээ:

1. Хохирол учрахаас урьдчилан сэргийлэх зарчим;
2. Мэдэгдэх зарчим;
3. Мэдээлэл цуглуулахад хязгаар тогтоох зарчим;
4. Хувийн мэдээллийн ашиглалтыг зохицуулах зарчим;
5. Сонгох зарчим;
6. Хувийн мэдээллийн нэгдмэл (халдашгүй) байдал;
7. Мэдээлэл хамгаалах;
8. Хувийн мэдээллээ авах, өөрчлөх эрхийн зарчим;
9. Бүртгэл, хариуцлагын зарчим.

**Гурав. Үндэсний эрх зүйн зохицуулалт, загвар:**

Хүний халдашгүй байх эрхийн талаар Монгол Улсын Үндсэн хуулийн §16.13–т заасантай төстэйгөөр Алжир<sup>29</sup>, Бутан<sup>30</sup>, Болив<sup>31</sup>, Бразил<sup>32</sup>, Камбож<sup>33</sup>, Хятад<sup>34</sup> зэрэг дэлхийн

<sup>28</sup> Greenleaf, Graham (2009). “Five years of the APEC Privacy Framework: Failure or promise?”. Computer Law & Security Report. 25: 28–43.

<sup>29</sup> Үндсэн хуулийн (2020) §47–д “Хүн бүр нэр төр, хувийн амьдралаа хамгаалуулах эрхтэй”.

<sup>30</sup> Үндсэн хуулийн (2008) §7.19–д “Хэний ч хувийн амьдрал, орон байр, ... нэр төрд хууль бусаар халдаж болохгүй”.

<sup>31</sup> Үндсэн хуулийн (2009) §21.2–т “Боливын иргэд дараах эрхтэй: Эрхэм чанар, хувийн халдашгүй байдал, ... нэр төр.

<sup>32</sup> Үндсэн хуулийн (1988 онд батлагдаж 2017 онд шинэчлэн найруулсан) §5–д “...хууль шүүхийн өмнө тэгш байж ... эрх эдэлнэ: 10. ... хувийн амьдралтай байх, нэр төртэй байх ...”.

<sup>33</sup> Үндсэн хуулийн (1993 онд батлагдаж 2008 онд шинэчлэн найруулсан) §40–д “... орон байр, шуудан, телеграм, утас зэрэг ... халдашгүй байх эрхтэй.

<sup>34</sup> Үндсэн хуулийн (1982) §40–д “БНХАУ–н иргэний



180 гаруй улсын Үндсэн хуульд янз бүрээр тусгагдсан байна. Тухайлбал, Энэтхэгийн Үндсэн хуулийн 21-р зүйл<sup>35</sup> АНУ-н Үндсэн хуулийн 1, 4 ба хэд хэдэн нэмэлт өөрчлөлтөд<sup>36</sup> ч мөн хуульчлагджээ. Түүнчлэн Африк тивийн 25 улс<sup>37</sup> Үндсэн хуулиар эл эрхийг бататгаснаас тодруулбал Өмнөд Африк “Хүн бүр халдашгүй байх эрхтэй: хүнийг болон түүний орон байрыг нэгжих; өмчийг нь нэгжих; эд хөрөнгийг нь хураан авах; харилцаа холбоог нь тагнахыг хориглоно” гэсэн байна.

Улс орнуудад үзэл баримтлалын шинжтэй зохицуулалтын ерөнхий ялгаа байгаа хэдий ч хоорондоо төстэй зохицуулалт мөн түгээмэл бий. Дэлхийн улсуудаас 70 гаран хувь нь халдашгүй байдлыг хамгаалах тодорхой хэмжээний зохицуулалтыг тухайлан тогтоосон <sup>38</sup>ба 2010-аад оноос хойш энэ талын зохицуулалт улам нэмэгджээ. Ойрх дорнодоос Бахрайн 2019 онд “Хувийн өгөгдөл хамгаалах тухай хууль”, Израйл 2017 онд “Өгөгдлийн аюулгүй байдлын зохицуулалт”, Турк 2016 онд “Хувийн өгөгдөл хамгаалах тухай хууль”, Африкаас Уганда 2019 онд “Өгөгдөл хамгаалах, халдашгүй байдлын тухай хууль”, Өмнөд Африк “Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”, Азиас Япон 2020 онд “Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”, Монгол 2021 онд “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”, Шинэ Зеланд 2020 онд “Халдашгүй байдлын акт”, Өмнөд Солонгос 2011 онд (2020 онд шинэчлэгдсэн) “Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”, Хятад 2021 онд “Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”,

---

харилцаа холбооны халдашгүй байдал, эрх чөлөөг хуулиар хамгаална”

<sup>35</sup> “Хуульд зааснаас бусдаар хүний хувийн амьдрал, эрх чөлөөнд халдахыг хориглоно”. БНЭУ-д Үндсэн хуулийн уг заалтын агуулгыг тайлбарлан шийдвэрлэсэн хэд хэдэн чухал хэрэг маргаан бий. Тухайлбал, *Smt. Maneka Gandhi v. Union of India & Anr.*, (1978); *Govind vs State Of Madhya Pradesh & Anr* (1975); *Naz Foundation v. Govt. of NCT of Delhi* (2009).

<sup>36</sup> АНУ халдашгүй байх эрхийн хөгжилд багагүй нөлөө үзүүлсэн. Үндсэн хуулийн эдгээр заалтаас гадна *Griswold v. Connecticut*, 381 U.S. 479 (1965); *Katz v. United States*, 389 U.S. 347 (1967) зэрэг олон алдартай хэргүүдэд хийсэн Дээд шүүхийн тайлбар нь хүний мэдээлэл, шийдвэр халдашгүй байх талаар үзэл санаанд өөрсдийн хувь нэмрийг оруулжээ. Флорида, Хавай, Монтана, Луйзана зэрэг олон мужууд нь мөн халдашгүй байдлын талаар өөрсдийн Үндсэн хуулинд тусгасан байна.

<sup>37</sup> Зимбаб, Бүрүнди, Лесото, Өмнөд Африк, Намиби, Ботсвана, Замби, Нигер, Либер, Кени, Гвен, Гана, Уганда гэх мэт.

<sup>38</sup> <https://unctad.org/page/data-protection-and-privacy-legislation-worldwide>

Орос 2007 онд (2014 онд нэмэлт өөрчлөлт) “Хувийн өгөгдлийн тухай холбооны хууль”, Өмнөд Америкаас Бразил 2020 онд “Өгөгдөл хамгаалах ерөнхий хууль”, Аргентин 2001 онд “Хувийн өгөгдөл хамгаалах акт”, Уругвай 2008 онд “Хувийн өгөгдөл хамгаалах тухай” гэх мэтээр дэлхий даяар халдашгүй байдлын зохицуулалт хийгдэж буй.

Үндэсний халдашгүй байдлын эрх зүйн тогтолцоог ерөнхийд нь салбарласан шинжтэй, төвлөрсөн шинжтэй хэмээн ангилж болох юм.

### Салбарчилсан зохицуулалтын загвар

Уг загвар нь халдашгүй байдлыг бүхэллэг ойлголт болохынх нь хувьд багцалсан ерөнхий хууль батлахгүйгээр эрүүл мэндийн, боловсролын гэх мэт салбаруудад мэдээлэл хамгаалах зохицуулалтыг тухайлан тогтоодог. Үүний сонгодог жишээ нь АНУ-ын халдашгүй байдлын зохицуулалт болно.

АНУ-ын халдашгүй байдлын зохицуулалтын онцлог: Тус улсад халдашгүй байдлыг бүхэлд нь хамгаалах буюу мэдээлэл хамгааллын талаар холбооны түвшинд бие даасан хууль үйлчилдэггүй бөгөөд Хүүхдийн цахим халдашгүй байдлын тухай (1998); Мэдээллийн эрх чөлөөний тухай (1966); Эрүүл мэндийн даатгалын бүртгэл, шилжүүлгийн тухай (1996) гэх мэт<sup>39</sup> салбар болгоныг тухайлан зохицуулсан хууль тогтоомж үйлчилдэг. Эдгээр нийгмийн харилцаанд зэрэгцэж үйлчлэх боловч тухайлсан нэгдмэл хуульгүй учраас муж улсуудын зохицуулалт хоорондоо зөрчилдөх тохиолдол бий болдог.

АНУ-ын халдашгүй байдлын үзэл санаа нь төрийн албадлага, эрх мэдлээс хараат бус байх эрх чөлөөний номлолд тулгуурладаг учраас Засгийн газраас иргэдээ хянаж цагдах, халдашгүй байдлыг нь зөрчих явдлаас олон нийт ихээхэн болгоомжилдог гэж болно. Үүний илрэл нь Снөүдений кейс, мөн 2001 оны 09 сарын 11 өдрийн террорист халдлагын дараах “Эх оронч хууль” гэгддэг<sup>40</sup> зохицуулалтыг

<sup>39</sup> Fair Credit Reporting Act of 1970 (FCRA), the Health Insurance Portability and Accountability Act of 1996 (HIPAA), Gramm-Leach-Bliley Act of 1999 (GLBA), Children's Online Privacy Protection Act of 1998 (COPPA), Privacy Act of 1974, Freedom of Information Act of 1966 (FOIA), Electronic Communications Privacy Act of 1986.

<sup>40</sup> Терроризмтэй тэмцэх, хянахад шаардлагатай хэрэгслийг ашиглаж Америкийг нэгтгэх, хүчирхэгжүүлэх тухай хууль (Uniting and Strengthening America by Providing Appropriate Tools Required to Intercept and Obstruct Terrorism), 2001 он, Ерөнхийлөгч Ж.Буш гарын үсэг зурсан.



иргэд шүүмжлэлтэй хүлээж авсан явдал юм. Тус хуулиар Засгийн газраас өөрийн улсын ба гадаадын иргэдийг хянах, тагнах эрх хэмжээг нэмэгдүүлсэн ба судлаачдын тэмдэглэсэнчлэн<sup>41</sup>г үйл явдал тус нийгэмд “Том ахын нийгэм”<sup>42</sup>–ийг бий болгох эрсдэлийг сануулж, төрөөс халдашгүй байх эрхээ хамгаалах ухамсрыг нэмэгдүүлсэн. Гэвч АНУ одоо ч салбарласан зохицуулалтаар халдашгүй байдлыг хамгаалж байна. Тухайлбал Санхүүгийн шинэчлэлийн актаар санхүүгийн салбарыг, Видео бичлэгийн халдашгүй байдлын хамгаалалтын актаар видео дэлгүүрүүдийг, Телефон утасны хэрэглэгчийн халдашгүй байдлын хамгаалалтын актаар телемаркетеруудыг, Теле харилцаа холбооны актаар телефон утасны компаниудыг, Эрүүл мэндийн даатгалын бүртгэл, шилжүүлгийн актаар эрүүл мэндийн байгууллагуудыг тус тус үйл ажиллагаа, зохион байгуулалтын хувьд хянах, зохицуулах арга хэмжээ авч буй.

Эрх чөлөөний сэтгэлгээнд тулгуурласан халдашгүй байдлын үзэл санаа нь Америкчуудад халдашгүй байх эрхээ төрийн эрх мэдлээс хамгаалах тогтолцоог эрэлхийлж, хувийн хэвшлийн мэдээлэл ашиглалтыг сул чөлөөтэй орхих нөхцөлийг бүрдүүлсэн гэж зарим эх сурвалжид<sup>43</sup> тэмдэглэсэн нь үндэслэлтэй. Хувийн хэвшлийн үндэстэн дамнасан томоохон корпорацууд байршдаг Калифорн мужид бие даасан мэдээлэл хамгаалах хууль баталсан<sup>44</sup> нь

<sup>41</sup> Stephan Grynwaic. Privacy at the Crossroads: A Comparative Analysis of Regulation in the U.S., the EU and Canada. 2021

<sup>42</sup> Жорж Оурэлийн 1984 зохиолд гардаг бүх нийтийг хатуу хяналтад байлгадаг төрийн зохион байгуулалтыг хэлж байна.

<sup>43</sup> Stephan Grynwaic. Privacy at the Crossroads: A Comparative Analysis of Regulation in the U.S., the EU and Canada. 2021

<sup>44</sup> Уг хууль Европын холбооны Өгөгдөл хамгаалах ерөнхий зохицуулалтыг жишиглэсэн байна. Хуулийг дагаж мөрдөх этгээдийн хувьд Калифорн мужийн иргэдийн хувийн мэдээллийг авч буй жилд 24 сая долларын орлого бүхий; 50.000 хэрэглэгчийн хувийн өгөгдлийг цуглуулсан; Орлогын тал буюу түүнээс дээш хувийг хувийн мэдээлэл худалдсанаар бүрдүүлдэг этгээдүүд хамаардаг бол ӨХЕЗ–д Европын иргэд болон оршин суугчдын хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах бүх этгээдэд хамаарна (үүнд ЕХ–ны нутаг дэвсгэрийн гадна үйл ажиллагаа явуулдаг эсэх нь хамаагүй – extraterritorial). Калифорнын хуулийн хэрэглэгчээс мэдээлэл цуглуулах зөвшөөрөл авах арга нь “Opt out” буюу хэвийн нөхцөлд хэрэглэгчийн мэдээллийг цуглуулах эрхийг нээсэн байх ба хэрэглэгч хүсвэл тодорхой үйлдэл хийж мэдээлэл цуглуулах зөвшөөрлөө цуцалдаг, зөвшөөрлийг эс үйлдэхүйгээр өгөгдсөн гэж үзэх хэлбэр бол ӨХЕЗ–ын хувьд “Opt in” буюу хэвийн нөхцөлд хэрэглэгчийн мэдээллийг цуглуулах эрхгүй бөгөөд хэрэглэгч өөрөө

үүний нэг илэрхийлэл болно. Эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийд тавд жагсдаг<sup>45</sup> уг мужид Фейсбүүк (Meta), Гүүгл (Алфавет) зэрэг олон улсын мэдээлэл шилжүүлэх, олон нийтийн цахим сүлжээг удирдах гол байгууллагууд байршдаг, мэдээллийн эдийн засаг асар хүчтэй хөгжсөн нь ийм хууль батлах гол хүчин зүйлүүдийн (эдийн засаг, аюулгүй байдал) нэг болжээ. Харин халдашгүй байх эрхийг хувийн секторт хамгаалах үзэл баримтлал уг хуулийг хэрэгжүүлэх үндсэн шалтгаан биш гэж болно.

### Төвлөрсөн зохицуулалтын загвар

Уг загварын гол шинж нь халдашгүй байх эрхийг бүхэллэг ойлголт болохыг хүлээн зөвшөөрч ерөнхий хууль тогтоомж батлан төвлөрсөн зохицуулалт хийдэг. Уг тогтолцооны тод жишээ нь Европын холбооны халдашгүй байдлын хамгаалах зохицуулалт мөн. Хэдий Европын холбооны зохицуулалт үндэсний эрх зүйн тогтолцоонд хамаарахгүй боловч холбооны гишүүн улсуудад нийтлэг үйлчлэх хуулийг тогтоосноороо гишүүн улсуудын үндэсний эрх зүйн зохицуулалтыг ерөнхий утгаар нь илэрхийлэх боломжтой тул энэ хэсэгт багтаав.

Европын холбооны халдашгүй байх эрхийг хамгаалах тогтолцооны онцлог: Европын холбооны халдашгүй байдлыг хамгаалах гол онцлог нь Европын улсуудын зохион байгуулалтын үүднээс төдийгүй үзэл баримтлалын хувьд халдашгүй байдлыг хууль зүйн бүхэллэг ухагдахуун хэмээн үздэгт оршино. Ерөнхийдөө эрхэм чанарын номлолд тулгуурласан халдашгүй байдлын үзэл хандлагыг баримталдаг утгаараа Европын халдашгүй байдлын зохицуулалт төрд гэхээсээ илүү хувийн хэвшлийн мэдээлэл цуглуулах, ашиглах явдалд чиглэсэн шинжтэй гэж болно. Уг санаанд тулгуурлан холбооны улсуудад түгээмэл үйлчлэх халдашгүй байх эрхийг хууль зүйн үзэл баримтлалыг тогтоож ирсэн байна. 2009 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Цахим

идэвхитэй үйлдлээр зөвшөөрөл олгосноор хувийн мэдээллийг нь цуглуулах эрх үүснэ. Сурталчилгааны, анализын зориулалтаар хэрэглэгчийн мэдээллийг ялгаатай цуглуулдаг учир ямар мэдээлэл, ямар зорилгоор цуглуулж байгаа талаараа хэрэглэгчид мэдээлнэ. Уг зохицуулалтад (ӨХЕЗ) зааснаар “зөвшөөрөл нь сайтар мэдээлэлжсэн, тухайлсан агуулгатай, мэдээллийн эзэн сайн дураараа олгосон, хоёрдмол утгагүй ... тодорхой, идэвхитэй үйлдлийн үндсэн дээр олгогдсон байх” шаардлагатай.

<sup>45</sup> Эдийн засгийн хэмжээ 2021 оны байдлаар 3.1 триллион америк доллар.



халдашгүй байдлын зааврыг 2018 оны Өгөгдөл хамгаалах ерөнхий зохицуулалтаар халсан нь бүсийн шинжтэй зохицуулалтыг гишүүн орнууд заавал дагаж мөрдөх шинжтэй болгожээ (зааврыг заавал мөрдөхгүй).

Хэдий олон харилцаанд тусгаар улсууд үндэсний хууль тогтоомжоороо ялгаатай хэм хэмжээ тогтоох боломжтой боловч ӨХЕЗ-ыг заавал дагаж мөрдөх ёстой нь нэгдмэл зохицуулалт тогтоох хандлагыг тод илэрхийлэл мөн. Улсууд өөрсдөө 50 гаруй харилцааг нарийвчлан зохицуулах боломжтой. Тухайлбал зохицуулалтын §9-д зааснаар эмзэг мэдээлэл (эрүүл мэндийн мэдээлэл, хурууны хээ зэрэг биометр мэдээлэл гэх мэт) цуглуулах нь ерөнхийдөө хориотой боловч мэдээллийн эзэн зөвшөөрсөн, эсвэл тухайн улс үндэсний хуулиараа тухайлан боломж олгосон бол тус мэдээллийг цуглуулах, боловсруулах боломжтой. Мөн §17-д зааснаар мэдээллийн эзэн мартагдах эрхтэй<sup>46</sup> боловч гишүүн улс уг эрхийг хязгаарлах нөхцөлийг дотоодын хуулиар тогтоож болно гэх мэт үндэсний нарийвчилсан хэм хэмжээ батлах боломжтой боловч ерөнхийдөө дурдсан зохицуулалтад нийцсэн байхыг шаардана.

Үндэсний эрх зүйн тогтолцооны нийтлэг зохицуулалт: Улс орнууд ерөнхийдөө халдашгүй байх эрх, эсвэл хувийн мэдээллийг хамгаалах зохицуулалтыг салбарчилсан буюу төвлөрсөн загвараар батлан мөрдүүлэхдээ хувийн мэдээлэл гэдэгт юуг ойлгох талаар тодорхойлсны үндсэн дээр төрийн болон хувийн байгууллагууд ямар тохиолдолд хэрхэн хувийн

мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах талаар; үүнд ямар байгууллага хяналт тавих талаар; мэдээллийн эзэн ямар эрхүүдийг эдлэх талаар; хууль зөрчигдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулсан байна.

#### Дүгнэлт

Иргэний хувийн мэдээллийн хамгаалалт нь нэг талаас үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагаанд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хязгаарлалт тогтоох боловч иргэдийн мэдээллийг хамгаалах, улмаар үндэсний эв нэгдлийг бэхжүүлэхэд нийлбэр утгаараа ач холбогдолтой. Цахим эринд хувийн халдашгүй байдлыг хамгаалах сорилтыг олон улсын ба үндэсний түвшний бодлого, зохицуулалтын тусламжтайгаар даван туулахаар оролдож байна.

Уг эрхийн хамгаалалтыг хууль зүйн талаасаа олон улсын эрх зүйн хэм хэмжээнүүдээр болон дотоодын үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор баталгаажуулжээ. Мөн олон улсын байгууллагууд энэ эрхийг хамгаалахад анхаарч тухайлсан үйл ажиллагаа явуулдаг ба үндэсний тогтолцоонд ч хувийн халдашгүй байдлыг хамгаалах бие даасан институтийг байгуулдаг жишиг байна. Үндэсний эрх зүйн тогтолцоог салбарчилсан ба төвлөрсөн загварт хувааж үзэх боломжтой ба манай улс 2021 оноос Европын төвлөрсөн загварыг хөгжүүлж эхэлсэн. Цаашид нэн даруй энэ хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, иргэдийн энэ талын боловсролыг нэмэгдүүлэх шаардлагатай.

<sup>46</sup> Мэдээллийн сангаас өөрийн хувийн мэдээллийг устгуулах.

#### Ашигласан материал:

1. М.Хатанзориг. Хувийн халдашгүй байх эрхийн орчин үеийн үзэл баримтлал., УБ, 2024. Хүний эрх сэтгүүлийн 2024/2 дугаар
2. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар. Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал” судалгааны тайлан. УБ, 2018
3. Н. Gross. 'The Concept of Privacy' (1967) 42 NYULR 34, 36
4. Greenleaf, Graham (2009). "Five years of the APEC Privacy Framework: Failure or promise?". Computer Law & Security Report. 25: 28–43
5. Handbook on European data protection law 2018.
6. Ensuring data privacy as we battle COVID-19"; "Tracking and tracing COVID: Protecting privacy and data while using apps and biometrics"; "Using artificial intelligence to help combat COVID-19.
7. Stephan Grynwajc. Privacy at the Crossroads: A Comparative Analysis of Regulation in the U.S., the EU and Canada. 2021



## ЦАЦРАГ, ХИМИ, БИОЛОГИЙН ОРЧИН ҮЕИЙН ЗАРИМ ТЕХНИК, ЗЭВСЭГЛЭЛИЙН ТУХАЙ

**Б.САМДАНДАМБА** ЛУБХИС-ИЙН ЦНДС-ИЙН ЦЭРГИЙН ИНЖЕНЕР, ХИМИЙН ТЭНХИМИЙН  
БАГШ, МАГИСТР, АХМАД

**Түлхүүр үг:** Цацраг, хими, биологи, зэвсэглэл, техник, орчин үе, зэвсэгт хүчин

**Key words:** radiation, chemistry, biology, armament, technique, modern, armed forces

### Оршил.

Эсрэг талын буюу дайсны амьд хүч болон зэвсэг техник, байшин барилга, ургамал амьтанд их хэмжээгээр буюу үй олноор нь хөнөөх, хордуулах, устгах зориулалттай байлдааны хэрэгслийг үй олноор хөнөөх зэвсэг (ҮОХЗ) гэнэ. Үй олноор хөнөөх зэвсэгт цөмийн, химийн болон биологийн зэвсэг орно. ҮОХЗ-ийн зөөгч хэрэгсэл нь олон төрөл бөгөөд ямар ч нөхцөлд явагдаж байгаа бүх төрлийн байлдаанд гэнэт, бөөнөөр цохилт өгөх чадвартай байдаг.

Дэлхийн II дайны үед болон түүний дараа ялангуяа оролцогч орнууд ҮОХЗ-ийн талаарх шинжилгээ судалгааны материалыг цуглуулж одоо хими биологийн зэвсэг үйлдвэрлэх боломжтой 9 улс цөмийн зэвсэгтэй болжээ. Ийнхүү хүн төрлөхтөн ҮОХЗ гэж нэрлэгддэг цөм, хими, биологийн зэвсгийн байнгын аюул занал доор амьдрах болсоор хагас зууны нүүр үзэж байгаа бөгөөд орчин цагт үйлдвэр аж ахуй, техник, технологи хөгжихийн хэрээр уран олборлох мөн цацраг, химийн хорт бодис ихээр хэрэглэх болсон учир түүнээс гарч болох аваар ослоос хамгаалах, урьдчилан сэргийлэх, сүүлийн үеийн хамгаалах хувцас, зэвсэглэл техникийг судлах шаардлага чухал байна.

Цацраг Хими, биологи, ба цөмийн аюултай тэмцэхэд нэн тэргүүнд энэ төрлийн аюулыг илрүүлэх, түүнээс бие бүрэлдэхүүн, иргэдийн аюулгүй байдлыг найдвартай хангаж чадах орчин үеийн техник хэрэгслийн шинэчлэлийг хийх шаардлага манай Зэвсэгт хүчний хувьд ч тулгарч байгааг анхаарахгүй байхын аргагүй бөгөөд энэ чиглэлээр судалгаа явуулж, тодорхой мэдээллийн баазтай болох, өөрийн орны нөхцөлд тохирсон техник хэрэгслийг дэс дараатайгаар сонгон нэвтрүүлэх арга хэмжээг урт, дунд хугацааны стратегийн төлөвлөлтөндөө тусгах шаардлагатай байна гэж үзсэн бөгөөд энэ асуудлаар судлахыг зорилго.

### Үндсэн хэсэг

Өнөөгийн тодорхойгүй цагийн байдлын

үед хүчирхэг улс орнуудын Зэвсэгт хүчнээс эхлэн террорист байгууллагууд хүртэл орчин үеийн цөм, химийн болон биологийн тактик, оператив, стратегийн хэрэгслүүдтэй болохын төлөө улайран тэмцэх болсон ба тэд өөрийн зорилгодоо хүрэхийн тулд үйл олноор хөнөөх зэвсэглэлийг хэрэглэх магадлал улам бүр ихсэх хандлагатай байна. Энэ нь улс орнуудыг өөрийн цэргийн хүчнийхээ үй олноор хөнөөх зэвсгийн хор хөнөөлөөс хамгаалах чадварыг нэмэгдүүлэх шаардлагыг улам бүр өндөржүүлж, түүнийхээ төлөө тодорхой хэмжээний санхүүгийн болон аж үйлдвэрийн нөөцийг жил бүр зориулдаг болжээ.

Сүүлийн жилүүдэд цөм, хими, биологийн зэвсгийг хөгжүүлэхэд чиглэсэн судалгааны ажлын цар хүрээ үлэмж нэмэгдсэний дээр энэхүү чиг хандлагыг дагалдан түүнээс хамгаалах шинэ төрлийн хэрэгслийг бий болгох чиглэлд ч багагүй амжилт олж, шинэ шинэ төрлийн хамгаалалтын хэрэгслүүдийг орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилтыг тусган үйлдвэрлэн гаргах боллоо.

Нөгөө талаар дэлхийн улс орнуудын дотор өөрийн аюулгүй байдлын баталгаа өөрийн үй олноор хөнөөх зэвсэгтэй болсноор хангагдах болно гэсэн хандлага нэлээд давамгайлах болж, сүүлийн жилүүдэд цөм, химийн зэвсэгтэй улс орнуудын тоо нэмэгдэх чигтэй байна. Тухайлбал: Хойд Солонгос, Ираны цөмийн хөтөлбөрийг тойрсон маргаан илэрхий олон улсын анхаарлын төвд байж, Пакистаны цөмийн зэвсгийн хамгаалалтын асуудал эмзэг байгаад дэлхийн улс орнууд улам бүр санаа зовох боллоо.

Иймээс дэлхийн тэргүүлэгч улс, орнууд ҮОХЗ-ийг тархаахгүй байхыг эрмэлзэн, энэ чиглэлийн олон улсын гэрээ, хэлэлцээрийг баталгаажуулах, түүнийг зөрчихгүй байх асуудалд ихээхэн санаа тавих болсны дээр болзошгүй аюул тулгарсан үед хүн ам, цэргийн хүчнээ найдвартай хамгаалах чадвараа нэмэгдүүлэх чиглэлд улам их анхаарал хандуулах болсон бөгөөд Монгол улс тэр дундаа Цацраг, хими,



биологиос хамгаалахын цэрэг ч санаа амар сууж болохгүйг анхаарах хэрэгтэй.

АНУ-ын Батлан хамгаалах яам цацраг, хими, биологи, цөмийн болон аюултай болон хортой бодисын өргөн хүрээг хамарсан осол, хэрэг явдал, халдлага болсон үед хариу арга хэмжээ авах чадавхаа нэмэгдүүлэх чиглэлд идэвхтэй судалгаа, туршилтын ажлыг үргэлжлүүлсээр байна. Тус улсын засаг захиргаа 5000 хүний бүрэлдэхүүнтэй онцгой байдлын үеийн уршгийг арилгах ангиудыг байгуулсаар байна. Ийм анги гурвыг байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд эдгээр ангиуд нь иргэний хохирол, уршгийг арилгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зориулалттай ажээ.

Цацраг, хими, биологи, цөмийн болон аюултай хорт бодисыг илрүүлэх, хор уршгийг арилгахад ашиглах техник хэрэгсэл, ослын голомтод ажиллах бие бүрэлдэхүүний аюулгүй ажиллагааг хангах хамгаалах хэрэгслүүд нь орчин үеийн технологийн хөгжлийг даган шинэчлэгдэн өөрчлөгдсөөр байна. Дэлхийн хөгжингүй улс орнуудын зэвсэгт хүчинд эдгээр төрлийн техник хэрэгсэл хурдацтайгаар нэвтэрч, шинэ шинэ зэвсэглэл, техник олноороо зах зээл дээр гарч, өрсөлдөх болсон нь тэдгээрийн чанар чансааг сайжруулахад түлхэц болсоор байгаа юм.

Нэгэнт цацраг, хими, биологи, цөмийн болон аюултай хорт бодисыг илрүүлэх, тэдгээрийн хор уршгийг арилгахад ашиглах техник хэрэгсэл, ослын голомтод ажиллах бие бүрэлдэхүүний аюулгүй ажиллагааг хангах, хамгаалах асуудал нь өнөөгийн цэргийн шинэчлэлийн тулгамдсан асуудлын нэг болж байгааг анхааран дэлхийн зарим орнуудын тэргүүлэх компаниудын үйлдвэрлэн нийлүүлж буй орчин үеийн зарим төрлийн дээрх чиглэлийн шинэ техник хэрэгслийн тоймыг хүргэхээр зорьж бэлтгэлээ. Цацраг, хими, биологийн орчин үеийн зарим техник, зэвсэглэлийн талаар дараах хоёр үндсэн хэсэгтэйгээр авч үзлээ. Үүнд

**Нэг. Илрүүлэх техник хэрэгсэл.**

**1.1. Хорт бодисыг илрүүлэх хэрэгсэл.**

Төрөл бүрийн аюултай хорт бодисыг илрүүлэх багаж хэрэгслийг үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлдэг олон улсын аж ахуйн нэгжүүд цөөнгүй байдгийн дотроос бүтээгдэхүүний чанар, шинэлэг технологи зэрэг дэвшилтэт талаараа тэргүүлэгч зарим нэг компанийн талаар товч танилцуулж байна.

Эдгээр компаниуд нь иргэний зориулалттай илрүүлэх багаж хэрэгслийг гол төлөв үйлдвэрлэдэг ч цэргийн захиалгаар зарим төрлийн илрүүлэх зориулалт бүхий багаж, хэрэгслийг үйлдвэрлэн нийлүүлдэг юм. Эдгээр компаниудын дотроос ХБНГУ-ын “Айрсинс аналитикс”, Финляндын “Энвироникс”, Францын NBC-SYS компанийн бүтээгдэхүүнүүд шаардлагад илүүтэй нийцэж байгаа гэж мэргэжилтнүүд үзэж байна.

“Айрсинс аналитикс” /Airsense Analytics GmbH/ (<http://www.airsense.com/de>) нь аюултай хорт бодисыг илрүүлэх, тодорхойлох, анализ хийх болон хүнсний бүтээгдэхүүний дээжид шинжилгээ хийх тоног төхөөрөмжөөр дагнадаг компани юм. Энэ компани нь өөрийн улсдаа төдийгүй олон улсад үйл ажиллагааг явуулдаг бөгөөд БНХАУ-ын Ensoul Technology Ltd, Rivers Enterprise Co. Ltd зэрэг компаниудтай хамтран ажилладаг.



Зөөврийн хэрэгсэл Gas Detector Array 2      Хэт ягаан туяаны хий тодорхойлогч SIGIS2      Дээж сорил авах багаж

Финляндын “Энвироникс” /EnviroNics / (<http://www.enviroNics.fi>) нь химийн хорт бодисыг илрүүлэх зориулалт бүхий төрөл бүрийн төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгслийг үйлдвэрлэдэг зах зээлд нийлүүлдэг компани юм. “Энвироникс” нь:

- Зөөврийн химийн хорт бодисыг илрүүлэгч,
- Химийн гар илрүүлэгч,
- автомашины химийн хорт бодисыг илрүүлэх цогцолбор,
- усан тээврийн хэрэгслийн химийн хорт бодисыг илрүүлэх цогцолбор,
- химийн хорт бодисыг илрүүлэх суурин цогцолбор,
- Нэгдсэн олон төрлийн мэдрэх цогцолборыг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэн,
- Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээг тус тус эрхэлдэг.



Гар илрүүлэгч ChemPro@100i      Зөөврийн химийн хорт бодисыг илрүүлэгч ID100 - Portable FTIR Gas Analyzer



M90-D1-C Chemical Warfare Agent Detector

Урьдчилан мэдээлэх хэрэгсэл /Bio100 Early Warning System/



Биологийн аюулыг илрүүлэх систем /ENVI Assay System/  
Францын NBC-SYS-ийн бүтээгдэхүүнээс танилцуулья. Үүнд:



Саа мэдрэлийн үйлчилгээтэй хорт бодисыг илрүүлэх иж DETINDIV



Хорт бодисын дуслыг илрүүлэх цаас PDF1



Хорт бодисыг илрүүлэгч CHAMELEON



Хорт бодисыг илрүүлэгч SNRMAIR



Хорт бодисыг илрүүлэгч SAFEAIR



Хорт бодисыг илрүүлэгч KDTC

## 1.2. Цацрагийн түвшинг хянах, нэг бүрийн тунг хянах техник хэрэгсэл.

### Гамма ба нейтроны цацрагийн түвшинг хянагч багажууд нь цацрагийн түвшин тогтоосон хэмжээнээс хэтэрсэн үед гол төлөв зарлан мэдээлэх дохио өгөх зориулалттай. Ийм төрлийн багаж, хэрэгсэл үйлдвэрлэдэг улс орнууд олон байдгийн дотроос “Мирион Техноложис” /Mirion Technologies/ компанийн багаж төхөөрөмжүүд нэлээд өргөн хэрэглээтэй ажээ. Энэ компани нь цацрагийг илрүүлэх, тодорхойлох, хянах зориулалт бүхий бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг бөгөөд Хойт Америк, Европ, Азид 13 салбартай, 700 гаруй ажилтантай. <http://www.mirion.com/>.

“Мирион Техноложис”-ийн багаж хэрэгслийн дотор цацрагийн түвшинг хэмжих, газар орны цацрагийн фоныг хянах багаж хэрэгсэл олон байна. Эдгээрийн заримыг доорх хүснэгтэд үзүүлье.

“Мирион Техноложис”-ийн багаж хэрэгслийн дотор цацрагийн түвшинг хэмжих, газар орны цацрагийн фоныг хянах багаж хэрэгсэл олон байна. Эдгээрийн заримыг доорх хүснэгтэд үзүүлье.



Цацрагийн түвшингийн дохиолоч - GIM 201K



Цацрагийн түвшингийн дохиолоч - GIM 204K



Нэг бүрийн дохиолоч - DMC 2000S



APA 91 – дээж цуглуулах сав



Бетта цацрагийн хэмжигч GMP 11-15 Beta Probes



Гамма цацраг хэмжигч GMP-12H-12L Gamm Probes

Эдгээр багаж хэрэгслийн байдлаас харахад багаж, мэдрэх хэрэгслийн ажиллах зарчмын хувьд өөрчлөлт ороогүй ч, харин технологийн хувьд хагас дамжуулагч, микросхем дээр тулгуурлан хийсэн байгаа нь багажны овор хэмжээ багасаж, ажиллагаа нь найдвартай, хэмжилтийн үр дүн илүү нарийвчлалтай болох боломжийг бүрдүүлсэн байна.

Энэ компани нь төрөл бүрийн нэг бүрийн дозиметр үйлдвэрлэж, зах зээл дээр гаргадаг байна. Тухайлбал: нейтроны CR39 Neutron, нүдний, ялтаст, хурууны, бөгжин гэх мэт зэрэг олон төрлийн бага оврын дозиметруудыг үйлдвэрлэж байна. Үүнд:



## Хоёр. Нэг бүрийн болон нийтийн хамгаалах хэрэгсэл

### 2.1. Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл.

Энэ төрлийн хамгаалах хэрэгслийн үйлдвэрлэлтээр дэлхий дээр олон компани байдгийн хамгийн орчин үеийн техник, технологийн шаардлага хангадаг гэж мэргэжилтнүүд үзэж байгаа Канадын “Айрбосс-дифенз”, Францын NBC-SYS компанийн бүтээгдэхүүнийг танилцуулахаар шийдлээ.

“Айрбосс-дифенз” компани (<http://airbossdefense.com>) нь хими, биологи, цацраг, цөмийн хэрэгслээс хамгаалах нэг бүрийн хэрэгслийг үйлдвэрлэдэг байна. Мөн түүнчлэн гал түймэртэй тэмцэх болон хэт хүйтэн нөхцөлд үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай гутал үйлдвэрлэдэг.



NBC-SYS компани (<http://www.nbc-sys.com>) нь үй олноор хөнөөх зэвсгийн төрөл бүрийн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэдэг, өөрийн бүтээгдэхүүнийг өөрийн орны төдийгүй дэлхийн олон орны зэвсэгт хүчний хэрэгцээнд нийлүүлдэг байна.



Газ эсрэгүцэгч  
ARF-A



Юудэн  
EVATOX



Шүүгч бортого  
CFF3/CFF4



Респиратор

## 2.2. Нийтийн хамгаалах хэрэгсэл.

Нийтийн хамгаалах хэрэгслүүдээс Финляндын “Темет” компаний (<http://www.temet.com/>) бүтээгдэхүүнийг дэлхийн стандартад нийцсэн байдаг гэж олон улсын энэ талын бүтээгдэхүүнийг хэрэглэдэг хүмүүс үнэлсэн байдаг байна. Ийм бүтээгдэхүүнийг Францын NBC-SYS компани ч хийж, НАТО-гийн болон бусад орнуудын хэрэгцээнд нийлүүлдэг байна

Финляндын “Темет” компани



Зөөврийн шүүгч төхөөрөмж  
FU-130



Нийтийн зориулалтын шүүгч FU-340 НАС



Хамгаалах цогцолбор LSS-80

Францын NBC-SYS нь машины, хоргодох байр болон усан онгоцны нийтийн хамгаалах хэрэгслийг үйлдвэрлэдэг байна. Үүнд:

Тусгай цэвэрлэгээний камер



Машины төхөөрөмж  
LECLERC - 180 м³/ш



Машины төхөөрөмж  
AFU 24m³/h



Машины төхөөрөмж  
AFU 90m³/h Compact



Зөөврийн төхөөрөмж  
AFU 300



Зөөврийн төхөөрөмж  
AFU 600

## Санал дүгнэлт.

1. Өнөөгийн аюулгүй байдлын нэн тодорхойгүй нөхцөлд химийн хорт бодис, цацрагийн хор хөнөөл үзүүлэх магадлал буураагүйгээр барахгүй, харин ч террористууд өөрийн зэвсгийн арсеналдаа үй олноор хөнөөх зэвсгийг оруулах санаархлаа хэрэгжүүлэхийн төлөө улайран буй байгаа нь энэ төрлийн зэвсэгт халдлага, үйлдвэрлэлийн ослоос иргэд, цэргийн албан хаагчдыг найдвартай хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх шаардлагыг улам бүр хүчтэй болгож, энэ нь дэлхийн улс орнуудын Зэвсэгт хүчинд тулгарч буй нэгэн онцгой сорилт болсоор байна.

2. Дэлхийн олон улсын зэвсэгт хүчнүүд дээрх шаардлагатай уялдуулан өөрийн энэ чиглэлийн хүч хэрэгслийг боловсронгуй болгох, цацраг, хими, биологийн хордолт, хөнөөлийг урьдчилан илрүүлэх, түүнээс сэргийлэх, иргэд, цэргийн албан хаагчдаа хамгаалах зориулалт бүхий орчин үеийн хэрэгслийг зэвсэглэлдээ нэвтрүүлэх асуудалд ихээхэн анхаарал хандуулах болсон нь бодитойгоор тулгарч болзошгүй аюулаас хамгаалах арга хэмжээг урьдчилан төлөвлөж хэрэгжүүлж буй үйл явц гэж үзэх үндэслэлтэй юм. Нөгөө талаар дээрх төрлийн шинэ зэвсэг, техник хэрэгслээр хангаж эхлэх нь тэдгээрийг хэрэглэх арга зүйд зарчмын өөрчлөлт оруулах үндэслэл болдог учир, бие бүрэлдэхүүнийг сургах үйл явцад нэлээд шинэчлэл хийх шаардлагыг бий болгож байгаад ч анхаарах хэрэгтэй байгаа болно.

3. Техник хэрэгслийн хөгжил дэвшилд орчин үеийн мэдээллийн техник хэрэгслийн хөгжил, хөгжилтэй орнуудын технологийн дэвшил ихээхэн нөлөөтэй байгаад анхааран, манай Зэвсэгт хүчинд хэрэглэгдэж буй дээрх төрлийн техник хэрэгсэл нь технологийн хувьд үлэмж хоцрогдох болсныг анхааралдаа авах хэрэгтэй болов уу. Олон улсын даяаршлын эрин үед шинэ төрлийн чанар, үзүүлэлт сайтай зэвсэглэл, техник хэрэгслийг өөрийн оронд ойрын зах зээлээс боломжийн үнэ өртгөөр шууд худалдан авч нийлүүлэх бололцоотой болсон давуу талыг ч орхигдуулж боломгүй санагдаж байна.

4. Хими, биологи, цацраг ба цөмийн аюулыг илрүүлэх, түүнээс бие бүрэлдэхүүнийг хамгаалах асуудал нь зөвхөн цэргийн ажиллагааны үед тохиолдох бус, хуулиар иргэдийг дээрх аюулаас хамгаалах үүрэг Зэвсэгт хүчинд ноогдох болсон өнөө үед энэ чиглэлийн шинэ технологи, шинэ техник хэрэгслийг зайлшгүй нэвтрүүлэх бодит хэрэгцээ байгааг COVID-19 цар тахал, Орос украины дайнаас авхуулаад ихээхэн харуулж байгаа бөгөөд мөн уул уурхайн салбар хөгжин мөнгөн ус, химийн бодис ихээр хэрэглэх болсон гэх мэт асуудлууд ихээр гарсаар байгаад дүгнэлт хийх хэрэгтэй гэж үзэж байна. Иймд Зэвсэгт хүчний цацраг, хими, биологис хамгаалахын цэргийн чадавхыг нэмэгдүүлэх техник, багаж хэрэгслийн шинэчлэлийг нэн даруй эхлэх нь зүйтэй гэж үзэж байна.



## Ашигласан материал:

1. <http://www.environics.fi>
2. <http://www.nbc-sys.com>
3. <http://www.temet.com/>
4. <http://airbossdefense.com>
5. <http://www.mirion.com/>
6. <http://www.Dod defense.gov>
7. Radiation chemistry from Basics to Applications in material and life Sciences I.V Berezin
8. Радиоактивность и радиационная безопасность А.И. Гуськов.
9. Токсикология химического оружия В.А. Степанов
10. Стокхолмын олон улсын энх тайвны судалгааны хүрээлэн – SIPRI year book 2023 он



## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ БИО АЮУЛГҮЙ БАЙДАЛД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛД

**Х.АЛТАНШАГАЙ** /ҮБХИС-ийн докторант/

**Түлхүүр үг:** Био аюул, үндэсний аюулгүй байдал, өвчний тархалт, эрсдэл

**Key words:** Biohazards, national security, disease outbreaks, risks

### **Оршил.**

Био аюулын үед үндэсний био аюулгүй байдлыг хангах шаардлагатай. Ялангуяа үүнийг үндэсний аюулгүй байдалд нөлөөлж буй талаас нь асуудлыг авч үзэх, тодорхойлох судалгааны ажил эрчимжих хэрэгтэй байгаа юм. Иймээс тус өгүүлэлд Монгол Улсын үндэсний био аюулгүй байдлыг хангахад тулгамдаж буй зарим асуудлыг тодруулахаар зорилоо.

Био аюулгүй байдлын үндэсний удирдлагын чадавхыг цогцоор нь сайжруулахад шинжлэх ухаан, технологийн дэмжлэг үзүүлэх явдал чухал юм.

COVID-19 өвчний дэгдэлтийн үед амьдралын аюулгүй байдал, эрүүл мэндийг зохицуулах, дайчилгаа, урьдчилан сэргийлэлт, хяналт, нээлттэй, ил тод байдлын системийг урьдчилан боловсруулах хэрэгтэй. Нөхцөл байдлыг эргэн харж, хүний аюулгүй байдлыг хангах, үндэсний аюулгүй байдлыг хангах, улс орны урт хугацааны тогтвортой байдлыг хадгалах үүднээс био аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын системийн бүрэлдэхүүнд оруулах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэж байна. Үндэсний био аюулгүй байдлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналт, засаглалын тогтолцоог бий болгож, үндэсний аюулгүй байдлын засаглалын чадавхыг цогцоор нь сайжруулахад анхаарах цаг болжээ. Сүүлийн жилүүдэд Монгол Улс болон олон улсад тохиолдсон нөхцөл нь үндэсний аюулгүй байдлын ерөнхий үзэл баримтлалын онолын үндэслэлийг шинээр харах, үндэсний аюулгүй байдлын тогтолцооны загварыг сайжруулах, үндэсний био аюулгүй байдлын засаглалын чадавхыг бүрдүүлэхийн чухлыг ойлгууллаа.

Үндэсний био аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын чухал хэсэг болохоос аргагүй болж байна. Био аюулгүй байдалд голчлон шинээр гарч ирж буй халдварт өвчин, биологийн нөөц, хүний генетик нөөцийн аюулгүй байдал, био технологийг буруу

ашиглах, гадны организмын довтолгоо, био терроризмын дайралт, лабораторийн био аюулгүй байдал болон бусад өргөн хүрээтэй биологийн холбоотой эрсдэлүүд зэргийг хамааруулж болно. Био аюулгүй байдал нь экологийн аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдалд шууд нөлөөлдөг бөгөөд үндэсний болон дэлхийн аюулгүй байдлын чухал хэсэг болох нь нэгэнт тодорхой болжээ.

Манай улс био аюулгүй байдлын олон эрсдэлт хүчин зүйлтэй тулгарч, томоохон бэрхшээлтэй учирч байна. Үүнд “нэгдүгээрт нийслэл хотдоо хүн амын сууршил ихтэй байгаа нь био аюулгүй байдлын өндөр эрсдэл дагуулж байна. Ялангуяа манай улсын хотжилт удаан хөгжиж байгаатай холбогдуулан хүн амын төвлөрөл, эрчимтэй хөдөлгөөн нэг газарт байгаа нь био аюулгүй байдлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хянахад ихээхэн бэрхшээлтэй болж байна. Хоёрдугаарт, хүн амын эрүүл мэнд, био аюулгүй байдлын салбарт шинжлэх ухаан, технологийн шинэчлэлийн чадавх дутагдалтай байгаа бөгөөд био аюулгүй байдалд нөлөөлөх зарим гол цөм технологи, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн дутагдал нь үүнийг хязгаарлаж байна. Гуравдугаарт, биологи, техник технологийн хурдацтай хөгжил нь зүй бусаар ашиглагдах, ёс зүйн эрсдэлтэй байж болзошгүй юм. Дөрөвдүгээрт нь стандарт бус биологийн нөөцийн менежментээс үүдэн гарч болзошгүй эрсдэл юм. Бид эдгээр эрсдэл, бэрхшээлтэй тулгараад био аюулгүй байдлын үндэсний засаглалын тогтолцоо, чадавхыг шинэчлэх ажлыг хурдасгах, хүмүүсийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, улс орны язгуур ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн тогтвортой байдал, үндэсний аюулгүй байдлыг хадгалах”<sup>1</sup> шаардлагатай байна.

Био аюулгүй байдлын чиглэлээр манай улсын шинжлэх ухаан, технологийн инновацийн

<sup>1</sup> Орхончимэг.Х. Үндэсний био аюулгүй байдлын онол, арга зүйн үндсэн асуудлууд.УБ.,2022.т.19



чадавхын байдлыг тодорхойлох нь чухал. Цаашид био аюулгүй байдлын салбарын шинжлэх ухаан, технологийн шинэчлэлд өндөр ач холбогдол өгч, хүний аюулгүй байдал, био аюулгүй байдлын салбар дахь шинжлэх ухаан, технологийн томоохон ололтууд нь үндэсний аюулгүй байдлын хамгаалалтын нэг чухал үндэс болно гэдгийг зөв тооцоолох хэрэгтэй. Манай улсын био аюулгүй байдлын чиглэлээрх шинжлэх ухаан, технологийн инновацийн чадавх сул, асуудлууд их байна.

Шинжлэх ухааны судалгааны хүчний хуваарилалтыг системчлэх түвшинг дээшлүүлэх шаардлагатай байна. Одоогийн байдлаар улсын био аюулгүй байдлын чиглэлээр хийсэн эрдэм шинжилгээний ажил нь эрүүл мэнд, үндэсний батлан хамгаалах судалгаа, шинжлэх ухааны байгууллага, хүрээлэн, их сургууль, аж ахуйн нэгжүүдэд хэсэгчилсэн, хүрээ бага, системгүй явагдаж байна. Системүүдийн хоорондын уялдаа холбоо сул, интеграцийн түвшин өндөр биш холбогдох судалгааны үндсэн үр дүн оношлогоо, эмчилгээний хэрэглээнд шилжих байдал жигд бус байна. Шинжлэх ухаан, технологийн хөрөнгө оруулалтыг эрс сайжруулах шаардлагатай. Манай улсын эрүүл мэндийн салбарт хийсэн судалгаа, хөгжлийн хөрөнгө оруулалт ба дэлхийн хүчирхэг гүрнүүдийнхтэй харьцуулахад асар их ялгаа бий. Шинжлэх ухааны судалгаанд оруулсан хөрөнгө оруулалт хангалтгүй байгаа нь манай улсын энэ чиглэлийн судалгаа, хөгжлийн чадавх сул байгаад нөлөөлж байна.

Манай улсын био аюулгүй байдлын технологийн шинэчлэл, чадавх дахь сул талуудыг харгалзан үндэсний аюулгүй байдлын тогтолцоог боловсронгуй болгох, шинжлэх ухааны судалгааны чадавхыг нэгтгэх, хэтийн төлөвлөлтийг удирдан чиглүүлэхэд анхаарлаа хандуулах ёстой. Технологийн гол цөм судлалыг үндэсний био аюулгүй байдлыг дэмжих шинжлэх ухаан, технологийн судалгааны системийг бий болгоход чиглүүлэхээс аргагүй юм.

Био аюулгүй байдлын чиглэлээр шинжлэх ухааны судалгааны хүчнүүдийн интеграцийг бэхжүүлж, системчилсэн байдлыг оновчтой болгоход судалгааны гол асуудал оршиж байна. Үндэсний био аюулгүй байдал, ялангуяа халдвараас урьдчилан сэргийлэх, хянах технологи нь вирус судлал, халдварт өвчин, нийгмийн эрүүл мэндийн менежмент,

генетик, фармакологи, сэтгэл судлал гэх мэт олон салбарыг хамардаг бөгөөд эмнэлзүйн оношлогооны өгөгдөл, нөөцийг шаарддаг. Тиймээс системтэй хариу арга хэмжээ авах чадварыг сайжруулахын тулд үндэсний стратегийн зорилтуудад био аюулгүй байдал тэргүүлэх байр сууриа олж, үндэсний шинжлэх ухаан судалгааны гол системүүдийн зангилаа болж биотехнологи, анагаах ухаан, эрүүл мэнд, эмнэлгийн тоног төхөөрөмжийн интеграцийг хурдасгах шаардлагатай байна. Үндэсний эмнэлзүйн анагаах ухааны судалгааны төвүүд болон салбар дундын, томоохон хэмжээний хамтын ажиллагаа, инновацийн үндсэн гүйцэтгэлүүдийг шаардлагатай үед хэрэглэх цогц системийг байгуулах нь тулгамдсан асуудал болно.

Шинэ нөхцөл байдалд үндэсний био аюулгүй байдлын систем байгуулах, технологийн дэмжлэг үзүүлэх улс орны томоохон стратегийн хэрэгцээнд дасан зохицуулахын тулд үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, био аюулгүй байдлын чиглэлээр шинжлэх ухаан, технологийн судалгааны ерөнхий байгуулалтыг бий болгох нь зайлшгүй байна. Үндэсний био аюулгүй байдлын засаглалын тогтолцоо, чадавхыг сайжруулах, улс орны стратегийн шинжлэх ухаан, технологийн хүч чадлыг бүрэн дүүрэн тогтоохын тулд:

“Нэгдүгээрт, дайны нөхцөлд хариу арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг харгалзан үзэх, био аюулгүй байдлын уялдаа холбоо, шийдвэр гаргах ажлын механизм, тархвар судлалын үндэсний шинжлэх ухаан, технологийн судалгааны шинэ механизмыг бий болгох.

Хоёрдугаарт, холбогдох шинжлэх ухаан судалгааны хүчний интеграцийг бэхжүүлж, био аюулгүй байдлын судалгааны системийг сайжруулах.

Гуравдугаарт, био аюулгүй байдлын үндэсний лабораторийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, үндэсний био аюулгүй байдлын систем дэх P3, P4 лабораторийн гүйцэтгэх үүргийг тодруулж, био аюулгүй ажиллагааны лабораторийн систем, өвчний үүсгэгч, халдвар ба эмгэг төрүүлэгч механизм, халдварын эсрэг урьдчилан сэргийлэлтийг сайжруулах

Дөрөвдүгээрт, био аюулгүй байдлын судалгаа, сургалтыг бэхжүүлэх явдал юм. Халдварт өвчний чиглэлээр эрдэм шинжилгээний суурь чадавхыг бэхжүүлэх урт хугацааны механизмыг боловсронгуй болгож,



өндөр тархалттай, гэнэтийн халдварт өвчнөөс сэргийлэх, үүрэг хариуцлагыг тодорхой болгох

Тавдугаарт, био аюулгүй байдлын чиглэлээр биологийн нөөцийн менежментийн тогтолцоог бэхжүүлэх, био аюулгүй байдлын чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх явдал юм.”<sup>2</sup>

Үүнийг эцэст нь дүгнэхэд Монгол Улс үндэсний аюулгүй байдлыг хангах, улс орны урт хугацааны тогтвортой байдлыг хангах, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс био

<sup>2</sup> 白春礼 . 为全面提高国家生物安全治理能力提供有力科技支撑. 中国科学院.2020/4/21. Орхончимэг.Х. Орхончимэг.Х. Үндэсний био аюулгүй байдлын онол, арга зүйн үндсэн асуудлууд. УБ.,2022.т.24-25

аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд оруулах шаардлага тулгарч байна гэж үзэж болох юм. Био аюулгүй байдлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хянах, удирдах тогтолцоог бий болгосноор үндэсний био аюулгүй байдлын засаглалын чадавх сайжрана. Сүүлийн хэдэн жилийн олон нийтийг хамарсан халдварт өвчний тархалтын үйл явцаас харахад манай улс эрсдэл тохиолдоход хамгаалах нөөц боломж сул, энэ талын судалгаа шинжилгээ дутмаг байгааг харууллаа. Иймээс Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд бо аюулгүй байдлын асуудлыг оруулах нь шаардлагатай байгаа болно.

#### Ашигласан материал:

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. <https://legalinfo.mn/mn/detail/6163>
2. Орхончимэг.Х. Үндэсний био аюулгүй байдлын онол, арга зүйн үндсэн асуудлууд. УБ., 2022
3. 白春礼 . 为全面提高国家生物安全治理能力提供有力科技支撑. 中国科学院.2020/4/21

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД АШИГТ МАЛТМАЛЫН ОЛБОРЛОЛТ, БОРЛУУЛАЛТЫН ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

**Б.БЯМБАСАЙХАН** /ҮБХИС-ийн магистрант/  
**Б.ЭРДЭНЭЧИМЭГ** /Доктор, профессор/

**Түлхүүр үг:** Ашигт малтмалын тухай хууль, эдийн засгийн аюулгүй байдал, ашигт малтмалын олборлолт, борлуулалт, байгалийн баялаг, уул уурхайн салбар, Баялагийн сан

**Key words:** Minerals law of Mongolia, economic security, mineral extraction and sales, natural resources, mining sector, National Wealth Fund

### Хураангуй:

Монгол Улсаас экспортод гарч буй эрдсийн баялгийн тоо хэмжээ, үнэ цэнтэй харьцуулахад дотогшоо чиглэсэн валютын орлого чамлахаар бага байгаа хэдий ч дам утгаар эрдсийн баялгийн нөлөөгөөр орж ирж буй их хэмжээний гадаадын зээл, хөрөнгө оруулалт нь жижиг зах зээл бүхий манай орны эдийн засагт хүчтэй нөлөөлсөөр байна.

Монгол Улсын эдийн засагт ашигт малтмалын салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин улам бүр өсөн нэмэгдсээр сүүлийн жилүүдэд тэргүүлэх салбар болж, ДНБ-ний 20 гаруй хувь, аж үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүний 70 гаруй хувь, экспортын нийт бүтээгдэхүүний 90–80 хувийг дангаараа үйлдвэрлэх болж байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл<sup>1</sup> нь эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгоход орших бөгөөд түүнчлэн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүлнэ гэж заасан байдаг.

Манай орны хувьд “голланд өвчин” –ний шинж тэмдэгүүд илэрдэг хэдий ч боловсруулах салбарын уналт нь өвчний шинж тэмдэг илрэхээс өмнө буюу –1990ээд оны эхэн үеийн өмч хувьчлалаас эхтэй байдаг. Харин тус өвчний нөлөөгөөр боловсруулах салбар эргэн сэргэхэд

хүндрэлтэй, эдийн засаг гадаад шоконд хэт өртөмхий гэж тайлбарлах нь илүү зохистой юм<sup>2</sup>.

Уул уурхай, ашигт малтмал нь хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбаруудын хамт Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдалд нэн чухал ач холбогдолтой ба эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч юм.

Эдийн засагчдын зүгээс төсвийн орлого уул уурхайгаас өндөр хамааралтай байгаа тул орлогыг бүрдүүлэх төлөвлөгөө чухал гэж онцолж байна.

Байгалийн баялагтай орнууд амжилттай хөгжиж чаддаггүй олон төрлийн шалтгаанууд байдаг хэдий ч, нийтлэг 2 шалтгаан бий. Эхнийх нь хэлбэлзэлтэй, цаг хугацааны тодорхой үед л орж ирдэг нөөцийн орлогыг зөв удирдаж, захиран зарцуулахад хүндрэл учирдаг. Хоёрдох нь, засаглал хангалттай сайн бүрдээгүй явдал буюу нөөцийн орлогыг богино хугацааны зарцуулалтын дарамтаас хамгаалж, урт хугацааны хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн стратегийг хэрэгжүүлэхэд чиглүүлж чаддаггүй явдал юм<sup>3</sup>.

Манай улсын хувьд энэ хоёр шалтгаан хоёулаа “асуудал” болж байна. Иймд байгалийн баялагт тулгуурлан амжилттай хөгжихийн тулд ашигт малтмалын нөөцийн орлогыг зохистой хуримтлуулж, зарцуулах, тухайн улсын засаглал, институцийг бэхжүүлэх явдал туйлын чухал юм. Үүний тулд нэгд; нөөцийн орлогыг нэмэгдүүлэх, тогтвортой байх татварын зохистой тогтолцоог бүрдүүлэх (шаардлагатай реформыг хийж, дараагийн том ордууд дээр

<sup>2</sup> Ө.Мөнхшиг. “Үндэсний аюулгүй байдлыг хангахад уул уурхайн салбарын үзүүлэх нөлөөлөл” аюулгүй байдлын ухаанаар магистрын зэрэг горилсон ажил. 2021 он

<sup>3</sup> Мөн тэнд

<sup>1</sup> Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2 дугаар зүйл.



мөрдүүлэх), хоёрт; нөөцийн орлого, түүний зарцуулалтыг ил тод байлгах, нөөцийн орлогыг баялгийн санд хуримтлуулж, зарцуулах төсвийн дүрмийг чанд мөрдөх, өнөөдөр хэрэглэхээс илүүтэй ирээдүйн тогтвортой өндөр өсөлтийг бий болгох хөрөнгө оруулалт болгох, гуравт; төсвийн сахилга батыг хангаж хяналт тавих, засаглалыг бэхжүүлж, улс төрөөс хараат бус байх эрх зүйн орчин хэрэгжилтийг бүрдүүлэх шаардлагатай юм.

Ашигт малтмал, эрдэс баялгийн олборлолт нь улс оронд эдийн засгийн хувьд үр өгөөжөө өгөх боловч орлогын тэгш бус хуваарилалт, улс төрийн буруу бодлогын улмаас үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг.

Олон улсын туршлага, сургамжаас харахад улс орны аюулгүй байдалд дараах эрсдэлүүд тулгарч болзошгүй байдаг байна. Үүнд<sup>4</sup>:

- Стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялгийг ашиглах, хяналтандаа байлгах зорилго бүхий байгалийн баялгаас үүдэлтэй зөрчил, сөргөлдөөний эх сурвалж нь баялгийн шударга бус хуваарилалт байдаг байна. Хэрэв тухайн улсын эдийн засаг нэг гол төрлийн бүтээгдэхүүнээс хамааралтай байдаг бол тухайн улсад зэвсэгт мөргөлдөөн гарах магадлал нэмэгддэг байна.

- Орлогын тэгш бус байдал нь нийгмийн тогтворгүй байдал, зөрчлүүд, хүчирхийллийн шалтгаан болдог бөгөөд баян ядуугийн ялгаа ихэсдэг. Сүүлийн жилүүдэд зарим стратегийн шинжтэй эрдэс, баялгийн нөөц хомсдож, үнэ огцом өсөн нэмэгдэж байгаа нь өрсөлдөөнийг улам ширүүсгэж сөргөлдөөний хэлбэрт оруулж байна.

- Манай улсын уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж, стратегийн ордуудыг ашиглаж буй өнөө үед үндэсний болон гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг аль алиныг нь эрхэмлэн тэнцвэржүүлж, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан тогтвортой хамтын ажиллагааг бий болгох нь чухал. Тогтвортой хамтын ажиллагаа нь хөрөнгө оруулагчийн болон үндэсний эрх ашиг хоёрын тэнцвэрийг хангасан үед бий болдог ба тэнцвэр алдагдвал зөрчил үүсдэг байна.

<sup>4</sup> Д.Батмагнай. “Ашигт малтмалын бодлого, үйл ажиллагааны үндэсний аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийн судалгаа”. Аюулгүй байдлын ухаанаар магистрын зэрэг горилсон ажил. Уб., 2023 он

- Төр засаг нийгэмдээ хэт их зүйлийг амлаж, уул уурхайн ашгаас хүртэх хүлээлт үүсгэдэг бөгөөд амлалт, нийгмийн хүлээлт хоёрын зөрүү их байх тусам зөрчил аажим үүсч, иргэдийн бухимдал нэмэгдэж, сөргөлдөөнд огцом хүргэх эрсдэлтэй.

- Байгалийн нөөц ихтэй улсын хувьд бүс нутгийн геостратегийн ашиг сонирхлын солбилцол болж, түүхий эдийн хавсарга, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын сөргөлдөөний талбар болох эрсдэлтэй бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтыг хэт дэмжин ард иргэдийнхээ амьдралыг доройтуулах эсвэл үндэсний эрх ашгаа хэт дөвийлгөж, гадны нөлөө бүхий улс орнуудын эрх ашгийг үл харгалзах аль аль нь зөрчил үүсгэх түгээмэл нөхцөл болдог байна.

- Уул уурхайн үйлдвэр хүрээлэн буй орчинд хүчтэй, олон талын нөлөө үзүүлдэг үйлдвэрийн тоонд ордог. Ашигт малтмал олборлолтонд газар нутгийг идэвхитэй ашиглах нь газрын гадаргууг сүйтгэх, уулын боловсруулалт, уулын газар шорооны ажил, голын гидрологи горим алдагдах, хөрсний бохирдол, гадаргуун болон гүний ус бохирдох, экологийн системийн бүрэн бүтэн байдал алдагдах, байгалийн тогтоцод эвдрэл гарах зэрэг таагүй нөлөө үзүүлдэг.

Гадаад улс орнуудын туршлага, сургамжаас харахад тэд өөртөө ашигтай нөхцөл байдлыг үүсгэхийн тулд байгалийн баялагтай улс орнуудад улс төрийн болон санхүү эдийн засгийн шахалтуудыг үзүүлдэг. Энэ нь манай оронд ч мөн адил үйлчилж, эх орны минь байгалийн баялагт эзэн суухыг хүсэж, төрөл бүрийн аргыг хэрэглэж байна.

Тухайлбал, Монгол Улсын Их Хурлаар Ашигт малтмалын тухай хуулийг батлахад Дэлхийн банкны болон бусад гадны экспертүүдээс зөвлөгөө өгөх нэрийн доор олон улсын стандартад нийцүүлэн хуулийн төслийг боловсруулж, өөрсдөдөө ашигтай нөхцөлөөр “тархи угаах” замаар батлуулж чадсан явдал юм. Мөн түүнчлэн манай улсын газар нутгийг өөрийн орны, эсвэл олон улсын зах зээлд хувьцаа гаргах маягаар Монгол Улсын хуулийн дагуу олон улсын конвенцоор батлагдсан хэм хэмжээнд хууль эрх зүйн дайны технологийн аргаар геостратегийн бодлого хэрэгжүүлэн баталгаажуулж авч байна.



Энэ үйл ажиллагаа нь<sup>5</sup>:

- Олон улсын конвенцуудад Монгол Улс нэгдэн орсон тохиолдолд үүсч болох эрсдлийг үндэсний аюулгүй байдлын бодлогын хүрээнд анхааралдаа авах асуудалд Монгол Улс хайхрамжгүй хандсан.

- Ашигт малтмалын тухай хуулийг Үндсэн хууль болон үндэсний аюулгүй байдлын бодлоготой нягт уялдуулж хийгээгүйн зэрэгцээ гадны зөвлөхүүдийн саналыг сайн нягтлаагүй, олон улсын стандартад нийцүүлэх нэрийн дор өөрсдөө мэдэхгүй асуудлуудыг шууд хуулбарлах маягаар хэрэгжүүлсэн.

- Ашигт малтмалын хуулинд нэг хуулийн этгээд болон хувь хүнд олгож болох лицензийн тоог хязгаарлаагүй.

- “Гадны хөрөнгө оруулалтанд таатай орчин бүрдүүлэх” гэдэг зөвхөн төлөвшсөн, хууль эрх зүйн сайн хамгаалалттай хөгжингүй орнуудад хэрэгждэг технологийг манай оронд буруу замаар хэрэгжүүлж, үндэсний аюулгүй байдлыг өндөр эрсдэлд оруулсан.

- Монгол Улс олон улсын гэрээ конвенцид захирагдах тул гарцаагүй байдалд оруулах стратегийг гадны хөрөнгө оруулалттай компаниуд цаанаасаа “тусгай” дэмжлэгтэйгээрээ хэрэгжүүлсэн байдлуудаар илэрч байна.

Монгол Улс үүнээс болж их өрөнд орох, эсвэл үндэсний аюулгүй байдлаа “өндөр эрсдэл”-д оруулах асуудалтай нүүр тулахгүйн тулд маш ухаалаг бодлого явуулах нь зүйтэй юм.

Буцалтгүй тусламжийн хэлбэрээр дэлхийн олон нийт нэг нэгэндээ туслах хамтын ажиллагааны хэлбэр байгаа нь сайшаалтай хэрэг хэдий ч нөгөө талаараа энэ нь тухайн улсын эдийн засгийг унагаах технологи юм. Энэхүү технологийн гол үүрэг бол тухайн салбарыг босгох тал

дээр биш, харин цааш нь хөгжүүлэхгүй тал дээр бага хэмжээгээр амин тариа хийх замаар явуулсаар, аажмаар өөрийн болгох асуудал юм. Сүүлийн жилүүдэд олон улсын харилцаа судлалд “өрийн занга”, “өрийн дарамт” гэх мэт ойлголтууд улам эрчимтэй ашиглагдаж байна.

Уул уурхайн салбарыг хөгжүүлэх нэрийн дор ихээхэн хөрөнгө оруулалтын зээлийг энэ салбарт өгөх замаар тухайн салбарын технологийг өөрийн улсад ашигтай технологиор солих бодлого байдаг. Тухайн салбарт шаардлагатай зээлийг өгөхдөө эдийн засгийн үр ашигтай байдлыг харгалзаж үз гэж хэлдэг болохоос өөрийнхөө орны аюулгүй байдлыг бод гэж хэзээ ч хэлдэггүй.

Ингэж эдийн засгийн үр ашигтай байдлыг үүсгэхийн тулд санаатайгаар дэлхийн зах зээлийн үнээс хэд дахин хямд үнээр технологи болон бүтээгдэхүүнийг нийлүүлэх замаар тухайн үйлдвэрийн технологийг өөрийн эдийн засгийн хараат байдалд оруулдаг байна. Үүний дараа нэгэнт тухайн улсын технологиос хамааралтай болсон үйлдвэрийн сэлбэг болон технологийн шинэчлэлтийг өөрийн хүсэл зоригийн дагуу удирдах нөхцөл байдал үүсдэг нь тухайн улсын засаглалын чадавхтай шууд холбоотой юм.

Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш үндэсний үйлдвэрлэл, ялангуяа уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж, Засгийн газраас үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих, эх орныхоо байгалийн нөөц баялгийг ашиглах замаар нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшилд хүргэхэд чиглэсэн бодлогыг баримталж ирсэн.

Монгол Улсын эдийн засгийн гол

<sup>5</sup> "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын судалгаа" судалгааны ажлын тайлан. БХЭШХ., 2020



тулгуур нь ашигт малтмалын нөөцийн олборлолт, борлуулалт болсоор олон жилийг өнгөрөөж байгаа боловч харамсалтай нь энэ нөөцийг зөв зүйтэй ашиглах, Үндсэн хуульд заасан “бүх ард түмний мэдлийн” төрийн нийтийн өмчийг төрөөс зүй зохистой “хянаж байх” асуудал орхигдсоор, үр ашгийг нь ард иргэд тэгш шударга хүртэх, олборлосон баялаг, түүний үнэ цэнэ дээр тулгуурлан улсын эдийн засгийг төрөлжүүлэн уул уурхайгаас бусад салбарыг хөгжүүлэх асуудал орхигдсоор өнөөдрийг хүрсэн.

Ашигт малтмалын тухай хуулийг ойлгож, хэрэглэхэд бас нэг хүндрэлтэй, шийдлээ зөв олоогүй асуудал нь манай одоогийн хууль эрх зүйн актуудад байгаа ашигт малтмал гэсэн ойлголт юм. Ашигт малтмалыг хайх, олборлох, ашиглах, борлуулах зэрэг асуудлын эрх зүйн орчинг бүрдүүлэхдээ тэдгээр ашигт малтмалууд нь газар ба түүний хэвлийд оршдог учир түүнээс нь салгаж, ялгаж авч ашиглахаас өөр аргагүй байгалийн зүй тогтлыг огт тооцож үзээгүй, ашигт малтмал буюу аливаа эрдэс баялгийн ашиглалт олборлолтыг газраас нь, газрын хэвлийгээс нь салгаж тусад нь шийдэх гэж оролдож байгаа явдал юм.

Үүнээс улбаалаад Үндсэн хууль, Баялгийн сангийн тухай хуулиуд болон бусад эрх зүйн баримт бичгүүд нь Ашигт малтмалын тухай хуулийн заалтуудтай зөрчигдсөн, давхардсан, хийдэлтэй байгааг дараах ажлын хэсгийн гаргасан дүгнэлт, судалгаа харуулж байна. ХЗДХЯ, УУХҮЯ хамтран 2017 онд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах” төслийн хүрээнд хийсэн судалгаагаар уул уурхайд

хамааралтай 10 гаруй хуулинд 267 давхардал, 150 хийдэл, 150 зөрчил байгааг тогтоосон байна<sup>6</sup>.

Хуульд нэг ижил утга, агуулга, илэрхийлэл бүхий “бүрэн эрхүүд”-ийг олон шатны хуулийн этгүүдэд хуулиар давхардуулан олгосон байна. Тухайлбал, Зөвхөн Газрын хэвлийн тухай хуулинд л гэхэд УИХ-ын бүрэн эрхэд 3, Засгийн газрын бүрэн эрхэд 3, Уул уурхайн хүнд үйлдвэрийн яаманд 5, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 3 бүрэн эрхийг тус тус олгосон байна. Эндээс газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх бүрэн эрхүүдийг хэд хэдэн субъектүүдэд зэрэгцүүлэн олгосон нь харагдаж байна.

Гэтэл Ашигт малтмалын тухай хуульд тусгасан энэ салбарын ганц, төрийн дээд шатны, мэргэжлийн байгууллага болох Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд олгосон эрхүүдийг харвал сонгон шалгаруулах; геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, тооцох; эрэх хайх, ашиглах; бүтээгдэхүүний стандартыг боловсруулж батлуулах; баяжуулах үйлдвэрт тавигдах үйл ажиллагаа эрхлэх; нөхөн сэргээлт, хаалтын; шинжээчийн хөлс олгох, ордын нөөц хайгуулын ажлын үр дүнг нээлттэй тайлагнах зэрэг 10 гаруй журам, ангилал заавар батлах, мэргэжлийн зөвлөл байгуулах бүрэн эрхүүдийг олгосон байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “Байгалийн баялаг гагцхүү ард түмний мэдэлд байна” гэж заасан нь байгалийн баялгийг өмчлөх-эрх мэдлийн эцсийн онцгой хэлбэр, эзэмших –бусдын мэдэлд байлгахгүй, хуваалцахгүй, зөвхөн өөрөө л

<sup>6</sup> ХЗДХСайдын 2017 оны “Уул уурхайн салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл зөрчлийг арилгах ажлын хэсэг байгуулах тухай” А/67 дугаар тушаал



хэрэгжүүлэх эрх мэдэл, ашиглах– төрийн хяналтанд зөв эрх зүйтэй, зөв ашиглах, үр ашгийг хүртэх ард түмний онцгой бүрэн, дээд эрхийн тухай асуудал бөгөөд ард түмэн энэхүү бүрэн, дээд эрхээ өөрсдийн сонгосон УИХ–аараа дамжуулан хэрэгжүүлэх боломжтой ба Үндсэн хуульд “гагцхүү” гэж заасан нь ард түмэн өөрийн эрх мэдлийн хэлбэр буюу өмчлөх эрхээ зөвхөн өөрөө л хэрэгжүүлнэ гэж ойлгогдож байна.

Ашиг малтмалыг олборлож, борлуулсны үр шимийг зөв удирдан, ирээдүйн үедээ хариуцлагатайгаар өвлүүлэн үлдээх бодлогын эхлэл нь Үндэсний баялгийн сан билээ. Үндэсний баялгийн санг үүсгэн байгуулснаар байгалийн баялгийн олборлолтоос бий болсон хөрөнгө нэг цэгт төвлөрч түүхий эдийн үнийн хэлбэлзэл эсвэл эдийн засгийн уналтын үед тогтворжуулах хүчин болох эхлэл тавигдсан юм. Уг сангаар иргэдийн аж амьдралыг сайжруулахад чиглэсэн дэд бүтцийн төсөл, нийгмийн хөтөлбөр, боловсрол болон бусад бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх боломжтой.

“Үндсэн хуульд “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх

эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно<sup>7</sup>.”

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд баялгийн сан нь Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэж төрөлжсөн сантай байхаар заасан<sup>8</sup>.



2.1 дүгээр зураг. Үндэсний баялгийн сангийн төрөл Эх сурвалж: Үндэсний баялгийн сангийн тухай хууль

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны зүгээс 2021 оноос хойш Үндэсний баялгийн сангийн тухай анхдагч хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаа, үр нөлөөг үнэлэх судалгааг тус тус хийлгэж, судалгааны нэгдсэн тайланг боловсруулж байсан.

Мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хамт боловсруулж Хууль тогтоомжийн тухай хуулийн хүрээнд 2022 оны 6 дугаар сард хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамтай хамтран батлуулсан байдаг. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 11 дүгээр сарын 22–ны өдрийн “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 192 дугаар захирамжийн дагуу 2022 оны 12 дугаар сарын 15–ны өдрийн 3297/01 дугаартай

<sup>7</sup> Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт. <https://legalinfo.mn/mn/detail?lawld=367> Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14–ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан

<sup>8</sup> Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт. <https://legalinfo.mn/mn/detail?lawld=367>



албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яам руу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, холбогдох баримт бичгийг хүргүүлсэн. Түүнээс хойш уг хуулийг эцэслэн батлуулах ажил нь Эдийн засаг, хөгжлийн яам руу шилжсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлаас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр баталсан болно.

Энэхүү сан нь Норвегийн “Government Pension Fund Global<sup>9</sup>”, Чилийн “Economic and Social Stabilization Fund<sup>10</sup>” зэрэг олон улсын туршлагыг үндэслэн боловсруулагдсан бөгөөд дараах үндсэн зорилтуудтай:

- Ашигт малтмалын орлогыг хуримтлуулах
- Ирээдүйд эдийн засгийн тогтвортой байдлыг хангах
- Иргэдийн амьдралын чанарыг сайжруулах хөрөнгө оруулалт хийх
- Төсвийн хэт хамаарлыг бууруулах

Мөн түүнчлэн Ашигт малтмал олборлох тухайд үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын төсөл хэрэгжиж, үр дүнд нь Монгол Улсын эрдэс баялгийн салбарын мэдээлэл харьцангуй ил тод эхэлж байгаа боловч үүнийг цаашид үргэлжлүүлж, Монгол Улсын уул уурхайн салбарын хууль эрх зүйн иж бүрэн тогтолцоо бүрдүүлэх боломж бас шаардлага байна. Тухайлбал, 2024 оны эцсийн байдлаар байдлаар нийт нутаг дэвсгэрийн 4,4 хувьд нь буюу 6,844.2 мянган га–д 2740 тусгай зөвшөөрөл олгосон байна<sup>11</sup>. Үүнээс 40 хувийнх нь эцсийн өмчлөгчийн мэдээлэл ил болсон байна.

Ашигт малтмалын ашиглалт болон

<sup>9</sup> <https://www.swfinstitute.org/profile/598cdaa60124e9fd2d05b9af>. Norges Bank Investment Management (Norway Government Pension Fund Global)

<sup>10</sup> <https://www.investopedia.com/terms/e/essf.asp> Economic and Social Stabilization Fund (Chile)

<sup>11</sup> Эрдэс баялгийн статистик мэдээ 2024/12 Ашигт малтмал, газрын тосны газар.

хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон байдлаар авч үзвэл, 2024 онд 2809 тусгай зөвшөөрөл тоологдож, нийт тусгай зөвшөөрлүүд 6,94 сая га талбайг хамарч, нийт нутаг дэвсгэрийн 4,4 хувийг эзэлж байна.<sup>12</sup>

Манай улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт 2023 оны гүйцэтгэлээр 15184,5 сая ам долларт хүрч, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт 13989,2 сая ам доллар буюу нийт экспортын 92,1 хувийг эзэлж байна. 2023 оны эцсийн байдлаар улсын төсвийн орлого бүрдэлтэд 31,6 хувийг буюу 7,68 их наяд төгрөгийн орлогыг уул уурхайн салбарын үйлдвэрүүд төвлөрүүлжээ. Үүний 94,8 хувь нь уул уурхайн олборлох салбараас, 4,0 хувь нь газрын тосны үйлдвэрлэлээс, 1,2 хувь нь бусад татварын орлого байна. Уул уурхайн үйлдвэрүүд улсын болон орон нутгийн төсвийн орлогод татвар төлбөрийн хэлбэрээр 30 гаруй хувийг бүрдүүлдэг хүчирхэг салбар болсон ба энэ нь уурхайн үйлдвэрүүдийн борлуулалтын орлогын –10 20 хувьтай тэнцэж байна<sup>13</sup>.

Эндээс харахад Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд уул уурхай, ашигт малтмалын салбар асар их үүрэгтэй бөгөөд цаашид ч тус салбарын эдийн засгийн үр өгөөж нэмэгдэж, ойрын 20 жилдээ энэ байдал үргэлжлэхээр байна. Өөрөөр хэлбэл, манай орны хөгжлийн өнөөгийн онцлог бол эдийн засаг нь ашигт малтмалын нөөцийн ашиглалтаас ихээхэн хамааралтай явдал бөгөөд цаашид ч үргэлжлэн нөөцийг зохистой ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар улс орны эдийн засгийн хөгжлийн ойрын ирээдүйн зорилтыг хангах болно.

<sup>12</sup> Эрдэс баялгийн статистик мэдээ 2024/12. Ашигт малтмал, газрын тосны газар

<sup>13</sup> 2023 оны Эрдэс баялгийн салбарын гадаад худалдааны статистик мэдээ

Монгол Улсын эдийн засагт ашигт малтмалын салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин улам бүр өсөн нэмэгдсээр сүүлийн жилүүдэд тэргүүлэх салбар болж, ард түмний амьдралын чанарыг дээшлүүлэх гол эх сурвалж нь болж байна. Монголын уул уурхай үндэсний хэмжээнээс халин дэлхийн тавцанд гарч, ДНБ-ний 20 гаруй хувь, аж үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүний 70 гаруй хувь, экспортын нийт бүтээгдэхүүний 90–80 хувийг дангаараа үйлдвэрлэх болж байна.

Өнөөдөр Монгол Улсын эрдэс баялгийн салбарт үндэстэн дамнасан корпорацийн төлөөлөл болох Рио Тинто, Хятадын Шеньхуа, Петрочайна, Канадын Сентрагоулд, Францын Арева, Оросын Ороснефть, Германы Тиссен групп зэрэг олон компани үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсад уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн экспортолдог 300 орчим аж ахуйн нэгж, иргэний гадаад худалдааны гэрээнд 2019 онд хийсэн судалгаанаас харахад нийт экспортлогчдын 27 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж, үлдсэн 73 хувь нь дотоодын хөрөнгө оруулалттай байна. Гэрээлэгч улсын хувьд 90 хувь нь БНХАУ байгаа бөгөөд бусад оронтой гэрээ хийсэн ч тэр нь зуучлагч орон болж, хүлээн авагч нь БНХАУ байсаар байна. Иймээс экспортын хувьд нэг орноос хэт хамааралтай байдал үүсжээ.

Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагааны нэг гол салбар бол түүхий эд, ашигт малтмал юм. **Монгол Улсад сууж байсан БНХАУ-ын Элчин сайд Гао Шүмао 2011 онд Хятадын [huanqiu.com](http://world.huanqiu.com) сайтад ярилцлага өгөхдөө** “Миний бодлоор Хятадын оролцоогүйгээр Монголын уул уурхайн олборлолт явагдах нь эрүүл бус юм.

Гагцхүү Хятад оролцож байж тэнцвэртэй, шударга, тогтвортой хөгжинө. Яагаад ингэж хэлж байна гэхээр бусад улс орнууд гагцхүү хувиа л бодож байгаа. Хятадууд шууд Монгол компаниас авах боломжгүй, заавал гурав дөрөвдөгч орны зуучлагч компаний гараас бараагаа авдаг. Тэд гадны компаниуд учир дундаас нь өндөр ашиг унагаадаг. Эндээс Хятад хохироод зогсохгүй Монгол ч хохирч буй. Ийм олон орон ашиг унагаасан хамтын ажиллагаа бол эрүүл бус. Монгол уул уурхайгаа үнэхээр хөгжүүлж гэж байгаа бол Хятадад эргэлздэгээ орхих хэрэгтэй”<sup>14</sup> гэж хэлж байсан нь өнөөдөр биелэлээ олсон байна. Энэ бүхнээс харахад тэдний зүгээс Монголын ашигт малтмалыг ашиглах асуудал Хятадад амин чухал болохыг гэрчилж байна.

### Дүгнэлт

Ашигт малтмалын тухай хуулийг Үндсэн хууль болон бусад хуулиудтай уялдуулж хийгээгүйн зэрэгцээ төрийн бодлогыг хэрэгжүүлэх, төрийн үйл ажиллагааны залгамж чанар алдагдах, батлагдсан бодлогоос ухрах, хууль эрх зүйн орчинд тогтворгүй байдал үүсэх зэргээс шалтгаалж, ашигт малтмалын салбарын тогтвортой хөгжил алдагдах, улмаар эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хандлага ажиглагдаж байна.

2. Ашигт малтмалыг олборлож, борлуулсны үр шимийг зөв удирдан, ирээдүйн үедээ хариуцлагатайгаар өвлүүлэн үлдээх үүднээс байгуулсан Үндэсний баялгийн сангаар байгалийн баялгийн олборлолтоос бий болсон хөрөнгө нэг цэгт төвлөрч, иргэдийн аж амьдралыг

<sup>14</sup> 专访中国前驻蒙古国大使：中蒙人民需增进相互信任  
<http://world.huanqiu.com/roll/2011-09/1988820>.



сайжруулахад чиглэсэн дэд бүтцийн төсөл, нийгмийн хөтөлбөр, боловсрол болон бусад бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх боломжтой болсон.

3. Монголын уул уурхай, ашгт малтмалын салбар ДНБ-ний 20 гаруй хувь, валютын нөөцийн 90 хувийг, аж үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүний 70 гаруй хувь, экспортын нийт бүтээгдэхүүний 90–80 хувийг дангаараа үйлдвэрлэн, нийгэм, эдийн засгийн хөгжилд их үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал, ДНБ 2.4 дахин нэмэгдсэн байхад уул уурхай ашигт малтмалын салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 4.5 дахин нэмэгдсэн байгаа нь энэ салбарын өсөлт ДНБ-ний өсөлтөөс илүү хурдацтай явж, манай улсын эдийн

засаг уул уурхай дээр тулгуурлаж байгааг харуулж байна.

4. Монгол Улсад уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн экспортолдог 300 орчим аж ахуйн нэгж, иргэдийн гадаад худалдааны гэрээлэгч улсын 90 хувь нь Хятад улс байгаа бөгөөд бусад оронтой гэрээ хийсэн ч зуучлагч, хүлээн авагч нь Хятад улс байсаар байгаа нь экспортын хувьд нэг орноос хэт хамааралтай байдлыг үүсгэжээ. Худалдааны дайнаас шалтгаалан Хятадын эдийн засаг агшиж, манай улсаас авч байгаа уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт буурах магадлалыг бий болгож байгаа бөгөөд энэ нь улмаар төсвийн орлого буурах, валютын урсгал саарах эрсдэлийг бий болгож байна.

# “АРТИЛЛЕРИЙН БАЙЛДААНЫ АЖИЛ” ХИЧЭЭЛИЙГ ХИЙМЭЛ ОЮУН УХААН АШИГЛАН ЗААХ БОЛОМЖ

**Б.БАТ-ЭРДЭНЭ** ЛУБХИС-ийн ЦНДС-ийн Артиллер, Зэвсгийн тэнхимийн ахлах багш, магистрант, хошууч/

**Түлхүүр үг:** Өргөтгөсөн бодит байдал, Хиймэл оюун ухаан, Гүн сургалт, Ухаалаг анги, Үндэсний Батлан Хамгаалахын Технологийн Их Сургууль, Ардын чөлөөлөх арми.

**Key words:** Augmented Reality, Artificial Intelligence, Deep learning, 智慧教室, National University of Defense Technology /NUDT/, People's Liberation Army.

**Оршил:** Хиймэл оюун ухаан бол –21р зууны хамгийн шилдэг систем ба хурдан хөгжиж буй технологийн нэг бөгөөд хүн төрлөхтний амьдралд асар их нөлөө үзүүлж байна.

Энэ нь компьютер, программ хангамж, болон бусад технологийн тусламжтайгаар хүний оюун ухааны зарим хэсгийг дуурайж, төрөл бүрийн асуудлыг шийдвэрлэх чадвартай системүүдийг бий болгохыг зорьдог байна. Хиймэл оюун ухаан нь машин сургалт, хэл ярианы боловсруулалт, дүрс таних, шийдвэр гаргах зэрэг олон чиглэлээр ажилладаг бөгөөд эдгээр технологи нь эрүүл мэнд, боловсрол санхүү, тээвэр, аюулгүй байдал зэрэг олон салбарт өргөн хэрэглэгдэж байна.

Цэргийн боловсрол, ялангуяа артиллерийн мэргэжлийн хичээлүүд нь нарийн тооцоолол, шуурхай шийдвэр гаргалт, бодит нөхцөлд ойр сургалт шаардаж байдаг.

Ийм онцлог шинж чанарууд нь ХОУ ашиглан сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтойг харуулж байна.

“Артиллерийн байлдааны ажил” хичээл нь офицер бэлтгэх сургалтын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд артиллерийн галт байран дээрх ажиллагаа мөн түүнчлэн засварлал тодорхойлох буу, галт хэрэглэлтэй харьцах аюулгүй ажиллагаанд суралцах зэрэг чадваруудыг эзэмшүүлэхэд чиглэдэг.

Судалгааны ажлаар хиймэл оюун ухааныг сургалтын төлөвлөлт, интерактив симуляци, нөхцөл байдалд суурилсан даалгавар боловсруулах, сургах болон үнэлэх үйл явцад ашигласнаар сургалтын үр өгөөж хэрхэн дээшилж болохыг судалж, цэргийн боловсролд шинэ аргачлал нэвтрүүлэх суурь болно гэж үзэж байна.

**Үндсэн хэсэг:** Хиймэл оюун ухаан гэж юу


вэ? Түүнийг дэлхийн улс оронд хэрхэн ашиглаж байна вэ?

Хиймэл оюун ухаан зарим үйл ажиллагааг компьютерийн систем болон программ хангамжийн тусламжтайгаар дуурайх, боловсруулах, шийдвэр гаргах, хэл яриаг ойлгох, дүрс таних зэрэг үүргийг гүйцэтгэх чадвартай технологи юм.

Хиймэл оюун ухаан нь хүний дараах оюуны чадавхуудыг техник хэрэгсэлд суулгаж хариу үйлдэл үзүүлэх зорилготой юм.

- Сэтгэн бодох,
- Суралцах,
- Асуудал шийдэх,
- Хэл ойлгох ба боловсруулах
- Орон зайн дүрслэл хийх,
- Туршлага хуримтлүүлж, дүгнэлт гаргах

гэх мэт маш олон чадавхуудыг шингээсэн дэвшилтэд технологи юм.



Хиймэл оюун ухаан дэлхийн улс орнуудад илүү хурдацтайгаар хөгжиж байна. Тиймээс дараах улс орнууд хиймэл оюун ухааныг хэрхэн ашиглаж байгааг судалгааны энэ хэсэгт авч үеье.

## **АНУ**

**Персоналчилсан сургалт:** ХОУ–д суурилсан платформууд (DreamBox Learning, Carnegie Learning) сурагч бүрийн сурах хурдад тохирсон

агуулга санал болгодог.

**Автоматжуулсан үнэлгээ:** Turnitin зэрэг ХОУ хэрэгслүүд сурагчдын бичсэн эссег шалгаж, хуурамч эх сурвалж ашигласан эсэхийг тодорхойлдог.

**AR/VR сургалт:** Химийн лаборатори, биологийн судалгааг виртуал орчинд турших платформууд өргөн хүрээтэй ашиглаж байна. Үүнээс Цэргийн салбарт хэрхэн ашиглаж байгааг авч үзвэл.

АНУ-ын Зэвсэгт хүчин хиймэл оюун ухааныг (ХОУ) цэргийн салбарт өргөнөөр ашиглаж, шинэ үеийн дайн тулаанд технологийн давуу талыг бий болгохыг зорьж байна.

### **БНХАУ**

**Ухаалаг анги танхим:** Камераар сурагчдын хичээлд оролцох идэвхийг ажиглаж, хариу үйлдлийг анализ хийх системтэй.

**ЭЕШ бэлтгэл:** ХОУ-д суурилсан тестийн програмууд сурагчдыг стандарт шалгалтад бэлтгэхэд тусалдаг.

**AI багш нар:** Зарим хичээлийг хиймэл оюун ухаанд суурилсан виртуал багш нар зааж эхэлсэн

БНХАУ-ын ухаалаг танхимууд нь орчин үеийн дижитал технологийг боловсролын салбарт нэвтрүүлж, сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилготойгоор хөгжиж байна.

Эдгээр танхимууд нь уламжлалт сургалтын орчныг шинэчилж, багш, сурагчдын харилцан үйлчлэлийг сайжруулж, сургалтын чанарыг дээшлүүлж байна.

БНХАУ-ын хэд хэдэн сургууль ухаалаг танхимыг бий болгосноос Хуанжун Шинэжлэх Ухааны, Технологийн Их Сургууль нь анх байгуулагдсан цагаасаа хойш өдгөө хүртэл нийт 97 ухаалаг танхимыг байгуулж, сургалтын орчныг сайжруулаад зогсоогүй эдгээр танхимууд нь өндөр хүчин чадалтай тоног төхөөрөхөмж, 3D харилцан үйлчлэл, сургалтын тусгай сүлжээтэй бөгөөд сургалтын чанарыг дээшлүүлэхийг зорьсон байна.

Тэгвэл БНХАУ нь хиймэл оюун ухааныг цэргийн салбарт ашиглаж байгаа байдал нь:

1. Ухаалаг зэвсэглэлийг бүтээх
2. Мэдээлэл, тагнуулын дүн шинжилгээ
3. Командлал ба удирдлагын систем
4. Сургалт симуляци
5. Кибер болон мэдээллийн дайн зэрэг чиглэлүүдэд түлхүү анхаарч ажиллаж байна.

БНХАУ-ын Засгийн газар 2017 онд “Хиймэл

оюун ухааны хөгжилтийн үндэсний стратеги”-ийг баталж улмаар 2030 он гэхэд БНХАУ-ыг дэлхийн тэргүүлэх ХОУ-той улс болгоно гэж тунхаглан зарласан байдаг байна.

Үүний хүрээнд:

- PLA (People's Liberation Army) буюу Зэвсэгт хүчний салбар тус бүр AI төслүүд хэрэгжүүлж байна.

- БНХАУ-ын Батлан хамгаалахын хамтарсан лабораториуд, Харбин, Цинхуа, NUDT зэрэг их сургуулиуд цэргийн ХОУ хөгжүүлж байна.

### **Хиймэл оюун ухаан нь “Артиллерийн байлдааны ажил” хичээлтэй холбогдох боломж**

“Артиллерийн байлдааны ажил” хичээлтэй холбогдох боломжтой байдлыг виртуаль байдлаар тайлбарлах нь энэ онлайн орчинд эсвэл сумиляцийн программ хангамж ашиглан суралцах боломж юм. Виртуал сургалт нь сургалтын үйл ажиллагааг илүү интерактив, үр өгөөжтэй болгоход тусална гэсэн үг юм.

Виртуал сургалт нь уламжлалт сургалтаас илүү хүртээмжтэй, аюулгүй, интерактив байж болно. Дараах аргуудаар энэхүү хичээлийг виртуал хэлбэрээр зааж болно:

1. Виртуал, симуляци ашиглах

–Виртуал, Симуляци: Артиллерийн зэвсэглэл, байлдааны ажиллагааг бодит мэт турших боломжтой. Сурагчид виртуал орчинд байрлал эзлэх, галын явуулах команд өгөх, целийг устгах зэрэг дадлагыг хийж болно.

– AR (Нарийвчилсан бодит байдал): Бодит байдал дээр хиймэл оюун ухаан ашиглан их бууны ажиллагааг 3D дүрслэлээр тайлбарлах, засвар үйлчилгээний хичээл заах боломжтой.

2. Интерактив сургалтын программ

–3D тактикийн сургалт: Бодит байлдааны нөхцөлд артиллерийн ангиуд хэрхэн ажиллахыг харуулах анимейшн загварыг ашиглах боломжтой.

–Гар утас, компьютер дээр суурилсан сургалтын платформ: артиллерийн онол, тооцоолол, ажиллагааны тактикийг интерактив хичээл, тестээр суралцах боломжтой.

3. AI ба автоматжуулсан сургалт

–AI зөвлөх: Оюутнуудад байлдааны ажиллагааны үед зөв шийдвэр гаргахад туслах боломжтой.

–Автоматжуулсан анализ: Оюутан, сурагчдын сургалтын явцыг хянаж алдаа, оноог дүгнэх боломжтой.



-Байр зүйн баримжаалал хийх



-Тактикийн баримжаалал

Виртуал технологид суурилсан сургалтын орчинг бүрдүүлбэл дараах давуу талууд үүснэ гэж үзэж байна.

Давуу тал

-Хичээлийг үр дүнтэй зохион байгуулна.

-Бодит зэвсэглэлийг орлож буй орчинд ажилладаг учир эдийн засагт хэмнэлттэй.

-Хэрэглэгч нь хиймэл ертөнцөд бүрэн орж, бодит ертөнцөөс тусгаарлагдсан байдаг учир суралцагсдад цэгцтэй нарийн ойлголт өгөх бүрэн боломжтой.

-Виртуал бодит байдлыг сургалт ашиглахад зарим төрлийн туршилтаас илүү өртөг багатай.

-Бодитоор турших боломжгүй туршилтуудыг турших.

-Виртуал бодит байдлыг ашиглан дадлага, хээрийн гаралтын өмнөх буудлагын бэлтгэл сургуулилтыг үр дүнтэй зохион байгуулах.

-Эрсдэлгүй үнэ, төлбөргүй дадлага

**Дүгнэлт:**

Виртуаль технологи нь бодит орчинтой харьцуулахад шинэлэг олон төрлийн шинэ боломжийг нээж өгч байна. Симуляци нь бодит орчинд гарч болох нөхцлийг виртуал орчинд туршиж үзэх, аюулгүй, үр ашигтай байдлаар сургалт явуулахад олон давуу талыг хангаж өгч байна.

-Хиймэл оюун ухаан нь бүх салбарт хувьсан хөгжиж ирээдүйг гэрэлтүүлэх боломж

-Энэ нь ямар ч хяналтгүй цаашид хурдацтайгаар хөгжвөл эрсдэл үүсгэж болох тул хэмжээ хязгаартай хэрэглээ, зохицуулалт

-AI-д суурилсан байны тооцоолол нь артиллерийн системүүдийг илүү нарийвчлалтай, үр ашигтай, хурдтай болгох

-Дрон, хиймэл дагуул, радар, мэдрэгчийн өгөгдлийг AI боловсруулснаар дайсны байршил, хөдөлгөөн, цаг агаар, газрын хэлбэр

зэргийг нарийвчлан тооцоолж, хамгийн үр дүнтэй буудлагын шийдвэр гаргах боломж

-Артиллерийн системүүд бүрэн автомат болж, бай илрүүлэхээс эхлээд, буудлагын төлөвлөлт, гүйцэтгэл хүртэл AI удирддаг болох

-AI-тай артиллерийн системүүд цаашид улам нарийвчлалтай, ухаалаг болж, байлдааны үр дүн сайжирна

Цэргийн ажиллагаанд хиймэл оюун ухааныг ашиглах нь үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах үйл ажиллагаанд чухал нөлөө бүхий өөрчлөлт шинэчлэлтийг авч ирэх

Цэргийн алба хаагчдад байлдааны зэвсэг техникийг хиймэл оюун ухаанд суурилсан цахим орчинд дуурайлган тоногдсон тустай тренажёрууд, буудлагын скат, төрөл бүрийн симмулятор, компьютерын программуудыг ашиглан сургалт явуулснаар хээрийн сургалт, бэлтгэлд зарцуулагдах зардлыг тодорхой хувь хэмжээгээр эрс бууруулах боломжтой

Цэргийн сургалтад хиймэл оюун ухааныг ашигласнаар цэргийн боловсролын чанарыг дээшлүүлж, үнэлгээгээр дамжуулан суралцагчдад буюу хувь хүнд тохирсон сургалтын туршлага олгох боломжтой

Цэргийн мэргэжил олгох сургалтад хиймэл оюун ухаанд суурилсан цахим сургалтыг хөгжүүлэх, эрчимжүүлэхийн тулд зайлшгүй төр засгийн бодлого дэмжлэг, бодлогын баримт бичиг боловсруулах шаардлагатай гэж дүгнэж байна.

### Ашигласан материал:

1. <https://peak.mn/news/.com>
2. <https://peak.mn/news/.com>
3. <https://www.ai.mil/?utm.com>
4. [https://en.wikipedia.org/wiki/Joint\\_AllDomain\\_Command\\_and\\_Control?utm\\_source.com](https://en.wikipedia.org/wiki/Joint_AllDomain_Command_and_Control?utm_source.com)
5. <https://www.afcea.org/signal-media/us-army-launches-generative-ai-platform-groundbreaking.com>
6. <https://www.washingtonpost.com/technology/2025/03/05/pentagon-ai-military-scale.com>
7. <https://mn.usembassy.gov/mn/khaan-quest-2023-mn/.com>
8. <https://www.wsj.com/tech/meta-army.com>
9. <https://cn.chinadaily.com.cn/>
10. [https://www.uscc.gov/sites/default/files/June%20%20Hearing\\_Panel%201\\_Elsa%20Kania\\_Chinese%20Military%20Innovation%20in%20Artificial%20Intelligence\\_0.pdf?utm](https://www.uscc.gov/sites/default/files/June%20%20Hearing_Panel%201_Elsa%20Kania_Chinese%20Military%20Innovation%20in%20Artificial%20Intelligence_0.pdf?utm)
11. [https://lib.yzu.am/disciplines\\_bk/efdd4d1d4c2087fe1cbe03d9ced67f34.pdf](https://lib.yzu.am/disciplines_bk/efdd4d1d4c2087fe1cbe03d9ced67f34.pdf)

## АВТОМАШИНЫ РЕЗИН ДУГУЙН АШИГЛАЛТЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ

**Б.МӨНХТУЛГА** /ХОШУУЧ, ҮБХИС-ИЙН ДОКТОРАНТ/

**Түлхүүр үг:** Автомашин, резин дугуй, хадгалалт, дугуйны элэгдэл

**Key words:** car, tire, storage, tire wear

### Оршил


Автомашинь зүтгэх хүч, тоормосны системийн ажиллагаа, түүний тогтворжилт, хөдөлгөөний аюулгүй байдал, хэмнэлттэй ажиллагаа нь резин дугуйны чанар байдлаас шууд хамаардаг.

Автомашинь ашиглалтын бүх зардлын 10–15% нь резин дугуйд ноогдож байгааг судалгаагаар тогтоосон байдаг ба резин дугуйн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх нь түүний ашиглалтын зардлыг хэмнэх боломжтой нь ажиглагдаж байна. Иймд тус өгүүлэлд автомашинь резин дугуйн ашиглалтыг дээшлүүлэх арга замын талаар тодруулан гаргахыг зорилоо.

Резин дугуйны ажиллагааны явц, түүний ашиглалтын найдвартай ажиллагаа, эдэлгээний хугацааг уртасгах арга замыг нарийвчлан судалж мэдэхгүйгээр түүний ашиглалтыг зөв зохион байгуулах боломжгүй юм.

Резин дугуйны ашиглалтад юуны өмнө дугуйн дээр дарах машины хүнд, динамик үйлчлэлийн хүч (татах, төвөөс зугтах) хажуугийн болон дугуйн дотоод даралт ихээр нөлөөлдөг.

Шахагдсан хий дотоод даралтын хүч нь резин дугуйны бүтцийн давхаргуудыг гадагш тэлж (1 дүгээр зураг) улмаар давхаргын утас тус бүрд 1–2 кг ачаалал өгдөг. Энэ ачааллын хэмжээ нь дугуйн хийн дотоод даралтын хэмжээтэй шууд хамааралтай байна.



1 дүгээр зураг. Резин дугуйд үйлчлэх хүч.

а–Ачааллын үйлчилгээгээр үүсэх дугуйны хотойлт.

б–дугуйд эргэх хүч дамжуулах үеийн хэв гажилт.

Рдот– дугуйны хийн дотоод даралт; Gм– дугуй дээр дарах машины жин.

Рк–зүтгэх хүч, Хк–зүтгэх хүчний реакц.

Дугуйн хийн даралт, түүний хүрээний цагирагуудад (1000–2000 кг– хүчээр цагираг тус бүрт) ихээхэн хүчээр гадагш тэлж, таслахаар тэмүүлдэг. Иймд резин дугуйг тодорхой хэмжээний нөөц баталгаатай (түүний давхаргыг 8–20кг, цагирагийг 5–7 кг) хийдэг. Гэвч ашиглалтын журам зөрчигдсөн тохиолдолд энэ хэмжээнүүд амархан буурдаг.

Ашиглалтын явцад дугуйд ноогдох машины хүндийн жин нь резин дугуйн бүтцийг хэв гажилтад оруулдаг. Хэв гажилтын хэмжээ нь резин дугуйны хэмжээ, хийний даралт, дугуйд ноогдох ачааллын язгуур хэмжээнээс хамаарна.

Резин дугуйн хотойлтын гажилт үүсэх хүчний 40% нь түүний бүтцийн материалаас, 60% нь хийн даралтаас тус тус бий болдог. Гажилтын зөвшөөрөгдөх хэмжээ нь дугуйн хээний өндөртэй харьцуулахад ачааны автомашинд 10–12%, суудлын автомашинд 12–14% байдаг.

Дугуйны элэгдэл нь замын нөхцлөөс ихээхэн хамаарах бөгөөд хатуу хөрстэй замд их, зөөлөн хөрстэй замд бага байна. Хүч дамжуулах ангиас, дугуйд ирсэн эргэлтийн хүчээр бий болох хөдөлгөх хүч нь резин дугуйг замтай барьцалдахаас өмнө болон барьцалтаас гарсны дараа үүсэх шахалтыг бий болгон өгөх шалтгаан нь болдог.

Ийм гажилтын ачааллын язгуур нь дугуйны харьцах хурд болдог. Гажилтын үүсэх давтамж, түүний хэмжээг дугуйны элементүүдийн ажлын ачаалал, замтай барьцах бүсэнд ямар байгаагаар тодорхойлогдоно.


Машины хөдөлгөөний резин дугуй нь хүнд динамик ачаалал хүлээн авдаг. Хэвийн



нөхцөлтэй замд резин дугуйд үйлчлэх динамик ачааллын хэмжээ нь статистикийн ачааллын хэмжээнээс барагцаалбал 1,5–3 дахин их байдаг. Бартаатай замд хад чулуу, бусад саадыг мөргүүлэхэд резин дугуйны динамик ачаалал дугуйны зарим хэсэгт статик ачаалаас 6–8 дахин их болж давхаргуудын утаснууд хэт ачаалалд орно.

Хүчтэй цохилтын үед буюу их хурдтайгаар явж буй үед динамик ачаалал нь дугуйн давхаргыг ханзарч урагдах явдалд оруулна. Дугуйны эргэлтийн үед төвөөс зугтах хүч нь резин дугуйг обудоос нь салгахаар тэмүүлдэг. Хэрэв дугуй зөв тэнцүүлэгдсэн бол энэ хүч нь резин дугуйны материалд үйлчилж, ачаалал нь жигд тэнцүү болно. Резин дугуй хэт элэгдэлтэй тохиолдолд төвөөс зугтах хүч нь бусад хүчнүүдтэй нийлж түүний элэгдлийг улам хурдасгана.

Дугуйны динамик болон статик тэнцүүлэлт алдагдсан тохиолдолд дугуйны булны холхивч жолооны механизмн нугасан холбоонд элэгдэлт ихэсдэг. Дугуйны байрлалын голын дагуу тэнцүүлэлт хийгээгүйгээс түүний эргэлтийн үед төвөөс зугтах хүчний нөлөөгөөр тэнцвэр алдалт үүснэ.



2 дугаар зураг. Дугуйг тэнцүүлээгүй үед үйлчлэх хүч а– статистикийн хүч, б– динамикийн хүч

Машины хөдөлгөөний үед төвөөс зугтах хүч ( $P_c$ ) дугуйг замаас хөндийрүүлэх буюу буцааж замд шахах хэлбэрээр үргэлж давтагдан үйлчлэх учраас резин дугуйны өнхрөх гадаргуу хамгийн түрүүнд элэгдэлд ордог. Энэ хүчний хэмжээг дараах томъёогоор тодорхойлно.

$$P_c = m_c \cdot r_k \cdot \omega^2$$

Энд:  $m_c$  – тэнцүүлэгдээгүй масс

$r_k$  – дугуйны радиус

$\omega$  – өнгийн хурд

Дугуйны эргэлтийн үед төвөөс зугтах хүч дугуйны тэнхлэгийн дагуу харилцан адилгүй үйлчлэх энэ агшин эсрэг чиглэлээр бий болоход

динамик тэнцүүлэлтийн алдалт үүснэ. Үүнд:

$$M_d = P_d \cdot b$$

Энд:  $P_d$  – төвөөс зугтах хүчний ялгавар ( $P_d = P_{d1} - P_{d2}$ )  
 $m_{d1}$ ,  $m_{d2}$  – массуудын тэнцвэргүй байрлалаас хамаарах төвөөс зугтах хүчний ялгавар

$b$  – хүчний үйлчлэлийн зай, см

Энэ хүч  $P_d$  нь дугуйг эргэлтийн анхны хавтгайгаас хазайлгахад тэмүүлдэг. Динамик тэнцүүлэлтийн алдалт нь жолооны удирдлагын нугасан холбоо резин дугуй булны холхивчийн элэгдлийг түргэсгэнэ.

Дугуйны байрлалт төвөөс зугтах хүчний байрлалт алдагдсан үед тэрээр байнгын цохилтонд орж машины агрегат, механизмд муугаар нөлөөлөхөөс гадна дугуйны элэгдлийг харилцан адилгүйгээр ихэсгэдэг.

Машины эргэх үед төвөөс зугтах хүч, резин дугуйг обудоос салгахаар тэмүүлэхээс гадна дугуйд хажуугийн хотойлтыг үүсгэж улмаар нэмэлт ачааллыг бий болгоно. Машиныг шарвах үед энэ хүч резин дугуйны гадаргууны элэгдлийг улам эрчимжүүлнэ.

Ашиглалтын хугацаанд резин дугуйн үйлчлэх хүчнүүд нь замын нөхцөл, хөдөлгөөний горимоос хамаарч хэмжээ чиглэлээрээ тогтмол өөрчлөгдөж байна.

Босоо, шулуун, шүргэх чиглэлээр хэдэн тонн хүртэл дарах ачаалал нь резин дугуйн тойргийн дагуух элэгдлийг түргэсгэж өгдөг бөгөөд энэ нь дугуйны овор хэмжээ, машины хөдөлгөөний хурдаас хамаарна.

Судалгаанаас үзэхэд машин цагт 50–60 км-ийн хурдтай явж байхад резин дугуйны хотойлтын давтамж нь 10–15 герц байна. Резин дугуйны дулаан дамжуулах чанар муу учраас хөдөлгөөний үед хотойлтын давтамж өндрөөс шалтгаалж дугуйны бүтцийн материал түргэн хална. (1000С хүртэл халаахыг хэвийн зөвшөөрөгдөх хэмжээ гэж үздэг бөгөөд 1150С-ийг хэт халуун, 1200С-аас дээшлэхийг аюултай гэж үздэг).

Резин дугуйд үүсэх хотойлт гажилтын хэмжээ түүний давтамж нь дугуйны хийн даралт, түүний хатуурал, ачаалал, хөдөлгөөний хурд, замын нөхцлөөс онцгой хамаарна. Ашиглалтын хугацаанд дугуйны хийн даралтыг тогтмол хэвийн байлгахад орчны агаарын даралтаас хамаарч түүний хийн даралт нэмэгдэх явдал ч гардаг.

Дугуйны халалтын үед хийн дотоод даралт тодорхой нөхцөлд хэвийн хэмжээнээс




1,0–1,5 кг/см<sup>2</sup> хүртэл нэмэгдэж, түүний бүтцийн давхаргуудад нэмэлт ачаалал үүснэ. Судалгаанаас үзэхэд резин дугуйны элементүүдийн ачаалал, температурын халалт, ихэсэх шалтгаанууд нь машины хөдөлгөөний хурдыг хэтрүүлэх, огцом эргэх, байнга ба гэнэт огцом тоормослох, явах ангийн механизмууд эвдрэлтэй байх, тэрчлэн цаг, улирал, замын муу нөхцлөөс шалтгаалдаг болох нь батлагдаж байна.

**Судалгааны ажлын үр дүн.**

Шинжлэх ухааны судалгааны ажлын үр дүн ба ашиглалтын туршлагаар резин дугуйны жагсаалаас гарах эвдрэлийн шалтгааныг резин дугуйн дахь хийн ихсэх буюу буурах явдал гэж тогтоосон байна.

Резин дугуйн дотоод хийн даралт буурах нь түүний хэв гажилтыг нэмэгдүүлдэг. Иймд резин дугуйны бүтцийн утаснууд үечлэн суларч түүнийг элэгдэлтийн эвдрэлд хүргэдэг. Резин дугуйны дотоод хийн даралтын ихсэлт нь түүний бүтцийн утаснуудын ачааллыг нэмэгдүүлж, тулгарсан саадын үед бүтцийн утаснуудын торон сүлжилтийг тасралтад хүргэдэг.


Машины хэт ачаалаас шалтгаалан резин дугуйны дотоод даралтаас хамааруулан түүнийг жагсаалтаас хасах хүртэл машины гүйлтийн хэмжээ хамаарах байдлыг 2 дугаар зурагт дүрслэн харуулав.



3 дугаар зураг. Резин дугуйн дотоод даралтаас хамааруулан жагсаалтаас хасах хамаарал

Тогтоосон нормоос хэтрүүлж машиныг ачаалах явдал нь резин дугуйны хэт ачаалалд хүргэдэг. Үүний нөлөөллөөр резин дугуйны хийн даралт буурна. Резин дугуйн дээрх ачааллыг 2 дахин ихэсгэхэд түүний эдэлгээний хугацаа 2 дахин буурах (эсрэг байдалтай нь харьцуулан үзэхэд энэ байдал резин дугуйн дахь хийн даралт 4 дахин ихэсэх үед ажиглагдана)–ыг ОХУ–ын эрдэмтэд судалгаагаар тогтоосон байна<sup>1</sup>.

Резин дугуйны эдэлгээнд ачаалал хэрхэн нөлөөлөхийг 3 дугаар зургаар дүрслэн харуулав.



4 дүгээр зураг. Резин дугуйны эдэлгээнд ачаалал хэрхэн нөлөөлөл

Резин дугуйны элэгдэлтийн хэмжээг түүний хээний өндрийн хэмжээгээр тогтооно. Резин дугуйны хээний өндрийн хэмжээ нь суудлын автомашинд 1,6мм, ачааны автомашинд 1,0мм, автобусанд 2,0мм–ээс багагүй байх ёстой. Хойд талын давхар резин дугуйнуудын хээний элэгдлийн хоорондын зөрүү нь 3мм–ээс хэтрэхгүй байх ёстой.

Резин дугуйны эдэлгээний хугацаа багасах гол шалтгаан нь:

- Огцом тоормослолт
  - Хөдөлгөөний зөвшөөрөгдөх хурд хэтрүүлэлт
  - Саадуудыг болгоомжгүй гатлах явал юм
- Машины хөдөлгөөний хурдаас резин дугуйны эдэлгээ хамаарах байдлыг 4 дүгээр зурагт дүрслэн харуулав.



5 дугаар зураг. Машины хөдөлгөөний хурдаас резин дугуйны эдэлгээ хамаарах байдал.

Хөдөлгөөний хурдыг 2 дахин (50 км/цагаас –100 км/цаг хүртэл) ихэсгэх үед түүний эдэлгээний данснаас хасагдах хүртэл гүйх гүйлтийн хэмжээ ойролцоогоор 3 дахин багасгана<sup>2</sup>.

Резин дугуйны жагсаалаас гарах шалтгааныг мэдсэнээр түүний эдэлгээний хугацааг дээшлүүлэх ашиглалтын арга хэмжээ авах боломж бүрдэж байна. Үүнд:

- Резин дугуйны ашиглалт, түүний эдэлгээний хугацааг дээшлүүлэх талаар

<sup>1</sup> Подчинок В.М “Эксплуатация военной автомобильной техники” 2006.

<sup>2</sup> Бидерман В.Л., Гуслицер Р.Л., “Автомобильные шины” М.: Госхимиздат, 1963. 383 с.



анги, салбарын бие бүрэлдэхүүнтэй тодорхой системтэй сургалтыг зохион байгуулах;

–Дугуйны эдэлгээ, тооцоолол, ашиглалт, хадгалалтад байнгын хяналт, шалгалт тавих;

–Резин дугуй, олгой хаймерт урсгал засвар хийх арга технологийг цэргийн анги, салбаруудын жолооч, техникийн ажилтан нарт нэвтрүүлж, резин дугуйны эдэлгээний хугацааг дээшлүүлэх арга хэмжээг өрнүүлэх;

–Хээ нь бүрэн элэгдсэн резин дугуйг ашиглалтын данснаас хасдаг байх;

–Резин дугуйг эдэлгээний тогтоогдсон нормын хэмжээнд хүргэхийн тулд цэргийн анги, салбаруудын хэмжээнд ядахдаа сард нэг удаа автомашинуудын дугуйнуудын хийн даралтын хэмжээг шалгаж тохируулах ажиллагааг хэвшүүлэх;

–Резин дугуйг 50–80%–ийн чийглэгтэй байранд –30–аас +350С–ийн температурт хадгална;

–Дугуйн тусгай тавиур дээр тавьж хадгалах бөгөөд хадгалалтанд байгаа автомашины дугуйны хийг 12–14 жид тохируулж, бусад дугуйнуудын хийг үйлдвэрлэгдсэн хугацаанаас нь 6–8 жилийн дараа тохируулна;

–Резин дугуйг нефтийн бүтээгдэхүүн, шатахуун тосолгооны материалтай хамт хадгалахыг хориглоно.

### Дүгнэлт

Статикийн судалгаанаас үзэхэд ачааны машины дугуйны 60%, суудлын машины дугуйны 50% хүртлэх нь тэдгээрийн ашиглалтын дүрмийг бүдүүлгээр зөрчих, техникийн үйлчилгээг цаг хугацаанд нь чанартай хийж хэвшээгүйгээс хугацаанаасаа өмнө элэгдэж жагсаалаас гардаг байна.

Резин дугуйны хугацаанаасаа өмнө элэгдэх шалтгаанд дугуйны хийн даралт, тогтоосон нормоосоо зөрчигдөх, түүнийг хэт ачаалах, машиныг жолоодох дүрмийг зөрчих, машины агрегат механизм, техникийн эвдрэл, гэмтэлтэй байх, дугуйг буруу задалж, угсрах, засварыг хугацаанд нь хийгээгүй зэрэг техник технологийн зөрчлүүд орно.

Дугуйн дотоод хийн даралтыг түүний овор хэмжээ, гадаргууны давхрагын тоо, резин дугуйд үйлчлэх ачааллын хэмжээтэй тохируулж тогтооно. Даралт тогтоосон нормоос ачааны автомашины болон автобусанд  $\pm 0,2$  кг/см<sup>2</sup>, суудлын машинд  $\pm 0,8$  кг/см<sup>2</sup> –аас хэтэрч болохгүй.

Судалгаанаас үзэхэд манай орны нөхцөлд зэвсэгт хүчний анги, салбаруудын удаан хугацааны хадгалалтад байгаа автомашины резин дугуйг данснаас хасагдах хүртлэх эдэлгээний нормыг 1 дүгээр хүснэгтэд заасны дагуу шинэчлэн тогтоох шаардлагатай байна.

№	Дугуйны засвар	Автомашины марк	Гүйлтийн норм, 1000км	Хадгалалтад байх хугацаа	Монголын нөхцөлд хадгалалтаас машины резин дугуйг данснаас хасах хүртэл гүйх гүйлтийн хэмжээ (1000км)
1	340–15 Я–245	УАЗ	38	10	19
2	185–14/7–35–14 АИД–23 () ИД–195 ()	ГАЗ–24 ГАЗ–24	32	5	16
			33	5	16
3	6.50–16 Я–248 Я–101	УАЗ–31511	38	10	19
		УАЗ–31511	33	10	11.5
4	12.00–20 (320–508) ВИ–243 УД–1	МАЗ–5335	57	8	28.5
5	9.00–20 (260–508) И–252Б ВИ–244 УД–4	ЗИЛ–130, 130Б ЗИЛ–4331, КамАЗ	57	5	28.5
			57	8	28.5
6	1100х400–533 О–47А	Урал–43202	42	10	21
7	370–508 (14.00–20) ОИ–25	Урал–4320, 375	40	10	20
8	320–508 (12.00–20)	ЗИЛ–131	35	10	17.5
9	320–457 (12.00–18) 70	ЗИЛ–157 ГАЗ–66–40	35	10	17.5
10	1220х400–533 ИП–184	КамАЗ–4310 КамАЗ–4310Б	25	10	12.5



## Ашигласан материал:

1. Подчинок В.М., "Эксплуатация военной автомобильной техники" 2006.
2. Мөнхдорж П., "Армийн автомашины ашиглалт" –УБ., 1981.
3. Бидерман В.Л., Гуслицер Р.Л., "Автомобильные шины" М.: Госхимиздат, 1963. 383 с.
4. Балабин И. В., Пугин В. А. "Автомобильные и тракторные колеса. Челябинск": Челябинское книжное издательство, 1963. 335 с.
5. Бидерман В.Л., Слюдиков Л.Д., "Влияние конструктивных и эксплуатационных факторов на износ, сцепление и сопротивление качению автомобильных шин" М.: ЦНИИТЭнефтехим, 1970. 106 с.
6. ГОСТ 4754-80. Шины пневматические для легковых автомобилей. Технические условия.
7. ГОСТ 5513-86. Шины пневматические для грузовых автомобилей, автоприцепов, автобусов и троллейбусов.
8. ГОСТ 10409-74. Колеса автомобильные с разборным ободом. Основные размеры
9. ГОСТ 13298-78. Шины с регулируемым давлением. Технические условия.
10. ГОСТ 20993-75. Шины пневматические радиальные и диагональные для легковых автомобилей. Основные параметры и размеры
11. ГОСТ 24779-81. Шины пневматические. Упаковка, транспортирование, хранение.
12. ГОСТ 24985-81. Шины с регулируемым давлением. Основные параметры и размеры.



## ЦЭРГИЙН ХӨГЖМИЙН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ХӨГЖМИЙН ЗЭМСГИЙН ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛД

**Г.БАТДОРЖ** /УБХИС-ийн ЦХПК-ийн ахлах багш, докторант/

**Түлхүүр үг:** Чанар, сургалт, хөгжмийн зэмсэг, нөхөн хангалт, шинэчлэл

**Key words:** Quality, training, a musical instrument, compensation, reformation

### Хураангуй:

Монгол Улсын Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд мэргэжлийн хөгжимчин ахлагчийг бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд ашиглагдаж буй хөгжмийн зэмсгийн өнөөгийн байдал, шинэчлэлийн асуудлын талаар авч үзнэ.

### Оршил

Монгол улсад Богд хааны торгон цэргийн үлээвэр найрал хөгжмөөр дамжуулан орчин цагийн сонгодог хөгжим үүсэн, хөгжиж 111 жил болж байна. Цэргийн үлээвэр хөгжим нь Төрийн болон Цэргийн ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаанд онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг салбар юм. Энэ салбарт ажиллаж буй мэргэжлийн хөгжимчин ахлагчдыг бэлтгэдэг улсдаа цорын ганц сургалтын байгууллага бол Үндэсний Батлан хамгаалахын Их Сургуулийн “Цэргийн хөгжмийн политехник коллеж” /ЦХПК/ билээ.

ЦХПК-ийн сургалтын үйл ажиллагаанд нэн чухал хэрэглэгдэхүүний нэг бол хөгжмийн зэмсэг юм. Хөгжмийн зэмсэг гэдгийг энгийнээр тайлбарлавал хөгжимдөхөд дуу авиа гаргах зориулалттай тусгайлан хийгдсэн хэрэглүүр хэмээн ойлгож болно. Хөгжмийн зэмсгүүдийг дотор нь хөгжимдөх чалх, хийц зэргээс нь үндэслэж дөрвөн анги болгон хуваадаг.

Үүнд;

1. Өөрөөр авиа үүсгэгч хөгжмийн зэмсэг /Их, бага хонх/

2. Бүрхэвчид хөгжмийн зэмсэг /төрөл бүрийн хэнгэрэг, цохивор хөгжим/

3. Чавхдаст хөгжмийн зэмсэг /Хийл, морин хуур, төгөлдөр хуур, ятга зэрэг хөгжмийн зэмсгүүд/

4. Үлээвэр хөгжмийн зэмсэг /Модон болон гуулин үлээвэр хөгжим/

ЦХПК нь Мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалтын хөтөлбөртөө нийт 11 төрлийн хөгжмийн зэмсгээр мэргэжлийн хөгжимчдийг бэлтгэж ирсэн. Үүнд; (Гобой–

Жимбүүр, Флейт– Лимбэ, Кларнет– Бялар, Саксофон– Сакс бүрээ, труба– Нарийн бүрээ, Валторна– Угалзан бүрээ, Тромбон– Татах бүрээ, баритон– Баргил бүрээ, Туба– Аргил бүрээ, Скрипка–Хийл, цохивор) зэрэг хөгжмийн зэмсгүүд багтдаг. Тус коллежийн сургалтын нэг онцлог бол суралцагчид цаг агаарын <<–40 өөс +40 хэмийн халуун, хүйтэнд>> газар орны байрлалаас үл хамааран өөрийн эзэмшиж буй хөгжмийн зэмсгээрээ дадлага, сургуулилт хийж, цэргийн ёслолын үйл ажиллагаануудад чухал үүрэг гүйцэтгэж байна.

ЦХПК–нь сургалтын үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш нийт 381 мэргэжлийн хөгжимчин ахлагч төгссөн. Үүний 227 хөгжимчин буюу 59.6 % –нь гуулин үлээвэр хөгжмийн төрөл, 148 хөгжимчин буюу 38.9% нь цохивор болон модон үлээвэр, 6 хүн буюу 1,6 %–ыг Чавхдаст нумт хөгжим (хийл) –ийн зэмсгээр тус тус мэргэжил эзэмшин төгссөн байна. Мөн мэргэшүүлэх болон мэргэжлийн сургалтаар нийт 115 хөгжимчин ахлагчдыг бэлтгэн амжилттай төгсгөсөн байна.

ЦХПК нь 1991 онд анх байгуулагдахдаа тухайн үеийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн хөгжмийн салаанд ашиглагдаж байсан хөгжмийн зэмсгүүдийг авч ашигласан байна. Мөн цэргийн ангийн хөгжмийн салааны сурагчид өөрсдийн ашиглаж байсан хөгжмийн зэмсгээ засаж, сэлбэж сайжруулан сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байсан байна. Харин сургалтын үйл ажиллагаа эхлэх үеийн хөгжмийн зэмсгүүдийн тоог тодруулахаар тухайн үеийн архивын материалтай танилцах үед холбогдох тушаал, шийдвэр олдоогүй тул сурагчдын элссэн тушаал болон тухайн үед багшаар ажиллаж байсан Г.Цэрэнсүхээс /бэлтгэл хурандаа/ асуулгын аргаар тодруулж тоо судалгааг хийсэн болно.


1993 онд Зэвсэгт хүчний жанжин штабын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим /



ҮЖҮНХ/–ийн бүрэлдэхүүн Чех улсын “Amati” үйлдвэрийн шинэ хөгжмийн зэмсгээр нөхөн хангалт хийгдэж тэдний ашиглаж байсан зарим хуучин хөгжмийн зэмсгүүд ЦХПК–д үзүүлэхээр хуваарилагдсан байна. Харин Хөгжмийн зэмсгийн тоог тодруулахаар тухайн үеийн архивын материалтай танилцах үед холбогдох тушаал, шийдвэр олдоогүй тул тухайн үед ҮЖҮНХ–ийн удирдаачаар ажиллаж байсан Д.Бат–Очироос /бэлтгэл хурандаа/ асуулгын аргаар тодруулж тоо судалгааг хийсэн болно.

2009 онд БХ–ын сайдын 2009 оны 06 дугаар сарын 10 ны өдрийн 173 тоот тушаалаар БНТУ–ын буцалтгүй тусламжаар нийт 76 ширхэг хуучин ашиглагдаж байсан хөгжмийн зэмсгээр хангагдсан байна. Тодруулбал; 2006 онд БНТУ–ын жанжин штабын дарга Монгол улсад албан ёсны айлчлал хийх үедээ ҮБХИС–ийн урилгаар үйл ажиллагаатай танилцаж хамтын ажиллагааны хүрээнд уулзалт зохион байгуулагдсан байна. Энэ уулзалтад Цэргийн хөгжмийн сургуулийн удирдлага хөгжмийн зэмсгийн туслалцаа авах санал тавьж, улмаар гурван жилийн дараа ажил болон хэрэгжсэн байна.

2021 онд Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим /ҮЖҮНХ/–ийн хуучин ашиглаж байсан хөгжмийн зэмсгээр нөхөн хангалт хийгдсэн байна. Тодруулбал; Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2020 оны 10 дугаар сарын 28 ны өдрийн А/456 тоот тушаалаар нийт 33 ширхэг 48.025.309 /дөчин найман сая, хорин таван мянга, гурван зуун ес/ төгрөгийн үнэ бүхүй хөгжмийн зэмсгүүдийг 2021 оны 1 дүгээр сард нөхөн хангалтаар авчээ. Эдгээр хөгжмийн зэмсгүүд нь 2006 оноос хойш тус байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байсан байна. ЦХПК –ийн сургалт үйл ажиллагаа явуулсан хугацаанд сонсогч, сурагчдын ашиглаж ирсэн хөгжмийн зэмсгийн нөхөн хангалтыг дараах байдлаар харьцуулалт хийж график 1–д үзүүлэв.




1 дүгээр график. ЦХПК–ийн сургалтын үйл ажиллагаанд сонсогч, сурагчдын ашиглаж ирсэн хөгжмийн зэмсгийн нөхөн хангалт

Дээрх судалгаанаас үзэхэд ЦХПК нь анх байгуулагдахдаа нийт 38 сурагч элсүүлсний 21

сурагч өөрсдийн хувийн хөгжимтэй байсан бол үлдсэн 17 сурагч сургуулийн данстай хөгжмийн зэмсгийг ашигласан байна. Үүнээс хойш 34 жилийн хугацаанд сургалтын үйл ажиллагаанд зориулж нийт 4 удаагийн нөхөн хангалтаар 164 ширхэг хөгжмийн зэмсгээр нөхөн хангагдаж байжээ. Энэхүү нөхөн хангалтаар ирсэн хөгжмийн зэмсгүүд нь бүгд ашиглалтын хугацаа дууссан хуучин хөгжмийн зэмсэг байжээ. Харин дээрх судалгаанд байгууллага, хувь хүний хандив, тусламжаар 1, 2 ширхгээр ирсэн хөгжмүүдийг оруулаагүй болно.

ЦХПК–д суралцаж буй хөгжмийн 1, 2, 3, 4 дүгээр ангийн нийт 86 суралцагчдын сургалтад ашиглаж буй хөгжмийн зэмсэгт дараах судалгааг хийж график 2–д үзүүлэв.



2 дугаар график. ЦХПК –ийн сонсогч, сурагчдын сургалтад ашиглаж буй хөгжмийн зэмсгийн судалгаа (2025 оны 1 дүгээр сарын байдлаар)

Дээрх судалгаанд нийт 86 сурагч хамрагдсан ба үүнээс хувийн данстай хөгжимтэй 59 сурагч, ЦХПК–ийн данстай хөгжим – 25 сурагч, огт хөгжмийн зэмсэггүй 2 сурагч байна. Нийт сурагчдын 68.6% –нь хувийн хөгжимтэй, 29% –нь сургуулийн данстай хөгжмийн зэмсгийг ашиглаж байгаа бол үлдсэн 2.4% нь хөгжмийн зэмсгээ дундаа ашиглаж байна. Тодруулбал; Хөгжмийн 1 дүгээр ангид туба хөгжим сурч буй 3 сурагч зэмсгээ дундаа ашиглаж байна. Энэ нь сурагчдад дараах сөрөг үр дагаварт хүргэж байна. Үүнд:

- Зэрэг гамм хийх боломжгүй;
- Бэлтгэл сургуулилт хийх боломж хомс;
- Ур чадварын түвшин бусдаас хоцрох.

Хувийн хөгжимтэй сурагчдыг тодотгон авч үзвэл, Лимбэ /Флейт/, Саксофон /сакс бүрээ/ зэрэг хөгжмийн ангийн суралцагчдын 100% өөрсдөө хөгжмийн зэмсгээ худалдан авч сургалтад ашиглаж байна. Эдгээр сурагчдын ашиглаж буй хөгжмийн зэмсгүүд нь мэргэжлийн түвшинд ашиглахад шаардлага хангахааргүй байгаа нь багш, удирдаачдаас авсан судалгаанаас харагдаж байна.

Тодруулбал; БНХАУ–ын хувийн



үйлдвэрүүдэд үйлдвэрлэгдсэн номер, дугааргүй, материалын орц, чанар муутай хөгжмийн зэмсгүүд нь бусад хөгжмийн зэмсгүүдтэй хамсран хөгжимдөх үед хөг нийцэлгүй байдаг байна. Учир нь төгөлдөр хуур хөгжмийн зэмсэгтэй зохиол бүтээл хамсран хөгжимдөхийн өмнө хөглөх үед хөглөгч хоолойны тусламжтай тааруулсан байх боловч хөгжимдөх үед зарим өнгө, аялгуу нийцэлгүй хагас тон доор эсвэл дээр дуугарах тохиолдол цөөнгүй тохиолддог. Үүнийг уруулын тусламжтай тааруулах боломжтой боловч 3 болон түүнээс дээш ноотны өнгө зөрөх үед нийцүүлж хөгжимдөхөд анхлан суралцагчдад хүндрэл учирдаг байна.

Найрал хөгжмийн бүрэлдэхүүнд багтах гуулин ба модон үлээвэр хөгжмийн зэмсгийг арчлахад дараах хэд хэдэн зүйлийг анхаарах шаардлагатай юм. Үүнд:

1. Хөгжмийн зэмсгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих;

2. Зэмсгийн нарийн, бүдүүн хоолойг гэмтээхгүй байх;

3. Хөглөгч хоолой, булыг хэрэглээний бохирдлоос шалтгаалж дунджаар 14 хоногт нэг удаа тогтмол тосолж цэвэрлэх;

4. Тасалгааны хэмтэй (+18 оос+20 градус) усаар хөгжмийн зэмсгийг сард нэг удаа зайлах /Өвлийн нөхцөлд спиртээр зайлсан нөхцөлд усаар зайлах/;

5. Хөгжмийн зэмсгийг хайрцаг саванд хийж, гаднын нөлөөтэй эвдрэх эрсдэлээс сэргийлж байх;

6. Хөгжмийн зэмсгийг зөөлөн даавуун болон элгэн арчуураар арчиж цэвэрлэх;

7. Мэргэжлийн багш, мэргэжлийн хөгжимчин, мэргэжлийн хөгжмийн засварчнаар засварлуулж байх. Үлээвэр хөгжмийн зэмсгийг ашиглалтын хугацааг уртасгах зэрэг болно.

Хөгжмийн зэмсгийн ашиглалтын талаар Зэвсэгт хүчний жанжин штабын даргын баталсан 2017 оны 01 дүгээр сарын 02 ны өдрийн А/02 дугаар тоот тушаалын хавсралт “Зэвсэгт хүчний цэргийн хөгжмийн албаны дүрэм”-д найрал хөгжмүүдийн хөгжмийн зэмсгийн ашиглах хугацааг тодорхой заажээ. Үүнийг дараах хүснэгт 1-д үзүүлэв.

1 дүгээр хүснэгт

Үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүнд хамаарах хөгжмийн зэмсгийн ашиглалтын хугацаа<sup>1</sup>

д/д	Хөгжмийн зэмсгийн нэр			Ашиглах хугацаа жилээр	Сургалтад ашиглаж буй хөгжмийн зэмсгийн ашигласан хугацаа
	Англи	Орос	Монгол		
1	Flute	Флейт	Лимбэ	10	15-аас дээс жил болсон
2	Oboe	Гобой	Жимбүүр	5	15-аас дээс жил болсон
3	Clarnet "B"	Кларнет В	Бялар	5	15-аас дээс жил болсон
4	Saxophone alto	Саксафон альт	Сакс бүрээ	10	15-аас дээс жил болсон
5	Tenor Saxophone "B"	Саксафон тенор	Сакс бүрээ (Цээл)	10	15-аас дээс жил болсон
6	Bariton Saxophone	Саксафон баритон	Сакс бүрээ	10	15-аас дээс жил болсон
7	Horn	Валторна F	Угалзан бүрээ	10	15-аас дээс жил болсон
8	Trumbet "B"	Труба В	Нарийн бүрээ	10	15-аас дээс жил болсон
9	Cornet -B	Корнет В	Бүрээ	10	15-аас дээс жил болсон
10	Tenor Trombone	Тромбон	Татах бүрээ	10	15-аас дээс жил болсон
11	Bass Trombone	Тромбон басс	Татах бүрээ аргил	10	15-аас дээс жил болсон
12	Orchestral snare drum	Малый барабан	Жижиг бөмбөр	5	15-аас дээс жил болсон
13	Bass drum	Большой барабан	Том бөмбөр	5	15-аас дээс жил болсон
14	Euphonium "B"	Тенор В	Цээл бүрээ	10	15-аас дээс жил болсон
15	Bariton "B"	Баритон В	Баргил бүрээ	10	15-аас дээс жил болсон
16	Tuba Es-1	Туба Es	Аргил бүрээ	10	15-аас дээс жил болсон
17	Tuba "B"	Туба	Аргил бүрээ	10	15-аас дээс жил болсон
18	Sousaphone	Сузафон	Аргил бүрээ (жагсаалын)	10	15-аас дээс жил болсон
19	Piano	Фортепиано	Төгөлдөр хуур	20	20-иос дээс жил болсон

Дээрх хүснэгтээс үзэхэд бялар, жимбүүр, том, жижиг бөмбөрийг 5 жил, бусад үлээвэр хөгжмийн зэмсгүүдийн ашиглах хугацааг 10 жил байхаар тусгасан байна. Харин ЦХПК-

<sup>1</sup> ЗХ-ний Цэргийн хөгжмийн албаны дүрэм. УБ.,



ийн сонсогч, сурагчдын сургалтад ашиглагдаж буй үлээвэр, цохивор хөгжмийн зэмсгүүд нь ашиглалтын хугацаа дуусаад 10–15 жил болсон байна. Энэ нь Боловсролын ерөнхий хуулийн 39.1 дэх заалт, мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуулийн 17.1.1 дэх заалт, 17.1.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Сурагчдад нөхөн хангалтаар ирж байсан хуучин хөгжмийн зэмсгүүд нь төрийн болон цэргийн ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа, гадаадын улс орнуудтай дипломат харилцааг бэхжүүлэх үйл хэрэгт жилийн 4 улирлын бүхүй л нөхцөлүүдэд үүрэг гүйцэтгэхэд ашиглагдаж байжээ. Эндээс үзвэл Монгол улсын цаг агаарын эрс, тэс уур амьсгалтай байдаг тул үлээвэр, цохивор хөгжмийн зэмсгийн ашиглалтын хугацааг багасгах, элэгдэл, хоргодолд асар их нөлөө үзүүлж, мэргэжлийн сургалт явуулахад дараах сөрөг хүчин зүйлсийг бий болгосон байна. Үүнд;

1. Хөгжмийн зэмсгийн өнгө үзэмж, чанар муудсан;
2. Хөгжмийн зэмсгийн хөг алдагдсан;
3. Найрал хөгжмийн дуугаралтад сөргөөр нөлөөлсөн;
4. Төгөлдөр хуур хөгжимтэй хөг нийцэл таардаггүй болсон;
5. Үе, үеийн төгсөгчдийн гараас, гарт дамжиж элэгдэл үүссэн;
6. Амьсгалын замаар дамжуулан халдварт өвчин тусгах.


Дээрх байдлаас үзэхэд, ЦХПК-ийн хөгжмийн зэмсэг нь олон улсын болон улсын чанартай мэргэжлийн наадам, уралдаанд оролцоход хөгжмийн зэмсгийн стандарт шаардлага хангадаггүй зэрэг олон сөрөг үр дагаврыг авчирч болзошгүй байна.

Харин хөгжмийн зэмсгүүдийг шинэчилж сургалтад ашигласнаар дараах давуу талууд бий болно хэмээн бид үзлээ. Үүнд;

1. Сурагчид амьсгалын замын өвчин тусгахгүй байх боломж бүрдэнэ;
2. Хөгжмийн зэмсгийн чанар, үзэмж сайжирна;
3. Хөгжмийн зэмсгүүдийн хөг, эгшиг хоорондоо нийцэх боломж бүрдэнэ;
4. Найрал хөгжмийн аялгуу эгшгийн дуугаралт сайжирна;
5. Олон улсын нийтлэг жишигт нийцэхүйц сургалтын орчин бүрдэнэ;

6. Олон улсын тэмцээн уралдаан, наадмуудад амжилттай оролцох боломж нэмэгдэнэ.

Өнөөдөр Монгол улсад үлээвэр, цохивор хөгжмийн чиглэлээр ижил төстэй сургалтын үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын Консерватор /МУК/-ын сургалтдаа ашиглаж буй хөгжмийн зэмсгийн чанар, нөхөн хангалттай харьцуулсан судалгааг судалгааг график 3–д үзүүлсэн байдлаар боловсруулав.



3 дугаар график. ЦХПК, МУК-ын сургалтдаа ашиглаж буй хөгжмийн зэмсгийн чанар, нөхөн хангалтын харьцуулалт

Судалгаанд нийт 6 асуулттай тест боловсруулж асуулгын арга ашиглан авахад дараах байдлаар хариулсан байна. Үүнд;

1. Сургалтад ашиглаж буй хөгжмийн зэмсгийн чанар

–МУК– Зэмсгийн чанар Сайн гэж хариулсан 0%–тай, дунд гэж–95% нь хариулсан бол 5 % нь муу гэж хариулжээ.

–Харин ЦХПК Зэмсгийн чанар Сайн гэж хариулсан 0%–тай, дунд гэж–24% хариулсан бол 76 % нь муу гэж хариулжээ.

2. Хөгжмийн зэмсгийн нөхөн хангалтын хугацаа

–МУК– 5–10 жилд 7%, 10–15 жилд нэг удаа гэж 88 % нь хариулсан бол 15 аас дээш жил гэж 5% хариулжээ.

–Харин ЦХПК– 5–10 жилд 11%, 10–15 жилд нэг удаа гэж 15 % нь хариулсан бол 15 аас дээш жил гэж 74% хариулжээ.

3. Хөгжмийн зэмсгийн хангалтыг хэрхэн шийдвэрлэдэг бэ?

–МУК– Улсаас хангадаг 85%, Сурагчид өөрсдөө авдаг гэж 15 % нь хариулжээ.

–Харин ЦХПК– Улсаас хангадаг 31%, Сурагчид өөрсдөө авдаг гэж 69 % нь хариулжээ.

Судалгаанаас үзэхэд сургалтын байгууллагуудын ашиглаж буй хөгжмийн зэмсгүүд чанарын зөрүү ихтэй байна. Мөн хөгжмийн зэмсгийн нөхөн хангалтыг харьцуулан



үзэхэд 10–15 жил дутам шинэчилдэг хэмээн МУК–ийн багш нар хариулжээ. МУК–ийн Үлээвэр цохивор хөгжмийн тэнхим нь суралцагчдаа Япон улсын “YAMANA” фирмийн хөгжмийн зэмсгээр сурагчдаа голчлон хангахын зэрэгцээ 10–15 жил тутамд холбогдох яамдаараа дамжуулан нөхөн хангалтаа хийсээр байна. Түүнчлэн Дуурь бүжгийн эрдмийн театр, Монгол улсын филарманийн ашиглаж байсан эдэлгээ багатай хөгжмийн зэмсгүүдээр тогтмол шинэчлэн сайжруулсаар байгаа нь тус сургуулийн бас нэгэн давуу тал юм.

#### Дүгнэлт

1. Өнөөдөр ЦХПК –ийг нийт 381 мэргэжлийн хөгжимчид төгссөн байна. Анх байгуулагдсанаас хойш 34 жилийн хугацаанд сургалтын үйл ажиллагаанд зориулж нийт 4 удаагийн 164 ширхэг хөгжмийн зэмсгээр нөхөн хангалт хийгдсэн нь нийт төгсөгчдийн тоо судалгаатай харьцуулбал огт хангалтгүй үзүүлэлт байна.

Мөн нөхөн хангалтаар ирсэн хөгжмийн зэмсгүүд нь ашиглалтын хугацаа дууссан хэдий ч гараас гарт дамжин, одоо ч ашиглагдсаар байна.

2. ЦХПК–д суралцаж буй хөгжмийн 1, 2, 3, 4 дүгээр ангийн нийт 86 суралцагчдын сургалтад ашиглаж буй хөгжмийн зэмсэгт судалгаа хийж үзэхэд хувийн данстай хөгжимтэй 59 сурагч, ЦХПК–ийн данстай хөгжим – 25 сурагч, огт хөгжмийн зэмсэггүй 2 сурагч байна. Нийт сурагчдын 68.6% –нь хувийн хөгжимтэй, 29% –нь сургуулийн данстай хөгжмийн зэмсгийг ашиглаж байгаа бол үлдсэн 2.4% нь хөгжмийн зэмсгээ дундаа ашиглаж байна.

3. Өнөөдөр сурагчдын ашиглаж буй хөгжмийн зэмсэг нь ашиглалтын хугацаа дууссанаас хойш 15 түүнээс дээш жил болж байна. Эдгээр хөгжмийн зэмсгүүд нь чанар муутай, ашиглалтын хугацаа дууссан нь найрал хөгжимд хамсран хөгжимдөх үед хөг нийцэлгүй хагас тон доор эсвэл дээр дуугарах тохиолдол цөөнгүй байдаг байна. Үүнийг уруулын тусламжтай тааруулах боломжтой боловч 3 болон түүнээс дээш ноотны өнгө зөрөх үед хөг нийцүүлж хөгжимдөхөд суралцагчдад хүндрэл учирдаг нь сурагчдын сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байна.

4. Судалгаанаас үзэхэд, суралцагчид цаг агаарын –40 өөс +40 хэмийн халуун, хүйтэнд газар орны байрлалаас үл хамааран

өөрийн эзэмшиж буй хөгжмийн зэмсгээрээ дадлага, сургуулилт хийж, цэргийн ёслолын үйл ажиллагаануудад оролцож байна. Мөн сургуулиа төгсөөд төрийн ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэдэг ба гадаадын төрийн дуулал хөгжимдөх үед нэг ноот хагас тон доор эсвэл дээр дуугарах үед хоёр орны дипломат харилцаанд сөрөг үр дагаврыг авчрах эрсдэлтэй байна. Тэгэхээр хамгийн сайн хөгжмийн зэмсгийг авч хүнийг сургахгүй л юм бол үүний цаана тэдний хөгжил орхигодож, ажлын байранд очоод хөг эгшгийнхээ нийцтэй дуугаралтыг сонсож чадахгүйд хүрч байгаа нь харагдаж байна.

ЦХПК нь өнөөдрийг хүртэлх хугацаанд сургалтын хөтөлбөрийн стандартад нийцсэн шинэ хөгжмийн зэмсгээр огт хангагдаагүй ба цаашид сургалтын чанарыг сайжруулахын тулд хөгжмийн зэмсгийн нөхөн хангалт хийх цаг нь болжээ.

Судалгаа хийх явцад хөгжмийн зэмсгийн нөхөн хангалтыг дараах байдлаар шийдвэрлэх боломжтой хэмээн үзлээ. Үүнд;

– Боловсролын ерөнхий хуулийн 38.5.1. 38.5.7. 38.5.10. 15.1.4 дэх

заалтуудыг тус тус үндэслэн Боловсролын ерөнхий газар болон холбогдох байгууллага болох Батлан хамгаалах яаманд хөгжмийн зэмсгийн нөхөн хангалтын авах боловсруулсан төслийн санал хүргүүлэх, шийдвэрлүүлэх;

– Боловсролын ерөнхий хуулийн 24.1.5, 38.2–дах заалтыг үндэслэн Монгол

Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 28 ны өдрийн 58 дугаар тогтоол, журам батлах тухай; Энэхүү тогтоолд нийцүүлэн 2024 оны 04 дүгээр сарын 17–ны өдрийн 164 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Монгол улсын консерваторын хөгжмийн дээд боловсролын сургалтын байгууллагад нэмэлт санхүүжилт олгох журам”–аа боловсруулж батлуулсан байна. Мөн дээрх хуулийн заалтад Мэргэжлийн болон Техникийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг хүүхдийн тоо, хэрэглээний үнийн дүнгийн үнэлгээнд үндэслэн төсөв тооцох, санхүүжүүлэх журам батлахаар тусгасан байдаг. Бид журмаа боловсруулан батлуулж жил бүр хувьсах зардлаа тооцуулж сургалтын орчин, хөгжмийн зэмсгийн нөхөн хангалтыг шийдвэрлэх боломж байна;

– Батлан хамгаалахын сайдын 2009 оны 06



дугаар сарын 10 ны 173 тоот

тушаалын хэрэгжилттэй ижил төстэй үйл ажиллагааг зохион байгуулах боломж мөн байна. Тодруулбал; холбогдох хууль дүрмийн дагуу МУ-ын Батлан хамгаалах яамаар дамжуулан БНТУ-ын Батлан хамгаалах яамд хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хөгжмийн зэмсгийн санал хүргүүлэх боломж бас байна.

5. Монгол Улсад “Цэргийн үлээвэр найрал хөгжим”-ийн хэрэгцээ шаардлага жилээс жилд өсөн нэмэгдсээр байна. Иймээс бид тус

сургуулийн материаллаг баазыг анхаарахгүй юм бол ҮЖҮНХ, ЦДБЭЧ, Зэвсэгт хүчний анги салбаруудад мэргэжлийн хөгжимчдийг бэлтгэхэд анхаарах шаардлага тулгарч байна.

6. Нийгмийн соёл, хөгжмийн боловсрол, дипломат харилцаа, төрийн болон цэргийн ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлдэг урлагийн энэ салбарын сургалтыг сайжруулахад хөгжмийн зэмсгийн нөхөн хангалт зайлшгүй шаардлагатай болжээ хэмээн нэгтгэн дүгнэж байна.

#### Ашигласан материал:

1. БХТА. БХЯ-ны сан. Х-85 Х/н -ҮБХИС-ийн тушаалын хуулбар.
2. ҮБХИС-ийн сан. Х-85 Х/н -ҮБХИС-ийн тушаалын хуулбар.
3. Ганбат Г., Ганбат Ч., “Цэргийн хөгжмийнхөн”. - УБ., 2019 он
4. Дэндэв Ж., “Зэмсэг судлал” - УБ., 2001 он
5. “Цэргийн хөгжмийн коллежийн түүхэн замнал” хамтын бүтээл. - УБ., 2021 он
6. “Цэргийн хөгжим” сэтгүүл ᠑1 - УБ., 2016 он
7. Зэвсэгт хүчний цэргийн хөгжмийн албаны дүрэм. - УБ., 2017 он
8. <https://legalinfo.mn/mn/detail/12122>

## МОНГОЛЧУУДЫН ЦЭРЭГ БИЕ ХҮНИЙГ СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЖ ИРСЭН ҮЗЭЛ САНААНЫ ҮНДЭС БҮРЭЛДЭН БИЙ БОЛСОН ЗАРИМ АСУУДАЛД

**Х.ОРХОНЧИМЭГ** /УБХИС-ийн АБДС-ийн НУТ-ийн багш, доктор (Ph.D), профессор/

**Түлхүүр үг:** Цэрэг, овог, үзэл санаа, үндэс

**Key words:** Soldier, tribe, ethos, stem

### Оршил.

Монголчууд эх болсон газар нутгаа монгол хүн бүрийн амин чухал эрх ашиг гэж хамтран хамгаалж ирсэн түүхэн уламжлалтай ард түмэн юм. Эртнээс аливаа хүндрэл бэрхшээлийг эр зоригийн хүчээр даван туулж, дэвшин хөгжиж байв. Ахмад настнаа хүндлэн, тэдний нэр хүнд, мэдлэг туршлагад түшиглэн эрдэм ухааны эрхэм баян хэмээн тэргүүн зэрэгт тавих, аливаа зүйлийг авсаархан мөртлөө оновчтой, хэрэглээгээ хангах өргөн боломжтой хийж бүтээж, хэрэглэдэг онцлогтой юм. Чухам дээрх онцлогийн үр дүнд монголчуудын цэрэг бие хүнийг сургаж хүмүүжүүлж ирсэн үзэл сургаалын үндэс бүрэлдэн бий болсон. Монголчуудын эртнээс цэрэг бие хүнийг хүмүүжүүлж ирсэн үзэл санааны үндэс хэрхэн бүрэлдэн тогтох болсныг судлах шаардлага байсаар байна. Иймд тус өгүүлэлд монголчуудын цэрэг бие хүнийг хүмүүжүүлж ирсэн үзэл санааны үндэс бүрэлдэн бий болсон зарим асуудлыг тодруулахаар зорилоо.

Судлан буй асуудал нь Монгол угсаатны үйл явц бүрэлдэх ба задрах үйл явц нийгмийн бүх үйл явцтай ямар нэг хэмжээгээр холбоотой. Угсаатан бүрэлдэн бий болж төр улс оршин тогтноход нэгтгэх нэгэн хүч бий болдог нь төр улсыг эрхэмлэх үзэл санаа юм. Чухам улсын иргэн байх цэрэг бие хүний бие сэтгэл, зориг хүсэл эх орноо хамгаалах үзэл санаан дээр тулгуурлан бий болжээ.

В.И.Козлов “...хүмүүс өөрсдийгөө ямар нэгэн ард түмэнд хамааруулан ухамсарлах явдал нь үндэстнийг бүрэлдүүлдэг.”<sup>1</sup> Л. Н.Гумилев “Хүмүүсийн ухамсараас үл хамааран угсаатан бүрдэх үйл явц явагдах бөгөөд эерэг таарамж, нийлэмжийн чанартай хүмүүс өөр хоорондоо ойртон нийлж, угсаатны

нийтлэгүүдийг бүрэлдүүлдэг байна. Аливаа ард түмнийг ард түмэн болгож байгаа хүчин зүйлс нь гарал үүсэл зэрэг илэрхий гадаад зүйлст байдаггүй, харин тухайн ард түмний гишүүн бүхэн өөрийгөө нэг ард түмэн гэж үзэх явдал юм.”<sup>2</sup> гэжээ.

Өөрөөр хэлбэл ард түмэн өөрсдийгөө тухайн улсын ард түмэнд хамааруулж ойлгох, өөрийгөө тэр ард түмнийх гэж үзэх үзэл санаан дээр үндэслэн оршин тогтнодог. Тухайн ард түмний нийтлэг бүрэлдэн бий болох нь нарийн төвөгтэй үйл явц бөгөөд хэл, соёл, сэтгэлгээний адилсал бий болоход улс төрийн нэгдэл буюу нэгэн төрийн дор нэгдэн төр улс бий болох нь гол нөлөөтэй.

Судалгаанаас үзэхэд үндэстэн оршин тогтнох гол үндэс нь тухайн үндэстний сэтгэлгээний адилсал буюу тухайн улсын иргэн хүн гэсэн үзэл санаа юм. Монгол цэрэг бие хүнийг сургаж зоригжуулж ирсэн үзэл санаа чухам энд л оршино.

Монгол нутагт амьдрагсад нэгэн үзэл санаатай болж байсны илрэл бол эцгийн эрхт овог бүрэлдэж эхэлсэнтэй холбогдоно. Эхийн эрхт овгоос эцгийн эрхт овогт шилжсэнээр овгийн гол хандлага нь нийгэм–аж ахуйн нэгж болон хувирч ураг нь садан төрлийн эрх үүрэг бүхий хувь хүмүүсийн дотоод нийтлэг болон үлджээ. МЭӨ II мянган жилд Монгол нутагт амьдарч байсан овог аймгийн нийгэмд хүй нэгдлийн овгийн байгууллын задрал хүчтэй явагдаж, нийгмийн бүтцийн шинэ хэлбэрүүд бүрэлдэж эхэлсэн. Хүй нэгдлийн байгууллын задралын явц нутаг нутагт харилцан адилгүй өрнөжээ. Монгол нутагт хүй нэгдлийн байгуулал задрах явц Хүрэл зэвсгийн үед эхэлсэн ба энэ үеийг цэргийн ардчиллын үе гэж нэрлэдэг. Хүрэл ба Төмөр зэвсгийн түрүү үед Монгол нутагт амьдрагсдын нийгэмд эцгийн эрхт овог ноёрхож, тэдний амьдралд цэрэг

<sup>1</sup> Бромлей.Ю.В. Очерки теории этноса.М.,1983. Дэлгэржаргал.П.Монголчуудын угсаа гарвал. УБ.,2005.т.22

<sup>2</sup> Гумилев.Л.Н.Этногенез и биосфера.М.,1994.т.6



эрс, дайн байлдаан чухал үүрэгтэй болсон нь археологийн олон баримтаас харагддаг. Төмөр зэвсгийн эхэн үед амьдрагсад өвөг дээдсийг, овог өрхийн онгийг шүтэн биширч оршуулгын нарийн дэг мөрдөж байсан. Цаашид монгол нутагт амьдрагсад овог, аймгийн зохион байгуулалтанд шилжиж, төр улсын бүрдлийн эхлэлийг тавьсан.

Овог нь “...өвөг дээдэс нэгэн бүхий учир ураг төрлийн барилдлагаар холбогдсон, овгийнхоо хүрээнд харилцан дотносох, бусдыг хүнийсэх, өнчин ядуусыг тэтгэн өргөх, тодорхой нэртэй энэ нь тухайн овгийн хүчин чадал, мандал буурлын гэрч баталгаа болдог, нийтийн нутагтай, гал голомт нэгтэй, нийтийн оршуулгатай, нийтийн хурал цуглаантай, сүлд тугтай, им тамгатай, өв хөрөнгөтэй, нийтээр дагаж мөрдөх өвөрмөц ёс заншил бүхий”<sup>3</sup> байсан нь хамтын үзэл санаан дээр суурилсан бүрэлдсэн болохыг харуулж байна.

Хүннү улс байгуулагдсанаар угсаатны адилсал улам эрчимтэй явагдаж, Алтайгаас Хянганы уулс, Байгаль нуураас Цагаан хэрэм хүртлэх өргөн уудам нутагт Хүннүгийн угсаа-соёлын нэгдэл бүрэлдэн тогтжээ. Монгол нутаг дээр ээлж дараалан төр улсаа эмхлэн зохион байгуулсан улсууд нэгдмэл нэгэн бүхэллэгийг бий болгосоныг түүхийн үйл явцаас харж болно.

Монгол нутаг дахь эртний улсууд нь нүүдэлчдийн нийгмийн бүтцийн онцлогоос үүдэн хэд хэдэн аймгууд нэгдэн ханлиг болдог бөгөөд холбооны маягийн бүтэцтэй бие даасан олон аймгуудын нэгдлээс бүрэлддэг байсан байна. Аймгийн нэгдлүүд нь хэл, угсаа, соёлын хувьд янз бүр, байсан төдийгүй аль хүчирхэг аймгийн нэгдлийн манлайлал дор нэгдэн тэдний ноёрхлыг хүлээн зөвшөөрдөг байсан. Энэ нь ч аргагүй бөгөөд угсаатны адилсал явагдах үйл явц удаан хугацаанд бүрэлдэн тогтдогтой холбоотой. Угсаатны сэтгэлгээний адилсал бүрэлдэхэд олон хүчин зүйл нөлөөлдөг, нилээд ээдрээтэй, нарийн төвөгтэй үйл явц бөгөөд уламжлалт нийтлэгүүдийг эвдэх, овог аймгуудын ялгарлыг багасган ойртон нягтруулах үйл явц үндсэндээ нүүдэлч овог аймгууд нэгэн төрийн дор нэгдсэний дараа төрийн бодлого зохицуулалтаар шийдвэрлэгдэн өрнөн явагддаг байна.

Монголчуудын үндэсний цэргийн сургалтын үзэл үүсэн бүрэлдэхэд байгаль, цаг уур, газар зүйн хүчин зүйл чухал нөлөөлсөн. Монгол орон

<sup>3</sup> Гонгор, Д. Халх товчоон. II. УБ., 1978. т. 8–9

говь тал, уул, ус хосолсон өргөн уудам газар нутагтай, байгалийн эрс тэс уур амьсгалтай билээ. Байгаль, цаг уур, газар зүйн энэхүү өвөрмөц нөхцөл, хүчин зүйл нь Монголчуудын төр, улсаа удирдах үйл ажиллагааны хэв маяг, үзэл, сэтгэлгээнд зүй ёсоор нөлөөлсөн юм. Тухайлбал, энэ нь Монголчуудын аж төрөх ёс, амьдралын хэв маягт тодорхой нөлөө үзүүлээд зогсоогүй байгаль, цаг уурын хатуу шалгарлын эсрэг тэдний хамтын үйл ажиллагаа, хамтарсан хүч чармайлтыг зүй ёсоор нөхцөлдүүлсэн юм.

Энэ тухай Н.Хавх “Гегель аливаа улс үндэстний хөгжил, эрхэлсээр ирсэн аж ахуй ухамсарын онцлогыг тэдний үеийн үед амьдарсаар ирсэн газар нутгийн байгаль цаг уурын нөхцөлтэй холбон тайлбарлаж болно “...өргөн уудам, тал хөндий ус чийг багатай уул толгод хосолсон нутагт амьдардаг ард түмэн нүүдлийн аж ахуй эрхэлж, эцгийн эрхт ёсонд суурилсан нийгмийн байгуулалтай, ард иргэд нь хэт туйлширсан сэтгэл зүйн онцлогтой байж, түргэн хувьсан өөрчлөгдөж байдаг нь ч тэдний оршин амьдарч байдаг байгаль цаг уурын нөхцөлтэй холбоотой”<sup>4</sup> гэжээ. Байгаль дэлхийтэйгээ зохицон амьдарч ирсэн ард түмэн байгаль, цаг уурын өөрчлөлтөнд тэсвэр хатуужилтай аливаа өөрчлөлтийг даван туулах чадвар өндөр байдаг нь тэдний үеийн үед амьдарч ирсэн газар нутгийн онцлогтой нь холбоотой.

Тийм ч учраас газар нутгийнхаа төлөө амь биеэ бүрэн зориулах үзэл санаа эрт үеэс л төлөвшин тогтжээ.

Монголын төр, нийгмийн хамгийн хүчирхэг, хүчтэй байсан хөгжлийн үе бол олон монгол аймаг, улс нэгдэн, их цаазат хуульт, төр улс нэгдсэн үе буюу XIII зуун болно. Тархай бутархай, өөр хоорондоо хямрал тэмцэлтэй байсан олон Монгол аймгийг Чингис хаан нэгтгэн захирч, хүчирхэг нэгдмэл төр улс байгуулснаар барахгүй тухайн үеийн олон улсад хүрээ нөлөөгөө түгээж чадсан. 2000 жилийн тэртээгээс монголд төрт улс байгуулагдсан нь иргэн төлөвшилтөнд хүчтэй нөлөөлсөн нь дамжиггүй бөгөөд тухайн үеийн төр нийгэм, улсын бодлого зорилгод нийцсэн тийм төгөлдөр бие хүнийг хүмүүжүүлэх явдал ч мөн чухлаар тавигдах болжээ. Энэхүү хүн нийгэмших үйл явц нь хүнийг үзэх, үнэлэх, шинжин таних, хүншүүлэх, хөгжүүлэх үзэл үнэлэмжид шинэ ахиц дэвшил болж, сурган

<sup>4</sup> Гегель. Философия историй. СПб. 1993. стр. 57. Хавх. Н. Соёл иргэншлийн онол. УБ., 2004. т. 86–87



боловсруулах үзэл санаа гүнзгий бүрэлдэн тогтож, улмаар энэхүү үзэл санаа нь нийгмийн оюун сэтгэлгээний хүрээнд боловсорч сурган хүмүүжүүлэх үзэл сэтгэлгээ болон хөгжжээ.

Дээрх бүгдийг товч дүгнэхэд Монгол угсаатны үйл явц бүрэлдэх ба задрах үйл явц нийгмийн бүх үйл явцтай ямар нэг хэмжээгээр холбоотой бөгөөд угсаатан бүрэлдэн бий болж төр улс оршин тогтноход нэгтгэх нэгэн хүч бий болдог нь төр улсыг эрхэмлэх үзэл санаа юм. Чухам улсын иргэн байх цэрэг бие хүний бие сэтгэл, зориг хүсэл эх орноо хамгаалах үзэл санаан дээр тулгуурлан бий болжээ. Үндэстэн оршин тогтнох гол үндэс нь тухайн үндэстний сэтгэлгээний адилсал буюу тухайн улсын иргэн хүн гэсэн үзэл санаа юм. Монгол цэрэг бие хүнийг сургаж зоригжуулж ирсэн үзэл санаа

чухам энд л оршино.

Монгол нутагт амьдрагсад нэгэн үзэл санаатай болж байсны илрэл бол эцгийн эрхт овог бүрэлдэж эхэлсэнтэй холбогдож буйг тодрууллаа. Цаашид өнө эртнээс өдгөөг хүртэлх монголчуудын туулсан уртын урт цагийн шугам дээр нийгмийн хөгжлийн онцлог чухал үеүдийг товч тэмдэглэн дурдах маягаар, энэ үеүдэд үндэстэн угсаатны мандал буурал өвөл зун мэт солилцсон, үндэсний сэргэн мандлын онцгой үеүдэд монгол цэргүүд хэрхэн сурч боловсорч хэрхэн төлөвшсөн, цэрэг бие хүнийг үзэх үнэлэх сэтгэлгээнд ямар өөрчлөлт гарсан хийгээд монгол цэргийн сургалтын хөгжлийн загвар, онолын үзэл баримтлал ямар байсныг тодруулж үзэх нь чухал байна.

#### Ашигласан материал:

1. Бромлей.Ю.В. Очерки теорий этноса.М.,1983.Дэлгэржаргал.П.Монголчуудын угсаа гарвал.УБ.,2005.т.22
2. Гонгор.Д. Халх товчоон.И.УБ.,1978.т.8-9
3. Гумилев.Л.Н.Этногенез и биосфера.М.,1994.т.6
4. Гегель.Философия историй.СПБ.1993.стр.57.Хавх.Н.Соёл иргэншлийн онол. УБ.,2004.т.86-87



## ЦЭРГИЙН УДИРДЛАГЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫГ АШИГЛАХ

**Э.ЖАЛБУУ** /Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Батлан хамгаалахын удирдлагын академи -Магистрант/

**Түлхүүр үг:** Цэргийн удирдлага, Хиймэл оюун ухаан.  
**Key words:** Military leadership, artificial intelligence

### Оршил.

Цэргийн удирдлагын шийдвэрт, хамт олны сэтгэл зүйн хүчин зүйл, үйл ажиллагааг боловсронгуй болгох, цаашид авах арга хэмжээ зэрэг асуудлуудыг судалгаанд тулгуурлан орчин үеийн дайны шинж чанар, хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдалд нийцүүлэн шийдвэр гаргах нь чухал шаардлага болсон. Энэхүү судалгааны ажлын зорилго нь хиймэл оюун ухааныг цэргийн удирдлагад нэвтрүүлж, түүнийг шийдвэр гаргалт, үүрэг гүйцэтгэлийн зохион байгуулалт, орон зайн мэдрэмж болон цагийн хүчин зүйлд хэрхэн үр дүнтэй ашиглаж болохыг судлахад оршино.

Цэргийн удирдлагыг зохион байгуулахад хиймэл оюун ухааныг дэлхийн улс орнууд өргөнөөр ашиглаж эхлээд байна. Хиймэл оюун ухааны систем нь машины хүрэхүй, ойлгогдож буй орчны мэдээллээс дүгнэлт хийх, камер, микрофон зэрэг мэдрэгч төхөөрөмжүүдээр орчныг бүрэн хянах, дүн шинжилгээ хийх зэрэг олон талт чадвартай. Өөрөөр хэлбэл, сонгосон объектын тухай яриа, нүүр царай, өнгө зэргийг таних замаар автомат шийдвэр гаргах, нөхцөл байдлыг урьдчилан үнэлэх зэрэг үйл ажиллагаанд тус дөхөм болохуйц дэвшилтэт систем юм.

Судалгаанд хиймэл оюун ухаан ямар зарчмаар ажилладаг, цэргийн орчинд хэрхэн ашиглагдаж болох талаар онолын болон практик үндэслэлээр хандаж, үр дүнг цэргийн сургалт, удирдлагын зохион байгуулалтад хэрхэн хэрэглэх боломжийг судлав.

### 1. УДИРДЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Байлдаанд цэргийг удирдах ажиллагаанд байнгын тогтвортой, тасралтгүй, шуурхай, нууц байх гэсэн шаардлагууд тавигддаг бөгөөд зохион байгуулалтын үндэс нь удирдлагын тогтолцоо юм.<sup>1</sup> Удирлагын тогтолцоонд удирдлагын байгууллагууд, удирлагын

байрууд, удирдлагын хэрэгсэл болох холбоо, автоматжуулалтын болон тусгай хэрэгслүүдээс бүрдэж байдаг.

### Цэргийн удирдлагын системийн автоматжуулалтын онол

Мэдээллийн эрин зууны зэвсэгт тэмцлийн прагматик нь мэдээллийн солилцоо, цагийн байдлын талаарх мэдээллийг авах, тагнуулын мэдээг олзворлох түгээх цэгүүд, цэргийн удирдлага ба хяналтанд суурилах чиглэлд өөрчлөгдөх болсон. Өргөн уудам газар нутагт тархсан, тэгш хэмгүй, түргэн өөрчлөгдөх тактикийн цагийн байдлуудын тухай мэдээллийг цаг тухайд нь солилцох чадавх бүхий мэдээллийн өргөн сүлжээтэй цэргийн хүч нь үргэлж давуу байдлыг олж авах хандлагатай байна.

Өнөө үед цэргийн удирдлагад байлдааны ажиллагааны өргөн уудам талбарыг бүхэлд нь хамарсан дуу, дүрс, видео бичлэг зэрэг хангалттай мэдээлэл, стратеги, оперативын түвшний өгөгдөлд үндэслэн цагийн байдлыг шуурхай үнэлэх, үндэслэлтэй шийдвэрийг түргэн гаргаж, цэрэгт үүргийг богино хугацаанд хүргэх боломжоор хангагдсан байх шинэ шаардлага тавигдаж байна.

Дэлхийд цэрэг-техникийн хөгжлөөр тэргүүлж буй улс орнууд сүүлийн үед Зэвсэгт хүчнийхээ холбоо, мэдээллийн системийг өөр хоорондоо харилцан уялдаа холбоо бүхий тактикийн болон стратегийн зориулалтай болон өөрчлөн, шинэчлэх үйл ажиллагааг идэвхтэй явуулж, түүндээ шинэ гарсан техник технологийг эхний ээлжинд туршиж, цаашид байнгын хэрэглээ болгож байна. Иймд цэргийг тасралтгүй, шуурхай, үр дүнтэй удирдахын тулд удирдлагын тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг болсон холбоо, мэдээллийн техник улам бүр боловсронгуй болж байгаа өнөөгийн нөхцөлд тэдгээрийг зэвсэглэлд шуурхай нэвтрүүлэх, цэрэг, зэвсгийн удирдлагын үр өгөөжийг

<sup>1</sup>Цэргийн удирдлагын үндэс Паламдорж.Ш, 2003 он



дээшлүүлэхэд ихээхэн анхаарах шаардлага бий болж байна.

### **Цэргийн удирдлага**

- онол,
- систем,
- мөн чанар,
- агуулга

### **УАС-ийн мөн чанар**

Стратегийн нэгжүүдийн удирдлагын команд болон дохиог цаг хугацаанд нь хүлээн авч, тактикийн нэгжүүдийг удирдлагад шуурхай хүргэх, дээд болон харилцан ажиллаж байгаа штабуудын удирдлагын төв, байрууд болон доод шатны удирдлагын байруудын хооронд дуу, өнгөт болон дүрст мэдээ, мэдээллийг солилцох, бүх шатны удирдлагын байруудын хооронд хэлбэржүүлсэн болон хэлбэржүүлээгүй мэдээллийг солилцох, цэрэг, зэвсгийг хэрэглэх үндэслэлтэй шийдвэр гаргахад чиглэгдсэн бодлогын даалгавруудыг боловсруулах, албан тушаалтнуудын боловсруулсан бүх төрлийн баримт бичгүүдийг автоматжуулахад оршино<sup>2</sup>.

Автоматжуулалтын техник хэрэгсэл ашиглахын учир холбогдол нь даргалах бүрэлдэхүүнийг бүтээлч бус хөдөлмөрөөс бүх талаар чөлөөлж, хүний боломжоос олон зуу, мянга дахин хурдан, ямар ч алдаагүй ажилладаг мэдээлэл, тооцооллын техник хэрэглэх технологийн үйл ажиллагаанд оршино.

### **Удирдлагын автоматжуулсан системийн ангилал<sup>3</sup> нь:**

- Удирдлагын үйл ажиллагааны хүрээ;
- Удирдлагын үйл ажиллагааны төрөл.

### **Удирдлагыг 5 чиг үүргээр хэрэгжүүлдэг.**

- Стратегийг төлөвлөх;
- Төлөвлөлтийг хэрэгжүүлэх;
- Стратегийн үүргийг хэрэгжүүлэх ажиллагааг зохицуулах;
- Стратегийн үр дүнд хүрэх ажиллагааг идэвхжүүлэх;
- Стратегийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих.

### **Цэргийн удирдлагын автоматжуулсан систем (ЦУАС) нь**

- Стратегийн,
- Оперативын,
- Тактикийн гэсэн 3 түвшинд хуваана.

### **ЦУАС нь дараах төрлийн хангалтын төрлүүдтэй байна. Үүнд:**

- Мэдээллийн;
- Програмын хангамжийн;
- Техник хангамжийн;
- Зохион байгуулалтын;
- Хэмжил зүйн;
- Эрх зүйн хангалтууд ордог

Удирдлагын байгууллагуудыг бүр орчин үеийн холбооны хэрэгсэл болон тусгай компьютеруудаар хангасан байлаа ч байлдааны талбар дээр цэрэг, тагнуул болон зэвсгийн удирдлагын шуурхай байдлыг дээшлүүлсэн гэж үзэж болохгүй юм. Цэрэгт удирдлагын автоматжуулсан тусгай цогцолбор зайлшгүй байх хэрэгтэй юм.

### **Цэргийн удирдлагын системийн автоматжуулах арга зам**

Цэргийн удирдлагын автоматжуулсан систем<sup>4</sup> бол цэргийг удирдах үр ашиг өндөртэй хэрэгсэл юм. Удирдлагын автоматжуулсан систем, цэргийн болон зэвсгийн удирдлагын бүтээмжийг дээшлүүлэх зориулалттай байдаг. Үүний тулд оперативын мэдээлэл болон байлдааны удирдлагын дохионуудыг маш богино хугацаанд цуглуулах, дамжуулах, дүрслэх, хадгалах, боловсруулах, ажиллагааны шуурхай, найдвартай, тогтвортой байдлыг хангахуйц мэдээллийн технологийн боломжийг ашиглана.

ЦУАС нь цэргийн болзошгүй ажиллагааны загварчлал гаргах болон тооцоог хурдан, чанартай хийх бололцоогоор хангана. Манай улсын ЗХ-ний нэгтгэл, анги, салбарууд ЦУАС-ийн хэрэгслийн хувьд бараг байхгүй буюу доод төвшинд байна. Гадаад орнуудын туршлага сургамжаас харахад Монгол Улсын хувьд цэргийн удирдлагын системийг автоматжуулах дараах үе шаттай арга замууд байж болох юм гэж үзэж байна. Үүнд:

- Бодлого тодорхойлох;
- Хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Нөхцөлийг бүрдүүлэх;
- Хүний нөөцийг бэлтгэх;
- Техник технологиор хангах арга зам.

Цэргийн удирдлагын системийг автоматжуулах асуудлаар бодлого тодорхойлж хэрэгжүүлэх арга зам гэдэг нь төрөөс цэргийн удирдлагын системийг автоматжуулах чиглэлээр баримтлах бодлогыг үндэслэлтэй

<sup>4</sup> Цэргийн удирдлагын автоматжуулсан системийн мэдээлэл хамгаалах технологийг сайжруулах арга зам / Цэргийн ухаанаар докторын зэрэг горилсон диссертаци/ 2019 он

<sup>2</sup> Цэргийн удирдлагын үндэс Улаанхүү.Ч, 2005 он

<sup>3</sup> Операци, Байлдаанд цэргийн удирдлага Түмэн.Б, Ганбямба.С, Ганзориг.Г, 2021 он



тодорхойлсны үндсэн дээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, хэрэгжүүлэх асуудал юм. Нөхцөлийг бүрдүүлэх арга зам гэдэг нь шинжлэх ухаан, инновац, үйлдвэрлэлийн чадавхыг бүрдүүлэх замаар цэргийн удирдлагын системийг автоматжуулах суурь нөхцөлийг бүрдүүлэх асуудал юм.

**ЦУАС–ийг байгуулах дараах стандарт үе шатууд байна.**

1. АС–д тавих шаардлагыг боловсруулах;
2. АС–ийн загвар боловсруулах;
3. Техникийн даалгавар хийх;
4. Зураг төсөл хийх;
5. Техникийн төсөл хийх;
6. Ажлын баримт бичгийг боловсруулах үе шатууд орно.

**Цэргийн удирдлагын автоматжуулсан системийн мэдээллийг хамгаалах<sup>5</sup>**

Цэргийн удирдлагын автоматжуулсан системийн онол, практикт хийсэн орчин үеийн нийгмийн хөгжилд удирдлагын гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байна. Шинжлэх ухаан техникийн хөгжил, нийгмийн үйл явцын төвөгтэй байдал, мэдээллийн агуулгын багтаамжийн байнгын өсөлт нь удирдлагын, түүний дотор цэргийн удирдлагын системд өндөр шаардлага тавьж байна. Өндөр хөгжилтэй орнуудын удирдлагын үр ашиг, боломж үлэмж нэмэгдэж, энэ нь цэргийн удирдлагын шинжлэх ухаан, автоматжуулалт, электрон тооцоолон бодох техник, холбооны хэрэгслүүдэд эрчимтэй нэвтэрч байна. Орчин үед байлдааны ажиллагааг явуулах арга, хэрэгслүүд ихээхэн өөрчлөгдөж байгаа нь цэргийн удирдлагад тавигдах шаардлагыг нэмэгдүүлж байна.

Цэргийн удирдлагын чадавх, автоматжуулалт, мэдээлэл, холбооны хэрэгслүүд, тэдгээрийн ажиллагааны найдвартай байдал болон бүх төрлийн тогтворгүйжүүлэгч хүчин зүйлсийн нөлөөллийн үед цэргийн удирдлагын систем дэх мэдээллийн тогтвортой байдал хэрхэн хангагдсанаас хамаарах болоод байна. Иймээс цэргийн удирдлагад түүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн асуудал хурцаар тавигдаж байна.

**Удирдлагын үйл ажиллагаа явагдах орчин:**

1. Амьгүй байгаль дахь удирдлага, түүний дотор машин, техникийн удирдлага;
2. Амьд байгалийн буюу биологийн

<sup>5</sup> Цэргийн стратегийн удирдлагын онол, арга зүйн тулгамдсан асуудал Паламдорж.Ш, 2015 он

удирдлага;

3. Хүний нийгмийн удирдлага;

Амьгүй байгаль, амьд организм, автомат төхөөрөмжийн удирдлага, зохицуулалтын үйл ажиллагааны ерөнхий хууль, зүй тогтлуудыг нээн илрүүлэх тэдгээрийг нийгмийн хүрээний удирдлагын үйл ажиллагаанд ч нийтлэг үйлчилдэг болохыг тогтоодог байсан.

Нийгмийн хүрээний хувьд удирдлага гэдэг нь нийгмийн үйл ажиллагааны функц, түүний бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нийгмийн амьдрал, хөдөлмөрийн явцад хүмүүсийн хамтын үйл ажиллагааг нь зохицуулах шаардлагын үүднээс урган гарсан ухагдахуун юм.

Удирдлага гэдэг<sup>6</sup> нь гадаад орчны хувьсах нөлөөн дор оршиж байгаа тогтолцооны нэгдэл, зөрчлөөс үүсэн гарах тэнцвэртэй байдлыг хангах үйл ажиллагаа.

Удирдлагат тогтолцоо нь түүний физик бүтцээс үл хамааран удирдах байгууллага (субъект), удирдагдах байгууллага (объект), тэдгээрийн хооронд мэдээлэл солилцоход зориулагдсан холбооны шугамаас бүрдэнэ.

**Удирдан зохицуулах үйл ажиллагааны бүтэц**

- нэгдүгээрт мэдээлэх,
- хоёрдугаарт оношлох,
- гуравдугаарт төлөвлөж прогнозчлох,
- дөрөвдүгээрт шийдвэр гаргах,
- тавдугаарт хэрэгжүүлэх,
- зургадугаарт хянах гэсэн зургаан үндсэн үйл ажиллагааны нэгдлээс бүрдэнэ.

**Цэргийн удирдлагын агуулга:**

- Цэргийн бэлэн байдлыг дээшлүүлэх, тэдгээрийн байлдах чадварыг хангах / сэргээн босгох/ арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх;
- цагийн байдлын мэдээг тасралтгүй олзворлож, цуглуулах, судлах, дүрслэн үзүүлэх, задлан шинжлэх, тогтоох; шийдвэр гаргах;
- захирагдагсаддаа үүрэг өгөх; байлдааныг төлөвлөх;
- харилцан ажиллагааг зохион байгуулах;
- бүх талын хангалтын арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх;–
- удирдлагын тогтолцоог зохион байгуулах;

Орчин үед цэргийн удирдлагын агуулгын эдгээр ажлуудаас хамгийн их цаг хугацаа шаардсан ажил болох–байлдааны ба

<sup>6</sup> Цэргийн удирдлагын үндэс Паламдорж.Ш, 2003 он



мэдээллийн орон зайн талбар дээр огцом хувьсан өөрчлөгдөж буй цагийн байдлын талаарх мэдээг цуглуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, боловсруулах, дүрслэн үзүүлэх, шийдвэр гаргахад шаардлагатай тооцоонуудыг бэлтгэх, гаргасан шийдвэрийг анги, салбаруудад видео, цахим, бичгэн хэлбэрээр, найдвартай, тасралтгүй хүргэж, дамжуулах ажиллагааг цэргийн удирдлагын автоматжуулсан хэрэгслийн тусламжтайгаар гүйцэтгэж байна.

Эдгээрийн дотроос цэргийн удирдлагын автоматжуулсан хэрэгслүүдийн хамгийн чухал үүргүүдийн нэг нь–байлдааныг удирдах үндэс болох–захирагчийн гаргасан шийдвэрийг цаг тухайд нь видео, дүрс, цахим хэлбэрээр цэрэгт нууцаар, цаг тухайд нь, мадаггүй, шуурхай хүргэх асуудал юм.

- тасралтгүй;
- шуурхай;
- нууц байх

### **Цэргийн удирдлагын автоматжуулалтын онолын үндэс**

Мэдээлэл, тооцооллын техник хэрэгслийг ашиглаж, цэргийг удирдах байгууллагын ажлыг хөнгөвчлөх үйл ажиллагааг цэргийн удирдлагын автоматжуулалт.

Удирдлагыг автоматжуулах<sup>7</sup> техник хэрэгсэлд тооцоолон бодох электрон машин, мэдээлэл тооцооллын цогцолборууд, түүнчлэн өгөгдөл дамжуулах аппаратур болон удирдах байгууллагын албан тушаалтнуудын ажлын байрыг автоматжуулах төхөөрөмж багтана. Удирдлагыг автоматжуулах техник хэрэгслийн үндсийг цахим төхөөрөмж ба программын удирдлагатай машинууд бүрдүүлдэг.

Орчин үеийн нөхцөлд цэргийн удирдлагыг төгөлдөржүүлэх үндсэн арга зам нь программын удирдлагатай тооцоолон бодох цахим төхөөрөмжийг ашиглаж, цэргийн удирдлагыг автоматжуулах асуудал байна.

Цэргийн удирдлагын автоматжуулалтын мөн чанар нь математикийн орчин үеийн аргууд болон цахим тооцоолох техникийг цэргийн удирдлагын сонирхолд цогцоор ашигласанд оршино.

### **Цэргийн удирдлагын мөн чанар ба үндсэн агуулга**

Цэргийг удирдах онолын анхны байдал нь “цэргийг удирдах” ойлголт (категори)

<sup>7</sup> Цэргийн удирдлагын үндэс Паламдорж.Ш., 2003 он

<sup>8</sup> Цэргийн удирдлагын үндэс Улаанхүү.Ч., 2005 он

юм. Удирдах гэдгийг удирдах субъект, удирдагдах объектдоо нөлөөлөх үйл явц гэж ойлгоно. Удирдлагын үйл явцыг хэрэгжүүлдэг, хангадаг элементүүдийн цогц нь удирдлагын тогтолцоог үүсгэнэ. Удирдлагын тогтолцоо нь удирдлагын субъект ба объект шууд ба буцах мэдээллийн холбооноос бүрдэнэ. Удирдлагын үйл явц удирдлагын субъект, удирдлагын объектын хүрэлцээ, удирдлагын мэдээллийг дамжуулж байдаг удирдлагын субъект ба удирдлагын объект хоорондын холбоогоор тодорхойлогдоно. Удирдлагын объектын мэдээлэл дамжуулах байдал буцах холбооны хүрэлцээнээс, түүнчлэн гадаад орчны нөлөөлөл /дайсны нөлөөлөл, техникийн үүсэлтэй осол болон байгалийн үзэгдэл –түймэр, үер гэх мэт/, дотоод орчны нөлөөлөл цэргийн удирдлагын байдал, тэдгээрийн бэлтгэлийн түвшин, ажиллагаа зохицуулагдсан байдал, цэргийн удирдлагын автоматжуулалтын түвшин болон бусад зүйлээс шалтгаална.

### **2. ХИЙМЭЛ ОЮУН УХААН**

Хиймэл оюун ухаан<sup>9</sup> буюу зохиомол оюун нь компьютерын програм хангамжаар бүтээгдсэн хүний сэтгэхүйг дууриалгасан ба бараг ижил түвшинд хүргэхийг хичээдэг технологийн төрөл ба аливаа хүний хийдэг үйл ажиллагааг хийж орлуулахад зориулагддаг болно. Мөн энэ асуудлыг судалдаг шинжлэх ухааны салбар, судалгааны чиглэл, их дээд сургуулийн хичээл, курсийг нэрлэхдээ энэ нэр томьёог ашиглана. Хиймэл оюун ухаан судлал, хиймэл оюун ухааны хичээл гэх мэт. Ихэнх хиймэл оюун судлаачид болон ном зохиолд судалгааны энэ чиглэлийг тодорхойлохдоо "ухаалаг агент бүтээх шинжлэх ухааны судалгаа"<sup>10</sup> гэсэн байдаг. Энд ухаалаг агент гэж "орчноо танин мэдэж, тохирсон үйлдлийг гүйцэтгэхдээ амжилтад хүрэх магадлалаа дээд зэрэгт хүргэхийг эрмэлздэг систем"-ийг хэлжээ. Анх "Хиймэл оюун ухаан" хэмээх нэр томьёог Жон Маккарти 1955 онд өөрийн бүтээлдээ ашиглаж, "ухаант машин техник бүтээх онолын болон инженерийн шинжлэх ухаан" гэж тодорхойлжээ.

Хиймэл оюун нь өөрөө өөрийгөө хөгжүүлж байдаг программ хангамжийн төгс программ юм<sup>11</sup>. Бид бүхэн хиймэл оюуныг роботоор төсөөлж болно. Гэхдээ ялгаа нь өнөөгийн робот бол зөвхөн тухайн зохиогчийн бичигдсэн

<sup>9</sup> <https://mn.wikipedia.org/>

<sup>10</sup> <https://news.xopom.com/>

<sup>11</sup> <https://www.google.com/>



алгоритмын дарааллаар ажилладаг билээ. Мөн өнөөгийн компьютер тоглоомууд нь үүний тод жишээ юм. Хэрэв бид төгс хиймэл оюуныг зохион бүтээх аваас хүн төрөлхтөн өөрсдийнхөө бүтээсэн зүйлд устаж үгүй болох аюул магадлал байгаа. Хиймэл оюунд байвал зохих чадварууд:

1. Өөрт дүн шинжилгээ хийж, хариултыг өөрийнхөөр илэрхийлдэг байх.

2. Өөрийнхөө алдааг өөрөө олж засварладаг

3. Хүний сэтгэхүйгээс илүү давсныг сэтгэх

Дэлхийн хоёрдугаар дайны дараа, хэсэг бүлэг хүмүүс бие даан оюун ухаант машиныг хийхээр ажиллаж эхэлсэн. Английн математикч Алан Тюринг 1947 онд анхны судалгаагаа танилцуулсан. Тэрээр машин бүтээхээс илүү компьютерын програмчлалаар<sup>12</sup> ХО–г судлах нь хамгийн сайн гэдгийг анх шийджээ. 1950 оны сүүлээр ХО–г олон хүн судлах болсон бөгөөд ихэнх нь компьютер програмчлалын суурьтай болсон.

Хиймэл оюун ухааныг бид хүнээс илүү ухаантай робот, супер хүчин чадалтай компьютероор төсөөлдөг. Гэвч энэ нь аль хэдийн орчин үеийн технологийн ертөнцийн салшгүй нэгэн хэсэг болж чаджээ. Учир нь бид өөрсдөө ч мэдэлгүй өдөр тутмын амьдралдаа үүнийг ашигладаг бөгөөд энгийн нэгэн гар утас, компьютер гэх мэт бүхий л ухаалаг төхөөрөмж болон цахим сүлжээнүүд хиймэл оюун ухаан дээр суурилагдсан байдаг юм. Ингээд та бүхэнд технологийн ертөнцийн хамгийн хурдацтай хөгжиж буй хүн төрөлхтний цаашдын ирээдүйг тодорхойлох энэхүү салбарын талаарх мэдээллийг хүргэж байна.

Хиймэл оюун ухаан бол мэдээллийг таних, ашиглах, түүнд дүн шинжилгээ хийж, хариу үйлдэл үзүүлэх чадвартай програм юм. Энэ нь үндсэн 3 давхаргаас бүрддэг.

Их хэмжээний мэдээллийн сангаас мэдээлэл боловсруулах боломжтой төхөөрөмж болон програмын хослол нь түүнээсээ суралцаж тохиромжит гаргалгааг гаргадаг.

Мэдээлэл боловсруулах чадвартай алгоритм болон програм нь их хэмжээний мэдээллийг олж авч түүнээсээ суралцаж хариу үйлдэл үзүүлэн гаргалгаа хийх чадвараа сайжруулдаг.

Хиймэл оюун ухаан<sup>13</sup> (Artificial Intelligence): Мэдрэх, үйлдэл үзүүлэх, дасан зохицох, хөгжих чадвартай програм.

Хиймэл оюун ухааныг "Нарийн хиймэл оюун ухаан буюу сул" болон "Ерөнхий хиймэл оюун ухаан буюу хүчирхэг хиймэл оюун ухаан" хэмээн 2 төрлөөр ангилдаг.

Нарийн хиймэл ухаан нь бидний эргэн тойронд өдөр бүр ашиглагддаг бөгөөд энэ нь ухаалаг утасны царай таних технологи, цахим орчны хайлтын систем болон өөрөө явдаг машин гэх мэт энгийн үйлдлүүдийг хийж, шаардлагатай гаргалгааг гаргадаг юм.

Харин хүчирхэг хиймэл оюун ухааны төгс жишээ болон хувилбарууд хараахан бий болоогүй байгаа бөгөөд энэ нь сэтгэх бодох, мэдрэх чадвартайгаас гадна бүхий л үйлдэлд шийдвэр гаргадаг хүнээс илүү төгс оюун ухаан юм. Мөн бүхий л төрлийн мэдээллийг нэгэн зэрэг хүлээн авч боловсруулах чадалтай уг оюун ухаан нь олон эрдэмтэн судлаачдын эцсийн зорилго болоод байгаа билээ.

#### **Хиймэл оюун ухаан болон хүн<sup>14</sup>**

Бүх төрлийн мэдээлэл боловсруулах төхөөрөмжид зөвхөн хэрэглэгч мэдээллийг оруулж болдог бол хиймэл оюун ухаан нь өөрөө мэдээллийг олж, боловсруулж, хариу үйлдэл хийхэд суралцаж чаддагаараа онцлогтой юм. Нарийн буюу сул хиймэл оюун ухаан нь тухайн програмчлагдсан үйлдлийг ямар ч хүнээс илүү хурдан, үр дүнтэйгээр хийж чаддаг. Үүнийг орчин үед хүний хэрэглээг сайжруулах, аюулгүй байдал, мэдээллийн хурдыг ихэсгэх гэх мэт олон төрлийн салбарт ашиглаж байгаа бөгөөд хиймэл оюун ухааны эсрэг шатар, видео тоглоомын тэмцээнүүд хүртэл зохиогдох болсон юм. Мөн зарим төрлийн ажлын байранд хиймэл оюун ухаан дээр суурилсан төхөөрөмжүүд хүнийг орлож эхэлжээ. Харин хүчирхэг хиймэл оюун ухаан нь онолын хувьд ямар ч хүнээс илүү ухаалаг, хурдан сурч хөгжих боломжтой юм. Мөн үүнтэй холбоотой маш олон таамаглал үүссэн ба энэ нь хүн төрөлхтний ирээдүйд хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй байгаа билээ.

#### **Хиймэл оюун ухаан ба аюулгүй байдал<sup>15</sup>**

Сүүлийн жилүүдэд хиймэл оюун ухаантай холбоотой олон тооны маргаантай асуудлууд үүсэж эхэлсэн билээ. Мөн Стевен Хавкинс, Илон Маск, Стив Возниак болон Билл Гейтс

<sup>13</sup> <https://mn.martech.zone/what-is-augmented-reality/>

<sup>14</sup> <https://hishigjargal9902.medium.com/>

<sup>15</sup> <https://nsiteam.com/>

<sup>12</sup> <https://www.techslang.com/>



гэх мэт технологи, шинжлэх ухааны томоохон төлөөлөгчид хиймэл оюун ухааны<sup>16</sup> аюулын талаар өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх болсон юм. Тэд хиймэл оюун ухаан нь одоо байгаагаасаа илүү нарийн судлагдаж, хөгжих ёстой хэдий ч ирээдүйд ямар эрсдэл гарч болохыг тооцож үзэх хэрэгтэй гэдгийг онцолсон. Жишээлбэл, ирээдүйд хиймэл оюун ухаан нь хуурамч бичлэг хийх, иргэдийг нууцаар тандах, цэрэг армийн<sup>17</sup> шийдвэрт нөлөөлөх гэх мэт олон зуун зүйлд ашиглагдаж болох аюултай аж.

<sup>16</sup> <https://ikon.mn/opinion/1lsy>

<sup>17</sup> <https://mn.martech.zone/what-is-augmented-reality/>

### Хиймэл оюун ухаан ба ирээдүй

Ирээдүйд төрөл бүрийн ажлын байрыг хиймэл оюун ухаан орлох нь аль хэдийн тодорхой болжээ. Хэдийгээр аюултай орчинд хүнээс илүү машиныг ажиллуулах нь үр дүнтэй, эрсдэл багатай боловч нөгөө талаасаа энэ нь цэрэг армийг ч орлож чадах хэмжээнд<sup>18</sup> хүрэх юм. Гэхдээ төгс хиймэл оюун ухааныг хүн төрөлхтөн бүтээж чадах эсэх нь тодорхой биш байгаа билээ.

<sup>18</sup> <https://habr.com/ru/companies/lanit/articles/554596/>

### Ашигласан материал:

1. Цэргийн удирдлагын үндэс Паламдорж.Ш, 2003 он
2. Цэргийн удирдлагын үндэс Улаанхүү.Ч, 2005 он
3. Операци, Байлдаанд цэргийн удирлага Түмэн.Б, Ганбямба.С, Ганзориг.Г, 2021 он
4. Цэргийн стратегийн удирлагын онол, арга зүйн тулгамдсан асуудал Паламдорж.Ш, 2015 он
5. Цэргийн удирдлагын автоматжуулсан системийн мэдээлэл хамгаалах технологийг сайжруулах арга зам /Цэргийн ухаанаар докторын зэрэг горилсон диссертаци/ 2019 он
6. Цэргийн мэргэжлийн удирлагын шийдвэрт хамт олны нийгэм сэтгэлзүйн хүчин зүйлийг харгалзан үзэх /Цэргийн ухаанаар магистрын зэрэг горилсон ажил/, 2005 он
7. <https://news.xopom.com/>
8. <https://mn.wikipedia.org/>
9. <https://www.google.com/>
10. <https://hishigjargal9902.medium.com/>
11. <https://www.rand.org/>
12. <https://nsiteam.com/>
13. <https://www.setav.org/>
14. <https://www.techslang.com/>
15. <https://ikon.mn/opinion/1lsy>
16. <https://mn.martech.zone/what-is-augmented-reality/>
17. <https://habr.com/ru/companies/lanit/articles/554596/>
18. <https://jasoren.com/augmented-reality-military/?fbclid=IwAR3tl3fh>

## УХААЛАГ ХОТЫН КОНЦЕПЦ ДАХЬ ЖОЛООЧГҮЙ АВТОМАШИНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

**Х.ХҮДЭРБОЛД** / Аюулгүй байдлын дээд сургуулийн Байгалийн ухааны тэнхимийн багш, ШУТИС-ийн Мехатроникийн докторант/

**Түлхүүр үг:** ухаалаг хот, автомат жолоодлоготой автомашин, явган зорчигч, хиймэл оюун ухаан, зүйлсийн интернет, аюулгүй байдал

### Хураангуй

Энэхүү өгүүлэл нь ухаалаг хотын хөгжлийн хүрээнд автомат жолоодлоготой автомашин (АЖА)-ы технологи, явган зорчигчдын аюулгүй байдал, болон тэдгээрийн харилцан үйлчлэлийг судлахыг зорьсон. Хиймэл оюун ухаан (ХОУ), зүйлсийн интернет (IoT), 5G холбооны технологиуд нь хотын замын хөдөлгөөний зохицуулалтыг сайжруулах, түгжрэлийг бууруулах, аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Автомат жолоодлоготой автомашин нь мэдрэгчийн систем, ХОУ, машин сургалт болон өндөр хурдны сүлжээний холболтыг ашиглан бодит цагийн шийдвэр гаргах боломжтой. Гэсэн хэдий ч технологийн өндөр өртөг, кибер аюулгүй байдал, хууль эрх зүйн зохицуулалт зэрэг сорилтуудыг даван туулах шаардлагатай. Цаашдын судалгаанд хүн-машины харилцан үйлчлэлийг оновчтой болгох, ХОУ загваруудыг сайжруулах чиглэлээр анхаарах нь зүйтэй.

### Оршил.

Хотжилтын хурдацтай өсөлт нь хотын тээврийг үр ашигтай удирдах, замын хөдөлгөөний зохицуулалтыг сайжруулах инновацлаг шийдлүүдийг шаарддаг болжээ. Ухаалаг хотын санаачилгууд нь хиймэл оюун ухаан (ХОУ), зүйлсийн интернет (IoT), 5G холбооны сүлжээг ашиглан автомат жолоодлоготой автомашин болон явган зорчигчийн аюулгүй орчинг бүрдүүлэхийг зорьж байна<sup>1</sup>. Энэхүү өгүүлэл нь хотын замын хөдөлгөөнийг оновчтой зохицуулж, түгжрэлийг бууруулах, аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн судалгааны үр дүнг танилцуулна.

### Ухаалаг хотын концепц

Ухаалаг хотын концепц гэдэг нь технологийн дэвшил, мэдээллийн систем, болон инновацийн ашиглалтыг хослуулан хотын амьдралын чанарыг сайжруулах, иргэдийн тав тухыг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах, эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн хамрах өргөн хүрээтэй стратеги юм<sup>2</sup>. Энэхүү концепц

нь тээвэр, эрчим хүч, дэд бүтэц, байгаль орчин, удирдлага, амьдралын хэв маяг, эрүүл мэнд, аюулгүй байдал зэрэг чиглэлд иж бүрэн шийдэл санал болгодог.



1 дүгээр зураг. Ухаалаг хотын концепцийн жишээ

Ухаалаг хотын гол чиглэлүүд

### 1. Ухаалаг тээвэр (Smart Mobility)

Ухаалаг тээвэр нь тээврийн системийг ухаалаг, аюулгүй, үр дүнтэй болгох, түгжрэлийг бууруулах, байгаль орчны нөлөөллийг багасгахад чиглэдэг. IoT, AI, 5G, автомат жолоодлоготой тээврийн хэрэгслүүд, ухаалаг гэрлийн дохио, бодит цагийн тээврийн мэдээллийн систем гэх мэт технологиудыг ашигладаг<sup>3</sup>. Явган зорчигчдын IoT мэдрэгч, ухаалаг гэрлэн дохио, аппликейшнүүд ашиглан тэдний маршрутыг оновчтой болгож, автомат тээврийн хэрэгслүүдэд мэдээлэл дамжуулдаг. AI ба Big Data-г ашиглан тээврийн хөдөлгөөний загварыг урьдчилан таамаглаж, маршрутыг оновчтой болгож, явган зорчигчдын аюулгүй байдлыг нэмэгдүүлдэг.

### 2. Ухаалаг Эрчим Хүч (Smart Energy)

Ухаалаг эрчим хүч нь эрчим хүчний хэрэглээг оновчтой удирдах, сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлж, хэмнэлтийг сайжруулахад чиглэдэг. IoT мэдрэгч, ухаалаг метр, сэргээгдэх эрчим хүчний систем, AI-ын эрчим хүчний удирдлага зэрэг технологиудыг ашигладаг. Ухаалаг эрчим хүчний системийг нэвтрүүлснээр эрчим хүчний хэмнэлт 30–40%-иар буурч, байгаль орчны нөлөөлөл багасдаг.

### 3. Ухаалаг Дэд Бүтэц (Smart Infrastructure)

<sup>1</sup> Mogul Helios

<sup>2</sup> Pedestrian detection and accident prevention in autonomous driving. Accident Analysis & Prevention, Park & Kim, 2023

<sup>3</sup> Pedestrian detection and accident prevention in autonomous driving. Accident Analysis & Prevention, Chen & Wang, 2023



Ухаалаг дэд бүтэц нь хотын барилга байгууламж, зам, гүүр, гэрлэн дохио зэрэг дэд бүтцийг ухаалаг, аюулгүй, үр дүнтэй болгоход чиглэдэг. IoT мэдрэгч, AI, ухаалаг камер, бодит цагийн мэдээллийн систем зэрэг технологиудыг ашигладаг. Ухаалаг камер, мэдрэгчүүд осол, гэмтлийг илрүүлж, бодит цагийн мэдээллийг хотын удирдлагын төвд илгээдэг. Автомат тээврийн хэрэгслийн маршрутыг ухаалаг замын тэмдэглэгээ, IoT системээр оновчтой болгодог.

#### 4. Ухаалаг Байгаль Орчин (Smart Environment)

Ухаалаг байгаль орчин нь байгаль орчны чанарыг сайжруулах, бохирдлыг бууруулах, ногоон талбайг нэмэгдүүлэхэд чиглэдэг. IoT мэдрэгч (агаарын чанар, дуу чимээ), AI, сэргээгдэх эрчим хүч зэрэг технологиудыг ашигладаг. Ногоон талбай, цэцэрлэгт хүрээлэнг IoT-ийн тусламжтайгаар удирдаж, ус, эрчим хүчний хэрэглээг оновчтой болгодог. Явган зорчигчдын хөдөлгөөнийг нэмэгдүүлж, автомашины хэрэглээг бууруулан, нүүрсхүчлийн хийн ялгарлыг багасгадаг.

#### 5. Ухаалаг Удирдлага (Smart Governance)

Ухаалаг удирдлага нь хотын удирдлагыг ил тод, үр дүнтэй, иргэдэд чиглэсэн болгоход чиглэдэг. Big Data, AI, IoT, блокчэйн, дижитал платформ зэрэг технологиудыг ашигладаг. Автомат тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг удирдах, ослыг хянах, кибер аюулгүй байдлыг хангахад AI, IoT-г ашигладаг. Блокчэйн технологийг ашиглан мэдээллийн ил тод байдал, аюулгүй байдлыг нэмэгдүүлдэг.

#### 6. Ухаалаг Амьдрахуй (Smart Living)

Ухаалаг амьдрахуйн хэв маяг нь иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, тав тухыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийг дэмжихэд чиглэдэг. IoT, AI, ухаалаг гэр ахуй, эрүүл мэндийн төхөөрөмж зэрэг технологиудыг ашигладаг. Ухаалаг гэр ахуйн систем (жишээ нь: IoT-суулгасан гэрэл, дулаан) эрчим хүчний хэмнэлт, эрүүл мэндийг дэмждэг. Автомат тээврийн хэрэгслүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх боломжийг нээж, амьдралын хэв маягийг хялбар болгодог.

#### 7. Ухаалаг Эрүүл Мэнд (Smart Health)

Ухаалаг эрүүл мэнд нь эрүүл мэндийн үйлчилгээг ухаалаг, хүртээмжтэй, үр дүнтэй болгоход чиглэдэг. IoT эрүүл мэндийн төхөөрөмж, телемедицин, AI оношлогоо, Big Data зэрэг технологиудыг ашигладаг. Автомат тээврийн хэрэгслүүд эмнэлгийн тоног төхөөрөмж, өвчтөнийг тээвэрлэхэд ашиглагдаж, IoT-ийн тусламжтайгаар бодит цагийн хяналт хийдэг. Эрүүл мэндийн мэдээллийг AI ба Big Data ашиглан анализ хийж, өвчлөлийн

урьдчилан сэргийлэлтийг сайжруулдаг.

#### 8. Ухаалаг Аюулгүй Байдал (Smart Safety and Security)

Ухаалаг аюулгүй байдал нь хотын аюулгүй байдлыг нэмэгдүүлж, гэмт хэрэг, ослыг бууруулахад чиглэдэг. IoT камер, ухаалаг мэдрэгч, AI, кибер аюулгүй байдлын систем зэрэг технологиудыг ашигладаг. Ухаалаг камер, мэдрэгчүүд осол, гэмт хэргийг бодит цагт илрүүлж, хотын удирдлагын төвд мэдээлэл дамжуулдаг. Явган зорчигчдын аюулгүй байдлыг нэмэгдүүлэх IoT аппликейшн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний удирдлагыг нэвтрүүлдэг.

Жолоочгүй автомашины технологийн суурь

Автомат жолоодлогтой автомашин (АЖА) нь хүний оролцоогүйгээр замын хөдөлгөөнд оролцох чадвартай бөгөөд дараах үндсэн технологиудад тулгуурладаг.

Мэдрэгчийн Систем

Автомат жолоодлогтой автомашин нь орчноо таньж, бодит цагт шийдвэр гаргахын тулд янз бүрийн мэдрэгчүүдийг ашигладаг:

- ЛиДАР (LiDAR): Лазер импульсийг ашиглан орчны 3D зураглалыг үүсгэж, саад тотгорыг тодорхойлно.
- Радар: Радиофон долгионы технологийг ашиглан тээврийн хэрэгслийн хурд, зайг тодорхойлно.
- Камер: Хэд хэдэн өнцгөөс зураг авч, замын тэмдэг, явган зорчигчийг таньж, мэдээллийг боловсруулна.
- Ультрасоник мэдрэгч: Ойр орчмын саадыг илрүүлэхэд ашиглагддаг<sup>4</sup>.



2 дугаар зураг. Бага оёрын АЖА загвар

AI ба Машин Сургалт

АЖА нь өгөгдлийг боловсруулж шийдвэр гаргахын тулд дараах технологиудыг ашигладаг:

- Компьютер хараа: Замын нөхцөл байдлыг таньж, мэдээлэл боловсруулна.
- Машин сургалт: Урьдчилсан хөдөлгөөний

<sup>4</sup> Sensor technologies in autonomous driving systems. Journal of Autonomous Vehicles, Johnson & Smith, 2022



загварчлал боловсруулж, ослоос сэргийлэх.

- Навигацийн систем: GPS болон газрын зураг ашиглан хамгийн оновчтой замыг тодорхойлох.

- ХОУ–д суурилсан хөдөлгөөн урьдчилан таамаглах систем: Замын хөдөлгөөний урсгалыг урьдчилан таамаглаж, хөдөлгөөнийг аюулгүй байлгах.

- Онцгой нөхцөлд яаралтай тоормослох, хурд зохицуулах технологи: Аюулыг илрүүлж, яаралтай арга хэмжээ авах.

Холболт ба Дэд Бүтэц

АЖА нь дараах холболтын технологиудыг ашигладаг:

- 5G болон V2X технологи: Жолоочгүй автомашин нь замын хөдөлгөөний мэдээлэлтэй бодит цагийн холбоо тогтооно.

- Үүлэн тооцоолол: Замын хөдөлгөөний динамикийг урьдчилан тооцоолох ба хөдөлгөөний урсгалын шинжилгээ хийх.

- Хот төлөвлөлтийн загварчлалд зориулсан дижитал ихэр (Digital Twin) систем: Хотын зам, барилга байгууламж, замын хөдөлгөөнийг дижитал хуулбарар загварчлан оновчтой шийдэл гаргах<sup>5</sup>.

Явган Зорчигчийн Хөдөлгөөн ба Аюулгүй Байдал

Явган зорчигчийн аюулгүй байдлыг хангахын тулд дараах технологиудыг ашигладаг:

- Ухаалаг мэдрэгчтэй гарц: Явган зорчигчдыг илрүүлж, хөдөлгөөнийг хянана.

- ХОУ–д суурилсан явган зорчигчийн хөдөлгөөн таамаглах систем: Явган зорчигчдын хөдөлгөөнийг урьдчилан таамаглаж, аюулгүй байдлыг хангана.

- IoT–тэй уялдсан гэрлэн дохио ба хөдөлгөөн зохицуулалт: Замын хөдөлгөөнийг бодит цагт зохицуулж, явган зорчигчдын аюулгүй байдлыг хангана<sup>6</sup>.

Жолоочгүй автомашины ухаалаг хотод үзүүлэх нөлөө

Замын Хөдөлгөөний Оновчлол

АЖА нь хөдөлгөөний урсгалыг оновчтой болгох, замын ослын тоог бууруулах боломжтой. AI, IoT, 5G технологиудын тусламжтайгаар хөдөлгөөний урсгалыг урьдчилан таамаглаж, замын хөдөлгөөнийг оновчтой зохицуулснаар түгжрэлийг 30–40%–иар бууруулах боломжтой.

Байгаль Орчинд Үзүүлэх Нөлөө

- Нүүрсхүчлийн хийн ялгаралыг багасгах: АЖА нь оновчтой маршрут, хурд, хөдөлгөөнөөр

нүүрсхүчлийн хийн ялгаралыг 20–30%–иар бууруулах боломжтой.

- Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан тээврийн хэрэгслийг ашиглах: Цахилгаан автомашин, нийтийн тээврийн хэрэгслийг илүү өргөн ашиглах боломжийг нээнэ.

Аюулгүй Байдал

- АЖА нь ослын эрсдэлийг багасгаж, хөдөлгөөний зохицуулалтыг оновчтой болгоно: Мэдрэгчийн систем, AI технологийн тусламжтайгаар ослын тоог 50–60%–иар бууруулах боломжтой.

- Явган зорчигчийг илрүүлэх, аюулыг урьдчилан таамаглах системтэй: AI, компьютер хараа, LiDAR–ын тусламжтайгаар явган зорчигчдын аюулгүй байдлыг нэмэгдүүлнэ<sup>7</sup>.

Сорилтууд ба анхаарах асуудлууд

Техникийн Сорилтууд

- АЖА–ийн мэдрэгчүүдийн нарийвчлалыг нэмэгдүүлэх шаардлага: Мэдрэгчүүдийн нарийвчлал, тогтвортой байдлыг сайжруулах шаардлагатай.

- Цаг агаарын нөхцөл байдлаас хамаарах асуудлууд: Цас, бороо, манан зэрэг цаг агаарын хүнд нөхцөлд мэдрэгчүүдийн ажиллагаа доройтдог.

Хууль, Эрх Зүйн Асуудал

- АЖА–тай холбоотой ослын хариуцлагыг хэрхэн хуваарилах асуудал: Ослын үед хэн хариуцлага хүлээх талаар хууль эрх зүйн зохицуулалт шаардлагатай.

- Замын хөдөлгөөний хуулийн зохицуулалтын шинэчлэл: АЖА–ийн хөдөлгөөнийг зохицуулах хууль, дүрмийг боловсруулах шаардлагатай.

- ХОУ–д суурилсан хөдөлгөөний зохицуулалт, аюулгүй байдлын ёс зүйн асуудлууд: AI шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал, ёс зүйн асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай<sup>8</sup>.

Дэд Бүтцийн Шинэчлэл

- АЖА болон явган зорчигчид хамтран ажиллах боломжтой зам, гарц, орчныг сайжруулах: Дэд бүтцийг шинэчлэх, ухаалаг зам, гарц, дохиоллын системийг нэвтрүүлэх шаардлагатай.

- Өндөр өртөг: Дэд бүтцийн шинэчлэлтийн өндөр өртөг нь хөгжиж буй орнуудад нэвтрүүлэхэд саад болж болно.

Кибер Аюулгүй Байдал

- АЖА–ийн өгөгдлийн хамгаалалт, хакерын халдлагаас сэргийлэх: АЖА–ийн системд

<sup>5</sup> Digital twin technology in urban transportation. Smart Cities Technology Review, Garcia & Lee, 2023

<sup>6</sup> Pedestrian safety systems in autonomous driving environments. Journal of Transportation Safety, Brown & Taylor, 2022

<sup>7</sup> Pedestrian detection and accident prevention in autonomous driving. Accident Analysis & Prevention, Kim & Park, 2023

<sup>8</sup> Ethical concerns in autonomous vehicle decision-making. Ethics and Information Technology, Johnson & Brown, 2022



халдах, хөдөлгөөнийг удирдах, мэдээллийг хулгайлах зэрэг кибер халдлагаас хамгаалах систем шаардлагатай.

- АЖА болон ухаалаг хотын сүлжээг кибер халдлагаас хамгаалах: Ухаалаг хотын бүх систем, сүлжээг кибер халдлагаас хамгаалах стратеги боловсруулах шаардлагатай.

Бусад Сорилтууд

- Технологийн өндөр өртөг: АЖА-ийн технологи, ухаалаг хотын дэд бүтцийн өндөр өртөг нь орон нутгийн болон үндэсний түвшинд нэвтрүүлэхэд саад болж болно.

- Иргэдийн итгэлцлийн дутагдал: АЖА-ийн аюулгүй байдал, найдвартай байдалд иргэдийн итгэлцлийг нэмэгдүүлэх шаардлагатай<sup>9</sup>.

### Дүгнэлт

Автомат жолоодлоготой автомашин нь ухаалаг хотын хөгжлийн салшгүй хэсэг бөгөөд замын хөдөлгөөнийг аюулгүй байдлыг сайжруулж, түгжрэлийг бууруулах, байгаль орчныг хамгаалах боломжтой. Гэсэн хэдий ч технологийн өндөр өртөг, кибер аюулууд, хууль эрх зүйн зохицуулалт, иргэдийн итгэлцлийн дутагдал зэрэг сорилтуудыг шийдвэрлэх шаардлагатай.

Автомат жолоодлоготой автомашин ба

явган зорчигчийн хөдөлгөөнийг ухаалаг хотын хүрээнд нэгтгэснээр замын хөдөлгөөнийг аюулгүй байдал нэмэгдэж, түгжрэл багасч, хотын амьдрах орчин сайжрах боломжтой. Энэ үйл явцыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд олон салбарын хамтын ажиллагаа, технологийг сайжруулах юм.

Цаашдын судалгаанд хүн-машины харилцан үйлчлэлийг оновчтой болгох ХОУ загваруудыг боловсронгуй болгох, АЖА ба явган зорчигчийн харилцааны найдвартай байдлыг сайжруулах чиглэлээр анхаарах нь зүйтэй. АЖА-ийн хүний харилцан үйлчлэлийн загварыг сайжруулах, AI алгоритмыг боловсронгуй болгоход анхаарч, IoT, AI, 5G зэрэг технологийг нэгтгэснээр хотын амьдралын чанарыг дээшлүүлж, тогтвортой байдлыг хангах нь чухал юм.

Автомат жолоодлоготой бага оврын тээврийн хэрэгслүүд, явган зорчигчдын хөдөлгөөнийг сайжруулахад IoT, AI, 5G зэрэг технологийг нэгтгэснээр хотын амьдралын чанарыг дээшлүүлж, тогтвортой байдлыг хангаж болно. Гэвч технологийн өндөр өртөг, кибер аюулгууд, хууль эрх зүйн зохицуулалт, иргэдийн итгэлцлийн дутагдал зэрэг сорилтуудыг шийдвэрлэх шаардлага бий.

<sup>9</sup> Smart mobility technologies in urban planning. Urban Studies Journal, Chen & Wang, 2022

### Ашигласан материал:

1. Brown, J., & Taylor, K. (2022). Pedestrian safety systems in autonomous driving environments. *Journal of Transportation Safety*, 15(3), 45-62.
2. Chen, H., & Wang, L. (2023). Smart mobility technologies in urban planning. *Urban Studies Journal*, 42(2), 123-145.
3. Garcia, J., & Lee, M. (2023). Digital twin technology in urban transportation. *Smart Cities Technology Review*, 11(4), 78-95.
4. Garcia, R., Martinez, S., & Johnson, L. (2022). Smart city infrastructure: Challenges and opportunities. *Urban Planning Review*, 32(2), 112-129.
5. Johnson, M., & Brown, R. (2023). Ethical concerns in autonomous vehicle decision-making. *Ethics and Information Technology*, 25(1), 56-72.
6. Johnson, R., & Smith, T. (2022). Sensor technologies in autonomous driving systems. *Journal of Autonomous Vehicles*, 8(2), 123-140.
7. Kim, S., & Park, J. (2023). Pedestrian detection and accident prevention in autonomous driving. *Accident Analysis & Prevention*, 31(3), 105-119.



## УХААЛАГ ХОТУУДАД ЗОРИУЛСАН ИОТ–Д СУУРИЛСАН ЦАХИМ ЗОГСООЛЫН СИСТЕМ

**Б.МӨНХЗАЯА** / УБХИС-ийн АБДС-ийн "Инженерчлэлийн тэнхим"-ийн багш, магистрант  
**Т.БАТ-АНД** / УБХИС-ийн АБДС-ийн "Инженерчлэлийн тэнхим"-ийн багш, магистрант

**Түлхүүр үг:** ухаалаг зогсоолын систем, зогсоол, зогсоол тоолуур, интернэт-зогсоол, цахим зогсоол.

**Key words:** smart parking system (SPS), parking lot, parking meter (PM), internet-of-thing (IoT), E-parking

### Хураангуй

Авто замаар зорчиж буй тээврийн хэрэгслийн тоо олширч, бэлэн зогсоол, зохион байгуулалт буруу байгаа нь авто зогсоолтой холбоотой асуудлуудыг бий болгож, хот суурин газрын замын түгжрэлийг нэмэгдүүлж байна. Тиймээс жолооч өөрийн тээврийн хэрэгсэлд тохиромжтой зогсоолыг маш хурд олоход туслах ухаалаг авто зогсоолын менежментийн автоматжуулсан системийг хөгжүүлэх шаардлагатай байна. Ухаалаг зогсоолын системийг хөгжүүлэх талаар олон тооны судалгааны ажил ном зохиолд байдаг ч ихэнх нь дүүрэн зогсоолыг хурдан хугацаанд илрүүлэх, зогсоолын төлбөрийг автоматаар авах асуудлыг шийдэж чадаагүй байна. Энэхүү нийтлэлд интернэтэд суурилсан цахим зогсоолын системийн загварыг санал болгож байна. Санал болгож буй цахим зогсоолын систем нь дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх, мөн хотын хэмжээнд ухаалаг зогсоолын менежментийг хангах зорилгоор зогсоолын тоолуур хэмээх нэгдсэн бүрэлдэхүүн хэсгийг ашигладаг.

Дараах асуудлыг шийдвэрлэхийн тулд зогсоолын тоолуур гэж нэрлэгддэг бүрэлдэхүүн хэсэг.

- Бэлэн зогсоолыг түргэн хугацаанд илрүүлэх
- Тээврийн хэрэгсэл бүрийн тооцож зогсоолын ашиглалтын хугацааг тодорхойлох
- Зогсоолын төлбөрийг автоматаар цуглуулах

Энэхүү судалгаанд санал болгож буй цахим зогсоолын систем нь зогсоолын бэлэн байдлын мэдээлэл, зогсоолын захиалгын системээр дамжуулан хотын хэмжээнд ухаалаг зогсоолын менежментийн шийдлийг өгдөг бөгөөд үүнийг зогсоолын тоолуур дээр суурилсан цахим зогсоол гэж нэрлэдэг.

**Abstract:** The increasing numbers of cars plying on the roads, the improper parking and the improper arrangement of the parking space have caused parking problems and caused traffic congestion in the city. Intelligent parking management, which is developing automated productivity to aid the driving vehicles in obtaining parking spaces in a very short time, is being developed. There are many research papers related to smart parking development, but the process cannot address the issue of the quick detection of full stops and automatic collection of parking charges. The main paper uses the Internet-based electronic parking funding. The electronic parking system discussed here solves the mentioned issues and addresses the combined parts of the parking device to improve the smart parking management in the city.

The components of the parking meter are considered to deal with the following problems.

- Rapid identification of empty parking spaces
- Identification of all the vehicles' stop usage tools
- Automated collection of parking charges

The research reveals that the proposed electronic parking system is a smart parking solution from the parking reservation system to render the parking service accessible.

### Оршил.

Авто зам дээр тээврийн хэрэгслийн тоо асар их олширч, бэлэн зогсоолын буруу менежмент нь зогсоолтой холбоотой асуудлуудыг<sup>1</sup> үүсгэж, хот суурин газрын замын түгжрэлийг нэмэгдүүлсэн. Иймд жолооч автомашиндаа тохирох зогсоол олоход дөхөм болохоос гадна түлшний зарцуулалт, агаарын бохирдлыг бууруулах

<sup>1</sup> M. Y. Idna Idris, N. M. Noor and Z. Razak, 00 Car Park System: A Review of Smart Parking System and Its Technology 00 Information Technology Journal 8(2), pp. 101 113, 2009, ISSN 1812-5638.



ухаалаг зогсоолын удирдлагын автоматжуулсан системийг<sup>2</sup> хөгжүүлэх шаардлагатай байна. Жолооч тохиромжтой зогсоол хайхад бараг 15 минут зарцуулдаг бөгөөд энэ нь тээврийн хэрэгслийн түлшний зарцуулалт, замын түгжрэл, агаарын бохирдлыг нэмэгдүүлдэг.

Ухаалаг зогсоолын системийг зохион бүтээх, хөгжүүлэх чиглэлээр багагүй хэмжээний судалгааны ажил хийгдэж байна. Ухаалаг зогсоолын системийн янз бүрийн онцлогуудыг доор жагсаав.

- Зогсоолын хүрэлцээ, зогсоолын захиалгын талаарх лавлагаа
- Бодит цагийн зогсоолын навигаци, маршрутын зааварчилгаа
- Тээврийн хэрэгслийн түгжрэлийг илрүүлэх, зогсоолын менежмент

Сүүлийн хэдэн жилийн турш ном зохиолд санал болгож буй ухаалаг зогсоолын системүүдийн ихэнх нь зогсоолын бэлэн байдлын мэдээллийн систем, зогсоолын захиалгын систем, зогсоолын хүн амыг илрүүлэх, удирдах, зогсоол доторх цагийн навигаци гэх мэт шийдлийг өгдөг. Гэсэн хэдий ч маш цөөхөн ажил нь буруу зогсоолыг бодит цаг хугацаанд илрүүлэх, зогсоолын төлбөрийг автоматаар цуглуулах талаар анхаарч үзсэн. Тиймээс энэхүү нийтлэлд интернэтэд суурилсан цахим зогсоолын системийн талаар авч үзэхээр зорилоо.

Радио давтамжийг таних (RFID), утасгүй мэдрэгчийн сүлжээ (WSN), Bluetooth, Wi-Fi, ZigBee гэх мэт төрөл бүрийн технологид суурилсан ухаалаг зогсоолын системүүд, түүнчлэн агент дээр суурилсан технологи, дүрс боловсруулах техникийг сүүлийн хэдэн жилийн турш судалж санал болгосон байдаг. Эдгээрийн дотроос RFID уншигч ашиглан зогсоолын талбайгаас тээврийн хэрэгслийг автоматаар бүртгэх, гаргах үйл явцыг хэрэгжүүлдэг RFID-д суурилсан ухаалаг анхны программын туршилтын загвар<sup>3</sup> үзүүлэв.

Нөгөөтээгүүр, мэдрэгчийн гол хэсэг эсвэл WSN-ийн аль нэгийг хэд хэдэн SPS-ийг зохион бүтээхэд ашигласан<sup>4</sup> Эдгээрийн дотроос утасгүй

мэдрэгчийн сүлжээнд суурилсан ухаалаг зогсоолын системийн загварыг үзүүлэв. Энэ систем нь зогсоол бүрийн төлөв байдлыг илрүүлэх, хянах зорилгоор зарим зогсоолын талбайн доторх зогсоол бүрд хямд мэдрэгчтэй төхөөрөмж байрлуулдаг байна. Төрөл бүрийн зогсоолын илрүүлсэн статусыг зогсоол дээр байрлуулсан WSN гарцаар дамжуулан мэдээллийн санд үе үе мэдээлдэг.<sup>5</sup> Энэ систем нь зогсоолын талбайг хянахаас гадна автомат төлбөр, аюулгүй байдлын удирдлага гэх мэт бусад үйлчилгээг үзүүлдэг.<sup>6</sup> Ухаалаг зогсоолын (SPARK) удирдлагын систем нь зогсоолын талбайг алсаас хянах, зогсоолыг захиалах, зогсоолын зайг автоматаар удирдан чиглүүлэх гэх мэт янз бүрийн функцийг гүйцэтгэхийн тулд утасгүй мэдрэгч сүлжээг ашигладаг, автомашины зогсоолыг автоматаар удирдан чиглүүлэх гэх мэт. Хэт туяаны мэдрэгч дээр суурилдаг. Суурилсан төрөл бүрийн мэдрэгчийг багтаасан.<sup>7</sup> Хоосон зайг илрүүлэх, буруу зогсоолыг илрүүлэх, боломжтой зогсоолын талбайг харуулах, төлбөрийн хэрэгсэл гэх мэт<sup>8</sup> SPS болон автомашины зогсоолын удирдлагын систем нь WSN болон RFID технологийг нэгтгэдэг.

Автомашины түр зуурын сүлжээ (VANET) дээр суурилсан том зогсоолтой ухаалаг зогсоолын системийг<sup>9</sup> санал болгосон бөгөөд энэхүү авто зогсоолын схем нь жолооч нарт цагийн зогсоолын навигаци, ухаалаг үйлчилгээ гэсэн гурван чухал үйлчилгээг үзүүлдэг.

Хулгайн эсрэг хамгаалалт, ээлтэй зогсоолын мэдээллийг түгээх.<sup>10</sup> Санал болгосон захиалгад

<sup>5</sup> S. V. Srikanth, P. P. J., D. K. P., T. S., M. U. Patil and S. C. B. N., 00Design and Implementation of a Prototype Smart PARKing (SPARK) System Using Wireless Sensor Networks, 00 2009 International Conference on Advanced Information Networking and Applications Workshops, Bradford, 2009, pp. 401–406. doi: 10.1109/WAINA.2009.53

<sup>6</sup> A. Kianpisheh et al., 00Smart Parking System Architecture Using Ultrasonic Detector, 00 Intern0 l Journal of Software Engineering and its Applications, Vol. 6, No. 3, July 2012, pp. 51–58.

<sup>7</sup> Patil, M., Bhonghe, V. N., 00Wireless sensor network and RFID for smart parking system, 00 International Journal of Emerging Technology and Advanced Engineering, Vol. 3, No. 4, pp. 188–192.

<sup>8</sup> Karbab, E., Djenouri, D., Boulkaboul, S., Bagula, A. (2015, May). Car park management with networked wireless sensors and active RFID. In 2015 IEEE International Conference on Electro/Information Technology (EIT) (pp. 373–378). IEEE.

<sup>9</sup> Lu, X. Lin, H. Zhu and X. Shen, 00SPARK: A New VANETBased Smart Parking Scheme for Large Parking Lots, 00 IEEE INFOCOM 2009, Rio de Janeiro, 2009, pp. 1413–1421. doi: 10.1109/INFCOM.2009.5062057

<sup>10</sup> Hongwei Wang and Wenbo He, 00A Reservation-based Smart Parking System, 00 2011 IEEE Conference

<sup>2</sup> Faheem et al., 00A Survey of Intelligent Car Parking System, 00 Journal of Applied Research and Technology, Volume 11, Issue 5, pp. 714–726.

<sup>3</sup> Z. Pala and N. Inanc, 00Smart Parking Applications Using RFID Technology, 00 2007 1st Annual RFID Eurasia, Istanbul, 2007, pp. 1–3. doi: 10.1109/RFIDEURASIA.2007.4368108.

<sup>4</sup> V. W. S. Tang, Y. Zheng, and J. Cao, 00An Intelligent Car Park Management System based on Wireless Sensor Networks, 00 Pervasive Comput. Appl. 2006 1st Int. Symp., pp. 6570, 2006



суурилсан SPS нь 802.15.4 бага чадлын утасгүй технологи, Bluetooth болон Wi-Fi ашигладаг бөгөөд жолоочид сул зогсоолыг хайж олох, нөөцлөх боломжийг олгодог. Үнэгүй зогсоолыг илрүүлэхийн тулд веб камер ашигладаг, жолоочид SMS-д суурилсан захиалгын үйлчилгээ үзүүлдэг ухаалаг зогсоолын зааварчилгаа, мэдээллийн системийг<sup>11</sup> санал болгож байна. Зураг боловсруулах техникийг зарим ухаалаг зогсоолын удирдамжийн системийг зохион бүтээхэд ашигладаг.<sup>12</sup>

GSM технологид суурилсан ухаалаг, аюулгүй зогсоолын захиалгын системийг<sup>13</sup> санал болгосон. Bluetooth технологийг харилцаа холбооны хэрэгсэл болгон ашигладаг автомат зогсоолын системийг<sup>14</sup> санал болгосон. Судлаачид тээврийн хэрэгсэл болон зогсоолын хооронд хурдан хэлэлцээр хийх, мөн утасгүй сүлжээгээр дамжих өгөгдлийн хэмжээг багасгахын тулд хөдөлгөөнт агентуудыг ашигладаг ухаалаг зогсоолын хэлэлцээр, удирдамжийн системийг танилцуулсан. Утасгүй суурилсан платформыг<sup>15</sup> судлаачид SPS-ийг зохион бүтээх үйлчилгээ болгон ашигласан.

Нөгөөтээгүүр, IoT-д суурилсан машины зогсоолын менежментийн системийг санал болгосон<sup>16</sup> Байршилд суурилсан IoTcloud дээр суурилсан гудамжны зогсоолын зөрчлийн удирдлагын системийг<sup>17</sup> санал болгосон. Энэ

зогсоолын зөрчлийн менежментийн систем нь эрх бүхий албан тушаалтнуудад гудамжинд буруу байрлуулсан тээврийн хэрэгслийн байршлыг тогтооход тусалж, замын зардал, зогсоолын зөрчлийг илрүүлэх дундаж хугацааг багасгахын тулд тэдгээр тээврийн хэрэгсэлд хүрэх хамгийн бага зардлын арга замыг бий болгож байна.<sup>18</sup>

Зогсоолын цагийг хэмнэж, зогсоолыг үр ашигтай ашиглахын тулд зогсоолын үүдэнд хамгийн ойр зайд үнэгүй зогсоол хуваарилдаг эрчим хүчний хэмнэлттэй автомат машины зогсоолын системийг<sup>19</sup> санал болгосон. Энэ систем нь зогсоол дотор зарим машин хөдөлж байх үед л гэрлийг асаах замаар эрчим хүч хэмнэдэг.<sup>20</sup> Нөөцийг үр ашигтай хуваарилах, захиалах, үнэ тогтооход суурилсан ухаалаг зогсоолын системийг<sup>21</sup> байна. Судлаачид зогсоолын менежерүүдэд илүү өндөр орлого, нөөцийг ашиглах зардал багатай, жолооч нарыг хайх хугацаа багатай зогсоолыг баталгаат захиалга өгөхийг оролддог бол. Харин энэ систем нь зорилгодоо хүрэхийн тулд холимог бүхэл тоон шугаман программчлалыг ашигладаг.

#### Цахим зогсоолыг санал болгох

Энэхүү санал болгож буй цахим зогсоолын систем нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ. Эдгээр нь зогсоолын тоолуур, WLAN эсвэл Wi-Fi нэгдсэн зөөврийн компьютер/ажлын станц, орон нутгийн зогсоолын удирдлагын сервер ба зогсоол болгонд байрлуулсан зарим Wi-Fi хандалтын цэгүүд (AP) болон хотын хэмжээнд зогсоолын бэлэн байдлын мэдээллийг өгөх, тээврийн хэрэгслийн жолоочоос зогсоолын захиалгын хүсэлтийг хүлээн авах төв сервер юм. Санал болгож буй цахим зогсоолын системийн сүлжээний бүтцийг Зураг 1 дээр үзүүлэв.

Санал болгож буй PM-EP системийн дагуу зогсоол бүр дунд хэсэгт байрлах PM-ээр тоноглогдсон байдаг.

on Computer Communications Workshops (INFOCOM WKSHPS), Shanghai, 2011, pp. 690–695. doi: 10.1109/INFOCOMW.2011.5928901

<sup>11</sup> P. Dharmar Reddy, A. Rajeshwar Rao, Syed Musthak Ahmed, 00An Intelligent Parking Guidance and Information System by using image processing technique, 00 In International Journal of Advanced Research in Computer and Communication Engineering Vol. 2, Issue 10, October 2013.

<sup>12</sup> H. Al-Kharusi and I. Al-Bahady, 00Intelligent Parking Management System Based on Image Processing 00 World Journal of Engineering and Technology, 2014, 2, pp. 55–67.

<sup>13</sup> Y. Rahayu and F. N. Mustapa, 00A secure parking reservation System using gsm technology, 00 International Journal of Computer and Communication Engineering, 2(4), 518.

<sup>14</sup> H. Singh et al, 00A. Automated Parking System With Bluetooth Access, 00 International Journal of Engineering And Computer Science ISSN, 2319– 7242.

<sup>15</sup> W. Longfei, C. Hong, L. Yang, 00Integrating Mobile Agent with MultiAgent System for Intelligent Parking Negotiation and Guidance 00, 4th IEEE Conference on Industrial Electronics and Applications, pp.1704– 1707, 25–27 May 2009.

<sup>16</sup> Z. Suryady et al, 00Rapid development of smart parking system with cloud-based platforms, 00 In IEEE Fifth International Conference on Information and Communication Technology for The Muslim World (ICT4M), 2014, pp.

<sup>17</sup> S. R. Basavaraju, 00Automatic Smart parking System using Internet of Things (IoT), 00 International Journal of Scientific


and Research Publications, Volume 5, Issue 12, December 2015

<sup>18</sup> B. M. K. Gandhi and M.K. Rao, 00A Prototype for IoT based Car Parking Management system for Smart cities, 00 Indian Journal of Science and Technology, 9(17).

<sup>19</sup> T. Dinh and Y. Kim, 00A novel location-centric IoT-cloud based onstreet car parking violation management system in smart cities, 00 Sensors (Switzerland), vol. 16, no. 6, 2016.

<sup>20</sup> V. Sumathi, N. V. Pradeep Varma, and M. Sasank, 00Energy efficient automated car parking system, 00 Int. J. Eng. Technol., vol. 5, no. 3, pp. 28482852, 2013.

<sup>21</sup> A. O. Kotb, Y. C. Shen, X. Zhu, and Y. Huang, 00IParker-A New Smart Car-Parking System Based on Dynamic Resource Allocation and Pricing, 00 IEEE Trans. Intell. Transp. Syst., vol. 17, no. 9, pp. 26372647, 2016.



1 дүгээр зураг. Санал болгож буй цахим зогсоолын системийн сүлжээний архитектур

Зурагт үзүүлсэн шиг зогсоолын арын үзүүр. Зогсоолын тоолуурын техник хангамжийн тохиргоог зурагт үзүүлэв. PM нь зогсоол дотор тээврийн хэрэгсэл байгаа эсэхийг илрүүлэхэд ашигладаг хэт авианы мэдрэгчийн зангилаа, зогсоолын статусыг заах гэрэл (захиалагдсан эсвэл нөөцгүй), микроконтроллер arduino MEGA2560, буруу зогсоол үүссэн тохиолдолд дохиоллын IC модуль, тээврийн хэрэгслийн зургийг авах камерын модулиас бүрдэнэ. улсын дугаар болон IEEE 802.11 b/g/n нийцтэй утасгүй модуль нь орон нутгийн зогсоолын удирдлагын сервертэй холбогдоход зориулагдсан. Мөн зурагт үзүүлсэн шиг батарейг цэнэглэх хоёр жижиг нарны зайг багтаасан болно. GSM модуль<sup>22</sup> нь сайтын ажилтан болон тээврийн хэрэгсэл рүү SMS илгээх зорилгоор зарим цуваагаар дамжуулан орон нутгийн зогсоолын удирдлагын серверт хавсаргасан. Жолоочид санал болгож буй цахим зогсоолын системийн программ хангамжийн бүтэц, функциональ үзүүлэлтүүдийг доор үзүүлэв.

А. Санал болгож буй PM-EP системийн программ хангамжийн архитектур

Энэхүү санал болгож буй PM-EP нь дөрвөн өөр модулиас бүрдэнэ. Эдгээр нь зогсоолын хяналтын систем (PLMS), орон нутгийн зогсоолын удирдлагын систем (LPMS), төвлөрсөн зогсоолын удирдлагын систем (CPMS) болон хамгийн сүүлд зогсоолын бэлэн байдлын мэдээлэл, захиалгын GUI юм. Эдгээр модулиуд тус бүрийн функциональ тодорхойлолтыг энэхүү санал болгож буй системээр хийсэн зогсоолын менежментийн ажлын урсгалын диаграммыг энэ хэсэгт үзүүлэв.

### 1. Зогсоолын хяналтын систем

(PLMS): Энэхүү программ хангамжийн модуль нь arduino MEGA 2560 микроконтроллер

<sup>22</sup> Y. C. Ma and Y. H. Huang, 00General Application Research on GSM Module, 00 Applied Mechanics and Materials 151, pp.96-100. January 2012 DOI: 10.4028/www.scientific.net/AMM.151.96.

дээр суурилагдсан. Энэ нь хэт авианы мэдрэгчийн зангилааны дамжуулж байгаа болон хүлээн авсан дохионы хоорондох цагийн зөрүүг үндэслэн зогсоол дотор тээврийн хэрэгсэл байгаа эсвэл байхгүй байгааг илрүүлэх боломжтой.



2 дугаар зураг. Зогсоолын тоолуурын (PM) блок диаграммд


60 миллисекунд тутамд дууны долгион. Зарим тээврийн хэрэгслийг илрүүлсний дараа 3 удаа дараалан зогсоол дотор байгаа тохиолдолд тухайн зогсоолыг ямар нэгэн тээврийн хэрэгсэл эзэмшиж байгаа нь нотлогддог. Дараа нь энэ нь агшин зуурын зургийг авч, зургийг LPMS руу илгээж, Wi-Fi холболтоор дамжуулан боловсруулдаг. Тээврийн хэрэгслийг буруу байрлуулсан бол LPMS зургаас улсын дугаарыг гаргаж чадаагүй бөгөөд дараа нь PLMS-д тээврийн хэрэгслийн буруу зогсоолын талаар дохиоллын IC-ээр дамжуулан анхааруулах дууг үүсгэх командыг өгнө. Энэ нь тээврийн хэрэгслийг илрүүлэх үед авто машины зогсоолоос гарах үед зогсоолын үргэлжлэх хугацааг тооцоолох боломжтой. Тээврийн хэрэгсэлд суусан хүн байгаа эсэхийг шалгаж, зураг дээрх ажлын урсгалын диаграммд үзүүлсэн шиг LPMS-д мэдээлнэ үү. Зураг 3. мөн PLMS LPMS-ээс холбогдох зогсоолын захиалгын командыг хүлээн авбал гэрэл асаалттай байгааг харуулж байна.

2. Орон нутгийн зогсоолын удирдлагын систем (LPMS): Энэ модуль нь зогсоолын талбай бүрд байдаг орон нутгийн зогсоолын менежментийн сервер дээр байрлуулсан. Энэ нь зогсоолын талбайг бүхэлд нь хянах үүрэгтэй. Энэ нь зогсоол бүрийн хоосон, нөөцөлсөн эсвэл эзлэгдсэн статусыг хянахын тулд бүртгэл хөтөлдөг. LPMS-ийн ажлын урсгалын диаграммыг зурагт үзүүлэв. Энэ системээр гүйцэтгэсэн төрөл бүрийн ажлуудыг доор жагсаав.

Энэ нь PLMS-ээс хүлээн авсан дүрсийг боловсруулахдаа автомашины дугаарыг



автоматаар таних (ALPR) алгоритм<sup>23</sup> ашиглан зогсоол дээр байгаа тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тодорхойлохыг оролддог. Хэрэв ALPR автомашины улсын дугаарыг гаргаж чадахгүй бол LPMS-д хавсаргасан GSM модулиар дамжуулан сайтын ажилтан руу дугаарыг (LPN) гараар системд оруулах зорилгоор SMS илгээдэг. Тээврийн хэрэгслийг буруу байрлуулсан бол ALPR амжилтгүй болох бөгөөд энэ тохиолдолд сайтын ажилтан LPN-г гараар оруулах SMS хүлээн авдаг. Зурган дээр улсын дугаар харагдахгүй байгаа тохиолдолд автомашины буруу зогсоолыг хялбархан илрүүлж болно, энэ тохиолдолд LPN-г гараар оруулах нь амжилтгүй болж, дараа нь LPMS нь буруу зогсоолын дохиог PLMS-д илгээж, ажлын урсгалын диаграммд үзүүлсэн шиг буруу зогсоолын талаар анхааруулга өгөх болно. Зургаг 3. ба зургаг 4.



3 дугаар зураг. Зогсоолын хяналтын системийн ажлын урсгалын диаграмм


• Нөгөөтээгүүр, зогсоол дээр байрлуулсан зарим тээврийн хэрэгслийн улсын дугаарыг амжилттай авсан тохиолдолд холбогдох зогсоол-ийн бичлэгийг төлөвийг нь өөрчлөхөөр өөрчилсөн “хоосон” руу “злэгдсэн” мөн түүнчлэн тээврийн хэрэгсэл оруулах-ийн мэдээлэл. Зарим тээврийн хэрэгсэл зогсоолоос гарах үед PLMS-ээс тухайн тээврийн хэрэгслийн зогсоолын үргэлжлэх хугацааг хүлээн авдаг.

<sup>23</sup> C. N. E. Anagnostopoulos et al., 00A License Plate-Recognition Algorithm for Intelligent Transportation System Applications, 00 IEEE Transactions on Intelligent Transportation Systems, vol. 7, no. 3, September 2006, pp. 377-392.

Дараа нь LPMS нь тухайн тээврийн хэрэгслийн зогсоолын төлбөрийг тооцож, төлбөр төлөх шаардлагатай бол жолооч руу төлбөрийн сонголттой SMS илгээдэг.

• Төвлөрсөн зогсоолын удирдлагын серверээс (CPMS) зогсоолын захиалгын хүсэлтийг хүлээн авах бүрдээ эхлээд зогсоол дүүрээгүй бол хоосон зогсоолыг сонгоод дараа нь холбогдох PLMS руу захиалгын командыг илгээдэг.

Захиалга PLMS-ээр баталгаажсан тохиолдолд тухайн зогсоолын бүртгэлд өөрчлөлт оруулж, статусыг нь хадгалсан байх ба мөн захиалгат тээврийн хэрэгслийн мэдээллийг оруулна. Үүний дараа LPMS нь ажлын зурагт заасан хоосон зогсоолын тоотой хамт захиалга баталгаажуулсан мессежийг CPMS руу илгээдэг.



4 дүгээр зураг. Орон нутгийн зогсоолын менежментийн системийн ажлын урсгалын диаграмм

Дээрх урсгалын диаграмм. Зогсоолын талбай дүүрсэн тохиолдолд LPMS нь тухайн зогсоолын талбайд үнэ төлбөргүй зогсоол байхгүй тухай CPMS-д мэдэгдэнэ.

Төвийн зогсоолын удирдлагын систем (CPMS): CPMS нь CPMS-ийг интернэтэд ашиглах боломжтой болгохын тулд дэлхийн IP<sup>24</sup> бүхий дээд зэрэглэлийн сервер болох төвийн зогсоолын удирдлагын сервер дээр байрлуулсан байдаг. Тиймээс интернэтээр дамжуулан харилцах боломжтой. Энэ нь тухайн зогсоол доторх үнэ төлбөргүй зогсоолуудыг бүртгэхийн тулд зогсоол бүрийн бүртгэлийг хөтөлдөг. Тиймээс энэ нь жолооч дээр ажиллаж

<sup>24</sup> V. Corts, Y. Ruiz, S. Fernandez, D. Lozano, D. Gonzalez and P. Dez, 00Global IP Services Delivery, 00 2009 13th International Conference on Intelligence in Next Generation Networks, Bordeaux, 2009, pp. 1-6. doi: 10.1109/ICIN.2009.5357103



байгаа GUI-ийн тусламжтайгаар зогсоолын бэлэн байдлын мэдээллээр дамжуулан хотын хэмжээнд байгаа зогсоолуудын мэдээллийг үнэ төлбөргүй зогсоолын тоогоор өгөх боломжтой гар төхөөрөмж. Энэ нь зарим тээврийн хэрэгслээс тодорхой байгууламжийн бүсэд байрлах зогсоол захиалах хүсэлтийг хүлээн авах үед жолоочийн хүсэлтийг тухайн зогсоолын талбайтай холбоотой харгалзах LPMS руу илгээдэг. LPMS нь зогсоол захиалж, захиалгын баталгаажуулалтыг илгээсний дараа CPMS үүнийг үйлчлүүлэгчид хүргэх боломжтой төлбөрийн сонголтуудын хамт программ.

Зогсоолын бэлэн байдлын мэдээлэл ба захиалгын GUI: Энэ нь драйвер дээр байрлуулсан үйлчлүүлэгчийн программ бүхий гар барих боломжтой төхөөрөмж. Энэхүү үйлчлүүлэгчийн GUI нь жолоочид хотын хэмжээнд янз бүрийн зогсоол байгаа эсэх талаар мэдээлэл авахаас гадна интернэтээр тохирох зогсоолын талбайн дотор зогсоол захиалах боломжийг олгодог. Захиалга амжилттай бол жолоочоос захиалгын хугацаанаас хамаарч төлбөрөө хийхийг хүсэх болно. Төлбөр төлсний дараа зогсоолын талбайг харуулсан зогсоолын дүрсийг үйлчлүүлэгчийн аппликейшнд хүргэнэ.

#### **Дүгнэлт**

Хотын авто зогсоолын хомсдол, замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах зорилгоор боловсруулсан энэхүү цахим зогсоолын систем нь орчин үеийн дижитал технологид суурилсан, үр ашигтай менежментийн цогц шийдэл юм. Судалгаанд танилцуулсан энэхүү систем нь жолооч нарт реаль цагийн мэдээлэл олгох, зогсоол захиалах, ухаалаг төлбөр тооцоо хийх

зэрэг олон талын давуу талтай.

Системийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох зогсоолын тоолуур нь зогсоолд автомашин орж, гарч буй мэдээллийг бүртгэх, зогсоолын ашиглалтын хугацааг хянах, мөн буруу зогссон тээврийн хэрэгслийг илрүүлэх функцтэй. Ингэснээр хүний оролцоог багасгаж, автомат хяналт, удирдлагыг бүрэн хангах боломжтой болно.

Түүнчлэн хэрэглэгчид (жолооч нар) ухаалаг төхөөрөмжөөр дамжуулан зогсоолын нээлттэй байдал, төлбөрийн нөхцөлүүдийг харах, захиалах, төлбөрөө цахимаар төлөх боломжтой бөгөөд энэ нь хэрэглэгчийн тав тухыг нэмэгдүүлж, цаг хугацаа хэмнэхэд шууд нөлөөлнө.

–Энэхүү системийг хотын хэмжээнд хэрэгжүүлснээр дараах үр нөлөөг үзүүлнэ

–Авто зогсоолын хүртээмж, менежментийн үр ашиг нэмэгдэнэ.

–Замын хөдөлгөөний түгжрэл буурна.

–Зогсоолын төлбөрийн хураамжийн ил тод байдал сайжирна.

–Жолооч нарт тав тухтай, ухаалаг шийдэл бүхий хэрэглэгчийн туршлага бүрдэнэ.

–Хотын ухаалаг дэд бүтцийн хөгжилд бодит хувь нэмэр оруулна.

Иймд энэхүү цахим зогсоолын систем нь ухаалаг хотуудад тээврийн менежментийн салбарт хэрэгжүүлж болохуйц, шинэ үеийн дэвшилтэт шийдлийн нэг болж байна. Цаашид уг системийг технологийн хөгжлөөс шалтгаалан улам боловсронгуй болгож, хиймэл оюун ухаан, IoT төхөөрөмжүүдтэй хослуулан өргөжүүлэх боломжтой юм

## Ашигласан материал:

1. Al-Kharusi, H. and Al-Bahadly, I., "Intelligent Parking Management System Based on Image Processing," *\*World Journal of Engineering and Technology\**, 2014, 2, pp. 55–67.
2. Anagnostopoulos, C. N. E., et al., "A License Plate-Recognition Algorithm for Intelligent Transportation System Applications," *\*IEEE Transactions on Intelligent Transportation Systems\**, vol. 7, no. 3, September 2006, pp. 377–392.
3. Basavaraju, S. R., "Automatic Smart parking System using Internet of Things (IoT)," *\*International Journal of Scientific and Research Publications\**, vol. 5, issue 12, December 2015.
4. Corts, V., Ruiz, Y., Fernández, S., Lozano, D., González, D. and Díaz, P., "Global IP Services Delivery," *\*2009 13th International Conference on Intelligence in Next Generation Networks\**, Bordeaux, 2009, pp. 1–6. doi: 10.1109/ICIN.2009.5357103
5. Dinh, T. and Kim, Y., "A novel location-centric IoT-cloud based on-street car parking violation management system in smart cities," *\*Sensors (Switzerland)\**, vol. 16, no. 6, 2016.
6. Faheem et al., "A Survey of Intelligent Car Parking System," *\*Journal of Applied Research and Technology\**, vol. 11, issue 5, pp. 714–726.
7. Gandhi, B. M. K. and Rao, M. K., "A Prototype for IoT based Car Parking Management system for Smart cities," *\*Indian Journal of Science and Technology\**, 9(17).
8. Hongwei Wang and Wenbo He, "A Reservation-based Smart Parking System," *\*2011 IEEE Conference on Computer Communications Workshops (INFOCOM WKSHPS)\**, Shanghai, 2011, pp. 690–695. doi: 11109/INFCOMW.2011.5928901
9. Idna Idris, M. Y., Noor, N. M., and Razak, Z., "Car Park System: A Review of Smart Parking System and Its Technology," *\*Information Technology Journal\**, 8(2), pp. 101–113, 2009, ISSN 1812-5638.
10. Karbab, E., Djenouri, D., Boukaboul, S., and Bagula, A., "Car park management with networked wireless sensors and active RFID," *\*2015 IEEE International Conference on Electro / Information Technology (EIT)\**, pp. 373–378.
11. Kianpisheh, A., et al., "Smart Parking System Architecture Using Ultrasonic Detector," *\*International Journal of Software Engineering and its Applications\**, vol. 6, no. 3, July 2012, pp. 51–58.
12. Kotb, A. O., Shen, Y. C., Zhu, X., and Huang, Y., "IParker—A New Smart Car-Parking System Based on Dynamic Resource Allocation and Pricing," *\*IEEE Transactions on Intelligent Transportation Systems\**, vol. 17, no. 9, pp. 2637–2647, 2016.
13. Longfei, W., Hong, C., and Yang, L., "Integrating Mobile Agent with MultiAgent System for Intelligent Parking Negotiation and Guidance," *\*4th IEEE Conference on Industrial Electronics and Applications\**, 25–27 May 2009, pp. 1704–1707.
14. Lu, R., Lin, X., Zhu, H., and Shen, X., "SPARK: A New VANET Based Smart Parking Scheme for Large Parking Lots," *\*IEEE INFOCOM 2009\**, Rio de Janeiro, pp. 1413–1421. doi: 1109/INFCOM.2009.5062057
15. Ma, Y. C. and Huang, Y. H., "General Application Research on GSM Module," *\*Applied Mechanics and Materials\**, vol. 151, pp. 96–100, January 2012. DOI: 10.4028/www.scientific.net/AMM.151.96
16. Pala, Z. and Inanc, N., "Smart Parking Applications Using RFID Technology," *\*2007 1st Annual RFID Eurasia\**, Istanbul, 2007, pp. 1–3. doi: 10.1109/RFIDEURASIA.2007.4368108.
17. Patil, M. and Bhonge, V. N., "Wireless sensor network and RFID for smart parking system," *\*International Journal of Emerging Technology and Advanced Engineering\**, vol. 3, no. 4, pp. 188–192.
18. Rahayu, Y. and Mustapa, F. N., "A secure parking reservation System using GSM technology," *\*International Journal of Computer and Communication Engineering\**, 2(4), p. 518.
19. Reddy, P. D., Rao, A. R., and Ahmed, S. M., "An Intelligent Parking Guidance and Information System by using image processing technique," *\*International Journal of Advanced Research in Computer and Communication Engineering\**, vol. 2, issue 10, October 2013.
20. Singh, H., et al., "Automated Parking System With Bluetooth Access," *\*International Journal of Engineering And Computer Science\**, ISSN 2319-7242.



## БАГШ ТАСРАЛТГҮЙ ХӨГЖИХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

**Д.ОЮУНЦЭЦЭГ** / Байгалийн ухааны тэнхимийн дарга, докторант  
doyunaa2025@gmail.com

**Э.АРИУНЗУЛ** / Байгалийн ухааны тэнхимийн багш, магистр  
zulaa0914@gmail.com

**Түлхүүр үг:** Багшийн хөгжил, багшийн хөгжлийн үзэл баримтлал, багшийн хөгжлийн загвар, багшийн мэргэжил дээшлүүлэх

**Key words:** Teacher development, teacher development concept, teacher developed model, teacher professional development

### Оршил.

Өнөө үед багшийн хөгжил нь улс орнуудын боловсролын бодлогын тэргүүлэх зорилт болж, боловсролын салбарын эрдэмтдийн судалгааны гол объект, зорилго болоод байна. Тиймээс өнөөдөр багшийн хөгжлийн онолын үзэл баримтлалд ч өөрчлөлт орж багшийн хөгжил мэргэжлийн хувьд өөрийнхөө болон бусдын үйл ажиллагаанаас сурч туршлагажих, хамтран ажиллах чиглэсэн зорилготой насан туршийн үйл явц болж байна.

Боловсролын олон улсын чиг хандлага багш боловсролыг олгохоос эхлээд, ажиллах явцдаа туршлага сууж, мэргэжлийн хувьд байнга хөгжиж байхыг шаардаж мөн суралцагчдыг хэрхэн идэвхтэй суралцах, чадавхжуулахад анхаарал хандуулж тэдний хэрэгцээнд нийцсэн мэдлэг, туршлагыг байнга нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага багш нарт бий байна.

Багшийн хөгжлийн талаар улс орнууд өөрийн онцлогт загваруудыг хэрэглэж байгаа ч багш бэлтгэх, дадлагажуулах, мэргэжил дээшлүүлэх, байнга хөгжиж бусдыг сургах дарааллаар явагдаж байна. Багшийн хөгжлийн асуудал нь багш бэлтгэх, багшийн хөгжил, оролцоог дэмжихээс гадна багшийн ёс зүй, нэр хүнд, нийгмийн баталгааг хангах зэрэг ойлголтыг мөн агуулдаг ба багш байнга суралцаж хөгжих нь мэргэжлийн тасралтгүй хөгжлийн илрэл юм.

Багшийн хөгжил гэдэг нь хувь багш өөрийгөө өөрчлөх бүхий л боломжийг ашиглан мэргэжил, мэргэшил боловсролоо байнга дээшлүүлж, цаг ямагт өсөж хөгжиж байдаг идэвхтэй хандлага үйл явц юм.

Багшийн мэргэжлийн багш нарыг боловсролын олон талт үйл ажиллагаанд Багш тасралтгүй хөгжих үйл явцын дүнд боловсролын салбарт шинэ мэдлэг, шинэ хандлага, шинэ итгэл үнэмшил, соёлын үнэт зүйл үйлдвэрлэгдэн тооны болон чанарын өөрчлөлт гарч байдаг.

### Судалгааны үндэслэл

Боловсролын хөгжлийг хангах тогтвортой хөгжлийн үндэс нь багш бүр өөрийн хөгжлийг хангах явдал учраас үйл ажиллагааныхаа явцад өөрийгөө хөгжүүлэх боломжийг бүрдүүлж улмаар хөгжлийн хурдацаас хоцрохгүй байх чадварыг багш бүрээс шаардагдаж байна. Багш нь оюутан залуусыг хөгжүүлэн төлөвшүүлэх, нийгэмшүүлэх үүргээ биелүүлэхийн тулд тасралтгүй хөгжиж байх, өөрийнхөө олон талын мэдлэг чадвараа үргэлж дээшлүүлж боловсронгуй болгох нь чухал юм.

Улс орнууд боловсрол өндөр хөгжсөн орнуудын туршлагаас судалж, түүний дэвшилтэй болон өөрийн орны нөхцөлд тохирохыг нь туршин хэрэгжүүлсээр байна.

Боловсролын бодлогын түвшинд багш нарыг хөгжүүлэх сургалт, олон талт үйл ажиллагааг зохих хэмжээнд гүйцэтгэж байгаа ч багш хөгжих хамгийн чухал хүчин зүйл болтухайн багшийн өөрийн идэвх, тасралтгүй хөгжих өөрийн оролцоо юм. Иймд багшийн хөгжлийн өнөөгийн байдал, гадаад орнуудын туршлагыг судлан багшийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлага багш бүрийн өмнө тавигдаж байна.

### Багшийн хөгжлийн онолын үзэл баримтлалууд

Багш тасралтгүй хөгжих үйл явцын дүнд боловсролын салбарт шинэ мэдлэг, шинэ хандлага, шинэ итгэл үнэмшил, соёлын үнэт зүйл үйлдвэрлэгдэн тооны болон чанарын өөрчлөлт гарч байдаг бөгөөд багшийн хөгжилд нөлөөлж болох дараах аргуудыг дэвшүүлж байна.

**Техникийн үзэл баримтлал:** Багшийн хөгжлийг сургахуйд сургах үйл явц талаас нь авч үздэг. Сурах үйл ажиллагааны биехоризмийн онолд тулгуурладаг энэхүү үзэл баримтлал нь удирдлагын дээд түвшнээс мэргэжил дээшлүүлэх сургалтаар багшийг хөгжүүлнэ гэж үздэг.



**Шинжээчийн үзэл баримтлал:** Багш бол шинжээч тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийг эрмэлзэгч гэж үздэг. Багш шавийнхаа болон өөрийнхөө үйл ажиллагаанд тохиолдож байгаа хүндрэл бэрхшээлийн шалтгааныг шинжлэн судлах замаар илрүүлж, засан сайжруулах арга замыг хайх явцдаа хөгждөг.

**Экологийн үзэл баримтлал:** Сурган хүмүүжүүлэх ухааны итгэл үнэмшлийн болон туршлагын өвөрмөц экологийн тогтолцоог илэрхийлэгч гэсэн санаанд үндэслэн гарч ирсэн бөгөөд багшийн хөгжил нь аяндаа явагдах үйл явц биш, сургуулийн өдөр тутмын амьдралд тасралтгүй үргэлжлэх, суралцах явцын үр дүн юм. Энэхүү үзэл баримтлал нь сурах үйл ажиллагааны конструктивизмын онолд тулгуурлана.<sup>1</sup>



1 дүгээр зураг. Багшийн хөгжлийн онолын үзэл баримтлал

Багш мэргэжлийн хөгжил гэдэг нь багшийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах үйл ажиллагаа бөгөөд иймээс хөгжсөн багшийн тухай ярих болсон бөгөөд энд мэргэжил, мэдлэг, ур чадвараараа төгс мэргэшсэн, нийгэмшил төлөвшлийн өндөр түвшинд хүрсэн, судалгаа, шинжилгээний ажлын арга барил, арга зүй эзэмшсэн, бусдад онол арга зүйн зөвөлгөө, мэдээлэл өгч чадах цаашид улам хөгжин мэргэших түвшинд хүрсэн багшийг авч үзэх боломжтой. Хөгжсөн багшийн загварыг дараахь байдлаар томъёолсон байна.<sup>2</sup>

**Хөгжсөн багшийн загвар**

Төлөвшил хувийн шинжийн хувьд:	Бүтээлч хандлагын хувьд:
Бие хүний ерөнхий шинж төлөвшсөн байх Өөртөө итгэлтэй байх Даяаршил, бус нутгийн хөгжлийн хандлагыг мэдэрдэг Хуулбарлах иррационал бус, танин мэдэх рациональ хандлагыг ухаардаг Ур ухааныг төлөвшүүлэх прагматик чиглэлийг баримжаалсан Хүмүүнлэгийн болон социаль шинжийг эзэмшсэн Харилцааны сэтгэл зүй эзэмшсэн	Шинэчлэгдэх чадвар Асуудлыг олон талаас нь иж бүрэн авч үзэх чадвар Олон хувилбараар сэтгэх чадвар Шийдвэр гаргах чадвар Өөрийгөө хөгжүүлэх чадвар Байнга суралцах чадвар Сургалт судалгааг хослуулах чадвар Орчны өөрчлөлтөд дасан зохицох чадвар
Арга зүй, эв дүйн хувьд:	Дидактик чадварын хувьд:

<sup>1</sup> М.Дэлгэржав, Багшийн мэргэжил дээшлүүлэх тухайд, ISBN-13:9789996253737, УБ, 2017.

<sup>2</sup> Ч.Пүрэвдорж, Сургалтын менежмент, ISBN:978-99929-1-845-4, УБ, 2012.

Ерөнхий ба тусгай дидактикийн үндсийг мэддэг Гадаад хэлний бэлтгэлтэй Төлөвлөх баримжаалах чадвартай Хамтран ажиллах чадвартай Хүн хэрхэн суралцдаг зүй тогтолыг мэддэг, сургалтандаа ашигладаг Компьютерийн мэдлэг чадвартай Бие хүн хамт олныг судлах арга зүйг эзэмшсэн Суралцагчийг үнэлэх, хөгжүүлэх чадвартай Хөтөлбөр сурах бичгээ боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөх чадвартай Мэдээлэл олж авах, боловсруулах, солилцох, түгээх чадвартай	Онолын мэдлэгээ сургалтанд хэрэглэх чадвар Судалгааны арга зүй эзэмшсэн байх Хүүхдийн үл ажиллагааг оношлох загвар Бүлгийн хөгжлийн зүй тогтлыг мэдэж хэрэглэх чадвар Сургалтын таатай орчин бүрдүүлэх чадвар Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадвар Хууль эрх зүйн мэдлэгтэй байх шаардлагуудыг хангасан
--	---

**Багшийн мэргэжлийн хөгжлийн загвар**

Олон улсад ажлын байран дахь багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхүйц дараах 9 загварыг судлаачид онцолж байна. Үүнд:

**Сургалтын загвар (the training model):**

Энэ загвар нь багшийг өндөр мэдлэгтэй болгоход анхаарч тэдний мэргэжлийн тодорхой чадваруудыг хөгжүүлэх болон сургалтын агуулга, хичээл заах арга зүйд төвлөрч багшийн ур чадварыг дээшлүүлэх зорилготой. Олон улсад түгээмэл хэрэглэгддэг загвар<sup>3</sup> хэдий ч практик үйл ажиллагаанаас хол, багшийг ажлын байрнаас нь хөндийрүүдэг хэмээн шүүмжилдэг.

**Зэрэг олгох загвар (the award-bearing model):**

Тодорхой кредит олгох, мэргэжлийн зэрэг ахих, шинэ мэдлэг чадварт суралцах сертификатын сургалтууд хамаарна. Мөн хэт онолжсон, академик агуулгаар зохион байгуулдаг<sup>4</sup> гэж зарим судлаачид үздэг.

**Хэрэгцээний загвар (the deficit model):**

Багш ажиллаж байх явцад төрөл бүрийн бэрхшээлийг даван тулгардаг. Энд багшаас гадна боловсролын байгууллага, хамт олон анхаарал хандуулж<sup>5</sup> багшийн мэргэжлийн хэрэгцээ, шаардлага юунд байгааг илрүүлж оролцох ёстой<sup>6</sup>. “Хувь хүний цогц чадамж”, “хамт олны цогц чадамж” зэрэг ойлголтыг дэвшүүлэн сургуулийн хөгжилд хамт олны цогц чадамж чухал үүрэгтэй

**Каскад загвар (the cascade model):**

Мэргэжлийн хувьд ахих төрөл бүрийн сургалтанд хамрагдсан багш нараас бусад багш нартаа мэдлэгээ хуваалцах зорилготой. Энэ загвар нь сургалтын зардлыг хэмнэж, бага зардлаар олон багшид мэдлэг түгээх боломжийг олгоно. Гэхдээ мэргэжлийн үнэт зүйлийг орхигдуулдаг.<sup>7</sup>

**Стандартад суурилсан загвар (the standards-**

<sup>3</sup> Little, 1994; Kelly & McDiarmid, 2009

<sup>4</sup> Hoban, 2002

<sup>5</sup> Rhodes, Benecike, 2008

<sup>6</sup> Борхэм (Boreham, 2004)

<sup>7</sup> Joan Solomon, Sue Tresman, 1999, <https://www.tandfonline.com/doi/pdf/10.1080/13674589900200081>



based model): Энэ загвар нь бихеворист онолд суурилсан ба багш нарын мэргэжлийн үйл ажиллагаа болон зорилготой холбоотой тул мэргэжлийн хүрээнд ойлголцон идэвхтэй оролцсоноор хамтдаа мэдлэг бүтээх сайн талтай. Энэ загвар нь багшлах үйлээс суралцагчдын сургалтын амжилт хоёрын хоорондын холбоог тусгаарлах талтай.<sup>8</sup>

Зөвлөн туслах, дагалдуулан сургах загвар (the coaching/mentoring model): Туршлагатай багш дагалдуулах эсвэл хэд хэдэн чадварлаг багш нарыг дагалдуулан туршлага хуримтлуулах хэлбэрээр явуулдаг ба сургуулийн орчинд, бодит асуудлын хүрээнд тэдгээрийг шийдвэрлэх туршлагатай хамт олноос суралцах явдал юм.

Мэргэжлийн хамтлагийн загвар (the community of practice model): Мэргэжлийн багш нар хамтарч сургалт хичээлийг төлөвлөх, сургалтын материал боловсруулах, туршлагаа солилцох зэргээр хамтран сургалтын нэгдсэн ойлголтыг бий болгох, тэрхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцох боломжийг олгоно.

Үйлийн судалгааны загвар (the action research model): Багш нар бусад мэргэжил нэгт нөхдийн үйл ажиллагаанаас суралцах зорилготой ба ажиглах, туршлага судлах болон туршлагаа хуваалцах, сургалтын явцад гарч буй бэрхшээлүүдийг олж тогтоон, задлан шинжлэх, түүнийг шийдвэрлэх арга замыг хамтдаа эрэлхийлэх, шинэ арга замыг боловсруулах, хөтөлбөр стандартаа боловсронгуй болгох зэргээр хамтарсан судалгаа хийх замаар явагддаг байна.

Сурах, сургахуйн практикийг өөрчлөх загвар (the transformative model): Энэ загвар нь сургуулийн янз бүрийн үйл ажиллагааг өөрчлөн шинэчлэх, сурах сургах үйлийн чанарыг дээшлүүлэх, боловсролын тогтвортой хөгжлийг хангах чиглэгдэнэ.

Дээрх загваруудаас улс орнууд өөрсдийн онцлог, боловсролын чиг хандлагад тохируулан сонгон хэрэглэж байна.

### Монгол улсын багшийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчин

2 дугаар зураг. Боловсролын хөгжлийг дэмжих тогтолцоо

**Багшийн мэргэжил дээшлүүлэх.** Монгол улс багшийн мэргэжил дээшлүүлэх асуудалд төрийн бодлогоор анхаарч ирсэн бөгөөд 1956 онд Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт (БМДИ) анх байгуулагдан багш нарын сурган

хүмүүжүүлэх ухаан, заах арга зүйн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, сургууль, багш нарын тэргүүн туршлагыг судлан нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж иржээ.



**Багшийн хөгжлийн төв:** БХДТХ-ийн 7.1-т бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвтэй байхаар заасан. Багшийн хөгжлийн төв (БХТ) гэж багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжихөд шаардлагатай хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж бүхий орчинг хэлэнэ.

**Ажлын байран дээр тасралтгүй хөгжих:** Багшийн хөгжил байнгын тасралтгүй үйл ажиллагаа бөгөөд “Ердийн орчин нөхцөлд явагдах мэргэжлийн сургалтыг ажлын байранд явагдаж болно. Ажилтнуудыг чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх, шинэ мэдээллээр хангах үйл ажиллагааг ажлаас хөндийрүүлэлгүйгээр зохион байгуулах үйл ажиллагаа юм.

### Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа


Түвшин	Хэрэгжүүлэх субькт
Үндэсний түвшин	Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага
Орон нутгийн түвшин	Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага
Байгууллагын түвшин	Захирал, сургалтын менежер, эрхлэгч, арга зүйч
Сонирхлын бүлгийн түвшин	Хамтын удирдлагын нэгдэл
Багшийн түвшин	Багш өөрөө

### ГАДААД УЛСЫН БАГШЫН ХӨГЖЛИЙН СУДАЛГАА

Багш хөгжлийн талаарх олон улсын чиг хандлагын судалгаа<sup>9</sup>

<sup>8</sup> Beyer, L. (2002). The politics of standardization: Teacher education in the USA. *Journal of Education for Teaching* 28, 239-245, <https://www.sciepub.com/reference/220353>

<sup>9</sup> Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас явуулсан олон улсын судалгаа (2014) (Continuous Professional Development among Primary Teachers in Ireland, OECD)



1 дүгээр график. Багш нарын хамгийн олон хамрагдсан мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаа


Багш нар мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд оролцох цагийн хувьд АНУ, Австралийн зарим муж, Финланд, Австри, Бельги, Унгар, Нидерланд, Шотланд, Швед, Швейцари зэрэг улсад жилд 5–аас доошгүй өдөр гэж заасан байдаг.

Судалгаанд оролцсон улс орнуудын хувьд жилд 15 цаг (Австри) –аас 104 цаг (Швед)–ийн хооронд байна. Багш нарт мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд оролцоход тухайн байгууллагад нэгдсэн ихэнх оронд судалгааны тэтгэлэг олгох, ажлаас чөлөөлөх зэргээр дэмжлэг үзүүлдэг байна. Хичээлийн жилийн явцад чөлөө олгохдоо орлох багшийг гэрээгээр ажилуулна.

Бельги, Чех, Финланд, Итали, Литви, Люксембург, Португал, Словени, Англи улсад цалинтай чөлөө олгодог. Чех улсад нэг хичээлийн жилд багшид 12 ажлын өдөр бие даасан судалгаа хийх, Итали улсад багш нараа эрчимтэй сургалтад хамруулахад хичээл хаах хүртэл сургалтын хуваарийг зохицуулах зөвшөөрөл олгодог байна.

Багш нараа сургалтад хамруулах асуудлаар дээр дурьдсан орнуудад тулгарч буй бэрхшээлд орлох багшийг олох, тэдгээрийн цалингийн асуудал орж байгаа бөгөөд энэ нь эргээд багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд хамрагдахад саад болж байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Хэдийгээр мэргэжлийн үйл ажиллагаанд багш нар өргөн хамрагдаж байгаа хэдий ч тэдгээр үйл ажиллагаа нь багш нарын хэрэгцээг хангах тал дээр хангалтгүй байдаг байна. Тухайлбал дээрх судалгаанд хамрагдсан багш нарын 50% нь хэрэгцээ хангаагүй, дахин мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд хамрагдах шаардлагатай гэж үзсэн байна.



2 дугаар график. Мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд оролцоход багш нарт учирч буй бэрхшээл<sup>10</sup>

Мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд оролцоход учирч буй бэрхшээлд хамгийн их нь багш нар ажлын ачаалал, хичээлийн хуваарь болон багшийн хэрэгцээг хангах, тохиромжтой үйл ажиллагаа ховор зохин байгуулагддаг зэргийг нэрлэсэн бол гэр бүлийн байдал, төсөв зардал өндөр нь мэргэжлийн хөгжилд нэлээд бэрхшээл болж байна. Харин сургуулийн удирдлагын дэмжлэг сул гэж хамгийн бага хувь нь хариулснаас харахад сургуулийн зүгээс тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлдэг ч хангалттай түвшинд хүрэхгүй байгаа харуулж байгаа болов уу.

### Багш, багшийн боловсрол, мэргэжлийн хөгжлийн судалгаа

Улс	Багш бэлтгэх	Заавал гүйцэтгэх дадлага, сургалт	Мэргэжил дээшлүүлэх сургалт, хугацаа
Монгол	Багш боловсролын 4 жил, Багш мэргэжлээр төгсөөгүй дээд боловсролтой төгсөгчид багшлах эрх олгох сургалтанд сууна.	Багш мэргэжлээр дээд боловсрол олгох ИДС–ийн сургалтын хөтөлбөрт 6 сарын хугацаатай дадлагажигч багшаар ажиллах агуулгыг багтаана	Багш мэргэжил зээмшсэнээс хойш 5 жил тутамд сургалтанд хамрагдана.
Финлянд	Магистрын зэрэг нь багшийн мэргэжлийн урьдчилсан нөхцөл болдог. Багш мэргэжлээр 300 кр бүхий магистрын сургалтанд 5–6 жил суралцдаг.	Сурган хүмүүжүүлэх ухааны хичээлд багтсан багшлах дадлага сургуулийг их, дээд сургуулийн багш бэлтгэх сургууль болон харьяа сургуулиудад зохион байгуулдаг.	Жилд 3 өдөр багшлах дадлагын мэргэжлийн сургалтанд суудаг.
Япон <sup>11</sup>	Багш мэргэжил олгодог их дээд сургуулийн багшлах эрхийн сургалтанд хамрагдана.	Шалгалт өгч багшаар 1 жил ажиллана. Энэ хугацаанд мужаас санал болгосон сургалтанд сууна.	10 жил ажилласан багш мэргэжил дээшлүүлэх курс, семинарт хамрагдана.

<sup>10</sup> ibid

<sup>11</sup> Kenji, 2015



Канад <sup>12</sup>	Багшийн мэргэжлээр 3 жил эсвэл бакалаврын боловсрол дээр 2 жил багшийн боловсрол	Шинэ багш 50 хоногос 6 сарын хугацаатай багшлах дадлага хийх	Зарим мужид багш нар 5 жил тутамд 100 цаг сургалтанд сууж ёстой.
Норвеги <sup>13</sup>	Багшийн мэргэжлээр 4 жил Их дээд сургуулийн багш бол магистр	Бага сургуулийн багш 30 кр Дунд, ахлах сургуулийн багш 60-аас доошгүй кр судалсан байх эсвэл 100 хүртэлх хоног дадлага хийх	Багш нар мэргэжлийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх зөвшөөрөлтэй аль ч байгууллагад мэргэшлээ дээшлүүлэх боломжтой.
ОХУ	Бага боловсролд багшлах бол 4 жил Дээд сургуульд багшлах бол 5 жил	Багшлах гэрчилгээ	Хуулиар багш нар мэргэжлийн түвшингээ дээшлүүлэх үүрэг хүлээдэг. 3 жилд 1-ээс доошгүй удаа нэмэлт мэргэжлийн боловсрол эзэмших эрхтэй.
Америк <sup>14</sup>	Сургуулийн өмнөх боловсролд багшлах бол 3 жил, Бага ангийн багш 5 жил, Дунд сургуулийн багш магистр	Багшаар ажиллахад мэргэжлийн шалгалт өгнө. Улсын сургуульд багшлахад 1-2 жил сургалтанд сууж үнэмлэх авсан байна.	Багшийн үнэмлэхийг сунгахын тулд тасралтгүй мэргэжил дээшлүүлэх, боловсрол эзэмшихийг шаарддаг.
БНХАУ	СӨБ, ЕБС, коллеж, түүнээс дээш боловсролтой байх Бага сургуульд ЕБС эсвэл коллеж, түүнээс дээш сургууль төгссөн байх Дунд сургуульд дээд сургууль эсвэл их сургуулийн багш коллеж, их сургуулийн бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй байх Дээд сургуульд магистр зэрэгтэй байх.	Багшаар ажиллахад мэргэжлийн шалгалт өгч гэрчилгээ авна. Багшийн мэргэжлийн гэрчилгээг 5 жил тутам тогтмол бүртгэнэ. Ээлжит бүртгэл нь шаардлага хангаагүй, бүртгэлийн хугацаа хэтэрсэн тохиолдолд цаашид боловсролын ажил эрхлэхийг хориглоно.	Багш нар мэргэжлийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн сэтгэлгээний хувьд өөрсдөө хөгжсөнөөр мэргэжлийн хөгжлийн түвшингээ дээшлүүлэх боломжтой. Мэргэжлийн зэрэглэлээс хамаарч жил бүр үнэлгээ өгөх бөгөөд шалгалтанд тэнцсэн бол жилд нэг удаа түвшин ахиж цалин нэмэгддэг байна

Судалгаанаас харахад шинэ багш нарт мэргэжлийн мэдлэгийг сайн олж авсан байхыг дээрх улсуудын багш мэргэжилтэн бэлтгэх байдлаас харж болохоор байна. Энд багшаар ажиллахад уг мэргэжлээр суралцсан хугацаа 3-5

жил хүртэл байна. Гэхдээ хэдий бага хугацаагаар сурсан, мөн багшаас өөр мэргэжилтэй байж болох ч ихэнх улсад багшлах эрхийн сургалтанд сууж үнэмлэх, гэрчилгээтэй (Америк улсад суралцах шалгалт өгч тэнцсэнээр авдаг) байж багшаар ажилладаг байна.

Хятад улсын хувьд 5 жил тутам уг гарчилгээг сунгуулах бөгөөд сунгуулаагүй тохиолдолд ажиллах эрх нь мөн хаагдана. Норвеги, Монгол улсын хувьд багш боловсролоор бакалаврын түвшинд суралцсан бол багшаар ажиллаж болох хэдий ч тодорхой кредит хангасан юмуу дадлага хийхийг шаарддаг байна.

Багшлах дадлага нь шинэ багшийн хувьд мэргэжилдээ дасах, практик дээр суралцах боломж юм. Үүнийг зарим улсад их, дээд сургуулийн багш бэлтгэх хөтөлбөрөөр хийж болох ч Норвеги, Канад, Япон улсын хувьд багшийн ажилд орсноос эхлээд 50, 100 хоног, 6 сар бүр нэг жил хүртэлх хугацаагаар хийдэг байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тухайд дээрх улсуудын хувьд харилцан адилгүй байна. Ихэнх улсууд багшид мэргэжлээр ажилласан 3, 5, 10 жил тутамд сургалтанд хамрагдахыг шаарддаг байна.

Монгол улсын хувьд багш мэргэжил эзэмшсэнээс хойш 5 жил тутамд сургалтанд хамрагдана гэжээ. Харин Хятад улсын хувьд мэргэжил дээшлүүлэх сургалтанд албан ёсоор хамрагдах талаар хуульчилж өгөөгүй ч мэргэжлийн үнэлгээний стандартанд үндэслэн жил бүр ажлын гүйцэтгэлээр албан тушаалын зэрэглэл ахиж боломж олгож байгаа нь багш өөрийн санаачлагаар мэдлэг, мэргэжилдээ хөгжих гаардлагыг бий болгодог байна.

Орос улсын хувьд 3 жилд 1-ээс доошгүй удаа нэмэлт мэргэжлийн боловсрол эзэмших эрхтэй. Канад улсад 5 жил тутамд 100 цаг сургалтанд суух ёстой байдаг бол Финлянд улсын багш жилд 3 өдөр багшлах дадлагын мэргэжлийн сургалтанд суудаг нь сонирхол татаж байна. Харин Монгол улсын хувьд 5 жил тутам мэргэжлээ дээшлүүлэхдээ ямар хугацааны сургалтанд суух нь тодорхойгүй байна.

Америкт багш нар багшийн үнэмлэхээ сунгахын тулд тасралтгүй мэргэжил дээшлүүлэх, боловсрол эзэмшихийг шаарддаг бол харин Хятад, Норвеги улсын хувьд багш нар хуулиар мэргэжлийн түвшингээ дээшлүүлэх үүрэг хүлээдэг ч хэзээ, ямар сургалтанд хамрагдах тухай зохицуулалт судалгааны явцад хараахан олж харсангүй. Харин мэргэжлийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх зөвшөөрөлтэй аль ч

<sup>12</sup> Charlotte, 2015

<sup>13</sup> The Progress in International Reading Literacy Study (PIRLS) 2015/16

<sup>14</sup> for TIMSS 2015 and PISA 2015



байгууллагад мэргэжлээ дээшлүүлэх боломжтой юм. Монгол улсын БХДТХ-иар багш өөрөө хөгжих нь багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны нэг хэсэг болохыг тусгаж өгсөн байна.

#### Дүгнэлт

Багшийн хөгжлийг үндэсний хэмжээний болон орон нутгийн байгууллага, сургууль боловсролын бодлогын түвшинд багш нарыг хөгжүүлэх сургалт, олон талт үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа ч багш хөгжих хамгийн чухал хүчин зүйлсийн нэг бол тухайн багшийн өөрийн идэвх, оролцоо юм.

Судалгаанд сонгон авсан улсуудын багшийн хөгжлийг багш мэргэжилтэн бэлтгэх, багшаар ажиллах мэргэжлийн сургалт дадлага, мэргэжил дээшлүүлэх сургалтыг байдлыг харьцуулан судаллаа.

Шинэ багш нарт мэргэжлийн мэдлэгийг сайн олж авсан байхыг дээрх улсуудын багш мэргэжилтэн бэлтгэх байдлаас харж болохоор байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тухайд дээрх улсуудын хувьд харилцан адилгүй байна. Ихэнх улсууд багшид мэргэжлээр ажилласан 3, 5, 10 жил тутамд сургалтанд хамрагдахыг шаарддаг байна. Хятад, Норвеги улсын хувьд багш нар хуулиар мэргэжлийн түвшингээ дээшлүүлэх үүрэг хүлээдэг ч хэзээ, ямар сургалтанд хамрагдах тухай зохицуулалт судалгааны явцад хараахан олж харсангүй.

Багшийн мэргэжил дээшлүүлэх нь үндсэндээ багшийн мэргэжлийг тасралтгүй хөгжүүлэх үйл явц бөгөөд багш нар шинэ мэдлэгийг үргэлжлүүлэн хүлээн авч, мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлсээр байдаг.

#### Багш тасралтгүй хөгжих чиг хандлага

Багшийн мэргэжил дээшлүүлэх хүчин чармайлт үр дүнтэй байгаа эсэхийг тодорхойлох санал хүсэлт, эргэцүүлэн бодох боломжид анхаарлаа хандуулах.

Бүтээлч багш нарын хамтын үйл ажиллагааг хөгжүүлэх, дэмжих, харилцан бие биенээсээ суралцах мэргэжлийн хамтын бүлэг хэлбэрээр хөгжих.

Гадаад орнуудын багшийн хөгжлийн дэвшилтэт туршлагыг өөрийн орны онцлогт тохируулан нутагшуулах. Багшийн мэргэжлийн хувьд ахиж дэвшихийг тэдний ажлын үр дүн, мэдлэг мэргэжлийн хөгжилтэй холбох гэх мэт.

Сургуульд түшиглэсэн нөөц бололцоог нэмэгдүүлэх, багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, сургуулийн удирдлага бүтээлч хамт олныг төлөвшүүлэх тал дээр санаачилгатай ажиллах

Багш нарын мэдээлэл технологийн хэрэглээ, боломжийг сурталчлах, зайн сургалтыг хэрэгжүүлэх, зохион байгуулах зэрэг нь багш хөгжлийг шинэ шатанд гаргаж шинэ эриний иргэдийг хөгжүүлэх үйлсэд нэмэр болно.

#### Ашигласан материал:

1. <https://content.page.mn/uploads/users/313/files/iltgel%202015zas.pdf>
2. Багшийн хөгжлийг дэмжих хууль. (БХДХ) бүлэг 3.1.2, <https://edu.gov.mn/public/article/426>
3. М.Дэлгэржав, Багшийн мэргэжил дээшлүүлэх тухайд, ISBN-13:9789996253737, УБ, 2017.
4. Ч.Пүрэвдорж, Сургалтын менежмент, ISBN:978-99929-1-845-4, УБ, 2012.
5. <https://prezi.com/1krnz867dbso/presentation/>
6. МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ТОЙМ, ЮНЕСКО, 2019, [https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/PDF%20files/EPR%20final\\_web%20version1020.pdf](https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/PDF%20files/EPR%20final_web%20version1020.pdf)
7. <https://lavai.msue.edu.mn/ppapers/21-LAV-008.pdf>
8. Overview MELQO Measuring Early Learning Quality and Outcomes, UNESCO, 2017., [https://www.google.mn/books/edition/Overview\\_MELQO/S50zDwAAQBA-J?hl=en&gbpv=1&dq=\(Little,+1994%20+Kelly+%26+McDiarmid,+2009\)&print-sec=frontcover](https://www.google.mn/books/edition/Overview_MELQO/S50zDwAAQBA-J?hl=en&gbpv=1&dq=(Little,+1994%20+Kelly+%26+McDiarmid,+2009)&print-sec=frontcover)



## БАГШ АЖЛЫН БАЙРАНДАА ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

**С.МӨНХЦЭЦЭГ** / ЦХПК-ийн Ерөнхий эрдмийн тэнхимийн ахлах багш  
багш **П.БАТЗУЛ**

**Түлхүүр үг:** Багшийн хөгжил, бүтээлч багш, сургуулийн хөгжил

**Key words:** Teacher's development, Creative teacher", School development

### Хураангуй:

Манай улс боловсролын системдээ өндөр хөгжилтэй орнуудын туршлагаас судалж, түүний дэвшилтэй болон өөрийн орны нөхцөлд тохирохыг нь туршин хэрэгжүүлж байгаа энэ цаг үед сургуулийг шинэчлэн боловсронгуй болгон хөгжүүлэх, үйл ажиллагааных нь үр дүнг дээшлүүлэх, чанартай сургалт явуулах зорилгыг хэрэгжүүлэхийн тулд нэн түрүүнд багшийг хөгжүүлэх зорилт хурцаар тавигдаж, багш хөгжих бүхий л бололцоотой, оновчтой ажлуудыг бодлогын хэмжээнд хэрэгжүүлж байна. Нөгөө талаас боловсролын шинэчлэлийн хөгжилд багш өөрөө хөгжих нөхцөл бололцоог удирдлагын болон үйл ажиллагааны шаг бүрд төлөвлөгөөтэйгөөр зохицуулан зохион байгуулах нь багшийн үүрэг билээ.

Багшийн ажлын гол үзүүлэлт нь чанартай сургалт байдаг. Иймээс чанартай сургалт явуулахын тулд багш хөгжих хэрэгтэй. Хөгжихийн тулд:

- Мэдлэгийн эрин зуунд шинэ мэдээлэл, технологийг хүлээн авч ашиглах,
- Тулгамдсан асуудалд судалгаа хийж, үр дүнгээ хэрэгжүүлэх
- Сурах, сургах үйл явцыг зөв жолоодох,
- Мэдлэг чадвартай харилцааны өндөр соёлтой хамтран ажиллах арга ухааныг эзэмшсэн байх асуудал чухлаар тавигдаж байна.

Өөртөө байхгүй юмыг бусдад өгч чадахгүйтэй адил өөрөө хөгжөөгүй боловсроогүй, хүмүүжээгүй хүн бусдыг хөгжүүлж хүмүүжүүлнэ гэж байхгүй<sup>1</sup> гэж Немцийн нэрт сурган хүмүүжүүлэгч Дистервег хэлсэн байдаг. Багш хүн өөрийн мэргэжлийн үйл ажиллагаандаа авьяас чадвараа чөлөөтэй хөгжүүлж түүгээрээ сурагчдыг бүх талаар зөв төлөвшүүлэхэд зориулах боломжоо олж авдаг байна. Багш нэг бүрийн ажлын хариуцлагыг тодорхойлох хүчин зүйлийн нэг бол хүүхдийн төлөө хүлээсэн үүргээ аль хэр ойлгож байна вэ? гэдгийг олж харах ёстой юм.

Онолын хэсэг: Сурган хүмүүжүүлэх ухааны дийлэнх нэр томьёо нь эртний Грек хэлнээс гаралтай. Педагогика /сурган хүмүүжүүлэх зүй/ гэдэг нь хүнийг төлөвшүүлэхийн тулд зориудаар зохион байгуулсан, эмх цэгцтэй зорилго бүхий <sup>1</sup> Батхуяг С., Ичинхорлоо Ш., Энхжаргал Б., нар. Сурган хүмүүжүүлэх үндэс. Улаанбаатар., 2011.т151.

үйл ажиллагаа, хүмүүжил, боловсрол, сургалтын агуулга, хэлбэр, аргын тухай шинжлэх ухаан юм. Сурган хүмүүжүүлэх зүй нь өөрийн гэсэн үндсэн 3 ухагдахуунтай. Энэ нь боловсрол, хүмүүжил, сургалт юм<sup>2</sup>.

Багш нарын эрхэм зорилт бол сайн сайхан чанаруудыг өөртөө төгс эзэмшээд түүгээрээ сурагчдаа хөгжүүлэх хүмүүжүүлэх явдал байх ёстой. Үүний тулд сургалт хүмүүжлийн ажлыг амжилттай сайн зохион байгуулах явдал багшийн ёс зүй, хувийн үлгэр жишээч байдал зэрэг хувь хүний шилдэг чанаруудыг өндөрт тавих ёстой. Хичээл дээр сурагчдын сэтгэл хөдлөлийн өрнөлийг сэргээх нь гоо зүйн хүмүүжилд их ач холбогдолтой. Тэр нь багшаас зааж байгаа хичээлээ зөв зохион байгуулах, сэтгэлээ уран сайхнаар илэрхийлэх явдлаас эхэлнэ гэж боддог.

### Юунд сургах вэ?

Үйлийн явцад эзэн өөрөө хөгжинө. Багш өөрийнхөө хөгжлийн бүсээс гарч хүүхдийн бүсэд нэгдэн тэдэнд туслах хамтран ажиллах замаар сурагчдаа үйл ажиллагааны эзэн болгох нь онолын үзэл баримтлалаар хичээлдээ бэлтгэх, зохион байгуулах шаардлага гарч байна. Хүүхэд хөгжих явцад “Хичээл бол хүүхдийн жирийн амьдрал байдаг” учраас ирээдүйд сайхан амьдрах хүний дотоод нандин чанар дасгалжин дадлагажиж нийгэм олны тусын тулд болон оюунаа дайчилж тэр чанараараа Монгол иргэн болон төлөвших ёстой. Үүний тулд хүүхдийг амьдрал хөдөлмөрт бэлтгэх талаар хэтийн чанартай зорилт дэвшүүлсэн хэдий ч зөвхөн агуулга талаас нь эзэмшүүлдэг. Харин агуулгын амьдрал дээрх хэрэглээний талаар одооноос л ярьдаг болж байна. Гэвч хичээл гэдэг маань өөрөө амьдрал гэдэг утгаар авч үзвэл энэ агуулгын хэрэглэгч бий болгоход тийм их төвөгтэй биш юм. Хүүхдийг багаас нь өдөр бүр ажил хэрэгч найрсаг харилцаагаар дасгалжуулж дадлагажуулаад байвал тийм чанар эзэмшсэн хүмүүн болон төлөвших нь мэдээж хэрэг. Нөгөө талаар хүний хөгжлийн онол ёсоор “Оюуны идэвхтэй хөгжлийн бүсээс ойрын ирээдүйн бүсэд шилжих үйл ажиллагаа нь хүн бүхэнд харилцан адилгүй байдаг бөгөөд энэ чанараараа багшийн болон нөхдийн туслалцаанд тулгуурласан

<sup>2</sup> Мөн тэнд. т178.



хамтын ажиллагаа байдаг”<sup>3</sup>.

Иймээс сургалт бол харилцаа юм. Оюуны хамтын ажиллагаа мэдээлэл солилцох буюу харилцаагаар илрэн гардаг.

Хүн материаллаг баялагийг үйлдвэрлэн хэрэглэх, танин мэдэхүйн хүрээнд бусадтай харилцах харилцааны дунд амьдардаг.

Бие биедээ харилцан нөлөөлж ойлголцсоны улмаас харилцаанд оролцогчдын аль альных нь хүсэл сонирхол хэрэгцээнд нийцсэн тодорхой зүйлийг шийдэн хийж бүтээх шинэ санааг сэдэх байдлаар хамтын хөдөлмөрийн үр дүнд давуу талыг олж мэдэрдэг байна.

Ардчилсан зарчимд тулгуурлан энэрэнгүй сурган хүмүүжүүлэх ухааны үндсэн шинжүүдийг хэрэгжүүлэх болох юм.

Үндэс болговол дараах үндсэн шинжүүдийг хэрэгжүүлж болох юм.

- Харилцаанд тэгш эрхэй оролцох
- Үзэл бодлоо чөлөөтэй солилцож багаар ажиллах

- Буруу үзэл бодол алдааг засаж залруулах
- Өөрийн санаагаа бусдад тулгаж хүлээлгэхгүй байх

- Харилцан ажил хэрэгч байх

Энэ бүхэн хэрэгжиж чадах аваас сурагчдын хөгжих сурч боловсрох төлөвших явцад эерэг нөлөөлөл бий болно. Үүнийг сургуулийн амьдрлын ардчилал гэж нэрлэж болох бөгөөд сургалт бол багш сурагчийн хоорондын тэгш эрхтэй чөлөөтэй ажил хэрэгч хамтын ажиллагаа гэж тодорхойлж болно. Энэ орчныг бий болгогч нь багш өөрөө байх ёстой юм.


**Судалгааны хэсэг**

Багш ажлын байрандаа хөгжихийн гол үндэс тулгамдсан асуудал нь юу болох талаар :


1. Мэдлэг боловсролын түвшин
2. Мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс
3. Сурган хүмүүжүүлэх авьяас чадвар, арга барилын талаарх цогц ойлголт
4. Байгууллагын уур амьсгал
5. Хөгжих арга замыг тодорхойлох судалгаа авлаа

Багш ажлын байрандаа хөгжих хандлагын талаар судалгааг нээлттэй асуулгын, түүврийн аргаар авлаа. /Google Forms/. Судалгаанд ҮБХИС–ийн нийт 50 гаруй багш хамрагдлаа.


1. Боловсролын байгууллагад хэдэн жил ажиллаж байна вэ?




2. Та өөрийн мэргэжлээ ямар арга хэлбэрээр дээшлүүлдэг вэ?




3. Та ажлын байрандаа өөрийгөө хэрхэн хөгжүүлж чадаж байна вэ?




4. Таны хувьд багш өөрийгөө хөгжүүлэхэд учирч байгаа саад бэрхшээлүүд юу байна вэ?



5. Таны бодлоор багшийг хөгжүүлэх чиглэлээр юу юу хийж болох вэ?



6. Багш өөрийгөө хөгжүүлэхэд мэдээллийн ямар эх үүсвэрийг түлхүү ашиглаж байна вэ?



Эндээс харахад, сургууль өөрийн нөөц боломждоо тулгуурлан техник технологийн хүртээмжийг дээшлүүлэх, мэдээлэл технологийн хэрэглээг сайжруулах, сэтгэл зүйн орчныг бүрдүүлж чадвал багш хурдан хөгжих боломжтой.

**Хэрхэн хөгжүүлэх вэ?**

Багш хүн нийгмийн хөгжлийн чиг хандлагыг урьдчилан харж сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаа хэтийн төлөвтэй хоорондын уялдаа холбоотойгоор явуулж үр дүнд хүрч байх ёстой бөгөөд багшийн хөгжлийн үйл явц, үр дүн нь

<sup>3</sup> Боловсрол судлал. №2. Улаанбаатар., 2007.т15.



багш бүрийн хамтын бүтээлч үйл ажиллагаанаас шууд хамааралтай. Тийм учраас багш бүр дараах чадвар суралцан тасралтгүй хөгжиж байх чухал.

- Судалгаа хийх чадварыг сайжруулах / багш бүр судалгаа хийх арга зүйг эзэмших, тогтмолжуулж чанаржуулах/

- Мэдлэг чадварыг дээшлүүлэх / мэргэжлийн болон сурган, сэтгэл зүйн хандлагыг өөрчлөх/

- Харилцааны чадварыг сайжруулах / бүтээлчээр хамтран ажиллах, бие биеэсээ суралцах уур амьсгал бүрдүүлэх/

- Манлайлах чадварыг хөгжүүлэх /бусдадаа үлгэрлэх, зорилгодоо хүрэх чин эрмэлзэлтэй байх/

- Орчин бүрдүүлэх /хөгжлийн бодлого боловсруулж, ажиллах нөхцөл бололцоог хангаж өгөх/

Эдгээр чадварыг багш бүр эзэмшихийн тулд үйл ажиллагаа бүтээлч хамт олныг бүрдүүлэх, өөрөө түүний нэг хэсэг нь байж хувь нэмрээ оруулах нь чухал юм.

### **Хамтын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх арга зам**

Ер нь багш хөгжихгүйгээр боловсролд шинэчлэл явагдах боломжгүй. Багш хөгжсөнөөр сургууль хөгжиж улмаар боловсролын хөгжил, нийгмийн хөгжилд хувь нэмэр болно.

Багш сурган хүмүүжүүлэгчдийг боловсролын шинэчлэлийн өнөөгийн шаардлагад нийцсэн сайн багш болгох, хөгжлийг нь дэмжих гол хүчин зүйл бол тэдний тасралтгүй сурч **хөгжих хөгжингүй орчныг бүрдүүлэх** явдал юм.

Мөн дэлхийн улс орнуудын нийтлэг жишгийн дагуу багшийн хөгжлийн талаар үзэл баримтлалыг шинэчилж багш ажлын байрандаа хөгжих тогтолцоо бодлогыг боловсруулах, сургууль багш нар мэдээллийг тогтмол шуурхай авах мэдээлэл технологийн найдвартай сүлжээ бий болгох хэрэгтэй байна.

#### **Дэвшүүлсэн санаа:**

Багш хүн шавийнхаа хөгжил төлөвшил, дотоод ертөнцөд нөлөөлөх хүчин зүйл

Суралцагсдад нөлөөлөх талаар

–Сурагчдын авьяас сонирхлыг илрүүлэн хөгжүүлэх бүх талын нөхцөл бий болгох нь багшийн сурган хүмүүжүүлэх ёс зүйн нэн чухал үүрэг мөн.

–Багшийн хувийн чанар мэдлэг чадвар ажил хэрэгч байдал эв дүй хичээл ба хичээлээс гадуурх ажил ахуй амьдралд нь илрэх ёс зүй соёлын хэвшил нийгэмтэй харьцах харилцааны бүхий л шинжүүд багтана.

#### **Багшийн шаардлага**

Сурагчдад ухаалаг бөгөөд итгэл найдвар хүлээлгэсэн шаардлага тавина гэдэг бол тэднийг хүндэтгэж итгэж сайн талыг нь дэмжиж хүмүүжүүлнэ гэсэн үг юм. Багшийн шаардлага нь хүүхдийг хайрлан хүндэтгэсэн биелэх

бололцоотой шударга, зүй ёсны байвал тэд хүлээн авч биелүүлдэг. Харин биелэх нөхцөл муутай, бүдүүлэг шаардлага хүүхдийн дургүйг хүргэж оромдох тал байдгийг анхаарах нь зүйтэй.

#### **Багшийн хайр халамж, нөхөр ёсны харилцаа**

Хүүхдийн нялх балчир насанд үгүйлэн дутагдаж байгаа хүний сайхан сэтгэл хайр энэрлийг сэтгэл зүрхэнд нь шингээж өгөх гэдэг нь сурган хүмүүжүүлэх маш нарийн урлаг юм. Өөрийн заах хичээлийг төгс мэддэг хэр нь сурагчидтайгаа харилцахдаа алдаа гаргадаг багш нар тохиолдолж л байдаг. Багш сурагчид харилцан ойлголцож бие биеэ хүндэтгэдэг болсон цагт сургалт-хүмүүжлийн ажлыг үр дүнтэй явуулж болно. Ийм харилцааг буй болгоход багшийг хувь чанар алхам дутамдаа нэр хүндээ хамгаалж явах шаардлага тавигдаж байна.

#### **Багшийн үлгэр дууриалал**

Багш, сурагчид ба тэр ангийн хамт олонд итгэл хүлээлгэхээс гадна зохиох ажлынхаа талаар зөвлөдөг, санал бодлоо солилцдог байх нь үр дүнд хүрдэг. Суралцагсдын санаачилгыг дэмжин санал хүсэлтийг нь хүлээн авч биелүүлдэг байх, гэхдээ ганц нэг хүүхдийг хэт анхаарах биш жигд байх нь зүйтэй юм. Багшийн үйл ажиллагаа, ёс суртахууны хэм хэмжээ сурагчдын өмнө ил тод байдаг. Иймээ багш, ахмад хүний хувьд сурагчдад ёс зүй гоо зүйн зөв баримтлалыг олгоход нь туслан сайн муу зүйлийн тухай тогтвортой ойлголттой, тэр илтгэл үзлээ хамгаалах чадвар төлөвшүүлэх нь хамгийн чухал байна.

#### **Сурган хүмүүжүүлэх ажилдаа бүтээлчээр хандъя гэвэл,**

Багш нар бүтээлч сэтгэлгээтэй хүн бол аргыг яаж сурья даа хэнд ямар арга байна гэж сураглацгаадаг. Жинхэнэ бүтээлч сэтгэлгээтэй хүн бол аргыг хүнээр заалгаж сурдаггүй. Үнэндээ ч аргыг хүнээр заалгаж сурч байгаа хүн маань өөрөө бүтээлч сэтгэлгээний хүн биш байж таарна. Хүнд бэлэн юм зааж өгөх нь бас бүтээлч ажиллагаатай биш юм. Ингэхлээр бүтээлчээр ажиллах аргыг өөрсдөө л бүтээх болж байна. Үүний тулд яах вэ унш бод оролд. Өнөөдрийг хүртэл манай багш нар ихэвчлэн бэлэн юм заадаг арга барилаасаа салж чадахгүй байгаа юм.

#### **Санал**

- Бүтээлч багш нарын хамтын үйл ажиллагааг хөгжүүлэх, дэмжих

- Сургуулийн удирдлага бүтээлч хамт олныг төлөвшүүлэх тал дээр санаачилгатай ажиллах

- Багш нарын мэдээлэл технологийн хэрэглээ, боломжийг сурталчлах, хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах хэрэгтэй.

#### **Дүгнэлт**

Багш ажлын байрандаа хөгжихөд олон хүчин зүйлс чухал болох нь ажиглагдаж байна.



Үүнд:

- Сургууль өөрийн нөөц бололцоог ашиглан ажлын байранд дахь сургалтыг төлөвлөх, чанартай гарын авлага, ном, сурах бичгээр хангах

- Багшийг ажлын байранд хөгжүүлэх арга зүй болон мэдээлэл технологийн боломж, давуу талыг нээлттэйгээр хангаж өгөх

- Багшийн хөгжил, сургуулийн шинэчлэл хамт олны хөгжилд оруулсан хувь нэмрийг

үнэлэх арга механизмыг боловсронгуй болгох

- Багшийг үндсэн ажлын хүрээнд тасралтгүй хөгжих ажлыг зохион байгуулах

- Хөгжлийн чиг хандлагад суурилсан сургалт хүмүүжлийн боловсронгуй хэлбэрийг багш сонгох авах

- Багш нар харилцан мэдээлэл солилцох, сургалт, семинар, секц зохион байгуулах нь ажлын байран дээр бие даан тасралтгүй хөгжих боломжийг бий болгоно гэж үзэж байна.

#### Ашигласан материал:

1. Боловсрол судлал. УБ., 2003 °03
2. Боловсрол судлал. УБ., 2007 °02
3. Боловсрол судлалын ерөнхий үндэс. УБ., 1999
4. Ичинхорлоо Ш., Багшийн ном, УБ., 2011
5. Оюун Ц., Багшийн хөгжил, УБ.
6. Сурган хүмүүжүүлэх зүйн үндэс. УБ., 2000

Цахим эх сурвалж:

[www.marketresearch.mn](http://www.marketresearch.mn)

[www.education.com](http://www.education.com)

[teacher.itpd.mn](http://teacher.itpd.mn)

## НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН АМЖИЛТАД НӨЛӨӨЛӨХ ИНСТИТУТИЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ СУДАЛСАН НЬ (2022 оны элсэлтийн ерөнхий шалгалтын жишээн дээр)

**Ц.ӨЛЗИЙСАЙХАН** /УБХИС-ийн АБДС Нийгмийн ухааны тэнхимийн багш, Доктор (Ph.D)/

**Түлхүүр үг:** Институт, гэр бүл, сургууль, багш, шалгалт.

**Key words:** Institute, family, school, teacher, examination

### Хураангуй

Энэхүү илтгэлдээ нийгэм судлал (2022 оны ЭЕШ-ын жишээн дээр) судлагдахууныг сонгон “Нийгэм судлал хичээлийн амжилтад нөлөөлөх институтын хүчин зүйлсийг судлан тодорхойлж, статистик тайлангийн мэдээллийг эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулах”-ыг судалгааныхаа зорилго болгон зарим асуудлуудыг тодруулан дүгнэхийг хичээв.

### Товчилсон үгийн жагсаалт

БҮТ – Боловсролын үнэлгээний төв

ЭЕШ – Элсэлтийн ерөнхий шалгалт

АО – Анхны оноо

АОД – Анхны онооны дундаж

ХО – Хэмжээст оноо

ХОД – Хэмжээст онооны дундаж

Оюутан, сурагч (сонсогч, сурагч) гэдэг бол Монгол улсын ирээдүйн хөгжлийн маш чухал тулгуур бөгөөд бүх шатны сургууль нь тэднийг чадварлаг иргэн болгон бэлтгэх үүргийг нэн тэргүүнд хүлээдэг.

Суралцагчийн гол үүрэг бол суралцах ба энэ нь тэдний зорилго, хариуцлага хэмээн ойлгож болно. Боловсролын чанарын асуудал маш анхаарал татаж, чанартай боловсрол нь улс орны ирээдүйн хөгжлийн баталгаа болохыг хаа хаанаа чухалчлан ойлгох болсон энэхүү цаг үед суралцагчдын идэвх сонирхол, сурлагын амжилтанд нөлөөлж байгаа институтын хүчин зүйлсэд хичээл тус бүрээр цогц судалгаа хийх, үр дүнг нэгтгэн дүгнэх, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах зайлшгүй шаардлага байна.

Монгол улсын хөгжлийн идээдүй нь боловсролын чанар, түвшинтэй салшгүй холбоотой. “Чанартай боловсрол нь ирээдүйд хандсан үр ашигтай хөрөнгө оруулалт, хүний хөгжлийн эх сурвалж, амьдрах арга ухаан гэж бүх нийтээр хүлээн зөвшөөрч байгаа нь боловсролын орчин үеийн үнэлэмжийг тодорхойлж...”<sup>1</sup> байгаа өнөөгийн нөхцөлд бүх

шатны боловсролын хөтөлбөрүүдийн тогтмол шинэчлэл, түүний стандарт, суралцагчийн эзэмшсэн мэдлэгийг бүх түвшинд бодитой үнэлж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсүүдийг зөв тодорхойлон, олон шалгуураар хэмжээсжүүлэх чиглэлээр тодорхой өөрчлөлтүүдийг Монгол улс хийсээр иржээ. Тухайлбал “ЭЕШ-ыг зохион байгуулахдаа жил бүр ашиглах программ хангамж болон хэрэгжүүлэх технологид хөгжүүлэлт хийж ирсэн. 2006 онд ЭЕШ-ыг зохион байгуулахад бүртгэл, бэлтгэл ажлын, засалтын 3 програмтай байсан бол өнөөдөр 20 гаруй цогц програм хангамжийг БҮТ-ийн бүхий л шалгалт судалгаанд ашиглаж байгаа”<sup>2</sup> нь статистик тайлангийн системийн үр дүнгүүдийг судлаачид судлан эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах өргөн боломжийг нээж байна. Харамсалтай нь энэ ажил бүрэн хэрэгжихгүй байгааг энд тэмдэглэв.

Судлагдахуун, даалгавар бүрийн гүйцэтгэл, хариулт, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн нь сургалтын үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын тоног төхөөрөмж, ахуй орчин, хэрэглэгдэхүүн, арга зүйн нөхцөл байдалдаа нарийвчлан дүн шинжилгээ хийх, хичээл сургалтын өдөр тутмын үйл ажиллагааны үр дүн, алдаа оноог нягтлан эргэн харж, цаашдын амжилтаа ахиулах, оновчтой шийдвэр гаргахад нь туслах томоохон эх сурвалж мөн.

2022 оны ЭЕШ-д нийт 37223 шалгуулагч хамрагдсанаас 19475 шалгуулагч нийгэм судлал хичээлээр шалгалт өгсөн. Энэ нь нийт шалгуулагчдын 52.3 хувийг эзэлж байна. Нийгэм судлал хичээлээр шалгагдсан шалгуулагчдын тоо болон АОД үзүүлэлтийг сүүлийн 5 жилээр дараах хүснэгтэд харуулав.

мөн.

<sup>2</sup> Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын үнэлгээний төв. Элсэлтийн ерөнхий шалгалтын тайлан-2022. УБ., 2022. Тал 2.

<sup>1</sup> Чанартай боловсрол хөгжлийн баталгаа. УБ., 2001. Тал 546. М.Золзаяа. Хамт олон-шинэчлэлийг хөдөлгөгч хүч



№	Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
1	Нийт шалгуулагчийн тоо	40643	19023	29501	36782	37223
2	Нийгэм судлал хичээлээр шалгалт өгсөн шалгуулагчдын тоо	27566	10689	18654	22527	19475
3	Эзлэх хувь /нийт шалгуулагч дунд/	67.82	56.18	63.2	61.2	52.3
4	АОД	53.1	48.2	55.7	59.1	50
5	ХОД	500.08	500.04	500	500.1	500

2022 оны нийгэм судлал хичээлийн шалгалтын АО-ны улсын дундаж 50, ХО-ны дундаж 500 байна. АОД өмнөх жилээс 9.1 хувиар буурсан ба сүүлийн жилүүдэд хэлбэлзсэн үзүүлэлттэй байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Мөн нийгэм судлал хичээлээр шалгалт өгсөн шалгуулагчдын тоо өмнөх жилийнхээс 13.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүйсийн хувьд шалгуулагчдын 40.3% нь эрэгтэй, 59.6% нь эмэгтэй ба эмэгтэй шалгуулагчдын амжилт эрэгтэй шалгуулагчдын амжилтаас илүү байгааг дараах хүснэгтэд харуулав.

№	Хүйс	Ш/тоо	АОД	ХОД
1	Эрэгтэй	7852	46	474
2	Эмэгтэй	11623	53	517

Шалгуулагчдын хэв шинжийн хувьд 84.7% нь тухайн (2022) онд бүрэн дунд боловсрол эзэмшсэн бол 15.2% нь 2022 оноос өмнө бүрэн дунд боловсрол эзэмшсэн ба үр дүнгээс харахад, тухайн (2022) оны шалгуулагчдын анхны онооны болон хэмжээс онооны дундаж өмнөх онуудад төгссөн шалгуулагчдын дунджаас илүү байгаа нь харагдаж байна. Шалгуулагчдын нийгэм судлал хичээлийн амжилтыг тэдний суралцаж буй хэв шинжээс хамаарч буй эсэхийг шинжилсэн үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв.

№	Хэв шинж	Ш/тоо	АОД	ХОД
1	Тухайн (2022) оны төгсөгч	16509	52	511
2	Өмнөх оны төгсөгч	2966	40	435

Статистик шинжилгээний үр дүнгээс харахад шалгуулагчдын хэв шинжээс хамаарсан үзүүлэлт статистикийн хувьд ач холбогдолтой байна.

Иймд нийгэм судлал хичээлийн амжилтад нөлөөлөх институтийн хүчин зүйлсийг судалсан дараагийн статистик шинжилгээнүүдэд зөвхөн тухайн (2022) онд төгссөн шалгуулагчдын үр дүнг авч үзэн, ХОД гүйцэтгэлийг орхин, АОД гүйцэтгэлийг нөлөөлөх хүчин зүйлсүүдтэй харьцуулан шинжилгээ хийлээ. Өөрөөр

хэлбэл үүнээс хойш 2022 оноос өмнөх оны шалгуулагчийн мэдээлэл, үр дүнг хасаж тооцсон болно.

Эдгээрээс ЭЕШ өгөхөөр бүртгүүлсэн 16509 шалгуулагчаас авсан 56 бүлэг статистик шинжилгээ, үүнээс сэдэвт үл хамаарах 31 бүлэг статистик шинжилгээг орхин, нийгэм судлал хичээлийн амжилтад нөлөөлөх институтийн хүчин зүйлсэд хамаарах 25 бүлэг статистик шинжилгээг 14 бүлэгт багцлан эмхэлж, АОД гүйцэтгэлтэй харьцуулан судлав.

SPSS програм ашиглан Монгол улсын хэмжээнд цуглуулсан дата мэдээлэлд боловсруулалт хийж, нийгэм судлал хичээлийн шалгалтын үр дүн АОД гүйцэтгэл болон түүнд нөлөөлөх институтийн хүчин зүйлсийн асуулга судалгааны үр дүн хоорондын хамаарал, нөлөөллийг тодорхойлсон статистик шинжилгээнд тулгуурлан зарим хэсгийг сонгон тайлбарлав. Энд тухайн оноос (2022) өмнөх оны шалгуулагчид (2966) асуулга судалгаанд хамрагдаагүй болно.<sup>3</sup>

1 дүгээр Зураг. Дата мэдээлэлээс

Нийгэм судлал хичээлийн амжилтад тухайн шалгуулагчдын сургуулийн үнэлэмж (урлаг спорт), интернэт ашигладаг төхөөрөмж зэрэг хүчин зүйлс нөлөөлдөггүй гэсэн үр дүн гарсан.

Харин ХАВСРАЛТ: Хүснэгт 1–14 дэхь институтийн хүчин зүйлсүүд нь тодорхой байдлаар нийгэм судлал хичээлийн амжилтад нөлөөлдөг ( $p < 0.05$ ) болох нь статистик шинжилгээний үр дүнгээс харагдаж байна. Шинжилгээний үр дүнгээс үзвэл:

1.Тухайн хичээлийн амжилтад гэр бүлийн нөлөөлөл онцгой их байна. Тухайлбал ам бүлийн тоо нь 2–6 хүртэл гэр бүлийн шалгуулагчдын АОД 52 байхад, ам бүлийн тоо нь 7–11 ба

<sup>3</sup> ХАВСРАЛТ: Хүснэгт 1. Нийт шалгуулагчдын тоо ба эзлэх хувь.т.1.



түүнээс дээш шалгуулагчдын АОД 47–50 байна. Мөн эцэг эхийн хамт элэг бүтэн амьдардаг шалгуулагчдын АОД 52, эмээ өвөөгийн хайр халамжинд амьдардаг шалгуулагчдын АОД 51 бол бүтэн өнчин АОД 48, үрчилж авсан аав ээжтэйгээ амьдардаг АОД 47, асрамжийн газарт амьдардаг АОД 46 болж тус тус буурсан. <sup>4</sup>ливаа түвшний гэр бүл нь нийгэм судлал хичээлийн амжилтад үндсэн шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэж байгаа нь судалгааны дүнгээр харагдаж байна. Нийгмийн өөрчлөлтийг дагалдаг өсвөр үеийнхний дунд бие даан суралцах хандлага нэмэгдэж байгаа хэдий ч сургалтын үйл ажиллагаанд гэр бүл онцгой үүрэгтэй. Ялангуяа эх, эцгийн хайр халамж, хол ойр байхаас хүүхэд сурлагын хувьд хоцрох эсэх нь ихээхэн хамаарч, тэдний боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлт нь шууд хүчтэй нөлөөлөгч институтийн хүчин зүйл болж байгаа нь статистик шинжилгээний үр дүнд тодорсон<sup>5</sup>. Түүнчлэн гэр бүлийн нийгэм дэх байр суурь, амьдран суугаа гэр орны нөхцөл, эмээ өвөө гэх мэт бусад ахуй орчин, зан үйл, үнэлэмж, итгэл үнэмшил, харилцаа, нөлөөллийн тогтолцоо нь нийгэм судлал хичээлийн амжилтад нөлөө үзүүлж байна. Эмээ, өвөөтэйгээ хамт амьдардаг 504 (3.1%) шалгуулагчдын АОД 51 буюу тухайн оны улсын дунджаас 1 шатлал дээгүүр байгаа нь тэдний хайр халамж ач нарт чухал нөлөөтэй хэвээр байгааг тодотгоно. Хауст АОД 56, орон сууцанд АОД 54, дотуур байранд АОД 53, түрээсийн байр, сууцанд АОД 52, хашаа байшинд АОД 51, монгол гэрт АОД 50, асрамжийн газрын байранд АОД 42 тус тус болж шатлан буурч байгаа явдал нь хичээлийн амжилтад гэр бүлийн орлого, нийгэм дэх байр суурь, амьдардаг орчин чухал байгааг илтгэнэ<sup>6</sup>. Энд нэг анхаарал татах зүйл нь асрамжийн газрын байранд амьдарч буй шалгуулагчдын АОД огцом буурч 42 болж тухайн оны улсын дунджаас 8 шатлал доогуур байгааг зохих эрх бүхий болон хариуцсан байгууллагууд анхаарвал зохистой.

2. Хүүхдийн нийгэмшилтэд албан ёсоор үүрэг хүлээгч байгууллага болох сургууль, түүний үнэлэмж, сахилга бат, дэг журам,

<sup>4</sup> ХАВСРАЛТ: Хүснэгт 2. Ам бүл, асран хамгаалагчдын мэдээлэл ба гүйцэтгэл. Тал 1.

<sup>5</sup> ХАВСРАЛТ: Хүснэгт 3. Эцэг ба эхийн боловсролын түвшин гүйцэтгэл. Тал 1., Хүснэгт 4. Эцэг эхийн хөдөлмөр эрхлэлт ба гүйцэтгэл. Тал 2.

<sup>6</sup> ХАВСРАЛТ: Хүснэгт 5. Амьдардаг орчин, сургалтын орчин ба гүйцэтгэл. Тал 2.

байгууллагын соёл, сургалтын орчин, чанар, үр дүн, багш, ажилчдын харилцаа хандлага нь нийгэм судлал хичээлийн амжилтад онцгой нөлөө үзүүлж байна. Асуулгад өөрийн сургуулийн сургалтын орчинг маш сайн гэж үнэлсэн шалгуулагчдын АОД 54 байхад, маш муу гэж үнэлсэн шалгуулагчдын АОД 52 болж буурчээ<sup>7</sup>. Эндээс харвал сургуулийн сургалтын орчин нь боловсролын чанарын түвшинг илэрхийлэх, сурлагын амжилтад нөлөөлөх гол хүчин зүйлүүдийн нэг гэдэг тодорхой харагдаж байна. Хүний тав тухтай амжилттай суралцах, хөдөлмөрлөх шалтгааныг түүнийг хүрээлэн буй орчин бий болгодог ба энд ямар таатай орчин шаардлагатай байна вэ? гэдгийг сургууль бүр өөр дээрээ тодорхойлох асуулт гарч ирнэ. Статистик шинжилгээний чухал хэсэг үр дүн (ХАВСРАЛТ: Хүснэгт 5) зөвхөн үүнийг тодорхойлон харуулж буйг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Иймээс суралцагчдын ур чадвар буюу сургалтын чанар нь суралцах орчноос хамаарна хэмээн үзэж сургалтын орчныг сайжруулах үндэслэлийг ул суурьтай тодорхойлох шаардлагатай хийгээд энэ нь суралцагчийн суралцах хандлагатай харилцан хамааралтай асуудал юм. Өөрөөр хэлбэл сургалтын орчны шинжилгээ, үнэлгээг хийж, цаашид сайжруулах арга замыг тодорхойлох шаардлага урган гарч байна. Өөрийн сургуулийн сахилга бат, дэг журам ба багш ажилчидаа маш сайн гэж үнэлсэн шалгуулагчдын АОД 52 байхад, сайн эсвэл дундаж хэмээн үнэлсэн шалгуулагчдын АОД 51 болж нэгж шатлал буурч байна<sup>8</sup>. Сургууль нь тодорхой зорилго, түүнд хүрэх арга ба хэрэгсэл, агуулга бүхий албан ёсны судлагдахуунуудын хөтөлбөрөөр суралцагчдын сурлагад хувь нэмэр оруулахаар зорьж ажиллан нийгэм судлал хичээлийн амжилтад шууд чухал нөлөө үзүүлж байна.

3. Тухайн сургуульд ажиллаж буй бүх мэргэжлийн багш нар нийгэм судлал хичээлийн амжилтад чухал нөлөө үзүүлж байна. Зөвхөн нийгэм судлалын бус нийт багш нарын зохион байгуулдаг үйл ажиллагаа, мэдлэг, заах арга барил, ур чадвар, туршлага, тогтвор суурьшил, суралцагчидтай харилцах эв зүй, ёс зүй, харилцаа хандлага нийгэм судлал хичээлийн амжилтад нөлөөлж байна.

<sup>7</sup> ХАВСРАЛТ: Хүснэгт 5. Амьдардаг орчин, сургалтын орчин ба гүйцэтгэл. Тал 2.

<sup>8</sup> ХАВСРАЛТ: Хүснэгт 6. Суралцаж буй сургуулийн үнэлэмж, багшийн зохион байгуулдаг үйл ажиллагаа ба гүйцэтгэл. Тал 2.



“Багш, суралцагчийн оновчтой сайн харилцаа сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах сургуулийн амьдралын чухал хүчин зүйл юм”<sup>9</sup>. Багш бидний сурлагын амжилтыг ахиулах чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулдаг гэж үзсэн 9705 (58.8%) шалгуулагчдын АОД 53<sup>10</sup>, нийгэм судлал, монголын түүхийн багшийн мэдлэг ур чадвар маш сайн гэж шалгуулагчдын АОД 55, математик, монгол хэл, англи хэл, орос хэл, физик, газар зүй, хими, биологийн багш нарын мэдлэг ур чадвар маш сайн гэж үзсэн шалгуулагчдын АОД 54 байгаа нь үүний нотолгоо. Монголын түүх хичээлийн багшийн мэдлэг ур чадвар маш хангалтгүй гэж үзсэн шалгуулагчдын АОД 49 байна<sup>11</sup>.

4.Бусад хүчин зүйлүүд (интернэт, чөлөөт цаг, үе тэнгийн харилцаа, сонирхол хандлага, давтлага, мэргэжил сонголт)<sup>12</sup> нийгэм судлал хичээлийн амжилтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлж байна. Статистик шинжилгээний үр дүнгээс хархад эерэг интернэт ашиглалт өдөрт 1–4 цаг байдаг шалгуулагчдын АОД 53, 1–2 цаг чөлөөт цагтай байдаг шалгуулагчдын АОД 54, үе тэнгийн харилцаа сайтай шалгуулагчдын АОД 53, Мэргэжил сонголт оо өөрийн сонирхол, мэдлэг, чадвартаа тулгуурлан хийсэн шалгуулагчдын АОД 53 тус тус байхад сөрөг интернэт ашиглалт өдөрт 11 ба түүнээс дээш цаг байдаг шалгуулагчдын АОД 44, 7 ба түүнээс дээш цаг телевиз үздэг шалгуулагчдын АОД 42, мэргэжлийн чиглэл хүчний байгууллага (цэрэг, цагдаа), соёл урлаг судлал сонгосон шалгуулагчдын АОД 46–47 байгаа нь анхаарал татаж байна.

Дүгнэн үзвэл нийгэм судлал хичээлийн амжилтад суралцагчдын сурах үйл явц, хэрэгцээ, сонирхол, нөөц боломж, идэвх зүтгэл ихээхэн чухал боловч тэднээс өөрсдөөс нь үл хамаарах ам бүл, асран хамгаалагч, эцэг эхийн боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлт, амьдардаг болон сургуулийн орчин, үнэлэмж, багш нарын үйл ажиллагаа, цахим орчин, чөлөөт цаг, үе тэнгийн харилцаа хандлага, шалгалтад хэрхэн бэлтгэсэн байдал,

мэргэжил сонголт ба түүнд үзүүлсэн нөлөө зэрэг институтийн хүчин зүйлс шууд ба шууд бусаар нөлөөлж байна. Хамгийн чухал нөлөө нь **гэр бүл – сургууль – багш** гэсэн гурван талт оролцоо байгаа бөгөөд эерэг сөрөг үр дүн нь тус судлагдахууны чанарт ихээхэн нөлөөтэй. Суралцагчид амжилттай, эсвэл амжилтгүй суралцахын ар талд судалгаанд дээр өгүүлсэн институтийн олон хүчин зүйлс эерэг, сөрөг нөлөө үзүүлж байдаг ба үүний далд шалтгааныг бодит мэдээлэлд үндэслэн тодруулан судалж, **сургалтын үйл явцыг нэгэн бүхэллэг цогц зүйл** гэж харж чадвал оюутан, сурагчийн (сонсогч, сурагчийн) сурлагын амжилт, бүх судлагдахуун, бүх шатны боловсролын сургалтын чанар, үр өгөөжийг мэдэгдэхүйц тодорхой хэмжээгээр ахиулах боломжтой гэж үзэж байна.

Иймээс сургалтын үйл ажиллагаанд боловсролын нэгж байгууллагын соёл, эмх цэгц, сургалтын нэгдсэн бодлого, материаллаг орчин нөхцөл, хичээлийн оновчтой зохион байгуулалт, цаг ашиглалт, дуу чимээ, сарниулагч хүчин зүйлс, удирдлага, багш, суралцагчийн харилцаа, ёс зүй, үнэлгээ, заах арга зүй, сургууль, анги хамт олны эв нэгдэл, нэгдэл нягтрал, багийн ажиллагаа, уур амьсгал, сургалтын оновчтой төлбөр болон хөнгөлөлт, урамшуулал зэрэг олон хүчин зүйлийг багцаар нь нэгдмэл гэж үзэн зөв тооцох шаардлагатай байна.

Санал: Багшийн ажлын амжилтат нөлөөлөх институтийн хүчин зүйлсийг судлах

#### ХАВСРАЛТ:

Асуулгын чиглэл	Шалгуулагчдын тоо	Эзлэх хувь
Асуулга авсан	16509	84.8%
Асуулга аваагүй	2966	15.2%
Нийт	19475	100%

2 дугаар хүснэгт. Ам бүл, асран хамгаалагчийн мэдээлэл ба гүйцэтгэл

Ам бүлийн тоо	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	
1	2 хүртлэх	768	4.7%	52
2	3–4	6977	42.3%	52
3	5–6	7500	45.4%	52
4	7–8	1151	7.0%	50
5	9–10	95	0.6%	50
6	11 ба түүнээс дээш	18	0.1%	47

Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	
1	Эцэг, эхийн хамт	13254	80.3%	52
2	Хагас өнчин /ээжтэйгээ/	1892	11.5%	51
3	Хагас өнчин /аавтайгаа/	320	1.9%	50
4	Бүтэн өнчин	146	0.9%	48
5	Төрсөн ээж болон хойд аав	328	2.0%	52
6	Төрсөн аав болон хойд ээж	42	0.3%	47

<sup>9</sup> Пүрэвдорж П. Багшлахуйн менежмент (Ардчилал, зах зээлийн орчин дахь багшлахуйн онол, практик). УБ., 2010. Тал 209.

<sup>10</sup> ХАВСРАЛТ: Хүснэгт 6. Суралцаж буй сургуулийн үнэлэмж, багшийн зохион байгуулдаг үйл ажиллагаа ба гүйцэтгэл. Тал 2.

<sup>11</sup> ХАВСРАЛТ: Хүснэгт 7. Багшийн мэдлэг, ур чадварын үнэлэлт ба гүйцэтгэл. Тал 3.

<sup>12</sup> ХАВСРАЛТ: Хүснэгт 8–14.



7	Урчилж авсан аав, ээж	9	0.1%	47
8	Эмээ, өвөө	504	3.1%	51
9	Асрамжийн газар	14	0.1%	46

3 дугаар хүснэгт. Эцэг ба эхийн боловсролын түвшин гүйцэтгэл

Асуулгын чиглэл	Эцгийн боловсрол			Эхийн боловсрол			
	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	
1	Боловсролгүй	2323	14.1%	51	783	4.7%	50
2	Бага боловсрол эзэмшсэн	1250	7.6%	50	838	5.1%	50
3	Суурь боловсролтой	1742	10.6%	52	1449	8.8%	51
4	Бүрэн дунд боловсролтой	7003	42.4%	51	7089	42.9%	51
5	ТМС төгссөн	469	2.8%	54	461	2.8%	52
6	Техникум төгссөн	359	2.2%	52	351	2.1%	50
7	Дипломын боловсролтой	566	3.4%	52	865	5.2%	52
8	Бакалаврын боловсролтой	2255	13.7%	56	3683	22.3%	56
9	Магистр болон түүнээс дээш түвшний боловсролтой	542	3.3%	58	990	6.0%	58

4 дүгээр хүснэгт. Эцэг ба эхийн хөдөлмөр эрхлэлт ба гүйцэтгэл

Асуулгын чиглэл	Эцгийн хөдөлмөр эрхлэлт			Эхийн хөдөлмөр эрхлэлт			
	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	
1	Төрийн байгууллагад	4876	29.5%	53	4902	29.7%	53
2	Хувийн хэвшилд	3713	22.5%	53	3626	22.0%	53
3	Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	3546	21.5%	52	3138	19.0%	51
4	Малчин	3094	18.7%	51	2880	17.4%	51
5	Суралцаж байгаа	31	0.2%	45	39	0.2%	46
6	Тэтгэвэрт	522	3.2%	54	606	3.7%	52
7	Ажилгүй	549	3.3%	51	1135	6.9%	51
8	Гадаадад ажиллаж амьдардаг	178	1.1%	51	183	1.1%	51

5 дугаар Хүснэгт. Амьдардаг орчин, сургалтын орчин ба гүйцэтгэл

Асуулгын чиглэл	Амьдардаг орчин			Сургалтын орчин				
	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж		
1	Монгол гэрт	3498	21.2%	50	Маш сайн	3784	22.9%	54
2	Хашаа байшинд	5660	34.3%	51	Сайн	8931	54.1%	52
3	Орон сууцанд	6720	40.7%	54	Дундаж	3438	20.8%	51
4	Дотуур байранд	237	1.4%	53	Муу	298	1.8%	53
5	Түрээсийн байр, сууцанд	260	1.6%	52	Маш муу	58	0.4%	52
6	Хауст	120	0.7%	56				
7	Асрамжийн газрын байранд	14	0.1%	42				

6 дугаар хүснэгт. Суралцаж буй сургуулийн үнэлэмж, багшийн зохион байгуулдаг үйл ажиллагаа ба гүйцэтгэл

Асуулгын чиглэл	Сургуулийн үнэлэмж			Багшийн зохион байгуулдаг үйл ажиллагаа			
	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж
Сахилга бат, дэг журам				Бидний урлагийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх чиглэлээр	1583	9.6%	49

Маш сайн	12102	73.3%	52	Бидний спортын авьяас чадварыг нээн хөгжүүлэх чиглэлээр	2039	12.4%	49
Сайн	4277	25.9%	51	Бидний сурлагын амжилтыг ахиулах чиглэлээр	9705	58.8%	53
Дундаж	130	0.8%	51	Бидний нийгмийн идэвх, оролцоог дэмжих чиглэлээр	2784	16.9%	52
Сайн багш, ажилчид				Бидний эцэг эх, гэр бүлтэй хамтран ажиллах талаар	398	2.4%	51

Маш сайн	12389	75.0%	52
Сайн	3882	23.5%	51
Дундаж	131	0.8%	51
Сургалтын чанар, үр дүн			
Маш сайн	11662	70.6%	53
Сайн	4551	27.6%	51
Дундаж	174	1.1%	51

7 дугаар хүснэгт. Багшийн мэдлэг, ур чадварыг үнэлэлт ба гүйцэтгэл

Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж
Математик				Монгол хэл			
Маш сайн	6806	41.2%	54	Маш сайн	7272	44.0%	54
Сайн	7669	46.5%	51	Сайн	7747	46.9%	51
Дундаж	1727	10.5%	51	Дундаж	1345	8.1%	50
Хангалтгүй	251	1.5%	51	Хангалтгүй	106	0.6%	50
Маш хангалтгүй	56	0.3%	55	Маш хангалтгүй	36	0.2%	51
Нийгэм судлал				Монголын түүх			
Маш сайн	7707	46.7%	55	Маш сайн	5356	32.4%	55
Сайн	7150	43.3%	50	Сайн	8009	48.5%	51
Дундаж	1429	8.7%	49	Дундаж	2023	12.3%	50
Хангалтгүй	173	1.0%	51	Хангалтгүй	278	1.7%	51
Маш хангалтгүй	46	0.3%	52	Маш хангалтгүй	120	0.7%	49
Англи хэл				Орос хэл			
Маш сайн	5957	36.1%	54	Маш сайн	4375	26.5%	54
Сайн	7803	47.3%	51	Сайн	7981	48.3%	52
Дундаж	2230	13.5%	51	Дундаж	2925	17.7%	51
Хангалтгүй	382	2.3%	53	Хангалтгүй	607	3.7%	50
Маш хангалтгүй	108	0.7%	53	Маш хангалтгүй	359	2.2%	51
Физик				Газар зүй			
Маш сайн	4908	29.7%	54	Маш сайн	4636	28.1%	54
Сайн	8102	49.1%	52	Сайн	8324	50.4%	52
Дундаж	2554	15.5%	50	Дундаж	2622	15.9%	51
Хангалтгүй	454	2.8%	52	Хангалтгүй	423	2.6%	50
Маш хангалтгүй	122	0.7%	51	Маш хангалтгүй	168	1.0%	51
Хими				Биологи			
Маш сайн	4701	28.5%	54	Маш сайн	4840	29.3%	54
Сайн	8110	49.1%	51	Сайн	8347	50.6%	51
Дундаж	2626	15.9%	51	Дундаж	2417	14.6%	51
Хангалтгүй	484	2.9%	51	Хангалтгүй	397	2.4%	51
Маш хангалтгүй	167	1.0%	51	Маш хангалтгүй	120	0.7%	51

8 дугаар хүснэгт. Интернэт ашиглалт, чөлөөт цагийн хугацаа ба гүйцэтгэл

Асуулгын чиглэл /өдөрт/	Интернэт ашиглалт			Чөлөөт цагийн хугацаа				
	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	
1	Цаг орчим	3206	19.4%	53	1-2 цаг	6418	38.9%	54
2	2-4 цаг	9619	58.3%	53	3-4 цаг	6944	42.1%	52
3	5-8 цаг	3212	19.5%	51	5-6 цаг	1994	12.1%	50
4	9-10 цаг	352	2.1%	47	7 хоногт 1-2 цаг	105	0.6%	50
5	11 ба түүнээс дээш	120	0.7%	44	7 хоногт 3-4 цаг	195	1.2%	52
6	-	-	-	-	7 хоногт 5-6 цаг	166	1.0%	53



9 дүгээр хүснэгт. Чөлөөт цагаараа хийдэг ажлын хугацаа ба гүйцэтгэл

Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж
Анхны онооны дундаж				Гэр орныхоо ажилд туслахад			
1 цагаас бага	9413	57.0%	52	1 цагаас бага	4250	25.7%	53
1-2 цаг	5125	31.0%	53	1-2 цаг	7689	46.6%	53
3-4 цаг	1468	8.9%	53	3-4 цаг	3403	20.6%	51
5-6 цаг	366	2.2%	53	5-6 цаг	730	4.4%	48
7 ба түүнээс дээш	137	0.8%	52	7 ба түүнээс дээш	378	2.3%	48
Дүү нараа асрахад				Найз нартайгаа уулзахад			
1 цагаас бага	8241	49.9%	53	1 цагаас бага	5340	32.3%	53
1-2 цаг	4928	29.9%	52	1-2 цаг	6884	41.7%	52
3-4 цаг	2035	12.3%	50	3-4 цаг	2978	18.0%	51
5-6 цаг	653	4.0%	49	5-6 цаг	720	4.4%	49
7 ба түүнээс дээш	502	3.0%	47	7 ба түүнээс дээш	321	1.9%	48
Телевиз үзэхэд				Грэйн даалгавар болон бие даалт хийхэд зориулан интэрнэтээс мэдээлэл хайхад			
1 цагаас бага	11059	67.0%	53	1 цагаас бага	2219	13.4%	50
1-2 цаг	3886	23.5%	51	1-2 цаг	5880	35.6%	51
3-4 цаг	946	5.7%	51	3-4 цаг	5110	31.0%	53
5-6 цаг	181	1.1%	49	5-6 цаг	1931	11.7%	54
7 ба түүнээс дээш	79	0.5%	42	7 ба түүнээс дээш	747	4.5%	54

10 дугаар хүснэгт. Үе тэнгийн харилцаа ба гүйцэтгэл

Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж
Манай ангийн хүүхдүүд надтай маш сайн харилцаатай байдаг.				Манай ангийн болон үе тэнгийн хүүхдүүд бие биедээ хүндэтгэлтэй харьцдаг.			
Тийм, маш их	7366	44.6%	53	Тийм, маш их	5384	32.6%	53
Тийм	7566	45.8%	52	Тийм	8054	48.8%	52
Заримдаа	1389	8.4%	50	Заримдаа	2702	16.4%	52
Үгүй	134	0.8%	51	Үгүй	273	1.7%	50
Огт үгүй	54	0.3%	52	Огт үгүй	90	0.5%	52
Миний хувьд аливаа бүх зүйлд өөртөө итгэлтэйгээр оролцдог, хийж чаддаг.							
Тийм, маш их	5805	35.2%	53				
Тийм	7309	44.3%	51				
Заримдаа	3003	18.2%	52				
Үгүй	276	1.7%	51				
Огт үгүй	75	0.5%	53				

11 дүгээр хүснэгт. Сонирхол хандлага ба гүйцэтгэл

Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж
Би математикийн хичээлдээ дуртай, үргэлж идэвхтэй оролцдог				Бусад хичээлтэй харьцуулахад та математикийн хичээлдээ хэр зэрэг дуртай вэ?			
Тийм, маш их	3679	22.3%	55	Тийм, маш их	3499	21.2%	55
Тийм	6980	42.3%	52	Тийм	7074	42.8%	52
Дунд зэрэг	4630	28.0%	50	Дунд зэрэг	4552	27.6%	50
Үгүй	958	5.8%	50	Үгүй	1077	6.5%	51
Огт үгүй	262	1.6%	52	Огт үгүй	305	1.8%	53
Би байгалийн ухааны хичээлдээ дуртай, үргэлж идэвхтэй оролцдог				Бусад хичээлтэй харьцуулахад та Байгалийн ухааны хичээлдээ хэр зэрэг дуртай вэ?			
Тийм, маш их	2627	15.9%	54	Тийм, маш их	2589	15.7%	54

Тийм	6729	40.8%	51	Тийм	6548	39.7%	51
Дунд зэрэг	5165	31.3%	52	Дунд зэрэг	5315	32.2%	52
Үгүй	1594	9.7%	54	Үгүй	1630	9.9%	54
Огт үгүй	391	2.4%	56	Огт үгүй	423	2.6%	55
Байгалийн ухааны хичээл таны амьдралд цаашид хэрэг болно гэж боддог үү?				Би гадаад хэлний хичээлдээ дуртай, үргэлж идэвхтэй оролцдог			
Тийм, маш их	3021	18.3%	54	Тийм, маш их	4423	26.8%	56
Тийм	7610	46.1%	52	Тийм	7849	47.5%	52
Дунд зэрэг	4557	27.6%	52	Дунд зэрэг	3724	22.6%	49
Үгүй	1013	6.1%	52	Үгүй	416	2.5%	50
Огт үгүй	292	1.8%	54	Огт үгүй	80	0.5%	50
Гадаад хэлний мэдлэгтэй байх нь миний амьдралд ихээхэн ач холбогдолтой гэж боддог				Би нийгмийн ухааны хичээлдээ дуртай, үргэлж идэвхтэй оролцдог			
Тийм, маш их	6882	41.7%	56	Тийм, маш их	6280	38.0%	56
Тийм	7241	43.9%	50	Тийм	7874	47.7%	51
Дунд зэрэг	2134	12.9%	47	Дунд зэрэг	2095	12.7%	46
Үгүй	140	0.8%	47	Үгүй	121	0.7%	46
Огт үгүй	28	0.2%	52	Огт үгүй	41	0.2%	49

Нийгмийн ухааны хичээлээр олж авч буй чадварууд цаашид маш их хэрэг болно

Тийм, маш их	7129	43.2%	56
Тийм	7352	44.5%	50
Дунд зэрэг	1732	10.5%	47
Үгүй	69	0.4%	46
Огт үгүй	32	0.2%	50

12 дугаар хүснэгт. ЭЭШ-даа хэрхэн бэлдсэн байдал, давтлаганд зарцуулдаг хугацаа ба гүйцэтгэл

Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж
ЭЭШ-даа хэрхэн бэлдсэн байдал ба гүйцэтгэл				ЭЭШ-н давтлаганд зарцуулдаг хугацаа ба гүйцэтгэл			
Сонгон судалсан хичээлээр	12193	73.9%	52	1 цаг хүртэл	943	5.7%	51
Төлбөртэй давтлагаар авдаг	2585	15.7%	55	1-2 цаг	3836	23.2%	50
Бие дааж бэлтгэж байна.	1424	8.6%	50	3 - 5 цаг	7523	45.6%	52
Төлбөртэй апплейкэшн ашиглан бэлтгэж байна.	129	0.8%	55	5 - 7 цаг	2736	16.6%	54
Тусгайлан бэлтгэл эхлээгүй байна.	178	1.1%	49	8 ба түүнээс дээш	1471	8.9%	55

13 дугаар хүснэгт. Мэргэжил сонголт хэнтэй зөвлөлддөг, мэргэжил сонголт үзүүлсэн нөлөө ба гүйцэтгэл

Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж	Асуулгын чиглэл	Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж
Мэргэжил сонголт хэнтэй зөвлөлддөг ба гүйцэтгэл				Мэргэжил сонголт үзүүлсэн нөлөө ба гүйцэтгэл			
Автайгаа	717	4.3%	52	МУ-д эрэлтэй мэргэжлүүдийг судалсны үндсэн дээр	2513	15.2%	51
Ээжтэйгээ	2676	16.2%	51	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг үндэс болгосон	958	5.8%	52



Эмээ, өвөөтэйгээ	186	1.1%	51	Тухайн мэргэжлийн үнэ цэнэ болон цалин хөлсний баталгаа	1341	8.1%	52
Гэр бүлийн бүх гишүүдтэйгээ	10413	63.1%	52	Гэр бүлийн уламжлалыг дагаж мэргэжил сонголт хийсэн	599	3.6%	49
Сургуулийн багш нартайгаа	276	1.7%	52	Өөрийн сонирхол, мэдлэг, чадвартаа тулгуурлан сонголт хийсэн	11098	67.2%	53
Найз нөхөдтэйгээ	318	1.9%	50				
Хан нэгэнтэй зөвлөлдөөгүй	1433	8.7%	53				
Суралцах мэргэжлээ хараахан сонгож амжаагүй	490	3.0%	56				

## 14 дүгээр хүснэгт. Мэргэжлийн чиглэл ба гүйцэтгэл

Асуулгын чиглэл		Ш/тоо	Эзлэх хувь	Анхны онооны дундаж
1	Инженер, технологи	1427	8.6%	47
2	Геологи, уул уурхай, ашигт малтмал	104	0.6%	45

3	Багш	870	5.3%	49
4	Эмч, анагаах ухаан	631	3.8%	46
5	Олон улсын харилцаа	1106	6.7%	57
6	Гадаад хэлний орчуулагч	218	1.3%	52
7	Хөдөө аж ахуй	59	0.4%	43
8	Банк, санхүү, нягтлан бодох	728	4.4%	56
9	Эдийн засаг	1001	6.1%	56
10	Менеджмент, маркетинг, бизнесийн удирдлага	1323	8.0%	57
11	Нийгэм, хүмүүнлэг, философи, шашин судлал	563	3.4%	55
12	Хууль, эрх зүй	3090	18.7%	55
13	Хүчний байгууллага /цэрэг, цагдаа/	1878	11.4%	46
14	Сэтгэл судлаач	1264	7.7%	56
15	Биотехнологи	69	0.4%	50
16	Компьютер, техник хангамж	228	1.4%	49
17	Мэдээллийн технологи, програм хангамж	291	1.8%	51
18	График дизайн	333	2.0%	49
19	Сэтгүүл зүй	294	1.8%	52
20	Түүх, археологи	48	0.3%	56
21	Аялал жуулчлал	159	1.0%	52
22	Экологи, хүрээлэн буй орчин	19	0.1%	55
23	Социологи	23	0.1%	58
24	Соёл, урлаг судлал	764	4.6%	47
25	Статистик	19	0.1%	60

## Ашигласан материал:

1. Боловсролын хүрээлэн. Бүрэн дунд боловсролын заавал судлах сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж. Нийгэм судлал X-XI анги. УБ., 2019.
2. Боловсролын хүрээлэн. Бүрэн дунд боловсролын сонгон судлах сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж. Нийгэм судлал X-XII анги. УБ., 2019.
3. Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын үнэлгээний төв. Элсэлтийн ерөнхий шалгалтын тайлан-2022. УБ., 2022.
4. Нийгэм судлал X. УБ., 2019.
5. Нийгэм судлал XI. УБ., 2019.
6. Пүрэвдорж П. Багшлахуйн менежмент (Ардчилал, зах зээлийн орчин дахь багшлахуйн онол, практик). УБ., 2010.
7. Суурь, бүрэн дунд боловсролын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур. Нийгэм судлал. УБ., 2021.
8. Суурь, бүрэн дунд боловсролын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж. Нийгэм судлал. УБ., 2021.
9. Чанартай боловсрол хөгжлийн баталгаа. УБ., 2001.  
“Нийгэм судлал хичээлийн амжилтад нөлөөлөх институтийн хүчин зүйлсийг судалсан нь” (2022 оны элсэлтийн ерөнхий шалгалтын жишээн дээр)

## ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТАД ТАВИХ ХЯНАЛТЫН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

**Г.БАТНАСАН** /Шихихутуг их сургуулийн нийтийн эрх зүйн тэнхимийн багш, докторант/

**Түлхүүр үг:** Захиргааны хэм хэмжээний акт, хяналт, улсын нэгдсэн бүртгэл, хууль дээдлэх зарчим, захиргааны хэргийн шүүх, .

**Key words:** Administrative regulatory acts, control, unified state registry, rule of law, administrative court

### Оршил

Нийгмийн суурь харилцааг Үндсэн хууль болон бусад хуулиар зохицуулах ёстой. Гэхдээ нийгмийн хувьсал өөрчлөлт, хууль тогтоогчийн хуулийн төслийг хэлэлцэх, батлах хугацаа их /хууль тогтоомжийн тухай хуулийн хугацаа/ байгаа гэсэн шалтгаанаар хууль тогтоох эрх мэдлийн байгууллага захиргааны хэм хэмжээний акт батлах эрхийг хуульд зааснаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага руу шилжүүлсэн байдаг. Захиргааны Ерөнхий хуулийн 65.1–т зааснаар “Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиргааны хэм хэмжээний актыг бүртгэхдээ энэ хуулийн 60, 61, 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэнэ” хэмээн заасан байдаг. Захиргааны байгууллага хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу захиргааны хэм хэмжээний акт гаргасан боловч захиргааны актад тавигдах шаардлагыг хангаагүйн улмаас хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгээгүй, захиргааны хэм хэмжээний акт гаргах хуульд заасан бүрэн эрхгүй захиргааны байгууллага захиргааны хэм хэмжээний акт гаргасан тэдгээр захиргааны хэм хэмжээний акт нь хэрэгжиж цөөнгүй тохиолдол байна. Энэ хууль ёсны шаардлага хангаагүй захиргааны хэм хэмжээний акт нийгэмд хэрэгжиж иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж байгаа хэрэг юм.

2015 онд батлагдсан Захиргааны ерөнхий хуулиар анх удаа захиргааны хэм хэмжээний актад юуг хамруулах, ямар шалгуур нөхцөл тавигдах, хэрхэн боловсруулагдаж, хянагдаж, бүртгэгдсэний дараа хүчин төгөлдөр үүсэх зэргийн хуулиар зохицуулж өгсөн юм.<sup>1</sup>

Монгол Улсад нийт 437 хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд тэдгээрээс

<sup>1</sup> <https://legaldata.mn/b/127> Ц.Цогт, Захиргааны хэм хэмжээний акт, өгүүлэл, УБ хот, 2016 он

Улсын Их Хурал нийт 318 хуулийн 2493 заалтаар захиргааны хэм хэмжээний акт батлах эрхээ холбогдох байгууллагад шилжүүлсэн байна. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 111 байгууллагын 2357 шийдвэр бүртгэлтэй, харин хуулиар тусгайлан эрх олгосон боловч шийдвэр нь батлагдсан эсэх нь тодорхойгүй 850 хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа нь хуулийн нэг мөр хэрэгжүүлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох хууль дээдлэх, тэгш байдлын зарчмын хэрэгжилт хангалтгүй байна. Хуулиар Засгийн газарт эрх олгосон 642, төрийн захиргааны төв байгууллагад эрх олгосон 919, төрийн захиргааны байгууллагад эрх олгосон 258 заалт байна.<sup>2</sup> Ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн захиргааны хэм хэмжээний актыг цэгцлэх практик шаардлага үүссэн байна.

### 1. Захиргааны хэм хэмжээний актын тухай

Төрийн эрх мэдэл хуваах онолын дагуу зөвхөн хууль тогтоочоос хууль /эрх зүйн хэм хэмжээ/–ийг батлан гаргах учиртай. Үндсэн хуулийн 20–д “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хадгална.” гэж зааснаас харвал гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллага хууль буюу эрх зүйн хэм хэмжээг батлах эрх олгогдоогүй байна. Гэвч хууль батлах үйл ажиллагааны удаан байдал, асуудлыг яаралтай шийдвэрлэх хугацаа, эсвэл зөвхөн техникийн нөхцөл зэрэг тодорхой шалтгааны улмаас хууль тогтоогчийн ачааллаас хөнгөлөх шаардлага гардаг.

<sup>2</sup> <https://mongolia.gov.mn/news/view/26864> Хуулиар тусгайлан эрх олгосон заалт, Захиргааны хэм хэмжээний актын тоог цөөрүүлэхийг Ерөнхий сайд үүрэг болголоо гарчиг бүхий Монгол Улсын Засгийн газрын мэдээ.УБ хот, 2023.11.29

Иймээс хууль /эрх зүйн хэм хэмжээ/ тогтоох эрх мэдлийн зарим хэсгийг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад шилжүүлсний үндсэн дээр парламентыг төлөөлөн эрх зүйн хэм хэмжээ батлах боломжтой болдог. Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно. Захиргааны хэм хэмжээний акт нь захиргааны үйл ажиллагааны нэгэн хэлбэр бөгөөд түүний зохицуулалтын хүрээ нь захиргааны хувьд шаталсан шинжтэй, захиргааны чиг үүргийг шууд биелүүлэхэд чиглэсэн байдгаараа бусад эрх зүйн эх сурвалжаас онцлогтой.<sup>3</sup>

**Нэгдүгээрт,** хэм хэмжээний актаар зохицуулах боломжгүй харилцааны талаарх ойлголтыг Үндсэн хууль болон зарим хуулиудад тусгагдсан “гагцхүү хуулиар...” гэсэн зохицуулалтын хүрээнд ихэнхдээ ойлгогддог. Жишээлбэл, Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.3–д “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.” 15 дугаар зүйлийн 15.1–д “Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно.” 19 дүгээр зүйлийн 19.2 2–д “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно.” 47 дугаар зүйлийн 47.1 “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” зэргээр зөвхөн хуулиар зохицуулах харилцааг тодорхойлжээ.

**Хоёрдугаарт,** хэм хэмжээний актын зохицуулалтын хүрээ буюу эрх шилжүүлж буй хуулиар олгогдсон хүрээ, хязгаарын хувьд Захиргааны ерөнхий хуулиар захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргах субьектэд заавал хуулиар тусгайлан эрх олгосон байхын дээр тусгайлан эрх олгож буй хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байхыг шаардаж байгаа нь дэвшилтэй зохицуулалт. Гэвч тусгайлан эрх шилжүүлж буй зохицуулалтад хэм хэмжээний үйлчлэх хүрээ, цаг хугацаа, зорилго зэргийг тусгах шаардлагыг оруулаагүй байна.<sup>4</sup> хэмээн судлаач Д.Баттулга “Хэм хэмжээний актаар зохицуулах харилцааны хүрээ, хязгаар болон хяналтын зарим асуудлыг боловсронгуй болгох нь” өгүүлэлдээ бичсэн байна.

## **2. Хууль бус захиргааны хэм хэмжээний акт түүний эрх зүйн үр дагавар, захиргааны хэргийн шүүхийн хяналт**

<sup>3</sup> П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги., УБ хот, т.287, ISBN99929-0-543-3

<sup>4</sup> <https://legaldata.mn/buteel/pdf?id=338> Д.Баттулга, Хэм хэмжээний актаар зохицуулах харилцааны хүрээ, хязгаар болон хяналтын зарим асуудлыг боловсронгуй болгох нь өгүүлэл, УБ хот, 2018 он, 4 дэх тал

Захиргааны хэм хэмжээний акт түүний эрх зүйн үр дагаврыг дараах байдлаар авч үзэх шаардлагатай. Үүнд:

1. Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага захиргааны хэм хэмжээний актыг батлан гараагүй байх;

2. Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргасан ч эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй байх;

3. Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй байгууллага захиргааны хэм хэмжээний актыг баталж хэрэгжүүлсэн байх зэрэг юм.

## **–Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага захиргааны хэм хэмжээний актыг батлан гараагүй байх:**

Улсын Их Хурал хууль батлахдаа тодорхой нарийвчилсан харилцааг зохицуулах зорилгоор гүйцэтгэх эрх мэдэлд /засгийн газар/ захиргааны хэм хэмжээний акт батлан гаргаж хэрэгжүүлэх эрхийг олгосон олон хууль тогтоомж бий. Үүний нэг нь Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль /2021 онд батлагдсан/ юм. Уг хуулийн 3.3–т “Энэ хуульд заасан харилцааг нарийвчлан зохицуулах Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална”; 4.1–т “Газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолой, тэдгээрийн үндсэн технологийн ба дагалдах, туслах байгууламжийн зураг төслийг гэрээ үйлдсэн хэлээр боловсруулж болох бөгөөд магадлал хийх, барилгын ажил гүйцэтгэх, үе шатны ажилд хяналт тавих, чанар аюулгүй байдлын шинжилгээ хийх, ашиглалтад оруулж, гэрчилгээжүүлэх харилцааг энэ хуулийн 3.3–т заасан журмаар зохицуулна” хэмээн заасан байна. Өөрөөрхэлбэр Засгийн газарнь газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг баталснаар газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолой, тэдгээрийн үндсэн технологийн ба дагалдах, туслах байгууламжийн зураг төслийг гэрээ үйлдсэн хэлээр боловсруулж болох бөгөөд магадлал хийх, барилгын ажил гүйцэтгэх, үе шатны ажилд хяналт тавих, чанар аюулгүй байдлын шинжилгээ хийх, ашиглалтад оруулж, гэрчилгээжүүлэх харилцааг зохицуулах юм. Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлээс шүүж үзэхэд Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам өнөөгийн байдлаар батлагдаагүй байна.<sup>5</sup> Үүний эрх зүйн үр дагавар нь газрын тосны үйлдвэр барих үйл явц өөрөө журмын дагуу явагдахгүй эрсдэл үүсч байна. Үүнээс үзэхэд хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага нь тухайн эрхийнхээ хүрээнд захиргааны хэм хэмжээний

<sup>5</sup> Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл, цахим орчинд тус тус олдоогүй болно.



актыг батлан гаргаагүй тохиолдол авах арга хэмжээг сайжруулах шаардлагатай юм.

–Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргасан ч эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй байх:

Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй төрөлжсөн хууль тогтоомж бүрт хуулиар тусгайлан эрх олгосон байгууллагад захиргааны хэм хэмжээний акт батлан гаргах эрхийг олгосон байна. Гэхдээ хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага тухайн захиргааны хэм хэмжээний актыг бүртгүүлээгүй хэрэгжүүлсэн тохиолдол цөөнгүй байна. Үүнд: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69.2–т<sup>6</sup> Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 04 дүгээр сарын 23–ны өдрийн 148 дугаар тогтоолыг<sup>7</sup> үндэслэж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 2019 оны 06 дугаар сарын 18–ний өдрийн 271 дүгээр тогтоолоор “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”<sup>8</sup> –ыг баталсан байдаг. Уг журмыг Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлээс шүүхэд бүртгүүлээгүй байна. Хуулиар тусгайлан эрх олгогдсон төрийн захиргааны байгууллага нь өөрийн салбарын нарийвчилсан харилцааг байнгын зохицуулах зорилгоор захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргаж болох ч хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэхгүй байж болохгүй, хуулиар хориотой юм. Дээр дурдсан захиргааны хэм хэмжээний актаар төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх ихээхэн мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудлыг зохицуулж байгаа юм. Уг журмыг баталсан тогтоолын 3 дахь хэсэгт “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”–ыг мөрдөж ажиллахыг төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагуудад даалгасугай гэжээ. Энэ төрийн өмчийн бүх хуулийн этгээд хүчин төгөлдөр бус захиргааны хэм хэмжээний актыг дагаж мөрдөж байгаа юм. Үүнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байгаа юм.

–Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй байгууллага захиргааны хэм хэмжээний актыг баталж хэрэгжүүлсэн:

<sup>6</sup> 2. Заавал хөтлөх нягтлан бодох бүртгэлийн нийтлэг маягтаас гадна төрийн өмчийн хуулийн этгээдэд хөтлөгдвөл зохих мэдээ, тайлангийн маягт, аргачлалыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батлан мөрдүүлж болно.

<sup>7</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawid=4212> Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 148 дугаар тогтоол

<sup>8</sup> <http://www.spa.gov.mn/file/3857> Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам

Хуулиар эрх олгогдоогүй байхад хэм хэмжээний актыг тогтоон мөрдүүлэх, хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүй байх, хуулиар хэм хэмжээний акт тогтоох эрхгүй этгээд дүрэм, журам батлан мөрдүүлэх зөрчил арилахгүй, давтагдан гарсаар байгааг таслан зогсоож, урьдчилан сэргийлэх, захиргааны хэм хэмжээний актад мониторинг, үнэлгээ хийж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг нэн тэргүүнд авах шаардлагатай юм.

Дээр дурдсан ёсоор хууль бус захиргааны хэм хэмжээний актын цөөнгүй тохиолдол байна. Үүнд:

–Эрүүл мэндийн салбарын хүрээнд: Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3–т “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төлбөрийн жишиг хэмжээг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэжээ. Уг заалтыг зөрчиж захиргааны хэм хэмжээний акт батлан гаргах эрхгүй байгууллага дараах захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргаж, хэрэгжүүлсэн байна.

#### 1 дүгээр хүснэгт<sup>9</sup>

№	Байгууллагын нэр	Төлбөрийн тусламж, үйлчилгээний журам	Огноо, дугаар
1.	Амгалан амаржих газар	Төлбөрт үйлчилгээний төлбөрийг төвлөрүүлэх журам	2022.05.02–ны өдрийн А/21 тушаалын 2 дугаар хавсралт
2.	Гэмтэл, согог судлалын үндэсний төв	Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний журам	2022.11.29–ны өдрийн А/163 тушаалын 1 дүгээр хавсралт
3.	Геронтологийн үндэсний төв	Төлбөртэй үзүүлэх тусламж, үйлчилгээний журам	2022.06.02–ны өдрийн А/35 тушаалын 1 дүгээр хавсралт
4.	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам	2023.01.20–ны өдрийн А/14 тушаалын 2 дугаар хавсралт
5.	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Тусламж үйлчилгээний санхүүжилтийн журам	2022.05.27–ны өдрийн А/170 тушаалын хавсралт
6.	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Эмнэлгийн төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний журам	2022.05.18–ны өдрийн А/141 тушаалын 3 дугаар хавсралт
7.	Халдварт өвчин судлалын үндэсний төв	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн төлбөртэй тусламж, үйлчилгээний журам	2022.08.09–ны өдрийн А/184 тушаалын 1 дүгээр хавсралт
8.	Хүүхдийн төв сувилал	Хүүхдийн төв сувилалаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний журам	2022.09.02–ны өдрийн А/56 тушаалын 1 дүгээр хавсралт

<sup>9</sup> Авлигатай тэмцэх газрын 2023 оны 11 дүгээр сарын 27–ны өдрийн 02/18217 дугаар албан бичгийн хавсралт



9.	Эмгэг судлалын үндэсний төв	Эмгэг судлалын тусламж үйлчилгээг төлбөртэй үзүүлэх журам	2023.01.31-ны өдрийн А/12 тушаалын 2 дугаар хавсралт
----	-----------------------------	---	--

Дээрх дурдсан захиргааны хэм хэмжээний актуудын зөрчлийн АТГ-аас мэдэгдэж хүчингүй болгох арга хэмжээг авсан байна.<sup>10</sup>

### –Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хүрээнд:

Хуулиар эрх олгогдоогүй байхад хэм хэмжээний актыг тогтоон мөрдүүлэх, хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүй байх, хуулиар хэм хэмжээний акт тогтоох эрхгүй этгээд дүрэм, журам батлан мөрдүүлэх зөрчил арилахгүй, давтагдан гарсаар байгааг таслан зогсоож, урьдчилан сэргийлэх, захиргааны хэм хэмжээний актад мониторинг, үнэлгээ хийж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах.

Авлигатай тэмцэх газраас Монгол Улсын Засгийн газар, Засгийн газрын гишүүд, салбарын сайд, аймгуудын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт 2017–2019 онуудад хүргүүлсэн зөвлөмж–д дурдсан асуудлууд бүрэн шийдвэрлэгдээгүй, зөрчил, дутагдал дахин илэрсээр байна. **Үүнд:**

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2–т<sup>11</sup> “Хуульд заасан хязгаар, шаардлагад нийцүүлэн орон нутгийн зарим татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох” эрхийг зөвхөн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгосон байхад дээрх заалтыг зөрчин иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид өөрт олгогдоогүй эрхийг хэрэгжүүлж, шийдвэр гаргасан;

2. Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална” гэж заасныг мөрдөөгүй, мөн хуулийн 65 дугаар зүйлийн 65.1–д заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх заалтыг хэрэгжүүлдэггүй;

3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2–т заасан “Энэ хуулийн ... 27.1.1, 27.1.4–27.1.6 дахь заалт, 27.2–27.4 дэх хэсэг,...–т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.” гэж

заасан байтал уг хэмжээг Засгийн газар бус Эрүүл мэндийн сайд (“Тэмдэгтийн хураамжийн төлбөрийн хэмжээ, зардлын жишиг”) баталсныг эргэж нягтлах, хуульд нийцүүлэхтэй холбоотой зөвлөмжийг АТГ–аас Засгийн газар, Эрүүл мэндийн сайдад хүргүүлсэн боловч холбогдох арга хэмжээг авалгүй орон нутагт мөрдсөөр байгаа;

4. Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1–д “Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актад жил бүр хяналт–шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг цаашид авах арга хэмжээний талаарх саналын хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасныг үр дүнтэй хэрэгжүүлдэггүй зэрэг болно.<sup>12</sup>

5. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2–т заасны дагуу тус комисс нь хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж, санал гаргах бүрэн эрхийн хүрээнд 2018 онд нийтээр дагаж мөрдүүлэхээр НИТХ болон түүний тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан 86 захиргааны хэм хэмжээний актыг судалж дүн шинжилгээ хийжээ.<sup>13</sup> НИХТ нь 1993 оноос хойш<sup>14</sup> 100 гаруй захиргааны хэм хэмжээний акт батлан гаргасан байх бөгөөд Захиргааны Ерөнхий хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө хууль асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад эдгээр актыг хүргүүлж, хянуулж, бүртгүүлээгүй иржээ.<sup>15</sup> Өнөөдрийн байдлаар Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 20, түүний тэргүүлэгчдийн тогтоолоор 66, нийт 86 захиргааны хэм хэмжээний актыг нийтээр дагаж мөрдүүлэхээр баталсан ч зөвхөн нэг захиргааны хэм хэмжээний актыг нийтээр дагаж мөрдүүлэхээр баталсан ч зөвхөн нэг захиргааны хэм хэмжээний акт буюу Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 04 дүгээр сарын 27–ны өдрийн 9/10 дугаар тогтоолоор баталсан Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журмыг Хууль зүй, дотоод хэргийн яам 2017 оны 06 дугаар сарын 06–ны

<sup>10</sup> <https://iaac.mn/40/nitem> Авлигатай тэмцэх газрын албан ёсны цахим хаяг, Л.Нарантуяа: Улсын эмнэлгүүд төлбөрийн жишиг хэмжээг 10 000–25 000 төгрөгөөр нэмснийг хүчингүй болгууллаа, мэдээ, Эх сурвалж: “Өнөөдөр” сонин, 2024.02.21

<sup>11</sup> 2006 оны 12 дугаар сарын 15–ны өдөр батлагдаж, 2020 оны 12 дугаар сарын 24–ний өдөр хүчингүй болсон Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд

<sup>12</sup> Авлигатай тэмцэх газрын 2020 оны 01 дүгээр сарын 24–ний өдрийн 01/1003 дугаар албан бичгийн хавсралт

<sup>13</sup> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссоос Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон түүний тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан захиргааны хэм хэмжээний актад хийсэн дүн шинжилгээ, УБ хот, 2018 он дам ишлэв

<sup>14</sup> 2018 оны байдлаар

<sup>15</sup> Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны мэдээллээс дам ишлэв



өдөр улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, улсын бүртгэлийн 3739 дугаар олгосон байгаагаас үзэхэд Захиргааны Ерөнхий хуулийн хэрэгжилт хангагдахгүй байна гэж үзэхээр байна.<sup>16</sup>

Захиргааны Ерөнхий хуулийн 59.1–т “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.” гэсэн байдаг. Гэтэл дээрх эрүүл мэндийн есөн тохиолдлыг үзвэл хуулиар тусгайлан эрх олгоогүй байгууллагаас гаргасан захиргааны хэм хэмжээний акт юм. Уг захиргааны хэм хэмжээний акт нь эмнэлэгийн байгууллагаас иргэдэд төлбөртэй үйлчилгээ үзүүлэх, түүний төлбөрийг төвлөрүүлэх агуулга бүхий байна. Үүнээс үзэхэд иргэнээс төлбөр төвлөрүүлэх уг журам нь хуулиар тусгайлан эрх олгоогүй байгууллага гаргасан захиргааны хэм хэмжээний акт байх тул иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлын зөрчсөн гэх үндэслэл болно. Хуулиар тусгайлан эрх олгоогүй захиргааны байгууллага захиргааны хэм хэмжээний акт батлан гаргахгүй байх, түүнд хяналт тавих нь эрх зүйн механизмыг сайжуулах шаардлагатай юм. Захиргааны Ерөнхий хуулийн 65.1–д “Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиргааны хэм хэмжээний актыг бүртгэхдээ энэ хуулийн 60, 61, 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.”; 65.2–т “Энэ хуулийн 60, 61, 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэхгүй.” хэмээн заасан нь захиргааны хэм хэмжээний актыг бүртгэлжүүлэх, хяналт тавих зорилго бүхий заалт хэдий ч дээрх хуулиар тусгайлан эрх олгоогүй захиргааны байгууллага захиргааны хэм хэмжээний акт батлан гаргаж, хэрэгжүүлснээр иргэний эрх хууль ёсны ашиг сонирхлыг ноцтой зөрчиж байна.

Судлаач Б.Ариунзаяа “Нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даан гаргасан захиргааны хэм хэмжээний актыг хянах, бүртгэхэд тулгамдаж буй асуудал” сэдэвт өгүүлэлдээ дараах байдлаар дүгнэн бичсэн байдаг. Нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даан гаргасан захиргааны хэм хэмжээний актыг бүртгэх, хянах тусгай зохицуулалт байх шаардлагатай. Харин ямар зохицуулалт байх вэ гэдэг асуулт гарч ирнэ. ЗЕХ–ийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэгт заасны дагуу захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актыг эмхэтгэлд”–д нийтэлсний

<sup>16</sup> З.Өнөржаргал, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон түүний тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан захиргааны хэм хэмжээний актыг зохицуулалттай холбоотой зарим асуудал, УБ хот, Хүний эрх онол, арга зүйн сэтгүүл 2018/02 дугаар

дараа хүчин төгөлдөр болдог нь урьдчилсан хяналтын хэлбэр. Гэтэл нутгийн өөрөө удирдах байгууллагын нутгийн өөрөө удирдах ёсонд нийцүүлэн бие даан гаргасан хэм хэмжээний актыг төв засгийн газраас урьдчилан хянаж, хүчин төгөлдөр болох эсэхийг шийдвэрлэх нь нутгийн өөрөө удирдах ёсыг хязгаарласан шинжтэй байж болзошгүй. Төв болон дээд шатны байгууллагын зүгээс нутгийн өөрөө удирдах ёсыг үгүйсгэж буюу хязгаарлаж болохгүй. МУЗЗНДНТУТХ–ийн 25 дугаар зүйлийн 4–т “Хурлаас гаргасан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газар, тухайн асуудлыг харьяалах дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно” гэж заасан. Энэ нь хурлын шийдвэрийг тус хурал өөрөө эсхүл шүүхээс өөр байгууллага хүчингүй болгох эрхгүй гэдгийг илэрхийлж байна. МУЗЗНДНТУТХ, ЗЕХ хоорондоо зөрчилддөг<sup>17</sup> хэмээжээ. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Захиргааны Ерөнхий хууль батлагдахаас өмнө /2015 оноос өмнө/, МУЗЗНДНТУТХ шинээр батлагдсаны /2020 оноос хойш/ дараа ч захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргахдаа хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, хэрэгжүүлээгүй байна. Өөрөөр хэлбэр хууль бус захиргааны хэм хэмжээний актаар нийгмийн харилцааг зохицуулсан юм.

#### Дүгнэлт

Монгол Улсад нийт 437 хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд тэдгээрээс Улсын Их Хурал нийт 318 хуулийн 2493 заалтаар захиргааны хэм хэмжээний акт батлах эрхээ холбогдох байгууллагад шилжүүлсэн байна. Захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн санд 111 байгууллагын 2357 шийдвэр бүртгэлтэй, харин хуулиар тусгайлан эрх олгосон боловч шийдвэр нь батлагдсан эсэх нь тодорхойгүй 850 хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа нь хуулийг нэг мөр хэрэгжүүлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох хууль дээдлэх, тэгш байдлын зарчмын хэрэгжилт хангалтгүй байна. Хуулиар Засгийн газарт эрх олгосон 642, төрийн захиргааны төв байгууллагад эрх олгосон 919, төрийн захиргааны байгууллагад эрх олгосон 258 заалт байна.<sup>18</sup> Эрх зүйт

<sup>17</sup> <https://legaldata.mn/b/1598#> Судалгааны цахим хаяг, Б.Ариунзаяа, Нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даан гаргасан захиргааны хэм хэмжээний актыг хянах, бүртгэхэд тулгамдаж буй асуудал өгүүлэл, УБ хот, 2022 он, 5 дахь тал

<sup>18</sup> <https://mongolia.gov.mn/news/view/26864> Хуулиар тусгайлан эрх олгосон заалт, Захиргааны хэм хэмжээний актыг тоог цөөрүүлэхийг Ерөнхий сайд үүрэг болголоо гарчиг бүхий Монгол Улсын Засгийн газрын мэдээ. УБ хот, 2023.11.29



ёсны үүднээс үзэхэд олон тооны бүртгэлгүй захиргааны хэм хэмжээний акт байгаа нь хяналтгүй хүчирхэгжсэн төр бий болж байгаа юм. Учир нь төр гэх нэрээр хяналтгүй, хуулиас давсан хэм хэмжээний акт тогтоох нь дураар авирлаж байгаа хэрэг юм. Ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн

үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн захиргааны хэм хэмжээний актыг цэгцлэх практик шаардлага үүссэн байна. Ийм захиргааны хэм хэмжээний актад тавих хяналтын /дээд шатны захиргааны байгууллага, шүүхийн/ механизмыг сайжруулах шаардлагатай байна.

#### Ашигласан материал:

1. Б.Ариунзаяа, Нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даан гаргасан захиргааны хэм хэмжээний актыг хянах, бүртгэхэд тулгамдаж буй асуудал өгүүлэл
2. Д.Баттулга, Хэм хэмжээний актаар зохицуулах харилцааны хүрээ, хязгаар болон хяналтын зарим асуудлыг боловсронгуй болгох нь өгүүлэл
3. З.Өнөржаргал, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон түүний тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан захиргааны хэм хэмжээний актын зохицуулалттай холбоотой зарим асуудал, УБ хот, Хүний эрх онол, арга зүйн сэтгүүл 2018/02 дугаар
4. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссоос Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон түүний тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан захиргааны хэм хэмжээний актад хийсэн дүн шинжилгээ
5. П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги
6. Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам
7. Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 148 дугаар тогтоол
8. Ц.Цогт, Захиргааны хэм хэмжээний акт, өгүүлэл



## “ГАЛ” ХЭМЭЭХ ТОЛГОЙ ҮГИЙН ТАЙЛБАРЫГ ХАРЬЦУУЛАХ НЬ

**Ж.ХИШИГЖАРГАЛ** /ЦХПК-ийн Ерөнхий эрдмийн тэнхимийн багш, докторант/

**Түлхүүр үг:** хэл, сэтгэлгээний онцлог, нийгэм хэл шинжлэл, тайлбар толь, үгийн тайлбар .

**Key words:** Characteristics of Language and Cognition, Sociolinguistics, Defining dictionary, Word definition

### Хураангуй:

Энэхүү өгүүлэлд хүн төрөлхтний түүхэнд нэн чухал байр суурь эзэлдэг “гал” хэмээх ойлголтыг нийгэм хэл шинжлэлийн үүднээс судалж, монгол хэлний болон гадаадын томоохон тайлбар толиуд дахь тухайн үгийн тайлбарын ялгааг хам ба цуваа цагийн хүрээнд харьцуулан дүгнэсэн нь өмнөх үеийн болон орчин цагийн монголчууд, түүнчлэн гадаад хүмүүсийн хэл, сэтгэлгээний өөрчлөлтийн талаар олж мэдэх боломжийг олгох юм.

### Оршил

Хэл ба нийгэм харилцан хамааралтай. Энэхүү хамаарал нь нийгмээс хэлэнд, хэлнээс нийгэмд үзүүлэх нөлөө гэсэн хоёр талтай байдаг. Аливаа хэл тухайн хэлээр хэлэлцэгч ард түмний оршин тогтнох үндэс болдог бөгөөд үндэсний сэтгэлгээтэй салшгүй холбогддог.

Хэлний судалгааны нэгжийн онцгой эх сурвалж нь толь бичиг юм. Харин толийн олон төрлөөс тайлбар толь голлох үүрэгтэй. Тайлбар толь бичигт нэг хэлний үгийг тухайн хэлний үгээр тайлбарласан байдаг бөгөөд тус толийн толгой үгс (толь бичгийн мөрийн эхэнд байрлах утгын тайлбар бүхий үг, хэллэг) олон төрлийн боловсруулалт, шалгуурыг давсан байдаг тул хэлний хэм хэмжээний нэгж хэмээн үзэж, судалгаа хийх үндэс болдог.

Монголчууд тайлбар толь бичиг зохион хэрэглэж ирсэн эртний уламжлалтай бөгөөд одоо ч цаасан болон цахим толь бичиг зохиогдсоор байна. Гэвч тэдгээр тольд толгой үгийг хэрхэн тайлбарлах, ямар зарчим, арга зүй баримтлах, өмнөх үеийн толь бичгүүдийн толгой үгийн тайлбар орчин үеийнхээс ямар ялгаатайг тодорхойлох, толийн толгой үгсийг хэрхэн дараалуулах, толгой үгийг тайлбарлах үгийн хүрээг хэрхэн тогтоох зэргийг судалсан нь харьцангуй хомс байна.

Тиймээс ч энэ судалгаандаа өөр өөр цаг үед зохиогдсон монгол хэлний болон гадаад хэлний тайлбар толиудад үгийг хэрхэн тайлбарласныг

харьцуулах, олон утгат толгой үгийг утгын хувьд хэрхэн дараалуулсныг судлах, түүнчлэн толгой үгийн тайлбарт ард түмний хэл, сэтгэхүйн онцлог хэрхэн туссаныг тодорхойлох зорилго тавьж, “гал” хэмээх үгээр төлөөлүүлэн, хам ба цуваа цагийн хүрээнд зэрэгцүүлэх, харьцуулах аргаар судаллаа.

Судалгаанд монгол хэлний ууган тайлбар толь болох “Хорин нэгт тайлбар толь” (1717), түүнд суурилан зохиогдсон “Гучин зургаат тайлбар толь” (1927), С.Шагжийн “Эрэхүйеэ хялбар болгон зохиосон монгол үгний тайлбар толь” (1929), “Хорин наймт тайлбар толь” (1943), Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” (1966), Ш.Сэцэнцогтын “Монгол үгсийн язгуурын толь” (1988), “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь” (2008), “Монгол хэлний их тайлбар толь” (2016)<sup>1</sup> болон англи, герман, орос, япон, хятад, солонгос хэлний цахим толь бичгүүдийг ашиглав. Эдгээр толь бичгийг сонгохдоо олон нийт түгээмэл хэрэглэдэг, нэр хүндтэй байх гэсэн шалгуурыг баримталсан болно.

Эрт балар цаг үеэс өнөөг хүртэл хүн төрөлхтний чухал хэрэгцээ болсоор буй “гал” хэмээх үгийн гарлын талаарх эрдэмтдийн санал янз бүр. Тухайлбал, М.Базаррагчаа монгол хэлний “га-л” хэмээх үг нь “г, к”-ийн сэлгэцээр “ка-ла-ку” (халах) гэх үгээс үүсэлтэй<sup>1</sup> хэмээсэн бол Т.А.Бертагаев “Га-л (гал) ка-ла (хал, хал үзэх), ка-ла-гу-н (халуун) хоёрыг гарал нэгтэй хэмээн үзжээ. Харин түрэг, перс хэлнээ энэ үгийг “kala<sup>2</sup>”, манж хэлэнд “gali<sup>3</sup>”, уйгур хэлэнд “kali, alaz<sup>4</sup>” (шатах, дөл), эртний монгол хэлэнд “al<sup>5</sup>” гэх зэргээр тэмдэглэсэн нь бий.

<sup>1</sup> Базаррагчаа М., Монгол үгийн гарлыг мөшгөх нь. Улаанбаатар., 1992.т.443–444

<sup>2</sup> Дулам С., Монгол домог зүйн дүр. Улаанбаатар., 2009.т.44

<sup>3</sup> Мөн тэнд

<sup>4</sup> Сэцэнцогт Ш., Монгол үгсийн язгуурын толь. 1988.т.1227

<sup>5</sup> Мөн тэнд



Уг үгийн утгыг хэрхэн ойлгож буй талаар 15–58 насны, мэргэжил, боловсролын хувьд ч ялгаатай 120 гаруй хүнээс аман судалгаа авлаа. Хүмүүс тухайн ойлголтыг “Түймэр (12), голомт (11), цахилгаан (10), аюул (9), тогоо (8), илч, чүдэнз (6), дөл, зуух, ус, халуун (5), энерги, махбод, тог, гэрэл (3), улаан, оч, тог цахилгаан (2), шаталтын үр дүн, асаагуур, монголчуудын шүтээн, илч гэрэл, команд, хөгжлийн үндэс, хам, халуун илч, амьдрал, ариутгагч, галын самбар (1)” хэмээн холбон сэтгэж байв. Энэхүү аман судалгааны дүн буюу хүмүүсийн ойлголт тайлбар толь бичигт хэрхэн буусныг судалж үзлээ.

Аливаа тайлбар толийн хамгийн чухал цөм нь болох толгой үгийн тайлбар дэлгэрэнгүй, тодорхой байх шаардлагатай байдаг. Үүнийг ч Ц.Өлзийхутагийн “Толь бичгийн тайлбар нь шинжлэх ухааны үндэстэй туйлын зөв ойлголт өгч, хүний хэрэгцээ шаардлагыг хангахаар... байх

нь чухал” хэмээсэн нь баталдаг.

Тиймээс ч юун түрүүнд монгол хэлний тайлбар толиудад “гал” хэмээх үгийг хэрхэн тайлбарласныг эрт болон эдүгээ цагийн илэрхийлэл болсон “Хорин нэгт тайлбар толь” (1717), “Гучин зургаат тайлбар толь” (1927), С.Шагжийн “Эрхүүеэ хялбар болгон зохиосон монгол үгний тайлбар толь” (1929), “Хорин наймт тайлбар толь” (1943), Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” (1966), Ш.Сэцэнцогтын “Монгол үгсийн язгуурын толь” (1988), “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь” (2008), “Монгол хэлний их тайлбар толь” (2016) зэрэг монголчуудын түгээмэл хэрэглэдэг тайлбар толиудаар төлөөлүүлэн судаллаа.

Эдгээр тольд “гал” хэмээх толгой үгийн 2–8 утгыг тайлбарласан бөгөөд үүнд гол болон шилжсэн утгыг багтаажээ.

<sup>1</sup> Өлзийхутаг Ц., Монгол хэлний үгсийн сангийн судлал. Улаанбаатар., 1979.т.118

#### 1 дүгээр хүснэгт. Монгол хэлний тайлбар толиуд дахь “гал” хэмээх үгийн тайлбар.

Хорин нэгтийн тайлбар толь (1717)	Гучин зургаатын тайлбар толь (1927)	С.Шагж, Монгол үгний тайлбар толь (1929)	Хорин наймтын тайлбар толь (1943)
–Таван махбодын дотоод нэг зүйл. –Хэт цахин авч хэрэглэхийг нь гал хэмээмүй (444).	Таван махбодын хоёрдугаарт буй. –Гал хэмээгч дээш мандах нь. –Амт гашуун Өнгө улаан (97).	Мод(ны) зэргийг түлэн үнс болгох –Дөрвөн махбодын дотоод халууныг нь (472).	Таван махбодын их арга буюу Халуун ширүүн бөгөөд Хатаах түлэхийн чанартай Харанхуйг гийгүүлэх гэрэл гэгээтэй Хамгийг боловсруулж ургуулах чадалтай Уруу хандуулаас улам дээш бадрагч Улаан өнгөтэйг гал хэмээмүй. Эртний цагт Сүй Жен овогтноор модныг холхидон гал гаргаж, олон иргэнд түүхийг боловсруулж идэхийг сургавай (1082–1083).
Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь (1966)	Ш.Сэцэнцогт, Монгол үгсийн язгуурын толь (1988)	Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь (2008)	Монгол хэлний их тайлбар толь (2016)
1. Шатаж байгаа бодисоос гарсан халуун, дөл 2. Аялах зэрэгт нэг оронд хамт нийлж явах 3. Бялт 4. Энэтхэгийн эртний гүн ухааны ёсны дөрвөн махбодын дотоод халуун 5. Гал од (Ангараг гараг) 6. Сарны зурхайн ёсны таван махбодын хоёрдугаар 7. Бичиг сударт гурвын тоог “гал” гэсэн нь бий. (134)	1.Шаталтаас гарах халуун дөл 2.шил. Гал мэт харагдах зарим оч гэрэл 3.шил. Аян замд хамт явж цуг туулдаг бүлэг хүмүүс 4.шил. Буудалт, харвалт, дэлбэрэлт 5.шил. Бялт буюу бялгаар цоргиж дуугаргах зэвсгийн тэмдэг нэр 6.шил. Уур унтуу 7.шил. Зарим үгийн эхэнд орж хүч нэмэгдүүлэх утгыг илтгэнэ. 8.Таван махбодын нэг (2953–2854)	Гал I 1.Бодисын илч; Шатаж байгаа бодисоос гарсан халуун; дөл гарган шатах үйл явц 2. Хээр гадаа явахдаа нэг оромжинд хамт нийлэн яваа хүмүүс 3. Төрөл бүрийн зэвсгээр дайсныг устган дарах хэрэгсэл 4. Сарны зурхайн ёсны таван махбодын нэг 5. шилжсэн. Цог жавхаа Гал II хуучирсан Гурвын тоо. Гал III гал од одон орон (ангариг гараг). Гал IV Гал сүүлт амьтан (ой болон цэцэрлэгт хүрээлэнд амьдардаг, байшингийн дээвэр болон модонд үүрээ засдаг, жижигхэн биетэй нүүдлийн шувуу, Ази, Африк, Европт тархсан) (461–462)	Гал I 1.Бодисын илч; шатаж байгаа бодисоос гарсан халуун; дөл гарган шатах үйл явц; 2.Хээр гадаа явахдаа нэг оромжид хамт нийлэн яваа хүмүүс; 3.Төрөл бүрийн зэвсгээр дайсныг устган дарах хэрэгсэл; 4.Сарны зурхайн ёсны таван махбодын нэг; 5. [шилжсэн] Цог жавхаа: Гал II Гурвын тоо. Гал III гал од (ангараг гараг). IV гал сүүлт (ой болон цэцэрлэгт хүрээлэнд амьдардаг, байшингийн дээвэр болон модонд үүрээ засдаг, жижигхэн биетэй нүүдлийн шувуу, Ази, Африк, Европт тархсан).



Уг үгийн утгыг хэрхэн ойлгож буй талаар 15–58 насны, мэргэжил, боловсролын хувьд ч ялгаатай 120 гаруй хүнээс аман судалгаа авлаа. Хүмүүс тухайн ойлголтыг “Түймэр (12), голомт (11), цахилгаан (10), аюул (9), тогоо (8), илч, чүдэнз (6), дөл, зуух, ус, халуун (5), энерги, махбод, тог, гэрэл (3), улаан, оч, тог цахилгаан (2), шаталтын үр дүн, асаагуур, монголчуудын шүтээн, илч гэрэл, команд, хөгжлийн үндэс, хам, халуун илч, амьдрал, ариутгагч, галын самбар (1)” хэмээн холбон сэтгэж байв. Энэхүү аман судалгааны дүн буюу хүмүүсийн ойлголт тайлбар толь бичигт хэрхэн буусныг судалж үзлээ.

Аливаа тайлбар толийн хамгийн чухал цөм нь болох толгой үгийн тайлбар дэлгэрэнгүй, тодорхой байх шаардлагатай байдаг. Үүнийг ч Ц.Өлзийхутагийн “Толь бичгийн тайлбар нь шинжлэх ухааны үндэстэй туйлын зөв ойлголт өгч, хүний хэрэгцээ шаардлагыг хангахаар... байх нь чухал<sup>6</sup>” хэмээсэн нь баталдаг.

Тиймээс ч юун түрүүнд монгол хэлний тайлбар толиудад “гал” хэмээх үгийг хэрхэн тайлбарласныг эрт болон эдүгээ цагийн илэрхийлэл болсон “Хорин нэгт тайлбар толь” (1717), “Гучин зургаат тайлбар толь” (1927), С.Шагжийн “Эрэхүйеэ хялбар болгон зохиосон монгол үгний тайлбар толь” (1929), “Хорин наймт тайлбар толь” (1943), Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” (1966), Ш.Сэцэнцогтын “Монгол үгсийн язгуурын толь” (1988), “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь” (2008), “Монгол хэлний их тайлбар толь” (2016) зэрэг монголчуудын түгээмэл хэрэглэдэг тайлбар толиудаар төлөөлүүлэн судаллаа.

Эдгээр тольд “гал” хэмээх толгой үгийн 2–8 утгыг тайлбарласан бөгөөд үүнд гол болон шилжсэн утгыг багтаажээ.

Орчин цагийн толь зүйн зарчмаар үгийн гол утгыг толийн эхэнд толгойлсон гэж үзвэл, харьцангуй өмнөх үеийн толь бичигт хамаарах “Хорин нэгт тайлбар толь”, “Гучин зургаат тайлбар толь”, “Хорин наймт тайлбар толь” – уудад “гал” хэмээх үгийн үндсэн утгыг “таван махбодын нэг” гэж үзжээ. Харин Шагжийн “Монгол үгний тайлбар толь” –д энэ утга дэд байранд шилжсэн бөгөөд Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” –д зургаадугаарт, Ш.Сэцэнцогтын “Монгол үгсийн язгуурын толь” –д наймдугаарт бичигдэж, харин “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь” болон “Монгол хэлний их тайлбар толь” –д

дөрөвдүгээр утга болон жагсжээ. Энэ нь “таван махбодын нэг” гэх эл утга хэрэглээнд голлох байдлаа алдсаар буйг илтгэнэ.

Өмнөх үеийн тайлбар толиуд дахь “Хэт цахин авч хэрэглэх, дээш мандах, мод зэргийг түлэн үнс болгох, түүхийг боловсруулж идэх” зэрэг үйлийн тайлбар нь орчин цагийн толиудад “шатаж буй бодисоос гарах халуун” болж нэршин өөрчлөгджээ. Улмаар утгын хувьд ч өргөжин тэлсэн нь тодорхой авч, тухайн үед энэ үг нэрлэлт байгаагүй хэмээн яаран дүгнэх боломжгүй юм.

“Гал” хэмээх толгой үгийг утгын давтамжаар нь нэгтгэн үзье (Толиудын нэрийг Хүснэгт 1–д бичсэний дагуу дараалуулан, товчиллоо).

**2 дугаар Хүснэгт. Монгол хэлний тайлбар толиуд дахь “гал” хэмээх үгийн утгын давтамж.**

	Утга	Хорин нэгт тайлбар толь	Гучин зургаат толь	С.Шагжийн толь	Хорин наймт толь	Я.Цэвэл МХТТ	Ш.Сэцэнцогт МУЯТ	МХДТТ	МӨИТТ
1	Шатах зэрэг үйлийн үр дүн	+	+	+	+	+	+	+	+
2	Шинж чанар		+		+				
3	Махбод	+	+	+	+	+	+	+	+
4	Аян зэрэгт цуг явагч					+	+	+	+
5	Бялт					+	+		
6	Зэвсэг хэрэгсэл							+	+
7	Од гараг					+		+	+
8	Тоо					+		+	+
9	Оч						+		
10	Уур						+		
11	Буудалт						+		
12	Хүч нэмэх үг						+		
13	Амьтан							+	+
14	Цог жавхаа							+	+

Хүснэгтээс үзвэл, аль ч үеийн толь бичигт нийтлэг тэмдэглэгдсээр буй утга нь “шатах, түлэх зэрэг үйлийн үр дүн болох халуун илч” болон “зурхайн таван махбодын нэг” хэмээх ажээ. Галыг шинж чанар (амт гашуун, өнгө улаан, халах түлэх чанартай, харанхуйг гийгүүлэх гэрэл гэгээтэй гэх мэт) – аар төлөөлүүлэн тайлбарласан нь орчин цагийн толь бичгүүдэд уламжлан үлдсэнгүй, харин “аян замд нэг оромжид явагч”, “од гараг”, “тоо” гэх зэрэг утгаар баяжжээ. Ш.Сэцэнцогт “оч, уур, буудалт, хүч нэмэх үг” хэмээн утга салаалуулан толгойлсон нь бусад тольд давтагдсангүй.

Тухайн хэлний үгийг өөр хэлтэй харьцуулан жишиж үзэхэд утгын ялгаа нь илэрдэг онцлогтой. Үүнийг зэрэгцүүлсэн судалгаагаар илрүүлдэг. Тэгвэл энэхүү “гал” хэмээх үгийг гадаад хэлний тайлбар толь бичгүүдэд хэрхэн тайлбарласныг мөн харьцуулан үзье.

Толь бичиг дэх толгой үгийн тайлбар уг толийн зорилтот бүлгээс хамааран, өөр өөр байх нь түгээмэл. Тиймээс судалгаандаа тухайн хэлний тайлбар толиудаас өргөн хэрэглэгддэг, нэр хүндтэй гэсэн шалгуурын

<sup>6</sup> Өлзийхутаг Ц., Монгол хэлний үгсийн сангийн судлал. Улаанбаатар., 1979.т.118



дагуу орчин цагийн англи, герман, орос, япон, хятад, солонгос хэлний цахим толийг ашиглан харьцуулав.

**3 дугаар хүснэгт. Гадаад хэлний тайлбар толиуд дахь “гал” хэмээх үгийн тайлбар.**

Англи хэлний тайлбар толь	Герман хэлний тайлбар толь	Орос хэлний тайлбар толь
1. Бодис агаар дахь хүчилтөрөгчтэй нэгдэж, ихэвчлэн хурц гэрэл, дулаан, утаа ялгаруулах үйл явц; шатах эсвэл шатаах 2. Хяналтаас гарч, барилга, мод зэргийг сүйтгэдэг дөл 3. Хоол хийх, өрөөг халаахад ашигладаг мод, нүүрс зэрэг шатаж буй түлшний овоолго 4. Өрөөг халаах зориулалттай тоног төхөөрөмж 5. Буугаар буудах нь 6. Ширүүн шүүмжлэл 7. Асар их сэтгэл хөдлөл, ялангуяа уур хилэн эсвэл урам зориг Шатаж буй мэдрэмж <sup>7</sup>	1. Гэрэл ба дулаан бий болгодог, дөл үүсгэдэг шаталтын хэлбэр 2. Хүний удирдлагатай гал (эрчим хүчний эх үүсвэр) 3. Хор хөнөөлтэй гал (түймэр) 4. Галт зэвсгээр буудах, бөмбөг дөлт 5. Шилж. Гэрэлт цамхаг (далайчдын хэл) 6. Шилж. Гэрэлтэх, гялалзах, туяарах (нүдний гал) 7. Шилж. Оюуны энерги, дотоод хүсэл эрмэлзэл, урам зориг нь үйлдэл, дохио зангаагаар илрэх 8. Шилж. Гал барих 9. Шилж. Галаар тоглох <sup>8</sup>	1. Шатаж, гэрэлтэж буй өндөр хэм бүхий хий, дөл 2. Гэрэлтүүлгийн хэрэгслээс гарч буй гэрэл (гудамжны гэрэл) 3. Байлдааны буудлага (гал нээх) 4. Шилж. Хүсэл тэмүүлэл 5. Шилж. Эрч хүч, энергизэр дүүрэн хүнийг хэлэх үед (ярианы хэлэнд) 6. Шилж. Халуун, дулааныг илтгэсэн утга (ярианы хэлэнд) <sup>9</sup>
Япон хэлний тайлбар толь	Хятад хэлний тайлбар толь	Солонгос хэлний тайлбар толь
1. Юм шатах үед гарах гэрэл ба дулаан, дөл 2. Гал түймэр 3. Галын төхөөрөмж 4. Түгшүүр <sup>10</sup>	1. Шатаж буй бодисоос ялгарах гэрэл, гэгээ, дөл 2. Гал түймэр 3. Галт зэвсэг 4. Уур 5. Биеийн халуун, эрүүл мэндийн асуудал 6. Улаан өнгө <sup>11</sup>	1. Эд юмс хүчилтөрөгчтэй нийлж, өндөр температурт гэрэл ба дулаан ялгаруулан шатах явц 2. Гал түймэр 3. Гэрэл ялгаруулж харанхуйг гэрэлтүүлэх зүйл <sup>12</sup>

Эдгээр тольд “гал” хэмээх толгой үгийн үндсэн болон шилжсэн 4–9 утгыг багтаан тайлбарласан бөгөөд шатах үзэгдэл, гэрэл, гал түймэр, зэвсэг буудлага, сэтгэл хөдлөлтэй холбоотой утга түгээмэл давтагдаж байна.

Дээрх толиудад тус үгийн үндсэн утга нь “Аливааг шатаах үед гардаг гэрэл, дулаан; гэрэл, дулааныг үүсгэдэг үзэгдэл” гэх физик ойлголтыг илэрхийлж байгаа нь аль ч хэлэнд үгийн сангийн ойлголтоороо ижил, өөрөөр хэлбэл утгын хувьд бүх хэлэнд ижил тэнцвэрт харьцаанд оршиж буй үг болохыг илэрхийлж байна. Тиймээс ч энэ үг аль ч хэлний уугуул үг болох боломжтой.

Харин дэд утгад “гал түймэр” гэх утга удаалж, улмаар олонх хэлэнд сэтгэлийн хүчтэй

<sup>7</sup> <https://www.oxfordlearnersdictionaries.com>

<sup>8</sup> <https://www.duden.de>

<sup>9</sup> <https://slovarozhegova.ru>

<sup>10</sup> <https://www.weblio.jp>

<sup>11</sup> <https://baike.baidu.com>

<sup>12</sup> <https://www.naver.com>

хөдөлгөөнийг илэрхийлэх эрч хүч, амжилт, урам зориг, халуун дулааныг илтгэсэн эерэг утга зонхилохоос гадна уур хилэнг илэрхийлэх сөрөг утга ч тохиолдоно.

Бид бодит зүйлийг харж, барьж болох тул тухайн зүйлийн шинжийг зөв тодорхойлоход дөхөмтэй байдаг бөгөөд түүний дүрс, хэлбэр хэмжээ, бусад шинжээр нь тайлбарлах боломжтой. Гэвч тухайн хэлээр хэлэлцэгч ард түмний хийсвэрлэх буюу зүйрлэх, адилтгах сэтгэлгээ тухайн орны соёл, орчин ахуй, зан заншлын ялгаанаас хамааран өөр өөр байдагтай холбоотойгоор ертөнцийн аливаа үзэгдлийг таньж мэдэн хүлээн авч, түүнийгээ илэрхийлэх нь өөр юм. Энэ үзэгдэл ч толь бичигтээ тусдаг тул аливаа хэлний толь бичиг тухайн цаг үеийнхээ соёлын өв, түүхийн гэрч болдог.

Тиймээс ч галын талаарх хүн төрөлхтний ойлголтын нийтлэг тал толь бичигт хэрхэн туссаныг олж мэдэхийн сацуу олон утгат үгийн аль утгыг эхэнд толгойлсныг харьцуулан дүгнэх боломжийг олгож байна.

### Дүгнэлт

Хүний хэл гэдэг нэгэн бүхэл амьд тогтолцоо тул нийгмийн хөгжлийн нөлөөгөөр үгийн утга нэмэгдэх, өөрчлөгдөх нь түгээмэл. Харин тухайн хэлний тайлбар толиуд хэлний хөгжил хувьслын талаар олж мэдэх сонирхолтой баримт болдог.

Гэхдээ хэлний үгийн санг, тухайн хэлээр хэлэлцэгч ард түмний түүх, соёл, аж байдал, сэтгэхүй, сэтгэлгээтэй холбон хөгжил хөдөлгөөнд судлах нь нэг талаар дэлхийн улс түмний нийтлэг болон өвөрмөц төрхийг илрүүлэн, ерөнхий дүр зураг гаргах зорилготой шинжлэх ухааны өнөөгийн чиг хандлагад бүрэн нийцэх бөгөөд нөгөө талаар шинжлэх ухаан хоорондын харилцан уялдаа улам нарийсаж буйн илрэл юм.

Хүн төрөлхтний сэтгэлгээний дээрх онцлог тайлбар тольдоо хэрхэн туссан, үгийг утгын дарааллаар хэрхэн толгойлсныг тодорхойлох зорилгоор хүний оршихуйн үндэс, амьдралыг тэтгэгч элемент болох “гал” хэмээх толгой үгээр төлөөлүүлэн судлахад дараах онцлог ажиглагдаж байна. Үүнд:

1. Аман судалгааны дүнгээс үзвэл, галын талаарх хувь хүмүүсийн ойлголт янз бүр боловч орчин цагт галыг “аюул буюу түймэр” гэж үзэх хандлага түлхүү ажиглагдлаа.

2. Тухайн толгой үг олон утгатай бол



аль утгыг эхлэн толгойлох асуудал маргаан дагуулсан хэвээр байна. Тухайлбал, герман хэлний Дүдэн зэрэг тольд хэрэглэгчдийн дунд давтамж ихтэй, өргөн хэрэглээтэй үгийг үндсэн утга болгон толгойлохыг зөвлөдөг бол монгол хэлний тайлбар толиудад тухайн үгийн анхдагч утгыг эхлэн толгойлох зарчим баримталдаг.

Монгол хэлний тайлбар толиудад галыг “шатаалтын үр дүнд гарах халуун илч” хэмээн тодорхойлсон нь анхдагч утга болон давамгайлжээ. Энэхүү утга нь 1960–аад оноос толь бичигт нэвтэрч, өнөөг хүртэл үндсэн утгаа хадгалсаар байгаа аж. “Аливааг шатаах үед гардаг гэрэл, дулаан; гэрэл, дулааныг үүсгэдэг үзэгдэл” гэх утга гадаад хэлний тайлбар толиудад ч үндсэн утга болон давтагджээ. Харин манжийн үеийн монгол хэлний тайлбар толиудад тайлбарын эхэнд жагсаж байсан “зурхайн таван махбодын нэг” хэмээх утга нь орчин цагийн монгол хэлний голлох толь бичгүүдэд 4–6 дугаар байрт шилжсэн нь хэлний хөгжил, хэрэглээний байдлыг илтгэж байна. Монгол хэлний тайлбар толийн дэд утга болон дараалж буй “дөрвөн махбодын нэг” хэмээх тайлбар бусад дорнын тольд тохиолдсонгүй нь сонирхол татна. Энэ нь тухайн үндэстний соёл,

сэтгэлгээний өвөрмөц онцлогийг илтгэх аж.

“Гал” хэмээх үгийн утгын тайлбарт давтагдаж байгаа “буудлага” гэх утга өрнийн толиуд болоод Сэцэнцогтын “Монгол үгсийн язгуурын толь”–д тохиолдох бөгөөд “дайсныг дарах зэвсэг хэрэгсэл” хэмээн тайлбарласныг “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”, түүний цахим хувилбар болох “Монгол хэлний их тайлбар толь”–оос ч олж харах боломжтой.

Түүнчлэн галын халуун дулаан шинж чанарыг илтгэсэн урам зориг, амжилт, эрч хүчийг илэрхийлсэн эерэг утгаас гадна оргилсон уур хилэнг илэрхийлэх сөрөг утга аль ч хэлэнд тохиолдож буй нь хүн төрөлхтний сэтгэлгээний нийтлэг талыг илэрхийлэх жишээ болох юм. Эндээс үзэхэд ард түмэн бүр тухайн юм үзэгдлийн шинж, төлөв, зориулалт, өнгө, хэлбэр дүрс зэргээс өөр өөрийн сонголтыг хийж, тэрхүү юм, үзэгдлийг нэрлэх буюу тайлбарладаг нь илэрхий байна.

Бидний хувьд энд сонгосон үгэндээ тулгуурлан, аль нэгэн толийн тайлбарыг үнэлэн дүгнэх боломжгүй бөгөөд уг үгийг хэл зүйн, хэрэглээний түвшинд судлан үзвэл, тухайн ард түмний хэл, сэтгэлгээний онцлогийн талаар илүү гүн гүнзгий олж мэдэх боломжтой байна.

#### Ашигласан материал:

1. Базаррагчаа М., Монгол үгийн гарлыг мөшгөх нь. Улаанбаатар., 1992
2. Дулам С., Монгол домог зүйн дүр. Улаанбаатар., 2009
3. Намжилмаа (эмх). Хорин наймт тайлбар толь. Хөх хот., 1988
4. Өлзийхутаг Ц., Монгол хэлний үгсийн сангийн судлал. Улаанбаатар., 1979
5. Равдан Э., Орчин цагийн хэл шинжлэл. Улаанбаатар., 2020
6. Саруул-Эрдэнэ М., Сонирхолтой хэл шинжлэл. Улаанбаатар., 2015
7. Сумьяабаатар М., Гучин зургаат тайлбар толь. Т.1-8. Улаанбаатар., 2005
8. Сэцэнцогт Ш., Монгол үгсийн язгуурын толь. Хөх хот., 1988
9. Түвшинтөгс Б., Шинэбаяр О., Хэл шинжлэл-Соёмбо нэвтэрхий толь. Улаанбаатар. 2012
10. Хорин нэгт тайлбар толь. Хөх хот., 1979
11. Цэвэл Я., Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар., 1966
12. Шагж С., Монгол үгний тайлбар толь. Дундад улсын үндэстний хэвлэлийн хороо. 1994
13. ШУА., Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Улаанбаатар. 2008

Цахим эх сурвалж

1. <https://www.oxfordlearnersdictionaries.com>
2. <https://www.duden.de>
3. <https://slovarozhegova.ru>
4. <http://xh.5156edu.com>
5. <https://www.naver.com>
6. <https://www.weblio.jp>
7. <https://baike.baidu.com>



## МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ЭХ ОРОНЧ ҮНДЭСНИЙ ҮЗЭЛ ХҮМҮҮЖЛИЙН АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

**Н.ЖАЛБАЖАВ** /Шихихутуг их сургуулийн зөвлөх профессор, доктор (Ph.D), профессор, хошууч генерал/

**О.ИЧИННОРОВ** /ҮБХИС-ийн Суртал, хүмүүжлийн албаны дарга, докторант, дэд хурандаа

**Түлхүүр үг:** Эх орон, эх оронч үзэл хүмүүжил, үнэт зүйлс, үндэсний үнэт зүйлс, ухамсар, сэтгэлгээ, хууль дээдлэх, шударга ёс, үлгэрлэл манлайллын менежмент..

**Абстракт:** Понятия, связанные с патриотическими чувствами, Патриотизм–иммунитет независимости государства, безопасности, интеллекта. Ценности и патриотизм. О неотложных вопросах в системе формирования патриотических чувств и путях решения. Обновление в руководящей деятельности. Финансовый менеджмент. Об активизации участия семьи, школы и трудового коллектива, гражданских общественных организаций в формировании патриотических чувств. Роль Вооружённых Сил, военной службы в патриотическом воспитании. О новых задачах патриотизма и патриотического воспитания

Дотоод, гадаадын судлаачдын бүтээл туурвил, хэлсэн ярьснаас үзэхэд улс орны иргэний эх оронч, үзэл хүмүүжил нь тухайн улс үндэстнийхээ оршин тогтнохуй, тусгаар тогтнол, аюулгүй байдлынх нь оюуны дархлаа нь болдог ажээ. Ийм учраас газар ,газрын эрдэмтэн мэргэд энэ асуудалд онцгой анхаарч “эх орон”, “эх оронч үзэл”, “эх оронч хүмүүжил”, “эх оронч” гэх ойлголт, ухагдахуунуудын утга учрыг олон талаас нь янз янзаар тайлж томьёолсоор иржээ. Тухайлбал **Я.Цэвэл** аругайн **“Монгол хэлний товч тайлбар толь”**–\*д “төрсөн орон нутаг, улс гэр,...эх орон/а,ямар нэгэн үндэстэн, хүн аймгийн соёл боловсрол,хувиар шүтэн оршиж хүмүүжсэн буюу улиран уламжилж оршин суусан газар, өссөн төрсөн эх орон...”эх оронч үзэл, эх орон, ард түмэндээ хайртай бөгөөд эх орон ард түмний төлөө яахаас ч буцахгүй байх үзэл...”гэх зэргээр томьёолсон бол нэгэн эх оронч “Эх орноо сэтгэл зүрхнээ тээж, сэтгэл зүрхнээсээ хайрлах, амь бие үл хайрлан тэмцэж хамгаалахыг” жинхэнэ эх оронч үзэл, хүмүүжил гэжээ. Ер нь эх оронч үзлийн тухай

тодорхойлолт хэдэн зуугаараа байдаг ажээ. Тухайлбал “Шилжилтийн нийгэм, шинэтгэл, соёл иргэншлийн асуудал” Орос, Монголын эрдэмтдийн бүтээлд эх оронч үзлийн тухай 460 гаруй томьёолол байдгийг дурдсан байх жишээтэй. Барууны ардчилал, иргэний нийгэм төлөвшсөн улс орнуудад жишээ нь АНУ–д шударга хөдөлмөр, авьяас билгээрээ олсон орлогынхоо хууль ёсны албан татварыг төлдөг иргэнээ эх оронч гэж үзэх хандлага ч байдаг ажээ.

Эдгээрээс үзэхэд “Эх орон”гэдэг ойлголт нь хүмүүний ухамсар, сэтгэхүйгээс ангид оршин буй бодит байдал, бас энэхүү бодит байдлын хүний ухамсар дахь тусгал” “хуулбарлалт”– ыг илэрхийлсэн ухагдахуун бол “эх оронч үзэл” нь хүний эх орондоо хандах байдал төлөвийг тодорхойлдог байна. Сэтгэл зүйд эх оронч үзэлтэн байх нэг хэрэг, харин хүний энэ ухаарал, мэдрэмж, үзэл бодол үйлдэл, үйл ажиллагааных нь дотоод сэдэл, “өдөөгч “ хүч болоход боловсрол, хүмүүжлийн олон зүйл тухайлбал: эр зориг, хандлага зэрэг чухал болохыг онцолдог. Тэгэхлээр эх оронч үзэл, хүмүүжил нь хүний оюуны болон биеийн хүчин зүйлс буюу ертөнцийг үзэхүй, итгэл үнэмшил, хүсэл эрмэлзэл, эр зориг,тэдгээрээ биелүүлэх бие сэтгэлийн хат, тэдгээрийн төлөвших орчин нөхцлийг хүртэл багтаасан ойлголт бөгөөд энэ нь эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх нь ухааруулах сэнхрүүлэхээс аваад хүнд шударга зан чанар,ёс суртахуун, хүний мөс жудаг, бие сэтгэлийн тэсвэр хатуужил суулгахад чиглэсэн, ур ухаан мэдлэг чадвар шаардсан ажил үйлс болохыг нотолж буй хэрэг юм.

“Монгол Улсын иргэдийн эх оронч үндэсний үзэл, хүмүүжил төлөвшүүлэх хөтөлбөр” –т “Монгол Улсын иргэний эх орноо хайрлах, түүх



соёлын үнэт зүйлсээр бахархах үндсэн дээр төр улсынхаа тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хамгаалах, бэхжүүлэх хөгжил дэвшлийн төлөө амь бие, авьяас билэг, эрдэм боловсрол, хүч чадлаа зориулах чин хүсэл эрмэлзэл, санаа зориг, бэлтгэгдсэн байдлын цогц” –ыг эх оронч, үзэл хүмүүжил гэж томъёолж буй.

Нийгмийн шинэчлэлийн явц, үр дагавраас хамааралтайгаар хүний амьдралын зорилго, баримжаа, үйлдэл үйл ажиллагааных нь идеал буюу оюун санааны туйлын хүслэн, хүрээлэн буй нийгэм, улс төрийн орчинд хандах байдал, ертөнцийг үзэхүй хүртэл хувьсаж өөрчлөгддөг жамтай. Ямар нийгэм байна, тийм иргэнтэй байна гэсэн яриа ч бий. Тухайлбал: хуучин цагт монгол улсын иргэдийн ухамсар сэтгэлгээний цөм нь сүсэг бишрэл үзэл суртал зэрэг оюун санааны хүчин зүйл болж байв. Үүний сацуугаар монгол хүмүүнд гачигдах, дутагдах юмгүй сэтгэл хангалуун аж төрөх материаллаг ашиг сонирхол /хөрөнгөжих, бэл бинчинтэй байх гэвэл илүү ойлгомжтой биз/ хэдийгээр үзэл сурталд хязгаарлагдаж, дарагдсаар байсан ч амьдралынх нь нэг утга учир байсныг огт үгүйсгэх аргагүй бизээ. Монгол Улсын иргэн өмчлөх эрхтэй болсноос хойш эд материалын анхдагч хэрэгцээ (идэж уух, өмсөх зүүх, орон байр, унаа машин гэх мэт) нь амин чухал болсон тул үнэт зүйлсийн чиг баримжаанд өмч хөрөнгөтэй болох, баяжих сэтгэлгээ зонхилох болов гэдэг нь үндэслэлтэй л дүгнэлт юм. Тэр ч бүү хэл өндөр хөгжилтэй аж үйлдвэржсэн орны ажиллагсдын хөдөлмөрлөх сэдэл нь эн тэргүүнд материаллаг хэрэгцээгээ хангах хэрэг байдаг бөгөөд зөвхөн үйлдвэржсэний дараах нийгэмд л материаллаг бус сонирхол хүний үйлдэл, үйл ажиллагааны сэдэл болох эхлэл тавигддагийг эрдэмтэд, судлаачид нотолсон байдаг.

Ардчилал түгж зах зээлийн харилцаа төлөвшсөн энэ цагт нийгэмд социал шинэ бүтэц, давхаргажилт бий болж нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхлын зөрчил, баян хоосны ялгарал лавширч нийгмийн сэтгэлгээнд “Эзэн хичээвэл заяа хичээх” философи үйлчилж, хувиа хичээх, мөнгө зоосыг шүтэх үзэл газар авч нийтлэг үнэт зүйлс, зорилгын талаар ухамсар сэтгэлгээ бүдгэрэх нигууртай. Ер нь эдийн засгийн зах зээлийн харилцаа, хувийн өмч, бизнесийн эрх

чөлөө, олон урьгалч үзэл бодол, зэрэг нь “ жолоо цулбуургүй” аваас үндэстний эв нэгдэл, нийгмийн “бат цул” байдлыг задлах, “төвөөс зугтаах” хүчин болдог нигууртай ажээ. Товчоор илэрхийлэхэд эх оронч үзлийн агуулга нь улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийг даган мөн хувьсч өөрчлөгдөх жамтай ажээ. Гэхдээ хичнээн хувьслаач монгол хүний зүрх сэтгэлийн гүнд “нуугдан” байх “Унасан газар угаасан усаа” гэх, эх орныхоо тусгаар тогтнол, баян тансгаар, бахархах нь хувиршгүй сэтгэл юм. Гагцхүү, болор мэт тунгалаг, эхийн сүү лугаа ариун энэ сэтгэлийг сэвтээхгүй, бохирдуулахгүй, өдөөж хөгжөөж байх нь төр, түмний бат оршихуйн нэг үндэс нь билээ.

Эдүгээ нийгэм зарим талаар ёс суртахууны доройтолд хүрч байгаа тухайд ч ярьж бичиж буй нь ортой л зүйл. Авлига, амар хялбараар хөрөнгөжиж бэлжих сонирхол, хүнд өөрөө өөрийнхөөрөө байх боломж хумигдсан улс төр, нийгмийн хүрээлэл, хүний төлөвшил хөгжлийн ариун дагшин орчин байх учиртай өрх гэр бүлд хүртэл нэвчин буй улс төржилт, ажилгүйдэл, ядуурал энэ бүхэн нийгмийн ёс суртахууныг бохирлож байна гэх үндэстэй байна. Ёс суртахууны доройтол хүмүүсийн шударга хөдөлмөрөөрөө баялаг бүтээлцэн сайн сайхан аж төрөх хүсэл эрмэлзэл, нийгмийн хариуцлага, төр, нийгмийн удирдлагын нөлөө нэр хүндийг сулруулаад зогсохгүй цаагуураа хүн ардын сэтгэл амар төвшинг, улмаар энх амгалан аж төрөхийг нь алдагдуулах нигууртай. Түүнчлэн боловсрол хүмүүжил, соён гэгээрүүлэх, эрүүлийг хамгаалах зэрэг төрийн нийгмийн нийтлэг үйлчилгээний хүндрэл бэрхшээлийн уршиг үр дагавар ч цэргийн хэрэгт ч хүрч нөлөөлөх магадлалтай байна.

Учир иймд цэрэг ардаа соён гэгээрүүлж улс үндэстний оршин тогтнохуй, хөгжил дэвшил, соёл иргэншлийн оюуны дархлаа нь болсон эх оронч үзэл, хүмүүжил, үндэстний бахархлаа өдөөн хөгжүүлэх нь энэ цагийн хамгаас чухал зорилт болж байна.

Өдгөө цагт Монгол Улсын иргэний эх оронч үндэстний үзэл, хүмүүжлийг Монголчуудын удмын санд шингэн үеэс үед уламжлагдан ирсэн эх орноо хайрлан хамгаалах, тусгаар тогтнол, хөгжил дэвшлийнх нь төлөө бие сэтгэлээ харамгүй зориулах нийтлэг мэдрэмж,



ухамсар, оюуны дотоод хүч тэнхээ, түүний бодит илрэл болсон амьдралын идэвхитэй байр суурь гэж ойлгох нь зүйтэй гэж үзэж байна. Философч Б. Даш-Ёндон абугай “Монголын төлөө гэсэн сэтгэл Бидний зүрхэнд уяатай” гэсэн их Нацагдоржийн “монголчуудын сэтгэлийг илэрхийлсэн” шүлэглэлийг ишлээд “Бид энэ уяаг сулруулах ёсгүй, харин ч улам чангалах ёстой. Бид –Эх орны үрс боловч эх орон маань бидний хүүхэд билээ. Иймд бид Эх орноо хүүхэд шигээ хайрлах ёстой. Эх орноо “зүрхэндээ уяж чадаагүй тийм хүмүүс эх орноо дээрэмддэг байна, бас харийнханд дээрэмдэх бололцоо олгодог, эсхүл ийм юмыг зүгээр хараад суудаг, эсхүл хамтарч нийлдэг ажээ. Ийм байдал бол зүй бусаар баяжигчдын “зүрх юм”<sup>1</sup> гэжээ. Эдгээр үгс эх оронч үзэл санаа хүний шударга ариун явдал, амьдралын идэвхитэй байр сууриных нь үндэс нь болдог гэдгийг хэлсэн гэж ойлгогдож байна.

Сүүлийн үед олон судлаачид эх оронч үзэл хүмүүжлийн утга, учрыг Монгол Улс, Монголын ард түмний эрхэм үнэт зүйлсийг хадгалан хамгаалах, бэхжүүлэхийн төлөөх санаа зориг хичээл зүтгэлд байна гэж тайлж, тайлбарлаж байна. Учир нь эдгээр үнэт зүйлс нь хүний эх орон хэмээх өлгий орчны утга учир, ноён нурууг нь илэрхийлдэг байна.

Ийм эрхэм үнэт зүйлсэд:

–Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, тэдгээрийг тээгч эзэн нь болсон Монгол Улсын иргэн, түүний эрх, эрх чөлөөний баталгаажилт;

–Монголчуудад мөнх тэнгэрээс заяагдсан өлгий нутаг, түүний баялаг;

–Мянга мянган жил бүтээгдэн дархлагдсан “хорвоод хосгүй, дахин давтагдашгүй” монгол соёл иргэншил, түүний үндэс нь болсон нүүдлийн мал аж ахуй, Монгол аж төрөх арга ухаан, монгол ахуй, амьдралын хэв маяг;

–Төр, цэрэг засах монгол арга ухаан;

–Монголын ард түмний хүсэл зориг, сонголтын үр дүн нь болох Монгол Улсын нийгмийн байгуулал, Үндсэн хуульт ардчилсан төрийн тогтолцоо;

–Монголын ард түмний оюуны их соёл, ой санамж, монголчуудын хэл сэтгэлгээ, утга

зохиол, яруу найраг, дуу хөгжим, шинжлэх ухаан, сурган боловсруулах, хүмүүжүүлэх, төлөвшүүлэх арга ухаан;

–Монголын нууц товчоо”, “Алтан товч”, “Арван буянт номын цагаан түүх”, “Болор тууль” зэрэг Монголын түүхийн эх сурвалж бичгүүдэд болон дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдын хөдөлмөрийн үр дүнд бичигдсэн бүтээгдсэн) Монгол Улс үндэсний үнэн бодит түүх;

–Монгол Улсын (Монгол Улсын иргэний) олон улсын нэр хүнд, байр суурь зэргийг багтаан томъёолдог байна.

**Тайлбар.** Үнэт зүйлс гэдэг ойлголтыг бид үнэлэгч субъектын хувьд объектын (үнэлүүлж буй юмс үзэгдэл гэсэн утгаар нь) нийгмийн, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн ач холбогдол гэсэн утгаар тааруулж хэрэглэж буй билээ. Өөрөөр хэлбэл үнэт зүйлс хэмээх философийн болон соёлын ойлголт нь үнэ цэнтэй биет тодорхой юмсыг бус харин абстракт (хийсвэрлэсэн) сэтгэлгээний үүднээс тухайн юмс, үзэгдэл (жишээ нь түүх, бахархал, эх оронч үзэл хүмүүжил гэх мэт)–ийн үнэт чанар, ач холбогдлыг илэрхийлж буй юм. Энэ бол нийгэмд, тухайн улс үндэстэнд нийтээрээ хүлээн зөвшөөрдөг, оюун санаа, үйлдэл, үйл ажиллагаандаа баримжаа болгодог нийтлэг зүйлүүдийг л үнэт зүйлс хэмээн ойлгоно гэсэн үг юм.

Мөн монгол хүн, Монгол Улсын иргэн төрж өсөх, төлөвших өлгий орчин нь болсон монгол гэр бүлийг үндэсний үнэт зүйлсэд хамааруулах чиг хандлага хүчтэй болж байна. Энэ бүхнээс үзвэл эх оронч үзэл, хүмүүжил нь Монгол Улсын иргэн бүрийн шүтэн дээдлэх хамгийн үнэ цэнэтэй зүйлс, итгэл үнэмшлийн оройн сүлдийг агуулсан ойлголт юм. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт Хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх:

“Монгол хүн, Монгол оюун ухаан, Монголын түүх, Монгол өв соёл, Монгол урлаг, Монгол ёс заншил, уламжлал бол улс эх орны бахархал, үнэт зүйл байх ёстой, Монгол Улсын тусгаар тогтнолын баталга болсон Монголоо гэсэн зүрхсэтгэлтэй Монгол хүнийг хүмүүжүүлэх эх үйлсийг бид цалгардуулах учиргүй” гэсэн нь эх оронч үндэсний үзэл хүмүүжил нь Монгол улсын иргэн бүрийн эрхэмлэн дээдлэх оройн сүлд болсон үндэсний үнэт зүйлсэд суурилсан

<sup>1</sup> Б.Даш-Ёндон. “Хүн ба шим ертөнц”. Философи, эрх зүйн судлал, УБ., 2024., №39, 247



байх учиртайг онцолсон хэрэг юм.

Энэ цаг үед эх оронч үндэсний үзэл хэмээх хүний дотоод нөөцийг хүн ардаа нэгтгэн нягтруулах, бүтээн байгуулах хүч болгоход соён гэгээрүүлэх үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтыг нийгмийн шинэ орчин нөхцөлд нийцүүлэх шаардлагатай байна. Урьд өмнө тухайлбал Их Монгол Улс, Богд хаант Монгол улс, БНМАУ-ын үед нийгмийн ухамсрын удирдлагад шашин шүтлэг, үзэл суртал төрийн сүр хүч, хууль цаазын эрхшээлээр “төрийн үзэл санаа”-г хүн ардад тулган хүлээлгэж номхон хүлцэнгүй, дуулгавартай байлгах зорилгод чиглэгдэж байжээ. Эдүгээ хүний ухамсар сэтгэлгээний төлөвшилд иргэний /хүний/ эрх, эрх чөлөө, нэр хүнд, тэдгээрийн гол баталгаа нь болох хувийн өмч, түүний халдашгүй байдлын нийгэм эдийн засаг, улс төрийн баталгаажилт, төрөөс иргэддээ үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж нэн чухал болсон цаг үе юм. Ийм нөхцөлд эх оронч үндэсний үзэл хүмүүжил төлөвшүүлэх бодлого үйл ажиллагаа нь төрийн нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, хүнийг хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангах, амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, нийгэмд шударга ёсыг тогтоох бодлоготой нягт уялдаатай хэрэгжих учиртай. Иргэддээ эх оронч үзэл суртлыг номлох, ухааруулахын хамт эх орондоо сэтгэл хангалуун аж төрөх нөхцөл бололцоо бүрдүүлэх нь төрийн нэн чухал үүрэг нь юм. Мөн хүн ардаа соён гэгээрүүлэх ажил үйлс иргэд, олон нийтийн идэвхитэй оролцоонд тулгуурлах учиртай.

Эдүгээ эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх тогтолцоо, арга хэлбэрийн тухай их ярьж, бичиж, маргаж байна. Энд бидний үзэж буйгаар хоёр гол асуудал байна гэж үзэж байна. Үүнд:

Удирдлага, менежментийн шинэчлэл; Төрийн “үзэл санааг түгээн дэлгэрүүлэх” ажил, үйлсэд хийсвэрлэх, онолдож цэцэрхэх, хэлбэрдэх, хоосон бардамнал, баяр цэнгэл зэрэг нь хэтийдээд эгэл хүний ой тойнд нь бууж сэтгэлд шингэхүйц, үйлдэл, үйл ажиллагааных нь сэдэл болохоор ажил арга хэмжээ үгүйлэгдэж байгааг олноороо шүүмжлэн буйд төр, иргэний нийгмийн холбогдох байгуулага, албан тушаалтан нар дүгнэлт хийх хэрэгтэй. Хүмүүн төрөхөөсөө л зөв аж төрөх, зөв сэтгэх,

зөв үйлд суралцахуйн тасралтгүй нөлөөлийн орчинд “боловсрох” учиртай. Нөлөөллийн ийм орчны гол зүйл нь гэр бүл, хүмүүжил боловсролын байгууллага, хөдөлмөрийн хамт олон гэж төсөөлөгдөж байна. Айл гэр, хүүхдийн цэцэрлэг, ЕБС, Их дээд сургууль, цэргийн анги, салбар, хөдөлмөрийн хамт олон гээд хүний амьдралын үе шат бүрт хүний хүмүүжил, төлөвшлийн тодорхой зорилтууд өөр хоорондын уялдаа холбоондоо, Монгол Улсын иргэний төлөвшүүлэх нэгдмэл зорилгод чиглэгдэн хэрэгжиж байх үндэсний удирдлага зохицуулалт шаардлагатайг бүгд ойлгож энэ чиглэлд ахиц гарч буйг үгүйсгэх аргагүй. Гагцхүү шинжлэх ухаанч мэргэжлийн удирдлага, үнэн зөв, бодитой мэдээлэл, судалгаа, чин сэтгэлийн хичээл зүтгэл, хариуцлага л илүүтэй чухал байна.

2. Санхүүгийн менежмент буюу шууд утгаараа мөнгө босгох арга ухаан. Учир нь зах зээлийн харилцаа төлөвшсөн нийгэмд ямарч сайн ажил арга хэмжээг мөнгөний ухаалаг менежментгүйгээр бүтээж үр дүнд хүргэх боломжгүй юм. Нэгэн үеэ бодвол зорилго, зорилт, учир утгыг ухаарч ойлговол сайн үйлсийг дэмжих буянтан нь монголд цөөнгүй. Энэ боломжийг ашиглах арга ухаан чухал байна.

Нийгмийн янз бүрийн давхаргын янз янзын ажил хөдөлмөр эрхэлж буй иргэн бүрт эх оронч үндэсний үзэл, хүмүүжлийг сэргээн хөгжүүлж, төлөвшүүлэх зорилгод хүрэх арга зам нь өөр өөрийн өвөрмөц онцлогтой байх нь дамжиггүй. Гэхдээ нэн тэргүүнд монгол хүн, монгол эх орон, монголын төр улс ашид мөнхөд оршин тогтнох-хөгжлийн үзлийг хөгжөөх хэрэгтэй гэж санагдаж байна. Үүний тулд иргэндээ өөртөө, ард түмнийхээ бүтээн байгуулах хүч чадал, төр, засагтаа итгэх итгэлийг бэхжүүлэх гол нөхцөл нь болсон шударга ёс, ёс суртахууны манлайлал ус агаар лугаа чухал. Манжийн 200 гаруй жилийн ноёрхол, гаднын хүч нөлөөг шүтсэн, монгол хүний мөн чанарт харш, үзэл суртлын монгол хүмүүний өөрийн итгэлийг дарангуйлсан уршиг ул мөр амь бөхтэйг, бас даяаршлын нөлөөг мартаж учиргүй. Энэ тухайд доктор, профессор **С.Одхүү:** Монголчууд сүүлийн 3 зууны хугацаанд харь гүрний эрхшээлд, оюун санааны эрх чөлөөгөөр гачигдаж ирсэн учир улс төр,

үзэл суртлын болон соёл шашны нөлөөнд автах, манжжуулах, хятаджуулах, оросжуулах, баруунжуулах алсын зорилго, далд бодлогын туршилтын талбар болж ирсэн гашуун сургамж бий. Харийн бодлого, гаднын нөлөөний үр дүнд бидний монголчууд унаган шинж төрх, үндсэн зан, үндэсний онцлогоо ямар нэг байдлаар гэж, "бүдгэрэн балартаж," олдмол маягийн зан чанартай болсон нууц биш, бас түүхийн үнэн юм"<sup>2</sup> гэжээ.

Оршихуйн хөгжлийн үзлээ гээвэл, ард түмнийхээ бүтээх их авьяас билэгт итгэх итгэл суларвал бусдын үзэлд автах аюултай. Монголчуудын оршихуйн хөгжлийн үзэл нь мөнх тэнгэр, эх дэлхийгээ дээдлэх, дахин давтагдашгүй соёл иргэншлээрээ бахархах, хуулийг дээдлэх, өвөг дээдсээ, эцэг эхээ дээдлэх, төрөө хүндлэх үзэл билээ. Эрдэмтэн зохиолч **Л.Түдэв гуай, доктор Ч.Далай, Д.Лхаашид нарын** зохиол, бүтээлээс үзэхэд энэ үзэл монгол хүний бүр мах цусанд нь шингэсэн байдаг ажээ.

Эх оронч үзэл ямагт үндэсний агуулга, өнгө төрхтэй байдгыг онцлох байна. Учир нь энэ ажил үйлс улс, үндэстнийхээ өвөрмөц онцлог/хүн ардын менталитет буюу зан чанар, ухамсар сэтгэлгээний онцлог, соёл иргэншлийн өвөрмөц байдал, үндэсний язгуурын ашиг сонирхол г.м/ –г шингээсэн, үндэстнийхээ үнэт зүйлс, ашиг, сонирхлыг хадгалах, хамгаалах зорилготой байдаг ажээ. Францын зохиолч **Франсуа Мориак гэгч "Үндэстэн бүхэнд төрөлхийн өвөрмөц шинж чанарууд байдаг"** гэсэн нь үзэл баримтлалын шинжтэй гаргалгаа гэж судлаачид үздэг байна.<sup>3</sup> Зарим судлаачид доктор **М.Бум–Очир нар "монголын ард түмэн 1, нүүдэлчин, 2, малчин, 3, байгальтай ойр амьдардаг онцлогтой"** гэсэн нь бий. Монгол хүнд дасан зохицох чадвар, хурц ухаан, тэсвэр хатуужил зэрэг сайн чанарын зэрэгцээ найзгай, асуудал шийдлийг хойш тавимгай гэж **И.С Майский бас үзсэн байдаг. Цагийн болон технологийн сахилгад тааруу, гэнэн сониуч зэрэг тааруухан зан чанар бийг** гадаад, дотоодын судлаачид тэмдэглэсэн нь бас бий. Нүүдэлчин удмын монголчуудын эдгээр зан

<sup>2</sup> Монголчуудын төрлөх өгөгдөл, унаган чанар. Философи, эрх зүйн судлал. УБ., 2024., No. 39. т.8–9

<sup>3</sup> С.Одхүү., Монголчуудын төрөлх өгөгдөл, унаган чанар. Философи, эрх зүйн судлал., УБ., 2024, No 39. т.9

чанар нь оюуных нь ертөнцийн өвөрмөцийг бүрдүүлж, хүмүүжил төлөвшлийнх нь чухал хүчин зүйл болдог. Эх оронч үзэлд үндэстний соёл иргэншлийн өвөрмөц онцлог, үнэт зүйлсээ хайрлан хамгаалах, монголын ард түмний түмний тусгаар тогтнон орших, хөгжих чадавх боломжийг бэхжүүлэх, монгол хүний ур ухаан, авьяас билиг, удмын санг хамгаалах, хөгжүүлэх бодлого, зорилт тэргүүлэх байр суурьтай бөгөөд тухайн ажил үйлсийн агуулгын нь ч арга хэлбэрийн нь ч өнгө төрхийг нь тодорхойлох хүчин зүйл нь болдог. Тийм учраас эх оронч үзэл "үндэсний" гэх тодотголтой байдаг.

Эх оронч хүмүүжлийн ажил ур ухаан, мэргэжил, хөрөнгө хүч шаардсан төрийн төдийгүй бүх нийтийн үйлс болохыг дахин давтах байна.

Монгол Улсын иргэн бүрт эх оронч үндэсний үзлийг сэргээн хөгжүүлэх, төлөвшүүлэхэд төр, засгийн бүх шатны байгууллага, албан тушаалтан нэн чухал үүрэгтэйг онцлон тэмдэглэж байна. Тэд төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, нийгмийн шударга ёсыг сахиулах, төр нийгэм, иргэдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулна. Тэд шударга үнэнийг эрхэмлэх, авьяас билгийг үнэлэх байдлаараа төрт ёс, хуулийг дээдлэхэд өргөн олныг манлайлан дагуулах ёстой. Энэ бол эх оронч үзлийг бадраах нэн чухал нөхцөл болсон нийгэм, төрийн удирдлагын чадавх, нэр хүнд, нөлөөг өргөх тухай асуудал юм.

Иргэдийн эх оронч хүмүүжилд гэр бүл, сургууль, цэцэрлэг зэрэг боловсролын бүх шатны байгууллага тэргүүлэх үүрэгтэй оролцох ёстой. Айл өрх бүрт ургийн бичгээ хөтлөх, өвөг дээдэс, эцэг эх, ахмадуудаа асран хүндлэх "унасан газар, угаасан усаа" хайрлан хамгаалах үндэснийхээ зан үйлийн эрхэм нандин уламжлалыг үр хүүхэддээ өвлүүлэх, нэг ёсондоо үндэсний бахархлыг бэхжүүлэх өлгий орчин болох учиртай билээ. Бүх шатны сургуулийн сургалтын агуулгад эх орны түүх, соёлын өвийг түлхүү судлуулах чиглэлээр дорвитой өөрчлөлт хийхийг цаг үе маань шаардаж байна. Өсвөр залуу үеийнхэнтэй зохиох хүмүүжлийн ажлын тогтолцоонд тойрон аялал, эх оронч хүмүүжлийн зорилго, агуулга бүхий клуб ажиллуулах зэрэг ажлын идэвхитэй арга хэлбэрийг байнга зохион байгуулах



хэрэгтэй байна. Манай залуучуудад гадаадын орнуудын үе тэнгийнхний нь тухай болон эрдэм боловсрол, ахуй амьдралаа өөд татаж улс орныхоо нэр төрийг авч яваа авьяас билэгт залуусын тухай мэдээлэл дутагдаж байгаа ч анхаарах хэрэгтэй.

Залуу үеийн хүмүүжил боловсролын тогтолцоонд мэдээллийн шинэ технологи, шинжлэх ухаан, техникийн дэвшлийг өргөн ашиглах учиртай. Өнөөдөр манай залуучууд интернетийн болон холбоо харилцааны шинэ технологи ашиглан өөр хоорондоо болон хилийн чанад дахь үе тэнгийнхэнтэй харилцан сонирхсон мэдээ мэдээллийг чөлөөтэй сонгон авах боломжтой боллоо. Монголын залуучууд дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад сурч хөдөлмөрлөн ардчилал, хүний эрх чөлөөний үр шимийг бие сэтгэлээрээ мэдэрч, төрж өссөн эх орон, ард түмэн соёл иргэншлээ харьцуулан жиших арга ухаанаар илүүтэй таньж мэдэх өргөн боломж, бололцоо олгож байна. Энэ бүхэн нь залуучуудтай зохих хүмүүжил, боловсролын тогтолцоог хүмүүнлэг ардчилсан нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчлөхөд түлхэц өгч буй нэгэн чухал хүчин зүйл болж байна.

Эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэхэд ахмад үеийн амьдралын их туршлага, юугаар ч орлуулашгүй үнэт зүйлс мөн. Ахмадууд эх оронч үзлийг залуу үедээ төлөвшүүлэх идэвхитэй хүч болох нийгмийн хэрэгцээ, захиалга нэгэнт бий болоод байгааг зориуд онцлон тэмдэглэж байна.

Тэднийг эх оронч хүмүүжлийн ажилд өргөн оролцуулах хөшүүрэг механизмыг бүрдүүлэх, ахуй амьдралд нийгмийн зүгээс тавих халамж анхаарлыг сайжруулах, нийгмийн хамгаалал халамжийн хүрээг өргөжүүлж, эрүүл мэндийг сахин хамгаалахад бүх талын тусламж дэмжлэг үзүүлж байх нь төрийн бүх байгууллага, тэдгээрийн удирдах албан тушаалтны хуулиар хүлээсэн үүрэг төдийгүй нийгмийн ёс суртахууныг эрүүлжүүлэх нэг үндсэн арга зам гэж үзэж байна. Энэ бол ахмад, залуу үеийнхний залгамж холбоог бэхжүүлж нийгэмд ахмад үеийнхэн, тэдний бүтээсэн гавьяа, хичээл зүтгэлийг шудрагаар үнэлэх ёс суртахууны эрүүл саруул уур амьсгалыг төлөвшүүлэх нэг үндсэн нөхцөл мөн.

Монгол хүн бүрт эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэхэд үндэсний урлаг, соёл чухал үүрэг гүйцэтгэнэ. Өнөөгийн соёл урлагт "Чингис", "Монгол хэл", "Монгол хүү", "Халуун элгэн нутаг", "Манай цэргийн жавхаа", "Эх орон" зэрэгтэй эн дүйцэхүйц цэрэг-эх орны сэдэвтэй шинэ уран бүтээл үгүйлэгдэж байна.

Үндэсний эх оронч үзлийг Монгол хүнд сэргээн хөгжүүлж, төлөвшүүлэхэд хэвлэл мэдээллийн бүх байгууллага чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй. Тэдгээр нь эх оронч үзлийг өдөөх гол хэрэгсэл байх учиртай.

Туурга тусгаар Монгол Улс оршин тогтнож үндэснийхээ аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах хэрэгцээ шаардлага байсан цагт цэрэг, эх оронч үзэл хүмүүжил иргэдийн эх оронч үзэл, хүмүүжлийн нэг тулах цэг болж байх естой гэж үзэж байна. Эх орны цэрэг халуун зэвсэг агсан, эх орны бамбай, нүд, чих нь болж байдаг учир, эх оронч үзэл нь бусдынхаас илүү хурц мэдрэмтгий байдаг. Цэргийн хүнд чанд сахилга, дэг журам, хууль дүрэмд захирагдсан албан харилцаа, бие сэтгэлийн тэнхээ зориг, ур ухаан, овсгоо самбаа шаардсан аюул эрсдэлтэй хөдөлмөр, үндсэн хуулиар хүлээсэн эх орноо хамгаалах, онцгой хариуцлагатай үүрэг нь цэрэг, эх оронч ухамсар хүмүүжил, төлөвшил, хатуужлын нь нэг баттай үндэс суурь болдог. Тухайлбал: харийн нутагт, аюул эрсдэл дүүрэн орчинд энхийг сахиулах үүрэг гүйцэтгэсэн цэрэг цагдаагийн албан хаагчид эх орноо хайрлах, бахархах, үүрэг хариуцлагын ухамсар мэдрэмж нь тэгширч, ямарч үүрэг хүлээх бие, сэтгэлийн тэнхээ зориг нь төлөвшсөн эх орончид болдог. Үүргээ биелүүлсэн цэнхэр дуулгатан дайчин эх орныхоо цэлмэг хөх тэнгэр, уудам дэлгэр нутаг, тайван амгалан аж төрөх ард олноо хараад монгол хүн болж төрж, энэ сайхан орныхоо эзэн байх хувь заяагаараа өөрийн эрхгүй бахдан бахархах сэтгэл нь бадарсан тухай ярьсан нь бий. Эдүгээ Монголд цэнхэр дуулгатан нарын бүхэл бүтэн арми бий болсон бөгөөд эх оронч ухамсар, хүмүүжлийн хүчирхэг нэгэн нөөц хүчин юм. Энэ их нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглах нь иргэдийн эх оронч хүмүүжил, соёл гэгээрүүлэх ажил үйлсийг идэвхижүүлэх нэг арга зам гэж үзэж байна.

Төрийн албанд хүчин зүтгэх хүмүүст улс орны батлан хамгаалах мэдлэг мэргэжил



зээмшүүлэх, хүн амд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшиг осолтой тэмцэх, энхийг дэмжих, сахиулах ажиллагаанд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний оролцоог нэмэгдүүлэх нь ард иргэдийн эх оронч үзлийг хөгжүүлэхэд цэргийн байгууллагаас үзүүлэх чухал үйлчилгээ болох учиртай.

Эдүгээ нийгмийн хөгжлийг даган цэргийн алба, амьдрал тасралтгүй өөрчлөгдөж, хөгжиж байна. Энэхүү өөрчилөлтийн гол утга учир нь:

1. Эх орноо хамгаалах, зэвсэгт хүчинд алба хаах үүрэгтэй Монгол улсын иргэний үзэл бодол, итгэл үнэмшил, амьдралын үнэт зүйлсийн чиг баримжаа өөрчилөгдсөн, цэргийн албанд өөр өөр ашиг сонирхол, үзэл бодолтой, нийгмийн янз бүрийн бүлэг, давхаргын хүмүүс ирж төрийн цэргийн байгууллагуудын бүтэц, бүрэлдэхүүний социал бааз суурь өөрчилөгдсөн,

2. Цэргийн албаны хууль, эрх зүйн зохицуулалтыг олон улсын стандарт, иргэний нийгмийн шаардлагад нийцүүлэх, иж бүрэн цогц байдлыг хангах, цэргийн албанд хүний эрх, эрх чөлөөний хязгаарлалтын хүрээг аль болох хумих, цэргийн албыг осол эндэгдэлгүй хаах орчин бүрдүүлэх, хүний нэр төрийг хамгаалах, хуулийн хүрээнд нээлттэй, хүмүүнлэг болгох чиглэлээр шинэчлэгдсэн гэж тодорхойлж болох байна.

3. Монголчууд хэзээнээс л цэргийн албыг залуу хүний төлөвшил хүмүүжил, эрдмийн сургууль гэж нэрлэсээр ирсэн. Цэргээс ирсэн залуус бие сэтгэл тэгширч, хэл яриа нь хүртэл цэгцэрсэн, нутаг орондоо, сум багтаа ямарч ажил албыг хаах чадвартай болсон байдаг учир ийм хүндэтгэл хүлээдэг учиртай байжээ. Эдүгээ зэвсэгт хүчин, төрийн цэргийн байгууллагуудын үүрэг зорилт, бүтэц зохион байгуулалт шинэчлэгдэн монгол цэрэг улс орныхоо аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах үндсэн үүргийнхээ зэрэгцээ олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаа хийгээд эх орныхоо бүтээн байгуулалтад идэвхитэй оролцох, хүмүүнлэгийн үүрэг гүйцэтгэх зэрэг олон талт үүрэг хуулийн дагуу гүйцэтгэх болсон нь цэргийн алба монголын залуучуудын эх оронч үзэл хүмүүжил, иргэний төлөвшил, тэсвэр хатуужлын жинхэнэ сургууль байдаг түүхэн уламжлалыг хөгжүүлэх, цэргийн албыг залуучуудын хөгжлийн орчин болгох нэн таатай

нөхцөл боломжийг бүрдүүлж байна.

Батлан хамгаалахын болон Зэвсэгт хүчний удирдлага цэргийн алба нь залуу хүний сэтгэл татахуйц байж, төр улсынхаа иргэн болж төлөвших, нийгэмд байр сууриа эзэлж, цаашдынхаа амьдрал ахуйг зохион байгуулахад нь оюун санаа бие бялдрын хувьд өсөж хөгжихөд амьдралын их сургууль болохыг цэргийн шинэчлэлийн нэг гол зорилго болгож байна.

Өнөөдөр эх орны тухай, түүний хөгжлийн уламжлал, шинэчлэлийн тухай, монгол эх оронч, дайчин баатарлаг үзлийн тухай үлэмж төгөлдөр, яруу тунгалаг, үнэмшил, итгэлтэй, хурц дайчин, нийтлэл, нэвтрүүлэг хомс байгааг хэлэхгүй байж болохгүй. Батлан хамгаалах зорилго, Зэвсэгт хүчнээ иргэддээ сурталчлах ажлыг бид шинэ агуулга хэлбэрээр баяжуулах шаардлага байгааг ойлгуулах талаар бид ч тун "хашин хойрго" хандаж байгаадаа зохих дүгнэлт ёстой.

Улс орон маань цөвүүн гэмээр цагийн хүндхэн сорилтыг туулж байна. Дэлхийн олон бүс нутагт хүчний төвүүд, улс үндэстнүүдийн зөрчил тэмцэл ширүүсч зэр зэвсэг хангинан хүн төрөлхтөнд дайны аюул нүүрлэн байна. Цаг агаарын дулаарлаас үүдэлтэйгээр дэлхийн мөсөн бүрхүүл хайлж, агаар мандлын амьдралыг хамгаалагч озоны давхарга цоорч гэмтэн газрын хөрс цөлжин нуур цөөрөм, гол мөрөн олноор ширгэж дундарч, ой мод шингэрч ан амьтан цөөрч байна.

Ийм цаг үед Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий Командлагчийн санаачлан хэрэгжүүлж буй хүн ардаа соён гэгээрүүлэх, эх оронч үндэсний үзэл хүмүүжлийг төлөвшүүлэхэд үндэсний эе эвээ хичээх, байгаль эхдээ хайр гамтай байх, түм түмэн мод тарих, эрүүл саруул аж төрөх зэрэг сайн үйлсийг манлайлан оролцох нь төрийн цэргийн байгууллагуудын эрхэм үүрэг, цэрэг, ардаа соён гэгээрүүлж эх оронч үндэсний үзэл, хүмүүжил төлөвшүүлэх үйл ажиллагааны нэг гол зорилт болж байна. Энэ бол Монгол Улсын төр, засаг/ Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Засгийн газар, улсыг батлан хамгаалахын удирдлага/сайд С.Бямбацогт/ –ын дэвшүүлэн буй “Үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги” –ийг боловсруулж хэрэгжүүлэх оюун



санааны үндсийг бүрдүүлэхэд онцгой ач холбогдолтой ажил үйлс болно. Чухамдаа хүн ардаа улс орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдал, хөгжил, дэвшлийн төлөө хүлээх үүрэг хариуцлагын ухамсар сэтгэлгээн дор нэгтгэн нягтруулж үндэсний эв нэгдэл бэхжүүлэх

нь “болзошгүй аюул заналхийлэл,гамшгаас урьдчилан сэргийлэх ,түүнийг хохирол багатай даван туулж,сэргээн босгох чадавх, бэлэн байдлыг хангах”зорилгыг хэрэгжүүлэх оюун санааны чухал нөхцөл нь юм.

#### Ашигласан материал:

1. Амар А. Монголын товч түүх. УБ., 1936.
2. Вернадский Г.В. “Монголчууд ба Орос орон” эмхтгэл. УБ., 2008, 2011, I боть.
3. У.Хүрэлсүх Үндэсний сөрөн тэсвэрлэх стратегийг боловсруулж хэрэгжүүлэх төрийн бодлогын тухайд. Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалтад хэлсэн үг.2025 он, 2 сарын 11,
4. С.Бямбацогт.,Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүнд өгсөн үүрэг чиглэл.2025. II.126
5. Даш-Ёндон Б. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж 3 боть.
6. Даш-Ёндон Б. “Цаг үе: Сэтгэл бодрол, философи” УБ., 2012.т. 54-56
7. Далай Ч. Монголын түүх. Их Монгол улс (1206-1260) Дэд дэвтэр. УБ.,1994.
8. Нацагдорж Ш. Манжийн эрхшээлд байсан Төв Халхын хураангуй түүх.т. 27, 29
9. Болдбаатар Ж. Лүндээжанцан.Д. “Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал”. УБ.,1997.
10. Болдбаатар Ж. “Монгол улсын түүх” УБ., 2006.
11. Жүгдэр Ч. “Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг” УБ.,1990.
12. Монголын нууц товчоо. УБ., 2005.
13. Монгол Улсын түүх. (таван боть зохиол). Гутгаар боть. (XIV зууны дунд үеэс XVII зууны дунд үе) УБ.,2004.
14. Сайшаал “Чингис хааны товчоон” УБ., 2004.
15. Санждорж М. “Монголын төрийн түүхээс” I, II, III боть УБ., 2006, 2007.
16. Хар Адуутан С.Чулуун. “XVII зууны Монголын гадаад ертөнц”: Орос, Манж Чин улсын харилцааны түүх. Түүхийн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл §9. Галдан бошигт ба Оросын элч нарын уулзалт, хууралт.
17. Болд Р. Геополитик ба Монгол. Удирдлагын Академиас хэвлүүлсэн “Нээлттэй лекц: 2016-2017 оны хичээлийн жил”, УБ., 2017 эмхтгэлд хэвлэгдсэн лекц УАК.
18. Гангааням С. “Монголчууд тугаар тогтнолоо хамгаалан тэмцсэн нь” УБ.,1993.т. 71
19. Гадаад Монголын тусгаар тогтнолын нууц Бээжин. 1993.04.10.
20. Бор Ж., Баатар Д. Монголын аюулгүй байдал. УБ.. 2016.
21. Дашбадрах Д. “Манжийн төрөөс Монголын шашны талаар явуулсан бодлого, үр дагавар”. УБ., 2008.
22. Дугарсүрэнгийн Энхцэцэг. Монголын Хутагт хааны учрал... УБ., 2007.
23. Урадын Э.Булаг (Орчуулсан Ч.Мөнхтуул) Миний “ҮНДЭСТЭН” чиний “АСУУДАЛ” Ярилцлагыг хөтөлсөн: Гао Чань, Ван Ниншинь. Эх сурвалж: “Монголын үнэн” сонин,
24. Балжинням Б. “Монголчуудын Бүрэн Түүхийн Товчоон” УБ, 2005, II боть.т. 270
25. Сосорбарам Ч. “Чингис хааны геополитик” УБ., 2012 он.
26. Сосорбарам Ч. “Монголын гадаад орчин дахь Аюулгүй байдлын болзошгүй төсөөллүүд” “Олон улс судлал” сэтгүүл, УБ., 2004.
27. Сосорбарам Ч. “Монголын түүх ба хар хайрцагны бодлогын...”. УБ., 2005.



## ХҮҮХДИЙН СУРАХ ОРЧНЫ ОЙЛГОЛТ, МӨН ЧАНАР, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

**Д.ЦЭВЭЛМАА** /Нийслэлийн Ерөнхий

боловсролын 44-р сургуулийн сургалтын менежер/

**Түлхүүр үг:** Сурах орчин, хүүхдийн аюулгүй байдал, танин мэдэхүйн хөгжил, асаргаа халамж, эрсдэлийн үнэлгээ

**Keywords:** Learning environment, child safety, cognitive development, caring and nurturing environment, risk assessments

### Хураангуй:

Хүүхдийн сурах орчин нь тэдний оюун санаа, танин мэдэхүйн хөгжилд шууд нөлөөтэй, тэдний амьдралын чанар, аюулгүй байдалд чухал үүрэгтэй гэж судалгаанд тэмдэглэжээ. Судлаачид орчныг зөвхөн материаллаг төдийгүй сэтгэл зүйн, нийгмийн нөхцөлтэй уялдуулан авч үзсэн байна. Хүүхдийн хөгжлийн онцлогт тохирсон аюулгүй байдлыг хангахын тулд багш, эцэг эх, нийгмийн оролцоо, хариуцлага зайлшгүй шаардлагатай. Мөн хүүхдийг аюулгүй орчинд өсгөхийн тулд тэдэнд тохирсон мэдлэг, чадварыг эзэмшүүлэх хэрэгтэй. Монголын нөхцөлд, ялангуяа гэр хороолол болон хөдөө орон нутгийн хүүхдүүд илүү эрсдэлтэй орчинд амьдарч байна. Тиймээс гэр бүлийн болон олон нийтийн хамтын оролцоотойгоор хүүхдийн аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ шаардлагатай.

### Abstract:

The study highlights that the learning environment of children has a direct impact on their intellectual and cognitive development, significantly influencing their quality of life and safety. Researchers have examined the environment not just in terms of physical aspects but also in relation to psychological and social factors. It is crucial for teachers, parents, and society to be actively involved and take responsibility to ensure a safe environment that aligns with the developmental needs of children. Moreover, children must acquire appropriate knowledge and skills to thrive in a secure setting. In Mongolia, children residing in ger districts and rural areas are exposed to greater risks, emphasizing the importance of implementing measures to enhance child safety through the engagement of families and communities.

### Үндсэн хэсэг:

“Орчин бол хүний сэтгэцийн үйл хөгжих эх үүсвэр, хөгжлийн гол хөдөлгөгч хүч. Орчин гэдэг нь харьцангуй ойлголт бөгөөд түүний нөлөөлөл нь тухайн хүүхдийн тэрхүү орчинд байсан мэдрэмжээр тодорхойлогдоно” гэж үзжээ.

Сургалтанд «орчин» гэдэг нэр томъёог С.Т.Шацкий «Орчны хүмүүжүүлэх нөлөө», П.П.Блонский «Хүүхдийн нийгмийн орчин» гэж нэрлэсэн. Багшийн зүгээс үзүүлэх нөлөөллийн объект нь хүүхэд ч, түүний зан төлөвийн шинж чанарууд ч биш, харин тэдний оршин амьдарч байгаа гадаад ба дотоод орчин, нөхцөл юм гэж үзжээ.

Хүний хөгжлийн орчны асуудлаар монголын судлаачид Ц.Балхаажав, Г.Гонгоржав, Н.Хавх нарын нилээд эрдэмтдийн бүтээлд дурдсан нь бий. Ц.Балхаажав «Хүнд байгаль нийгэм гэсэн үлэмж том орчин<sup>1</sup>» байдаг.

Энэ хоёр орчныг хүний сайн сайхны болон хөгжил дэвшлийн үүднээс зөвхөн эрдэмтэн мэргэд төдийгүй хэн боловч танин мэдэхийг оролдох хэрэгтэй гэсэн нь хүний хөгжлийн орчныг танин мэдэхийг чухалчилжээ.

Сургалтын орчин гэж Боловсролын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12-д заасан «Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн материаллаг болон сэтгэл зүйн нөхцөл, сурах, сургах харилцааг»

<sup>1</sup> Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, –УБ., 2020:ху 183].



хэлнэ гэжээ.

Сургалтын орчин нь сургалт явуулж буй орчин нөхцөл нь сургалтын чанар, үр өгөөжид нөлөөлдөг нэг гол хүчин зүйл байдаг. Иймд бид дараах шаардлагыг хангасан өөрийн сургалтын анги, танхимд сургалтаа зохион байгуулдаг.

- Олон цагаар хичээллэхэд тохиромжтой, тав тухтай, дулаахан, цэвэр анги, танхимууд

- Танхимын сургалтанд ашиглагддаг орчин үеийн тоног төхөөрөмжүүд (Компьютер, проектор гм)

- ХАБЭА–н сургалт явуулахад ашиглах тусгай тоног, төхөөрмж, үзүүлэх таниулах материалууд

- Суралцагч дараах зүйлсийг мөн төлбөргүй ашиглах боломжтой:

- Номын сангаар үйлчлүүлэх, WiFi, Цэвэр ус гэх мэт.

Хүүхэд хамгааллын бодлогын бүрэлдэхүүн хэсэг болох хүүхдийн аюулгүй байдлыг судлах, бүх нийтийн хүртээл болгох асуудал нийгмийн нэн тэргүүний хэрэгцээ байсаар байна.

1. Жан Пиаже (Jean Piaget): Хүүхдийн аюулгүй байдлыг танин мэдэхүйн хөгжил ба оюун санааны хөгжил талаас нь дараах байдлаас тодорхойлохдоо: Танин мэдэхүйн хөгжил дөрвөн шаттай байдгийг тодорхойлсон ба үүнд Бетон үйл ажиллагааны шат (7–11 нас), Алгебрын шат (12 ба түүнээс дээш нас) гэж тодорхойлсон. Хүүхэд танин мэдэхүйн хөгжлийн шатандаа тохирсон аюулгүй байдлын хэрэгцээтэй байдаг. Үүнтэй холбоотой эрсдэлүүд: Мэдрэхүйн–моторын шатанд (0–2 нас): Зүрх судасны асуудал, биеийн гэмтэл, Урьдчилсан үйл ажиллагааны шатанд (2–7 нас): Химийн бодист хордлого, тоглоомын аюул.

2. Эрик Эриксон (Erik Erikson): Психосоциал хөгжил. Хүний амьдралын туршид хөгжлийн найман үе шат байдаг гэж үзсэн бөгөөд хүүхдийн хөгжилд 0–18 насныхан дөрвөн шат нь онцгой ач холбогдолтой гэж үзсэн. Хичээл зүтгэл эсвэл доогуур үнэлэх (6–12 нас): Найз нөхөдтэй харилцах харилцаа нь хүүхдийн өөрийгөө үнэлэх чадварт нөлөөлдөг.

3. А. Маслоу: Хэрэгцээний онолын

дагуу хүний хэрэгцээний шатлал нь бие махбодын үндсэн хэрэгцээгээс эхэлж, аюулгүй байдал, хайр халамж, хүндэтгэл, өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ рүү улам бүр дээшлэх зарчмаар өрнөдөг.<sup>2</sup> Хүүхдийн аюулгүй байдал нь Маслоуны хэрэгцээний шатлалд аюулгүй байдлын хэрэгцээг хангах түвшинд орно, учир нь хүүхэд өөрийн амь нас, эрүүл мэндээ хамгаалагдсан байгаагаар мэдрэх хэрэгтэй байдаг.



1 дүгээр зураг. Хэрэгцээний шатлал. А. Маслоу

4. Лев Выготский (Lev Vygotsky): Социо–аюулгүй байдлын хөгжил ба бүсчлэлийн онолд “Хүүхдийн суралцах орчин (зохион байгуулалттай тоглоом, багшийн тусламж) хүүхдийн хөгжлийг хурдасгадаг” гэж үзсэн. Онолоос үүдэлтэй **холбоотой эрсдэлүүд:** Багш, эцэг эхийн зүгээс хангалттай харилцаа байхгүй бол сурах үйл явц саардаг. Хүүхдийн бүтээлч үйл ажиллагаа хязгаарлагдах үед хөгжлийн боломжийг алдах эрсдэлтэй гэж үзсэн.

5. Жон Боулби (John Bowlby): Холбоо (attachment) ба сэтгэл зүйн хөгжилдөө хүүхдийн сэтгэл зүйн хөгжилд эцэг эхийн хайр халамж, аюулгүй орчин чухал гэж үзсэн. Эцэг эхтэй холбогдох харилцааны чанар нь хүүхдийн итгэлцэл, нийгэмд дасан зохицох чадварт нөлөөлдөг. Үүнтэй **холбоотой эрсдэлүүд нь** эцэг эхийн

<sup>2</sup> А. Маслоу. Х Хүний сэтгэл судлалын үндэс, William James, УБ, 2010;



оролцоогүй орчинд өссөн хүүхдүүд стресс, сэтгэл зүйн гэмтэлд өртөх магадлалтай.<sup>3</sup>

### 6. Монголоос судалгаа хийсэн эрдэмтэд:

Хүүхдийн аюулгүй байдлын талаар Монгол Улсад болон олон улсад хийгдсэн судалгаанууд нь хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн нөхцөлийг сайжруулахад чиглэсэн олон чухал асуудлыг хөнддөг. Доорх хэд хэдэн чиглэлээр судалгаанууд хийгдсэн байна:

- Цахим орчин дахь аюулгүй байдал: Хүүхдүүдийн цахим орчны хэрэглээ, аюулгүй байдлын талаарх мэдлэг, эцэг эхийн оролцоо, хандлагыг судалж, цахим аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зөвлөмж гаргасан. Судалгааны нэг жишээ нь “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын үндэсний суурь судалгаа” бөгөөд интернет хэрэглээний эерэг хандлагыг төлөвшүүлэхийг зорьсон байдаг<sup>4</sup>).

- Осол гэмтэл болон гэр бүлийн орчинд учрах аюул: Гэмтэл, түлэгдэлт зэрэг ослоос хүүхдийг хамгаалах асуудлыг тусгасан судалгаагаар бага насныхан хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах шаардлагыг онцолсон. Монголд бага насныхан хүүхдийн түлэгдэлтийн шалтгаант нас баралтын ихэнх нь халуун хоол, ундаа, усанд түлэгдэхтэй холбоотой байгааг судалсан байдаг<sup>5</sup>

- Сургуулийн аюулгүй орчин: Хүүхдүүдийн сурах орчныг аюулгүй болгох талаар олон улсын туршлага, сурах арга зүйг хөгжүүлэх чиглэлээр судалгаанууд хийгдэж, багш нарын чадавхыг сайжруулах, хүүхдийг эерэгээр хүмүүжүүлэх арга барилыг дэмжихийг зөвлөсөн байна<sup>6</sup>

- Нийгмийн орчны нөлөө: Агаарын бохирдол, амьдрах орчин, нийгмийн стресс зэрэг нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөг судалсан. Жишээ нь, Улаанбаатарын агаарын бохирдол хүүхдийн

<sup>3</sup> ОУУИС–ийн Гэр Бүл Судлалын тэнхимийн багш

Ө.Байгаль, Б.Нандинцэцэг, Хүүхдийн хөгжлийн хандлагууд, –УБ, 2017;

<sup>4</sup> Харилцаа холбооны зохицуулах хороо, Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаарх үндэсний суурь судалгааны тайлан, 2023

<sup>5</sup> ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолын хавсралт, 4 тал;


<sup>6</sup> UNICEF, ХҮҮХЭД ХАМГААЛАЛЫН ХӨТӨЛБӨР,–УБ, 2023;

амьсгалын замын өвчлөлд ихээхэн нөлөөлдөг гэж үзсэн байдаг<sup>7</sup>

Судалгааны ажлын хүрээнд баримт бичиг судлалын арга, гүнзгийрүүлсэн (эксперт) ярилцлага, фокус бүлгийн хэлэлцүүлэг, түүвэр судалгаа (асуулга), ажиглалт хийх зэрэг судалгааны мэдээлэл цуглуулах аргуудыг хэрэглэсэн бөгөөд мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ чанарын мэдээлэлд ангилал, зураглалыг тоон мэдээлэлд оруулж статистик шинжилгээ хийсэн нь дараах хүснэгтээр харуулав.

1 дүгээр хүснэгт  
Судалгааны түүвэр

№	Аймаг, нийслэл	Материаллаг орчны судалгаа		Эрх судалгаа	
		N=хүүхэд	N=насанд хүрэгчид	N=хүүхэд	N=насанд хүрэгчид
Аймаг орон нутгийн төлөөлөл – 8 аймаг					
1	Архангай	50	40	1	
2	Дархан–Уул	50	50	2	2
3	Баянхонгор	40	50		2
4	Булган	30	50	1	
5	Дундговь	10	50		2
6	Орхон	50	50	1	
7	Сэлэнгэ	40	50	2	2
8	Төв	50	50	2	2
Улаанбаатар хотоос төлөөлөл–5 дүүрэг					
9	Баянзүрх	105	65	1	2
10	Сонгинохайрхан	105	65	2	2
11	Сүхбаатар	50	65	1	2
12	Чингэлтэй	50	65	2	2
13	Налайх	25	20	1	
	Нийт	1025	1000	15	20



2 дугаар зураг. Эрх зүйн орчин ба материаллаг байдал судалгааны мэдээллийг уялдуулсан байдал

Баримт би судлалын арга	Хүүхэд хамгааллын тухай хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль эрх зүйн баримт бичиг, Аюулгүй байдлын талаар эрдэмтэн судлаачдын бүтээл, Хүүхдийн болон аюулгүй байдлын талаар судалгаа шинжилгээний бүтээлүүд болон бусад эх сурвалжуудыг судалсан.
Гүнзгийрүүлсэн ярилцлага	Орон нутгийн олон нийтийн түвшинд 2, нийслэлд 3, нийт 5 удаа ярилцлага зохион байгуулсан.
Фокус бүлгийн хэлэлцүүлэг	Сурах орчин дунд 1, олон нийтийн дунд 5 удаа нийт 6 удаа бүлгийн хэлэлцүүлэг хийсэн.

<sup>7</sup> ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолын хавсралт, 65 тал



Асуулга	“Сурах орчны давуу тал дэмжлэгийг тодорхойлох” болон “Хүүхдийн аюулгүй байдлын талаар иргэдийн ойлголт, хандлага” 2 судалгаагаар мэдээлэл цуглуулсан.
Оролцсон ажиглалт	Хүүхдийн аюулгүй байдлын хүрээнд Хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллын чиглэлээр бүс нутаг, байгууллагын түвшинд уулзалт хэлэлцүүлэг болон сургалт нийт 4 талбарт зохион байгуулсан арга хэмжээнд зөвлөх, модератор, сургагч багшийн үүргээр оролцож ажиглалт хийсэн.

Хүүхдийн аюулгүй байдлыг хангах нь гэр бүлийн болон нийгмийн хариуцлагатай чухал асуудлуудын нэг юм. Энэ нь хүүхдийг осол гэмтэл, эрсдэлээс хамгаалах онолын үндэслэл болон практик үйл ажиллагаануудыг багтаана.

Хүүхдийн хөгжлийн онцлог: Хүүхэд өсөж хөгжих явцдаа өөрийн биеийн болон оюун санааны чадвар, аюулыг мэдрэх мэдрэмжийг хөгжүүлдэг. Мөн насны онцлогоос шалтгаалж эрсдэлд өртөх магадлал өөр байдаг (жишээ нь: бага насны хүүхэд ахуйн осолд өртөх, өсвөр насныхан нийгмийн эрсдэлд өртөх гэх мэт). Хүүхдийн хөгжлийн явцад аюулыг мэдрэх мэдрэмж нь нас, оюун санааны хөгжил, туршлагаас хамаарч өөрчлөгддөг. Энэ нь хүүхдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

2 дугаар хүснэгт. **Хүүхдийн хөгжлийн үе шат ба аюулыг мэдрэх мэдрэмж<sup>8</sup>**

Бага сургуулийн нас (6–12 нас)	Хөгжлийн онцлог	Аюулыг мэдрэх мэдрэмж	Хамгаалалт:
	Биеийн болон сэтгэл санааны хувьд илүү тогтвортой болж, дүрмийг ойлгох чадвар сайжирна. Найз нөхөд, бусдын нөлөөнд автах магадлал өндөр	Зарим аюулыг урьдчилан мэдэрч чадна, гэхдээ эрсдэлийг үнэлэх чадвар хараахан бүрэн хөгжөөгүй. Түргэн шийдвэр гаргах үед алдаа гаргах магадлалтай.	Хүүхдэд тодорхой дүрэм, хязгаарлалт тавих. Осол, аюулын талаар тэдний ойлголтыг гүнзгийрүүлэх.
Өсвөр нас (12–18 нас)	Бие махбодын болон сэтгэл зүйн өөрчлөлт эрчимтэй явагдана. Бие даасан байх хүсэл нэмэгдэж, эрсдэлтэй үйлдэл хийх хандлага гарч болно.	Аюулыг ойлгож мэдрэх чадвар нэмэгдсэн боловч туршлагагүйгээс болж буруу дүгнэлт хийх боломжтой. Бусдын нөлөөнд автах, сонирхол, сэтгэл хөдлөлдөө хэт автдаг.	Хүүхдэд аюулгүй байдлын талаар бие даасан шийдвэр гаргах ур чадварыг хөгжүүлэх. Хамгийн итгэлтэй насанд хүрэгчдийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.

<sup>8</sup> О. Мягмар, Сэтгэл заслын зөвлөгөөний онол арга зүй, 180–р тал, –УБ., 2009;

**Аюулыг мэдрэх мэдрэмжийг хөгжүүлэх арга замууд**

1. **Хүүхдэд тохирсон мэдээлэл өгөх:** Насанд тохирсон, ойлгомжтой жишээ ашиглан аюулын талаар тайлбарлах.

2. **Туршлагаар суралцуулах:** Энгийн аюулгүй орчинд хүүхдийг өөрөө асуудлыг шийдвэрлэх боломж олгох.

3. **Зан төлөвийг зөв чиглүүлэх:** Хүүхдэд эерэг дадал хэвшил бий болгох (жишээ нь: зам хөндлөн гарахдаа дохио тэмдэгийг анхаарах).

4. **Сургалт, тоглоом ашиглах:** Аюулгүй байдлын талаарх хичээл, дүрслэлтэй тоглоомыг ашиглан хүүхдийг суралцуулах.

Хүүхэд эрсдэлийг үнэлэх мэдрэмжийг хөгжүүлэх нь осол гэмтлээс урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга юм. Хүүхдийн аюулгүй байдлыг хангахын тулд амьдралын бүхий л орчинд (гэр, сургууль, нийгэм, цахим орчин гэх мэт) бодит арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүүхдийн аюулгүй байдлын хөгжил нь аюултай нөхцөл байдлаас зугтах, түүнийг гэмтээж, бэртээж болзошгүй эд зүйлсээс зайлсхийх, тойрон гарах гэх мэт хүүхэд өөрөө өөрийнхөө аюулгүй байдлыг хангах чадварууд юм<sup>9</sup>. Түүнчлэн бага насны хүүхдийг аюулгүй орчин нөхцөлд өсгөж хүмүүжүүлэх нь эцэг эх, асран хамгаалагчдын хариу үйлдэлт буюу хүүхдийн хэрэгцээнд тулгуурласан асаргаа халамжийг илэрхийлж байдаг.

“НҮБ–ын Хүүхдийн Сан”–ын захиалгаар “Бага насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын хариу үйлдэлт асаргаа халамж судалгаа” –г 2023 оны 07 дугаар сарын 20 өдрөөс 2024 оны 1 дүгээр сарын 20–ны өдрийг хүртэл судалгаа, Ажиглалтын судалгаанд хамрагдсан айлын орчны аюулгүй байдлыг үнэлэхэд нийт хүүхдүүдийн 15.6 хувь нь аюултай болон маш аюултай орчинд амьдарч, тоглож байна. Тоглох орчны аюулгүй байдал нь хөдөө орон нутагт илүү муу (аюултай) байгаа төдийгүй эцэг эх, асран хамгаалагч нь ажил хийдэг байх, тухайн айл олон хүүхэдтэй байх зэрэг үзүүлэлт нь орчны аюултай байдал нэмэгдэхэд нөлөөлж байна.

Хүүхдийн гэрт хийсэн ажиглалтын үеэр

<sup>9</sup> Бага насны хүүхдийн сургалт, хөгжлийн Бинчмарк, Вашингтон муж, АНУ, 2005;



хүүхдийн тоглох орчны аюулгүй байдлыг 5 онооноос үнэлэхэд 3.38 байгаа бөгөөд орон нутагт (3.23) нийслэлээс бага, 19 хүртэл насны асран хамгаалагчийн (2.33) хувьд бага байна. Харин хүүхдийн тоглоомын чанар, ариутгал, цэвэрлэгээний байдал 3.09 байгаа бөгөөд орон нутагт, боловсролгүй, бага боловсролтой асран хамгаалагчтай, 36-аас дээш сартай хүүхэд, 19-с доош насны асран хамгаалагчтай өрхийн хувьд тус тус доогуур үзүүлэлттэй байна. Тоглоомын чанар, ариутгалд огт анхаардаггүй буюу эвдэрсэн, хуучирч муудсан тоглоомтой, огт цэвэрлэж арчлаагүй, ах, эгчээс нь үе дамжиж ирсэн тоглоом наадгайнуудтай өрхүүд ажиглалтын явцад нэлээд тохиож байна.

Хүүхдийн тоглоомуудыг бүтэн хайрцаг саванд хадгалахын оронд урагдаж муудсан цүнх, цаасан хайрцагт хадгалж орны доогуур тоос шороо ихтэй орчинд хадгалж буй дүр зураг мөн түгээмэл тохиолдож буй нь хүүхдийн тоглоом наадгайн аюулгүй байдал, ариутгал цэвэрлэгээнд анхаарахгүй байх хандлага эцэг эхчүүдийн дунд байгааг илтгэж байна. Цөөн тоотой боловч хүүхдийнхээ тоглоомыг байнга ангилан ялгаж, хуучирч муудсан тохиолдолд хаядаг, хүүхдийнхээ насны онцлогт тохирсон тоглоомыг худалдан авч өгдөг, тоглоомуудыг нь байнга ариутгаж цэвэрлэдэг эцэг эхчүүд байгаа нь сайшаалтай. Түүнчлэн ялангуяа гэрт амьдардаг өрхүүдийн хувьд хүүхэд тоглоход зориулсан тусгай орон зай байдаггүй бөгөөд хүүхэд хаана тоглодгийг асуухад гэрийн хоймор хэсэгт тоглодог гэсэн хариултыг түгээмэл өгч байна. Монголчуудын уламжлалт сууц болох гэрийн хойд хэсэг дэх хүүхдүүдийн тоглох орон зайг ажиглавал ихэвчлэн хивсээр бүрхэгдсэн байх хэдий ч бага насны хүүхэд удаан суух болон хаалга, үүд онгойход гаднаас салхи жавар үлээх зэргээр даарч хөрөх эрсдэлтэй, олон хүн гутлаараа зорчдог зэргээс улбаалж тоос шороо ихтэй, улмаар ариутгал цэвэрлэгээ хангалтгүй байх зай талбай хязгаарлагдмал бусад тавилга эд хогшилд даруулах эрсдэлтэй байж болох юм. Иймд монгол гэрт өсөн торниж буй бага насны хүүхдийн хувьд тоглох орон зай төдийлөн хангалттай биш гэж үзэж болно. Харин нийтийн орон сууц, хувийн байшинд амьдарч буй өрхийн бага насны хүүхдүүдийн тоглох орон зай нь ихэвчлэн аль нэг өрөөний

булан, эсвэл том өрөөний зурагтын өмнөх орчин байна

Хүүхдэд аюулгүй байдлын чадвар олгоход чиглэсэн асаргаа халамжийн дундаж үнэлгээ 3.28, аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн асаргаа халамжийн дундаж үнэлгээ 4.49 байна. Эцэг эх, асран хамгаалагчийн боловсролын түвшин буурахад хүүхдийн аюулгүй байдалд анхаарах, аюулгүй байдлын боловсрол олгох байдал буурч байна. Түүнчлэн эцэг эх, асран хамгаалагч ажил хийдэг байх нь бага насны хүүхдэд аюулгүй байдлын боловсрол олгох байдал буурахад нөлөөлж байгаа төдийгүй тэтгэвэр, группт байдаг эцэг эх, асран хамгаалагчдын энэхүү үзүүлэлтийн үнэлгээ доогуур байна.

Нийт эцэг эх, асран хамгаалагчдын 78.9 хувь нь ямар нэг байдлаар хүүхдээ бага насны хүүхэд эсхүл гэрт нь ганцаар нь үлдээх, сайн танихгүй, харуулах зэрэг арга хэмжээг авч байгаагүй гэжээ. Эцэг эх, асран хамгаалагчдын хувьд сүүлийн нэг сарын хугацаанд 10 хүртэлх насны хүүхдээр бага насны хүүхдээ харуулан үлдээх нь хамгийн түгээмэл байсан бол үүний дараа 6 хүртэлх насны хүүхдээр харуулдаг нөхцөл байдал орж байна. Эцэг эх, асран хамгаалагчдын ярилцлагаас хөдөө орон нутагт илүү байх хандлагатай байгаа бол бага насны хүүхдээ гэрт нь ганцаар үлдээх явдал Улаанбаатар хотод илүү тохиолдож байна.<sup>10</sup>

Хүүхдийн аюулгүй байдлыг хангах нь системтэй, тасралтгүй үйл явц юм. Энэ нь хүүхдийн сэтгэл зүй, бие махбод, нийгмийн орчинд зохицсон бодлого, арга хэмжээг шаарддаг. Хүүхдийг аюулгүй өсгөж хүмүүжүүлэх нь зөвхөн гэр бүл төдийгүй, сургууль, олон нийтийн хамтын хүчин чармайлт юм.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны тушаалаар батлагдсан Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаанд баримтлах чиглэлийн 4 дэх хэсэгт:

• Сургалтын орчны эрүүл, аюулгүй байдлыг сайжруулахад баримтлах чиглэлийг тодорхойлохдоо хичээл, сургалтын үйл ажиллагааг эрүүл, аюулгүй байдал хангасан

<sup>10</sup> "НҮБ-ын Хүүхдийн Сан"-ын захиалгаар "Бага насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын хариу үйлдэлт асаргаа халамж судалгаа", 74-76-р тал, -УБ, 2024;



анги, танхим, лабораторид зохион байгуулах;

- “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал” ерөнхий шаардлага, “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын орчин, үйлчилгээ” ерөнхий шаардлагын хэрэгжилтэд үнэлгээ хийж, шаардлагатай арга хэмжээ авах;

- Энэ арга хэмжээг нутгийн захиргаа, сургууль, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоог хангах;

- Сургалтын орчны аюулгүй байдалд тодорхой давтамжтай үзлэг, шалгалт хийхээр төлөвлөх, хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авах;

- Сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, бодис урвалж, хэрэглэгдэхүүний хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах;

- Сургалтын ажлын явцад хийгдэх лаборатори, дадлага ажил, семинар, аялал, туршилт хийх явцад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, аливаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх;

- Сургуульд сэтгэл зүйн таатай орчин, эерэг уур амьсгал бүрдүүлэх, харилцааны зөв дадал хэвшил төлөвшүүлэхэд удирдлага, багш ажилтны үлгэр дуурайлал, манлайллыг эрхэмлэх тухай тус тус тусгасан.

### **Дүгнэлт**

Хүүхдийн сурах болон өсөж хөгжих орчин нь зөвхөн физик орчин биш бөгөөд сэтгэл зүй, нийгэм соёлын хүчин зүйлсийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт юм. Энэхүү өгүүлэлд хүүхдийн хөгжлийн онолуудыг үндэслэн орчны нөлөөлөл, түүний чанарын тухай гүнзгий тусгасан байна. Сурах орчин нь тухайн хүүхдийн хөгжлийг хурдасгах, эсвэл сааруулах үндсэн

хүчин зүйл болдог тул боловсролын бодлого, сургалтын орчны төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтад онцгой анхаарах шаардлагатай. Жишээлбэл, Лев Выготский, Жан Пиаже, Эрик Эриксон зэрэг сэтгэл судлаачдын онолд орчны зохион байгуулалт нь хүүхдийн бүтээлч чадвар, сурах идэвхэд хүчтэй нөлөөлдөг болохыг тодорхойлсон байдаг.

Монгол Улсад хийсэн судалгаагаар бага насны хүүхдүүдийн аюулгүй байдал, орчны нөхцөл, эцэг эхийн хандлага нь хүүхдийн хөгжлийн орчинтой нягт холбоотой болохыг харуулсан. Тухайлбал, гэр хороололд амьдарч буй бага насны хүүхдүүдийн тоглох орон зай нь хангалтгүй, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл хангалтгүй байдгаас хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн тоглоомын чанар, хадгалалтын байдал, орчны цэвэрлэгээ зэрэг нь асран хамгаалагчдын боловсрол, ажлын байдал, нийгмийн нөхцөлөөс хамааран ялгаатай байгааг тогтоожээ.

Хүүхдийн аюулгүй байдлыг сайжруулахын тулд зөвхөн хууль тогтоомж, стандартуудыг мөрдөхөөс гадна эцэг эх, багш, орон нутгийн байгууллагуудын хамтын оролцоо, хяналт, сургалт, хандлагын өөрчлөлт шаардлагатай. Хүүхэд насандаа аюулгүй, тайван орчинд өссөнөөр өөртөө итгэлтэй, эерэг харилцаатай, бие даах чадвартай иргэн болон төлөвших боломжтой. Тиймээс хүүхдийн аюулгүй байдал бол ганц гэр бүлийн бус, нийт нийгмийн үүрэг, хариуцлага юм. Боловсролын байгууллага, олон нийт, төр засаг хамтран ажилласнаар хүүхдийн хөгжлийг дэмжсэн, аюулгүй, таатай орчныг бүрдүүлэх бүрэн боломжтой.

## Ашигласан материал:

1. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, -УБ., 2020;ху 183].
2. А. Маслоу. Х Хүний сэтгэл судлалын үндэс, William James, УБ, 2010;
3. ОУУИС-ийн Гэр Бүл Судлалын тэнхимийн багш Ө.Байгаль, Б.Нандинцэцэг, Хүүхдийн хөгжлийн хандлагууд, -УБ, 2017;
4. Харилцаа холбооны зохицуулах хороо, Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаарх үндэсний суурь судалгааны тайлан, 2023;
5. ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолын хавсралт, 4 тал;
6. UNICEF, ХҮҮХЭД ХАМГААЛАЛЫН ХӨТӨЛБӨР,-УБ, 2023;
7. ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолын хавсралт, 65 тал
8. О. Мягмар, Сэтгэл заслын зөвлөгөөний онол арга зүй, 180-р тал , -УБ., 2009;
9. Бага насны хүүхдийн сургалт, хөгжлийн Бинчмарк, Вашингтон муж, АНУ, 2005;
10. “НҮБ-ын Хүүхдийн Сан”-ын захиалгаар “Бага насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын хариу үйлдэлт асаргаа халамж судалгаа”, 74-76-р тал, -УБ, 2024;

## References

1. National Security Concept of Mongolia. Ulaanbaatar, 2020; p. 183.
2. A. Maslow. Foundations of Human Psychology, William James Publishing, Ulaanbaatar, 2010.
3. O. Baigal, B. Nandintsetseg – Lecturers at the Department of Family Studies, International University of Ulaanbaatar. Trends in Child Development, Ulaanbaatar, 2017.
4. Communications Regulatory Commission. National Baseline Study Report on Child Safety in the Digital Environment, 2023.
5. National Program on Child Development and Protection, Annex to Government Resolution No. 270 of 2017, p. 4.
6. UNICEF. Child Protection Program, Ulaanbaatar, 2023.
7. National Program on Child Development and Protection, Annex to Government Resolution No. 270 of 2017, p. 65.
8. O. Myagmar. Theory and Methodology of Psychological Counseling, p. 180. Ulaanbaatar, 2009.
9. Early Learning and Development Benchmarks, State of Washington, USA, 2005.
10. Responsive Parenting and Caregiving for Young Children – A Study Commissioned by UNICEF, pp. 74–76, Ulaanbaatar, 2024.



## ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОЙЛГОЛТ, МӨН ЧАНАР

**Д.ЦЭВЭЛМАА** /Нийслэлийн Ерөнхий

боловсролын 44-р сургуулийн сургалтын менежер/

**Түлхүүр үг:** Хүний аюулгүй байдал, нэр төр, эрх чөлөө, эрсдэл, хөгжлийн үзэл баримтлал, хүүхдийн аюулгүй байдал, байгалийн гамшиг, нийгмийн хамгаалал

**Keywords:** Human security, Dignity, Freedom, Risk, Development paradigm, Child security, Natural disaster, Social protection

### Хураангуй:

Энэхүү илтгэлд хүний аюулгүй байдлын ойлголт, мөн чанарыг онолын үндэслэл, түүхэн хөгжил, олон талт хэрэглээний хүрээнд авч үзсэн. Хүний аюулгүй байдал нь уламжлалт улс төвтэй аюулгүй байдлын үзэл баримтлалаас илүү өргөн хүрээтэй бөгөөд хувь хүнийг ядуурал, өлсгөлөн, өвчин, хүчирхийлэл, байгаль орчны эрсдэл зэрэг архаг аюулаас хамгаалахыг зорьдог. Уг ойлголт нь хүний эрх, нэр төр, эдийн засаг, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, боловсрол зэрэг олон салбарыг хамардаг цогц ойлголт юм. Хүний аюулгүй байдалд заналхийлж болох аюулыг физик, биологийн, нийгмийн тогтолцооны гэсэн гурван үндсэн ангилалд хуваан үзэж, тэр дундаа байгалийн гамшиг, халдварт өвчин, ядуурал, ялгаварлан гадуурхалт зэрэг нь хүний амь нас, амьдралын чанар, нэр төрд хэрхэн нөлөөлж буйг тайлбарласан. Хүн төвтэй хөгжлийг дэмжих, хүний эрхийг хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс суурь болохыг онцолсон. Мөн хүүхдийн аюулгүй байдлыг тусгайлан авч үзсэн бөгөөд энэ нь хувь хүний аюулгүй байдалтай салшгүй холбоотой бөгөөд боловсрол, сэтгэл зүй, эрүүл мэнд, нийгмийн орчин зэрэг олон чиглэлд хамгаалал шаарддаг болохыг тодруулсан. Хүний аюулгүй байдлыг хангахад төр, олон улсын байгууллага, иргэний нийгэм, хувь хүний оролцоо чухал болохыг дүгнэсэн болно.

### Abstract:

This paper examines the concept and essence of human security through its theoretical foundations, historical development, and multifaceted applications. Human security goes beyond the traditional state-centered notion of security by aiming to protect individuals from chronic threats such as poverty, hunger,

disease, violence, and environmental risks. It is a comprehensive concept that encompasses various sectors including human rights, dignity, the economy, health, environment, and education.

Threats to human security are categorized into three main groups: physical, biological, and socio-systemic. This study elaborates on how natural disasters, infectious diseases, poverty, and discrimination impact human life, quality of living, and dignity. It emphasizes that supporting human-centered development and protecting human rights are fundamental to ensuring human security.

The paper also highlights child security as an inseparable part of individual security, pointing out the need for protection in areas such as education, psychological well-being, health, and social environment. It concludes that the protection and promotion of human security require the active participation of the state, international organizations, civil society, and individuals.

### Үндсэн хэсэг:

Хүний аюулгүй байдлыг хангахад сурах орчны үзүүлэх нөлөөллийн онол, практикийн асуудлуудыг үзэхдээ, аюулгүй байдал, хүн, сурах орчин хэмээх ойлголтуудын талаар тодорхойлолтуудыг авч үзэх нь сэдвийг судлахад чухал ач холбогдолтой байх болно.

Аюулгүй байдлын ухааны нэг чухал асуудал нь хүний аюулгүй байдал билээ.

Аюулгүй байдлын талаар толь бичиг, эрдэмтэн судлаачдын өгсөн олон тодорхойлолт байдаг.

Монгол хэлний тайлбар тольд “Аюулгүй байдал гэдэг нь аюул байхгүй, айж эмээх сандрах түгшүүргүй гэсэн утгатай бол аюулгүй байдал гэдэг нь осол түгшүүргүй байх төлөв” гэжээ

Аюулгүй байдлыг аюул ба заналаас найдвартай хамгаалагдсан байдал гэж үзэж



тодорхойлолтыг хэрэглэдэг. Энэ тодорхойлолт нь тодорхой хэмжээний аюул, аюул заналыг зайлшгүй хүлээн авахаас өөр аргагүй байдгийг тодруулж өгөхийн зэрэгцээ объектийг хамгаалах шаардлагатай гэдэг утгыг илэрхийлж байна. Эхний тохиолдох аюулуудаас хамгаалах боломжтой нөхцөл байдал буй болсон бол (объектыг) хамгаалах арга хэмжээг дахин зохион байгуулах шаардлагагүй байж болно.

Аюулгүй байдал гэдэг нь хүний амьдралын чухал ашиг сонирхолд хүлцэлгүй хор уршиг (хохирол) учруулах (чадвар) хор нөлөөтэй аюул болон аюул занал байхгүй байгаа нөхцөл байдал юм.

Аюулгүй байдал нь хүн, байгууллага, нийгэм, улс орон болон хүрээлэн буй орчин гаднын эрсдэл, аюулын хор хөнөөлөөс хамгаалагдсан байгааг илэрхийлдэг. Энэ нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, мэдээллийн аюулгүй байдал болон бүхий л төрлийн сайн сайхан нөхцөлийг хангах боломжийг бүрдүүлнэ.<sup>1</sup>

Хүн гэдэг нь хөхтний анги, приматын баг, гоминидын овогт багтах *Homo sapiens* (лат.: "ухаант хүн") зүйлийн амьтан юм<sup>2,3</sup>.

Монгол хэлний их тайлбар тольд, хүн гэдгийг "Багаж зэвсгийг бүтээж түүнийгээ нийгмийн хөдөлмөрийн үйл ажиллагаанд хэрэглэж чаддаг, хэл, сэтгэхүйг эзэмшин амьдрагч дээд хөхтөн<sup>4</sup> гэж тодорхойлсон байна.

Дэлхий дээр оршин буй бусад амьд организмтай харьцуулахад хүн нь маш өндөр хөгжсөн тархитай бөгөөд ярих, сэтгэх, өөрийгөө шинжих чадвартай болно.

Бүх хүмүүст нийтлэг байдаг түгээмэл шинж чанар, авьяас чадварыг тодорхойлож байдаг хамгийн ерөнхий ойлголт байна. *Homo sapiens* хэмээх төрөл зүйлийг амьдралын үйл ажиллагааныхаа аргаар бусад бүхий л амьтдаас ялгагдаж байдаг хүн төрөлхтөн хэмээх

<sup>1</sup> Япон улсын Үндэсний батлан хамгаалахын академийн багш нарын хамтарсан бүтээл, Аюулгүй байдлын тулгуур асуудлууд, 24-р тал, 2017;

<sup>2</sup> Goodman M, Tagle D, Fitch D, Bailey W, Czelusniak J, Koop B, Benson P, Slightom J (1990). "Primate evolution at the DNA level and a classification of hominoids". *J Mol Evol.* **30** (3): 260–6. [PMID 2109087](https://pubmed.ncbi.nlm.nih.gov/2109087/).

<sup>3</sup> "[Hominidae Classification](https://www.zoology.umd.edu/hominidae/)". *Animal Diversity Web @ UMich*. *Татаж авсан*. 2006–09–25.

<sup>4</sup> <https://mongoltoli.mn/>

тодорхойлолтыг илэрхийлнэ.

Хүний түүхийн эхэн үед хүмүүс нь ус болон бусад төрлийн байгалийн баялаг (газар тарилан эрхэлж болохуйц тал, ан гөрөөгөөр баялаг ой гэх мэт), уур амьсгалын нөхцөлөөс ихээхэн хамаарч байжээ.

Хүмүүс хүрээлэн буй байгаль орчиндоо ихээхэн хэмжээгээр нөлөөлж байна.

Хүн байгалийн зүй тогтлоор төрж өсдөг учраас байгалийн амьтан мөн боловч оюун санаа сэтгэхүйн өндөр хөгжилтэй нийт олноороо амьдарч оюун ухааныхаа хүчээр хамтран хөдөлмөрлөж нийгэмшин амьдардаг болохоор нийгмийн амьтан билээ.

Нийгмийн амьдрал нь бие хүмүүсийн оролцоо идэвхтэй үйл ажиллагаанаас ихээхэн шалтгаалдаг. Иргэдийн хөгжлийн түвшингөөр нийгмийн хөгжлийн түвшин тодорхойлогдож байдаг. Иймд иргэнийг хөгжүүлэхэд нийгмийн хэрэгцээ байнга өндөр шаардлага тавьж өндөр боловсролтой, мэргэжилтэй, эрүүл саруул иргэд л нийгэмд тодорхой үүрэг гүйцэтгэдэг учраас тухайн нийгмийг удирдаж байгаа төр засгаас энэ талаар байнга анхаарч ихээхэн хүч хөрөнгө зарж тодорхой бодлого явуулж байдаг билээ. Үүний нэг тодорхой илрэл нь бүх нийтийг суурь боловсролтой болгох, улмаар бүрэн дунд боловсролтой болгох, 12 жилийн сургалтын тогтолцоотой болгох, 6 наснаас эхлэн сургах, бага насны хүүхдүүдэд сургууль дээр үдийн цай гээд л өч төчнөөн зүйлийг дурьдаж болно.

Харин төр нийгмээс тавьж байгаа шаардлагыг биелүүлж нийгэмдээ тодорхой үүрэг гүйцэтгэх нь иргэн бүрийн зайлшгүй биелүүлэх нь эрхэм зорилго байдаг. Хүн бүр өөрт ноогдсон үүргээ бусдаас дооргүй биелүүлснээр нийгмийн үүрэг хэрэгждэг

Нэгдсэн үндэсний байгууллагын 1994 оны Хүний хөгжлийн (НҮБХХ) тайланд анх удаа хүний аюулгүй байдлын тодорхойлолт тусгагдсаж, хүний аюулгүй байдлыг "айдас, амьжиргааны наад захын хомсдолоос ангижрах гэсэн хоёр үндсэн эрхийг хангах явдал" гэж тодорхойлсон бөгөөд «Байгаль орчны аюулгүй байдал» нь хүний аюулгүй байдлын тодорхойлолтын үндсэн бүрэлдэхүүн хэсэг гэж онцлон тэмдэглэсэн байдаг<sup>5</sup>. Үүнээс хойш энэ ойлголт олон улсад эрчимтэй гарч

<sup>5</sup> Human development report, UNDP, 1994

ирж, 2001 онд “Хүний аюулгүй байдлын комисс” байгуулагдсан байна. Садако Огата, Амартья Сен нарын хамтран удирдсан “Хүний аюулгүй байдлын комисс” 2003 онд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад “Хүний аюулгүй байдлын одоогийн байдал” сэдэвт тайлан өргөн барьсан байна. Уг тайланд хүний аюулгүй байдлыг «хүний эрх чөлөө, сэтгэл ханамжийг дээшлүүлэх арга замаар хүний амьдралын амин чухал цөмийг хамгаалах» хэмээн тодорхойлжээ.

“Хүний аюулгүй байдал” нь дэлхий нийтийн энх тайван, хөгжил ба дипломат үзэл баримтлалын асуудалд томоохон орон зай эзэлдэг сэдэв хэдий ч ойлголтын тодорхой бус байдлаас шалтгаалан ихэндээ олон шүүмжлэл дагуулдаг. НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2012 онд Хүний аюулгүй байдлын тухай нийтлэг ойлголтод хүрч, 9-р сарын сарын 10-нд батлагдсан НҮБ-ын А/RES/66/290-р тогтоолдоо хүний аюулгүй байдлыг “хүний эрх чөлөөтэй, нэр төртэй, ядуурал болон айдсаас ангид амьдрах эрх” хэмээн илүү өргөн хүрээгээр тодорхойлсон байна.

Энэхүү баримт бичиг нь хүний аюулгүй байдалд учрах аюул заналын төрлийг бие мах бодийн, амьжиргааны болон нийгмийн тогтолцооны гэж ангилан тэдгээрийн учир шалтгаан, даван туулах хэрэгсэл, хүний аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага зэрэг хүний аюулгүй байдлын гол асуудлуудыг салбар хоорондын харилцан уялдааг чухалчилж, онолын хүрээнд системтэйгээр тусгасан байна. Аюул заналхийллийн эх үүсвэрийг бие мах бодын, амьжиргааны, нийгмийн тогтолцооны гэж гурван ангилсан нь (1) физик ба химийн шинжлэх ухаан дээр үндэслэгдсэн инженерчлэл, (2) экологий ба биологийн шинжлэх ухаан, (3) нийгмийн шинжлэх гэсэх эрдэм шинжилгээний гурван чиглэлийн судалгааны объектуудтай тохирч байна.

Хүний аюулгүй байдалд заналхийлэх аюул нь хүний бие махбодь, биологи, нийгмийн тал дээр нөлөөлдөг тул хүний аюулгүй байдлын онол нь янз бүрийн системүүдийн харилцан үйлчлэлийг судлах ёстой гэж үздэг.

Хүний эрхийн тухай баримт бичиг нь хүний аюулгүй байдал ба хүний хөгжлийн хүрээнд

боловсруулсан бодлого ямар эрхийг хамгаалж, дэмжих ёстойг зааж өгдөг.

Хүний аюулгүй байдлын комиссын (2003) онцлон тэмдэглэсэнээр хүний аюулгүй байдлын үзэл баримтлал нь хүний амьдралд учирч болох “сөрөг эрсдэлүүд”-д анхаарал хандууллага бол хүний хөгжлийн үзэл баримтлал нь хүний чадавхийг улам өргөжүүлэхэд чиглэгддэг тул хүний аюулгүй байдлыг хүний хөгжлөөс ялгаж авч үзэх нь түгээмэл байдаг гэжээ. Хүний эрхийн олон асуудал эрсдэл болон боломжуудтай тулгардаг тул хүний аюулгүй байдал ба хүний хөгжил аль алиныг нь ямар үндсэн эрхийг хамгаалж, дэмжиж байгаас хамаарч өргөн утгаар эсвэл явцуу байдлаар тодорхойлогдож болно.

НҮБХХ (1994) хүний аюулгүй байдлын зорилго нь айдас, хомсдолоос ангижрах гэсэн хоёр үндсэн эрхийг хангах явдал гэж үздэг. Хүний аюулгүй байдлын комисс (2003) хүний аюулгүй байдлыг тодорхойлохдоо «хүний эрх чөлөө, хүний сэтгэл ханамжийг дээшлүүлэх арга замаар хүний амьдралын амин чухал цөмийг хамгаалах» гэсэн тодорхойлолт нь «хүний нэр төр»-ийн тухай багтааснаараа НҮБХХ-ийн (1994) тодорхойлолтоос илүү өргөн хүрээтэй болсон юм<sup>6</sup>.

НҮБ-ын А/RES/66/290 тогтоолд НҮБХХ (1994) болон Хүний эрхмийн комисс (2003)-аас хойш үзэл баримтлалын хөгжлийн шугамыг голчлон баталж, хүний аюулгүй байдлыг «хүний эрх чөлөөтэй, нэр төртэй амьдрах эрх, ядуурал ба айдсаас ангид байх» гэж тодорхойлсон байдаг.

Хүний аюулгүй байдал, хүний хөгжил хоёр хоорондоо нягт холбоотой байдаг нь ойлгомжтой. Хүний хөгжил нь үндсэн эрх, тухайлбал боловсрол эзэмших эрх, эрүүл байх эрх, амьжиргааны зохистой түвшинд байх эрх болон бусад эрхээ эдлэх боломжийг олгодог бол айдас, хомсдолоос ангид байх нь хүний хөгжлийн зайлшгүй нөхцөл болж өгдөг<sup>7</sup>. Хүний аюулгүй байдал бол хүний хөгжлийн

<sup>6</sup> For various definitions of Human Security, see Tadjbakhsh and Chenoy (2007).

<sup>7</sup> The Human Development Index, used by the UNDP, is a composite measure of education, life expectancy, and per capita income, roughly corresponding to the basic rights to education, health, and standard of living.



үндэс суурь юм. Нөгөөтэйгүүр хувь хүнийг чадавхижуулах, тэдний чадавхийг хөгжүүлэх нь хүний аюулгүй байдлыг нэмэгдүүлдэг. Хүний хөгжил нь хүний аюулгүй байдлыг бэхжүүлдэг. Тиймээс хүний аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхдээ хүн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийг орхигдуулж болохгүй.

### **Хүний аюулгүй байдалд учирч болох аюул заналууд**

Нэгдүгээрт, хүний аюулгүй байдалд заналхийлж болох аюул заналыг “Хүний аюулгүй байдлын комисс, 2003”-д заасан хүний аюулгүй байдлын тодорхойлолтод үндэслэн энгийнээр: амь насанд, сайн сайхан амьдрал, нэр төрд заналхийлэх аюул гэж ангилж болно. Эдгээр аюул заналуудыг эх үүсвэрт нь тулгуурлан физик системийн, биологийн системийн, нийгмийн тогтолцооны аюул гэж дахин ангилна.

Амь насанд заналхийлэх аюулын эхний төрөл нь физик системээс үүссэн буюу ихэвчлэн газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт, цунами, үер, далайн шуурга, хүчтэй цасан болн шороон шуурга, хар салхи, ойн түймэр зэрэг байгалийн гамшиг байдаг. Амь насанд заналхийлэх хоёр дахь төрлийн аюулд биологийн системээс үүдэлтэй цар тахал, орон нутгийн чанартай халдварт өвчин, өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдал, экологийн гамшиг зэрэг орно. Харин хүний амь насанд заналхийлэх гурав дахь төрлийн аюул нь санаатай болон санаатай бус хүчирхийлэл (гэр бүлийн хүчирхийлэл, аллага, хүчингийн хэрэг, терроризм, үймээн самуун, эмх замбараагүй байдал, иргэний дайн, осол гэх мэт), нүүлгэн шилжүүлэлт (дүрвэгсэд), амьдралын хэв маяг өөрчлөгдөх, эрүүл мэндийн байгууллагуудын хангалтгүй байдал гэх мэт нийгмийн тогтолцооноос үүсдэг.

Хүний санаатай болон санамсаргүй зарим үйлдэл нь физикийн болон биологийн системийн механизмаар дамжуулан хүнд хор хөнөөл учруулдаг байна. Жишээ нь гэхэд Япон улсад Минамата хотын нэгэн том үйлдвэрээс Минаматагийн буланд мөнгөн усаар бохирдсон усыг гадагшлуулсанаас мөнгөн усны хордлого болох Минамата өвчин үүдсэн байдаг.

Хүний сайн сайхан амьдралд заналхийлж буй заналхийллийг мөн адил гурван төрөлд хувааж болно. Эхний төрөлд амь насанд

нөлөөлдөг физик үзэгдлүүд, түүнчлэн амь насанд шууд заналхийлдэггүй ч эдийн засгийн ноцтой үр дагавартай бусад үзэгдлүүд, тухайлбал онц хүчтэй биш боловч өргөн газар нутаг хамарсан үер, газар доорх усны түвшин буурах, байгалийн гамшгаас үүдэлтэй тусгаарлалт зэрэг орно. Үүний нэгэн адил хоёр дахь төрөл нь биологийн системээс гаралтай аюулыг агуулдаг.

Амь насанд нөлөөлж буй аюул занал нь сайн сайхан амьдралд ч мөн аюул учруулдаг бөгөөд ургац алдах, ойн хомсдол, шавж ихсэх зэрэг амь насанд шууд заналхийлдэггүй олон үзэгдлийг энэ төрөлд хамруулах шаардлагатай. Сайн сайхан амьдралд нийгмийн системээс заналхийлж буй аюулд зөвхөн амь наснд учирах аюул төдийгүй засгийн газрын дорой байдал (өөрөөр хэлбэл янз бүрийн түвшний алдаатай бодлого), зах зээлийн доголдол (жишээлбэл, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, санхүүгийн системийн эвдрэл гэх мэт), ядуурал (зохион байгуулалт болон дэд бүтцийн хангалтгүй байдал, ялгаварлан гадуурхах нийгмийн бүтэц) эрэг үзэгдлүүд багтдаг.

Хүний аюулгүй байдалд заналхийлж буй аюулын гурав дахь ангилал нь нэр төрд заналхийлэх аюул юм. Энэ нь онолын хувьд мөн л энэ физик системээс, биологийн системээс, нийгмийн системээс гэсэн гурван төрлийг агуулна. Нэр төр гэдэг нь үндсэндээ нийгмийн ойлголт учраас нэр төрд заналхийлж буй асуудлыг авч үзэхэд нийгмийн системийн аюул занал маш чухал байдаг. Үүнд санаатай/илэрхий ялгаварлан гадуурхах/дарамтлах, санамсаргүй /далд ялгаварлан гадуурхах, нийгэмд эдийн болон эдийн бус баялгаар хомсдох зэрэг хамаарч болно. Мөн нөгөөтэйгүүр физик систем болон биологийн системд үүссэн аюулууд, ялангуяа тэдгээр нь нийгмийн системийн аюултай хавсах үед хүний нэр төрд нөлөөлөх тохиолдол байдаг. Тухайлбал, халдварт өвчин туссан хүмүүс, ялангуяа тэдний халдвар авсан шалтгаан тодорхойгүйн улмаас гадуурхагддаг бол байгалийн гамшгаас амьд үлдсэн хүмүүс ихэвчлэн гэр бүл, найз нөхдөө алдсан дурсамжаас болж ихээхэн цочирддог.

Дэлхийн түвшинд геологи, газарзүй, цаг уур, биологи болон нийгмийн тогтолцооны хоорондын хамаарал улам нарийн төвөгтэй

болж, энэхүү харилцан хамаарлаас үүдэн шинээр гарч ирж буй аюул заналыг даван туулахад нэг улсын нэг талыг баримтлалсан явцуу арга хэмжээ хангалтгүй болсон энэ 21-р зууны дэлхийн тогтолцоонд хүний аюулгүй байдал гэдэг ойлголт маш чухал юм. Хүний аюулгүй байдлыг хангахад төр чухал боловч улс орнуудын чадавхид хязгаар байдаг бөгөөд зарим нь маш эмзэг байдаг тул хүний аюулгүй байдалд шаардлагатай олон элементийг хангаж чадахгүй. Зарим өндөр орлоготой орнуудад ч гэсэн хүний аюулгүй байдлыг хангахад буурай орнуудтай ижил хэмжээгээр биш ч гэсэн хүндрэл тулгардаг байна. Хүний аюулгүй байдлыг хангахад олон улсын болон дэлхийн хамтын ажиллагаа шаардлагатай бөгөөд бүх оролцогч талуудыг дайчлах ёстой байдаг байна. Энэ бүхэн бидэнд аюул заналын шалтгаан, тэдгээрийн харилцан үйлчлэл, аюул заналыг даван туулахад туслах хэрэгслүүдийн талаар бид ихээхэн мэдлэггүй байгааг ойлгуулж байна. Хүний аюулгүй байдлын талаарх мэдлэгээ нэмэгдүүлэхийн тулд онолын тодорхой, ойлгомжтой байдал чухал бөгөөд илүү эмпирик судалгаа хийх шаардлагатай байна.

### **Байгалийн гамшиг ба хүний аюулгүй байдал**

“Гамшиг” гэдэг үг үргэлж цаанаа «хүний аюулгүй байдал» гэх утгыг давхар агуулж байдаг. Байгалийн гамшиг гэдэг бол дан ганц байгалийн үзэгдэл биш, хүний амьдрах нөхцөл, нийгмийн тухай асуудал байдаг.

Хувь хүн болон нийгмийн аюулгүй байдалд заналхийлж байдаг байгалийн гамшигт үзэгдлийг урт хугацааны өмнөөс бүрэн урьдчилан илрүүлэх, аюулгүй байдлын бүрэн бэлтгэл хангахад хүндрэлтэй байдаг. Байгалийн гамшиг нь хүний амь насанд шууд заналхийлэх, хэвийн амьдралын тулгуур болох эдийн засаг, нийгмийн суурийг сүйтгэх, гамшигт өртөж амьд үлдэгсэд болон тэдний гэр бүл найз нөхөд бэртэх зэргээр хүн төрөлхтний аюулгүй байдалд заналхийлж буй томоохон аюул юм.

Байгалийн гамшигт өртөмтгий бүс нутагт хүний аюулгүй байдлыг хангахад гамшгийн эрсдэлийг бууруулах тогтолцоо зайлшгүй шаардлагатай юм. Хүний амь нас, амьжиргаа, эрүүл мэнд, эдийн засаг, мөн хувь хүн, байгууллага, нийгэмлэг ба улс орны биет

болон биет бус өв хөрөнгөд учирч болзошгүй гамшгийн эрсдэл, хохирлыг жинтэй бууруулах нь “Гамшгийн эрсдлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015–2030”-ний хүлээгдэж буй үр дүн юм. Цогц арга хэмжээ хэрэгжүүлэх замаар шинээр буй болох гамшгаас урьдчилан сэргийлэх, одоо байгаа гамшигт өртөмтгий байдлыг бууруулах, гамшгийн эсрэг хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх, бэлэн байдлыг нэмэгдүүлэх, тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх нь “Гамшгийн эрсдлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015–2030”-ын гол зорилго байдаг. “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын Үзэл Баримтлалд” хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн гэж заасан байдаг<sup>8</sup>.

Байгалийн аюул гэдэг нь хүн болон хүний нийгэмд сөргөөр нөлөөлөх боломжтой байгалийн физик үзэгдэл юм. Харин байгалийн гамшиг гэдэг бол бодитойгоор хүн төрөлхтөнд болон хүний нийгэмд ихээхэн хохирол учруулсан байгалийн аюулыг хэлнэ. Байгаль, цаг уурын гамшгийн дараа хүмүүсийн амьдралын түвшингээ хэвийн болгохын төлөө тэмцэж буй байдал нь дайн, зэвсэгт мөргөлдөөн зэрэг хүнээс үүдэлтэй гамшгийн дараах байдалтай төстэй байдаг байна<sup>9</sup>. Иргэд цаг уурын гамшигт өртөж амь насаа алдсан, бэртэж гэмтсэн, гэр оронгүй болсон тохиолдлын ихэнх нь ган зуд биш, гэнэтийн чанартай цаг агаарын аюул болох хүчтэй салхи шуурга, үер, аянга цахилгаан, их хуртунадас зэргээс болсон байдаг.

Байгаийн гамшгийн үед хүний аюулгүй байдлыг хангахад дараах 5 зүйлийг чухалчилан авч үздэг:

1. Нэгдмэл арга хэмжээ авах: байгалийн тогтолцоо ба нийгмийн зохион байгуулалтын харилцан үйлчлэлийг цогц байдлаар авч үзэх, байгалийн аюулыг даван туулахад шинжлэх ухаан, инженерийн дэвшилээс гадна хүний аюулгүй байдлын асуудлуудыг анхаарах,

2. Нийгмийн нөхцөлд анхаарах: Тухайн

<sup>8</sup> Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын Үзэл Баримтлал

<sup>9</sup> Towards a Fourth Pillar of Human Security: “Freedom from Hazard Impacts “Addressing Global Environmental Change, Environmental Stress and Natural Hazards



нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан байгалийн аюул нь байгалийн гамшиг болж хувирдаг. Тиймээс хүний аюулгүй байдлыг хангахад зөвхөн хатуу дэд бүтэцэд төдийгүй хариу арга хэмжээ авах, дасан зохицох чадвар бүхий нийгмийн тогтолцоог бүрдүүлэх зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийхэд ахнаарах,

3. Тайвширч болохгүй: Ямар ч төрлийн гамшиг тохиолдож болох тул байж болох хамгийн муу тохиолдолыг төлөвлөлтийн явцад орхигдуулагүй байх,

4. Хамгийн эмзэг бүлгийн хэрэгцээ: Гамшигт нэрвэгдсэн бүс нутгийн хамгийн эмзэг бүлгийн хэрэгцээг хүн рүү чиглэсэн, бодит байдлаар тодорхойлох,

5. Амьд үлдэгсдийн аюулгүй байдал: Амьд үлдэгсэд цаашид гамшгийн дараах нийгмийн эмх замбараагүй байдалд өртөж болзошгүй байдаг тул хохирогчдыг бүх төрлийн хүчирхийллээс хамгаалах, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрүүд хэрэгжүүлэх зэрэг юм.

Гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагаанууд бүгд хүний аюулгүй байдлын асуудлуутай холбоотой байдаг. Энэхүү холбоогамшгийн эрсдлийг бууруулахад чиглэгдсэн бодлого, үйл ажиллагаануудад илүү тодорхой тусгаснаар бид гамшигт хамгийн эмзэг бүлгийг үлдээлгүйгээр гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг илүү сайн төлөвлөж, бэлтгэх боломжтой болно. Хүний аюулгүй байдлын тухай ойлголт нь хүн амын хамгийн эмзэг хэсгийн хэрэгцээ, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настнуудыг хамгаалах хэрэгцээг илүү анхаарч үзэхэд хүргэдэг гэж онцлон тэмдэглэсэн байдаг<sup>10</sup>. Үүнээс хойш энэ ойлголт олон улсад эрчимтэй гарч ирж, 2001 онд “Хүний аюулгүй байдлын комисс” байгуулагдсан байна.

Садако Огата, Амартья Сен нарын хамтран удирдсан “Хүний аюулгүй байдлын комисс” 2003 онд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад “Хүний аюулгүй байдлын одоогийн байдал” сэдэвт тайлан өргөн барьсан байна. Уг тайланд хүний аюулгүй байдлыг «хүний эрх чөлөө, сэтгэл ханамжийг дээшлүүлэх арга замаар хүний амьдралын амин чухал цөмийг хамгаалах» хэмээн тодорхойлжээ.

“Хүний аюулгүй байдал” нь дэлхий нийтийн энх тайван, хөгжил ба дипломат үзэл баримтлалын асуудалд томоохон орон зай эзэлдэг сэдэв хэдий ч ойлголтын тодорхой бус байдлаас шалтгаалан ихэндээ олон шүүмжлэл дагуулдаг. НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2012 онд Хүний аюулгүй байдлын тухай нийтлэг ойлголтод хүрч, 9-р сарын сарын 10-нд батлагдсан НҮБ-ын A/RES/66/290-р тогтоолдоо хүний аюулгүй байдлыг “хүний эрх чөлөөтэй, нэр төртэй, ядуурал болон айдсаас ангид амьдрах эрх” хэмээн илүү өргөн хүрээгээр тодорхойлсон байна.

Харин 1994 онд НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрөөс аюулгүй байдлын цөм нь улс гүрэн биш, хувь хүн байх учиртайг онцолсоноор “Хүний аюулгүй байдал” өнөөдөр дэлхий хэмжээний бодлогын тулгуур үзэл баримтлал боллоо.

Хүн өдөр тутмын амьдралын батлагаага дэлхийн дахины үйл явдал, улс орнуудын хоорондын харилцааны зэрэгцээ өөрийн гэр бүл, орлого, хүнс, орон байрны тухай нөхцөл дэхь батлагаа, үр удмынхаа ирээдүйтэй холбон үзэх болсон бөгөөд өлсөглөн, ажилгүйдэл, өвчин эмгэг, омог аймгийн сөргөлдөөн, хэлмэгдүүлэлт, байгаль орчны элдэв бохирдолоос хамгаалагдсан байхыг эн тэргүүнд хүсч байна.

Улс орны хөгжил эдийн засгийн өсөлтийн гол зорилго нь өнөөгийн хүн ардын төдийгүй ирээдүй хойч үеийн сайн сайхан байдлыг хангахад чиглэгдэх ёстой гэж үздэг. Хүн төвтэй хөгжлийн үзэл хандлагаар үндэсний болон хүний аюулгүй байдал нь тогтвортой зөв бодлого, онч мэргэн удирдлагын хүчээр хангагдана. Хүний аюулгүй байдлыг хангах нь хөгжлийн зорилго төдийгүй тухайн улс орны хөгжлийн үр дүн байдаг. Гэхдээ хүний аюулгүй байдлыг хангахад нэг талаас төрийн, нөгөө талаас хувь хүний өөрийнх нь үүрэг хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай.<sup>11</sup>

Улс орны хөгжлийг харуулах нэг үзүүлэлт болох боловсролын индексийг бичиг үсэгт тайлагдсан байдлаар төлөөлүүлэн авч үзэхэд 10 хүн тутмын нэг нь бичиг үсэг тайлагдаагүй байна. Бий болсон эдийн засгийн өсөлтийг

<sup>10</sup> Human development report, UNDP, 1994

<sup>11</sup> Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Хүний аюулгүй байдал 4-р тал, –УБ, 2010;

хүний хөгжлийн суурь болгон хувиргах гол хүч нь төрийн ухаалаг бодлого байгаа нь улс орнуудын туршлагаар нэгэнт тодорхой болсон. Түүнчлэн эдийн засгийн өсөлт нэмэгдэж байгаа нь ядуурал, тэгш бус байдал, гэмт хэрэг зэрэг хөгжлийн хүчин зүйлсийн хоцролгдол байсаар байгаа нь улс орны хөгжилд орлогоос гадна нийгмийн шудрага ёс, тэгш хувиарлалтыг хангаж, нийгмийн хүчин зүйлүүдийг тооцож, бодлого, хөтөлбөрт тусгах зайлшгүй шаардлагыг бий болгож байна. Үүнээс үзэхэд, хүний хөгжил нь үндэсний орлогыг өсгөх, бууруулахаас илүү өргөн хүрээтэй ойлголт юм. Хүн бол аливаа үндэстний гол баялаг юм.<sup>12</sup>


Улсын хөгжлийн үр шимээс энгийн ард иргэд хожиж, үр шимийг нь хүртэж байх ёстой. “Хүн бол бүхний хэмжүүр” гэж үзэж болно.<sup>13</sup> Аливаа үндэстний баялаг нь хүн учраас хөгжлийн зорилго нь хүн ардаа эрүүл энх, бүтээлчээр урт удаан амьдрах таатай орчинг бүрдүүлэхэд оршино.<sup>14</sup> Өөрөөр хэлбэл, хөгжлийн үр шимээс иргэд хүртэж байх ёстой гэдэг утгаараа улс орны хөгжлийг тодорхойлогч гол хүчин зүйл нь тухайн улсад амьдарч буй хувь хүмүүсийн хөгжлийн түвшин байдаг. Тэгэхээр хөгжлийн үндсэн зорилго нь зөвхөн хөгжлийн нэгэн хэрэгсэл болох эдийн засгийн өсөлтөөс ч илүү өргөн утгатай, хамгийн чухал нь хүмүүсийн сонголтыг бий болгох, өргөжүүлэхэд оршиж байна. Үүнээс үзэхэд хүний аюулгүй байдал нь хүний хөгжлийн баталгаа, түүний урьдач нөхцөл нь болдог.

Дээрх бүгдээс үзэхэд хүний аюулгүй байдал нь хувь хүн амьдралын наад захын хэрэгцээгээр хангагдсан байдал болон айдасгүй байхыг хамгаалахад чиглэсэн хүн төвтэй ойлголт байдаг бөгөөд энхийг бэхжүүлэх, хүмүүнлэгийн тусламж, хөгжил, боловсрол, эрүүл мэнд зэрэг олон салбарт өргөн хэрэглэгдэж байна. Иймээс хүн амын аюулгүй байдлын онол аргагүйн үндэс ба цаг уурын аюулт үзэгдлийн мөн чанар, туршлага, сургамжийг судалж, Монгол Улсын хүн амын аюулгүй байдалд цаг уурын аюулт

үзэгдлийн нөлөөлөх нөлөөллийн өнөөгийн байдалд шинжилгээ хийх замаар түүний эрсдэлийг бууруулах арга замыг тодорхойлох нь тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Хүний аюулгүй байдлын ойлголт нь хүмүүс өөрсдийнхөө сонголтыг чөлөөтэй, аюулгүй байдлаар хийх, өнөөдрийн эзэмшиж байгаа бүхэндээ маргааш эзэн нь байх агуулгатай.<sup>15</sup>

Хүний аюулгүй байдлын онол нь хувь хүн болон нийгэмд тулгарч болзошгүй аюул заналыг урьдчилан харж, тэдгээрээс хамгаалах арга хэмжээг тодорхойлдог. Энэхүү онол нь зөвхөн цэргийн болон улс төрийн аюулгүй байдалд хязгаарлагдахгүй бөгөөд хүний эрх, эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгмийн сайн сайхан байдал зэрэг өргөн хүрээг хамардаг. Хүний аюулгүй байдал нь үндсэндээ дараах гол чиглэлүүдээр ангилагддаг. Үүнд:



Зураг 1. Хүний аюулгүй байдлын онолын гол чиглэл

Энэ онолын үндэс нь хүний аюулгүй байдлыг хамгаалах нь зөвхөн төрийн үүрэг биш, харин олон улсын байгууллага, иргэний нийгэм, бизнесийн байгууллагууд болон хувь хүмүүсийн хамтын хүчин чармайлтын үр дүнд хэрэгжих ёстой гэсэн ойлголт дээр суурилдаг.

Аюулгүй байдлыг хангахын тулд зөвхөн богино хугацааны арга хэмжээ авах бус, харин урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлого, эрх зүйн зохицуулалт, олон нийтийн оролцоог чухалчилсан бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй. Хүний аюулгүй байдлын онол нь цогц, олон талт асуудлуудыг хөндөж, хувь хүний амьдралын чанар, тогтвортой байдлыг хангахад чиглэдэг.

Аюулгүй байдлын онол нь хувь хүнээс эхлээд дэлхийн түвшний аюулгүй байдлын асуудлуудыг хамарч, өргөн хүрээг хамардаг. Хүн бүр аюулгүй орчныг бүрдүүлэхэд хариуцлагатай байж, хувь нэмрээ оруулах нь чухал.

Аюулгүй байдал гэдэг нь хувь хүн, нийгэм, <sup>15</sup> Ж. Соёмбо, Хүний аюулгүй байдал, ху17, –УБ, 2021;

<sup>12</sup> UNDP, “Human development report 1990: Defining and measuring Human development”, p.9

<sup>13</sup> <http://www.president.mn>, УИХ–ын намрын чуулганы дээр Монгол улсны Ерөнхийлөгч Н. Энхбаярын хэлсэн үгнээс, 2005 оны 10–р сарын 3–ны өдөр.

<sup>14</sup> НҮБ–ийн хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн хүний хөгжлийн илтгэл, 1990;



төр, хүний амьдрах орчны дотоод, гадаад аюулаас хамгаалагдсан байдал бөгөөд энэ нь хоол хүнс, хувцас хунар, орон байр, мэдээллийн хэрэгцээтэй уялдсан хүний оршин тогтнох хамгийн чухал нөхцөл<sup>16</sup> гэж Академик олон улсын цахим тайлбар тольд дурьджээ.

### **Хувь хүний аюулгүй байдлын тухай авч үзэх нь**

Дэлхийн улс орнууд хүний хувийн аюулгүй байдлыг боловсролын түвшин, орон байрны нөхцөл, хөгжлийн ялгаатай байдалтай иргэдийн тоо, гэр бүл салалтын тоо, дарамт шахалт, хүчирхийлэлд өртөгчдийн тоо, ажилгүйчүүдийн тоо, хүн амын хоол тэжээлийн байдал, хүнд нөхцөлд ажиллаж буй иргэдийн тоо зэрэг үзүүлэлтүүдээр тодорхойлох оролдлого хийж байгаа болно. Монгол улс дахь хүний хувийн аюулгүй байдлыг хэмжихдээ боловсролын түвшин (бичиг үсэг мэдэхгүй байх), орон байрны нөхцөл, хөгжлийн ялгаатай байдалтай иргэдийн тоо, гэр бүл салалтын тоо, дарамт шахалт, хүчирхийлэлд өртөгчдийн тоо, ажилгүйчүүдийн тоо, хооллолтын байдал, хүнд нөхцөлд хөдөлмөрлөж буй иргэдийн тоо зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг ашиглах оролдлого хийж байна. Аливаа хүн бие махбодийн болон сэтгэл санааны хүчирхийлэлийг өөрийн гэр бүл, амьдарч буй улс орон бусад улс орноос авахаас хамгаалагдсан байхыг хүний хувийн аюулгүй байдал гэж нэрлэдэг.<sup>17</sup>

Хувь хүний аюулгүй байдал гэдэг нь хүний амьдралд үзүүлэх аюултай хүчин зүйлсээс хамгаалагдсан, амар амгалан, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг илэрхийлдэг ойлголт юм. Энэ нь зөвхөн физик аюулгүй байдал төдийгүй, сэтгэл зүй, эрүүл мэнд, нийгмийн орчин, эдийн засгийн аюулгүй байдал, хүний эрхийн хамгаалалт зэрэг олон талын асуудлыг хамардаг. Хувь хүний аюулгүй байдал нь тухайн хүний амьдралын чанарыг тодорхойлж, өдөр тутмын амьдралд учирч болох аюул, эрсдлээс хамгаалахад чиглэгдсэн олон хүчин зүйлийн нэгдэл юм. Энэ ойлголт нь эхлээд физик аюулгүй байдал-аас эхэлдэг. Өөрөөр хэлбэл, хүний амь нас, бие махбодийг аюулгүй байлгах нь хувь хүний аюулгүй байдлын үндсэн хэсэг юм. Гэмт хэрэг, байгалийн гамшиг, төрийн

хүчирхийлэл гэх мэт хүчин зүйлс нь хувь хүний аюулгүй байдалд шууд нөлөөлдөг бөгөөд эдгээрээс хамгаалахын тулд хүн орон гэр, ажил төрөл, гэр бүл, нийгмээсээ хамгаалалттай байх ёстой.<sup>18</sup>

Эрүүл мэндийн аюулгүй байдал нь хувь хүний амьдралыг тогтвортой хадгалахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүний эрүүл мэнд нь амьдралын чанарыг тодорхойлох гол хүчин зүйлсийн нэг бөгөөд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар, зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, сэтгэл зүйн тогтвортой байдал нь хүний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг юм. Хүн эрүүл байх нь зөвхөн физик төдийгүй сэтгэл санааны аюулгүй байдлыг ч бүрдүүлдэг.

Сэтгэл зүй, сэтгэл хөдлөлийн аюулгүй байдал нь хувь хүний аюулгүй байдалд бас чухал нөлөөтэй. Хүн зүгээр л биологийн хувьд аюулгүй байх нь хангалтгүй, тэрээр сэтгэл санаагаар тайван, дарамтгүй байх ёстой. Энэ нь стресс, сэтгэл зүйн дарамт, депресс, сэтгэл санааны эрсдэлээс хамгаалалттай байх шаардлагатай болдог.

Нийгмийн аюулгүй байдал ч мөн чухал. Хүний амьдралд олон зүйлийг нийгмийн орчин тодорхойлдог. Боловсрол, нийгмийн харилцаа, орлого, ажил эрхлэлт зэрэг асуудлууд хувь хүний аюулгүй байдалд хамаарна. Ядуурал, ажилгүйдэл, хоосрол, боловсролгүй байдал нь хүний аюулгүй байдалд нөлөөлж, нийгмийн эмзэг байдлыг бий болгож болно.

Эдийн засгийн аюулгүй байдал нь хувь хүний аюулгүй байдлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Хүний орлого, санхүүгийн байдал, ажлын байрны тогтвортой байдал нь амьдралыг дэмжих чухал зүйлсийг бүрдүүлдэг. Эдийн засгийн хямрал, орлогын тэгш бус байдал нь хувь хүний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж, ядуурал, ядуу зүдүү амьдралыг бий болгож болзошгүй.

Хүний эрхийн аюулгүй байдал нь хувь хүний хамгийн үндсэн эрх, эрх чөлөө, шударга байдлыг хадгалах үүрэгтэй. Хүний эрхийн хамгаалалт нь хүн бүрийн эрхийг баталгаажуулах, тэгш байдлыг хангах, аюулгүй байдлыг эдлэхэд

<sup>18</sup> Ж. Батдэлгэр, Доктор Б. Төртогтох, Х. Алтанхундага, Х. Жүгдэрнамжил (2022) Ялгаатай орчны хүүхэдтэй ажиллах арга зүй : 24 цагийн цэцэрлэгийн жишээн дээр, МУБИС

<sup>16</sup> <https://dic.academic.ru/dic.nsf/emergency/>

<sup>17</sup> Human development report. UNDP. 1994

чухал ач холбогдолтой. Энэ нь зөвхөн хуулиар хангагдсан эрхүүдийг хамгаалах төдийгүй, тухайн хүний хувийн эрх чөлөө, үзэл бодол, мэдлэгийн хүрээг хамгаалахтай ч холбоотой.

Тэгэхээр хувь хүний аюулгүй байдал нь олон талт, олон хүчин зүйлсээс бүрдсэн нэгдмэл ойлголт бөгөөд эдгээр бүх хүчин зүйлс нь хүн амьдрах орчны аюулгүй байдал, эрүүл мэнд, сэтгэл зүйн дэмжлэг, нийгмийн хамгаалал, эдийн засгийн баталгааг бүрдүүлдэг. Энэ нь зөвхөн хүний амьдралыг хамгаалах төдийгүй, нийгэмд аюулгүй, тэгш, шударга орчин бүрдүүлэхэд чухал үүрэгтэй.

**Хүүхдийн аюулгүй байдал** нь хувь хүний аюулгүй байдалтай шууд холбоотой бөгөөд хүүхдийн аюулгүй байдал нь зөвхөн физик хамгаалал, эрүүл мэндийн байдлаас гадна, сэтгэл зүй, нийгмийн орчин, боловсрол, хүний эрхийн талаас ч нөлөөлдөг<sup>19</sup>. Хүүхдүүд нь хөгжиж буй амьдралын үе шатаараа аюулгүй байдлын эрсдэлд өртөмтгий байдаг бөгөөд энэ нь тодорхой чиглэлүүдэд тусгай хамгаалалт шаарддаг.

**Физик аюулгүй байдал:** Хүүхдийн хувьд физик аюулгүй байдал нь хамгийн чухал асуудал юм. Хүүхдүүд нь хөгжиж буй насны хүүхэд учраас бие махбодийн бүтцийн хувьд аюулгүй байдалд олон төрлийн эрсдэлд өртөмтгий байдаг. Гэмт хэрэг, хүчирхийлэл, хулгай, осол, гал түймэр, байгалийн гамшиг зэрэг нь хүүхдийн аюулгүй байдалд шууд нөлөөлж болох хүчин зүйлс юм. Хүүхдүүдийн хяналтгүй байдал, тусгай хамгаалалттай орчинд амьдрах шаардлага байна.

**Эрүүл мэндийн аюулгүй байдал:** Хүүхдийн эрүүл мэндийн аюулгүй байдал нь хувь хүний аюулгүй байдалд чухал хэсэг бөгөөд хүүхэд өвчнөөр өвдөх, халдварт өвчнөөс сэргийлэх, эрүүл хооллолт, зөв зохистой амьдралын хэв маягтай байх нь чухал. Эрүүл мэндийн үйлчилгээнд хүртээмжгүй байдал, халдварт өвчин, вакцинжилт зэрэг асуудлууд нь хүүхдийн аюулгүй байдалд аюул занал учруулж болдог.

**Сэтгэл зүй, сэтгэл хөдлөлийн аюулгүй байдал:** Сэтгэл зүйн аюулгүй байдал нь хүүхдийн аюулгүй байдалд чухал үүрэг

гүйцэтгэдэг. Хүүхдүүд гэр бүлийн хүчирхийлэл, хулгай, сэтгэл санааны дарамт, олон нийтээс хандлагагүй байдал зэрэгт өртөх боломжтой. Хүүхдийн сэтгэл зүй, хэм хэмжээ, амьдралын стрессийг удирдах нь сэтгэл санааны аюулгүй байдлыг хадгалах үндэс юм. Сэтгэл санааны тогтвортой байдал нь хүүхдийн хөгжлийг дэмжихэд чухал нөлөө үзүүлнэ.

**Боловсрол, хүмүүжлийн аюулгүй байдал:**

Хүүхдүүдийн боловсрол нь тэдний ирээдүйн аюулгүй байдлыг баталгаажуулах нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Боловсролын байгууллагууд нь хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй байдаг бөгөөд эцэг эхийн оролцоо, хяналтгүй орчинд өртөхгүй байх нь тэдний хөгжлийг хязгаарлахгүйгээр хэрэгжих ёстой. Хүүхдүүдийн боловсрол нь зөв хүмүүжлийн суурийг тавихад тусалдаг бөгөөд ирээдүйн амьдралын олон эрсдэлээс хамгаалдаг.<sup>20</sup>

**Хүний эрхийн аюулгүй байдал:** Хүүхдүүдийн хүний эрхийн аюулгүй байдал нь зөвхөн тэдний бие махбодийн аюулгүй байдал төдийгүй, тэдний сонгох эрх, мэдээлэл авах эрх, хувийн орон зай, тусгаарлалтыг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүүхдүүдийг хүчирхийлэл, хүүхдийн хөдөлмөр, хулгай, садар самуунд өртөхөөс хамгаалах нь хүний эрхийн аюулгүй байдлын нэг хэсэг юм. Хүүхдүүдийн хүн болгохын тулд тэдний эрхийг хангах, хамгаалах нь хувь хүний аюулгүй байдлыг баталгаажуулах үндсэн бүрдэл хэсэг.

**Нийгмийн аюулгүй байдал:** Нийгмийн орчин нь хүүхдүүдийн аюулгүй байдалд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлсийн нэг юм. Хүүхдүүдийн амьдарч буй орчин нь аюулгүй байдалд нөлөөлдөг, тусгай хамгаалалт шаарддаг орчинд байх ёстой. Хүүхдийн эрхийг хамгаалахын тулд нийгмийн хариуцлагатай оролцоо, гэмт хэрэг, хүчирхийллийн эсрэг хууль эрх зүйн зохицуулалт, боловсролын системийн дэмжлэгийг бий болгох шаардлагатай.

Хүүхдийн аюулгүй байдал нь олон талт бөгөөд хувь хүний аюулгүй байдалтай салшгүй холбоотой байдаг. Хүүхэд нь нийгэм, гэр бүл, боловсролын байгууллагууд болон төрийн

<sup>19</sup> Б. Бямбасайхан Ph.D Coёл иргэншлийн аюулгүй байдал өсвөр насныхны төлөвшилд нөлөөлөх нь, УБ, 2024;

<sup>20</sup> Кремененко, Ольга Дмитриевна, Аюулгүй боловсролын орчныг бүрдүүлэх хүчин зүйл болох ерөнхий боловсролын сургуулийн удирдагч багш нарын амьдралын стратегийн онцлог. 2006;



хамгаалалтад байдаг учраас аюулгүй орчинд өсч, хөгжих нь тэдний амьдралын үндэс суурь юм. Тиймээс хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах нь зөвхөн гэр бүлийн асуудал биш, харин нийгмийн болон улс орны бүх түвшний асуудал юм.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол Улсын хуулинд “18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” гэж тодорхойлсон.<sup>21</sup>

Хүүхэд боловсролын харилцаанд оролцогч, онцгой эрх эдлэгч этгээд юм. Хүүхэд бүр хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдлаас хамгаалагдах эрхтэй. Тэд нас, бие, сэтгэц, амьдралын онцлог байдлын улмаас эрсдэлд өртөх магадлал өндөр байдаг. Хүүхдийн хамгийн их цагаа өнгөрөөдөг газар нь сургууль, цэцэрлэг байдаг тул багш сурган хүмүүжүүлэгчид нь бусад мэргэжилтнээс илүүтэй хүүхэдтэй хамгийн ойр, харилцаатай ажилладаг хүмүүс. Багш нарын үүрэг нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах явдлын эсрэг хариу арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэхэд мэдээллээр хангах, тухайн мэдээллийг түгээх явдал юм.<sup>22</sup> Хүүхдийн аюулгүй байдал нь нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ.<sup>23</sup> Сургалтын байгууллагын багш ажилтнууд олон арга замаар хүүхдийн сайн сайхан байдлыг хангахын төлөө хувь нэмрээ оруулдаг. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах эхний алхам бол ойлголт мэдлэгтэй байх явдал юм. Хүүхэд хамгаалал нь хүүхдийн бүх эрхийн хамгаалал биш бөгөөд өөрөөр хэлбэл, хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, боловсрол эзэмших, хамгаалуулах, нийгмийн суурь үйлчилгээг хүртэх зэрэг эрхүүдийг хамгаалах тухай ойлголт юм. “Эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад

хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна”<sup>24</sup> гэжээ. Халамжийн үйлчилгээ хангалттай үзүүлдэг нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл үгүй болно гэсэн үг биш ээ. Хүүхэд хамгааллын асуудал нь хүүхэд, гэр бүлийн аюулгүй, сайн сайхан байдлыг хангах, улмаар нийгмийн сайн сайхан байдлыг илтгэх чухал зүйл гэдгийг судлаачид онцлон тэмдэглэж байна

Хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах нь зөвхөн нийгмийн ажилтан, эсвэл анги удирдсан багш, цагдаа, мэргэжлийн хүмүүсийн үйл ажиллагаагаар хэрэгжинэ гэж ойлговол тун өрөөсгөл юм. Тухайлбал хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалалд дараах субъектүүдийн үүрэг оролцоо чухал юм. Үүнд:

- Хүүхэдтэй ажилладаг хүн бүр хүүхдийг хэрхэн хамгаалах талаар мэддэг байх ёстой.
- Хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах явдал нь зөвхөн хувь хүний асуудал биш бөгөөд олон нийтийн зайлшгүй анхаарах шаардлагатай асуудал мөн.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхэд бүрд хүргэх замаар аюулгүй орчинд хүүхэд эсэн мэнд амьдрах, сурч боловсрох, нийгмийн амьдралд оролцох эрхийг ханган биелүүлэх нь хүүхдийн эрхийг дээдлэгч бүх улсын засгийн газар, олон нийт, эцэг эх, асран хамгаалагчдын нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага юм.

• Боловсролын орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын асуудлыг зөвхөн сургуулийн орчин гэдгээр харж болохгүй юм. Гэр бүлийн таагүй харилцаа, хүчирхийллээс шалтгаалан хүүхэд, гэрээсээ дайжих, төрөл садан, түр хамгаалах байранд амьдрах хичээл таслах, сурлага муудах зэрэг хүүхдээс өөрөөс нь шалтгаалахгүй хүчин зүйлсээс болж сөрөг үзэгдлийн золиос, сургууль, анги хамт олноосоо хөндийрөх тохиолдол байдаг. Энэ байдлыг сургалтын байгууллагын багш ажилтан таньж, илрүүлэх, хүүхэд, гэр бүлтэй ярилцаж,

<sup>21</sup> НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, 14-р зүйл, –УБ, 1989;

<sup>22</sup> Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол Улсын хууль, 24-р тал, –УБ, 2016;

<sup>23</sup> НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, 18-р зүйл, –УБ, 1989;

<sup>24</sup> НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, 19-р зүйл, –УБ, 1989;



шалтгаан нөхцөлийг тодруулах, эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн судалгаанд оруулах хэрэгтэй.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь хүүхэдтэй зүй бус харилцах явдлыг таслан зогсоох, хянах, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн цогц арга хэмжээ юм. Хүүхдийн хөгжлийг дэмжиж, зан үйлийн өөрчлөлтийг ажиглаж байдаг анги удирдсан багш, тухайн мэргэжил бүрийн багш, нийгмийн ажилтан, эмч, сэтгэлзүйч, захиргааны болон сургалтыг дэмжих ажилтнууд бүгд хүүхдэд туслах боловсролын багийн салшгүй мэргэжилтнүүд юм.<sup>25</sup> “Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд<sup>26</sup> байгаа хүүхдийг хэлнэ.

Хүүхэдтэй зүй бус харилцах эрсдэл бага хэдий ч нийгэм– эдийн засгийн дарамт, хүндрэлтэй, асуудалтай нөхцөлд амьдарч байгаа хүүхэд гэр бүл, олон нийтэд чиглэсэн урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлэх шаардлагатай. Багш сурган хүмүүжүүлэгчид хүүхдийн эсрэг хүчирхийллийг бий болгодог эрсдэлт болон хамгааллын хүчин зүйлсүүдийн талаар ойлголт сайтай байх нь хүүхэд, гэр бүлтэй ажиллахад ихээхэн тус нэмэр болдог.

### Дүгнэлт

Хүний аюулгүй байдал нь өнөөгийн дэлхий дахины нийгэм, улс төр, эдийн засаг, байгаль орчны өөрчлөлт, эрсдэлт нөхцөл байдал дунд улам бүр чухалчилж авч үзэх шаардлагатай, цогц ойлголт болсон байна. Энэхүү судалгаанд хүний аюулгүй байдлыг уламжлалт цэрэг, улс төрийн хүрээнээс ангид авч үзэн, хувь хүний

эрх, эрх чөлөө, нэр төрийг хамгаалах, айдас ба хомсдолоос ангижруулах, өдөр тутмын амьдралын наад захын хэрэгцээг хангах, орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн хандлагын талаас тодорхойллоо.

Илтгэлд хүний аюулгүй байдалд заналхийлж болох аюулуудыг физик (байгалийн гамшиг, хүчирхийлэл, дайн), биологийн (цар тахал, өлсгөлөн, халдварт өвчин), нийгмийн тогтолцооны (ядуурал, ялгаварлан гадуурхалт, төрийн чадамжгүй байдал) гурван гол чиглэлд ангилан авч үзсэн. Энэ нь хүн төвтэй, салбар хоорондын уялдаа бүхий нэгдсэн хандлагыг шаарддагийн нотолгоо юм.

Хүний хөгжлийн үндэс нь хүний аюулгүй байдлыг бүрэн хангах явдал бөгөөд эсрэгээрээ хүний эрх зөрчигдөж, аюулгүй байдал алдагдсан нөхцөлд хөгжил, амьдралын чанар, ирээдүйн боломжууд хязгаарлагддаг. Хүүхдийн аюулгүй байдал нь уг асуудлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хүүхэд хамгааллын тогтолцоо, боловсролын орчны аюулгүй байдал, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн дэмжлэгийн хүрээнд иж бүрэн анхаарал шаарддаг.

Тиймээс хүний аюулгүй байдлыг хангах үйл явц нь зөвхөн төр, хууль сахиулагч байгууллагын үүрэг бус бөгөөд олон улсын байгууллагууд, иргэний нийгэм, боловсролын байгууллагууд, эцэг эх, хувь хүн бүрийн хамтын оролцоонд тулгуурлах ёстой. Ялангуяа гамшгийн эрсдлийг бууруулах, эмзэг бүлгийг хамгаалах, хүүхэд ба эмэгтэйчүүдийн эрхийг хүндэтгэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зэрэг олон талт арга хэмжээ хэрэгжүүлснээр хүний аюулгүй байдлыг бодитойгоор хангах боломж бүрдэнэ.

Иймд энэхүү сэдвийн хүрээнд илүү нарийвчилсан судалгаа хийх, бодлого боловсруулагчдын анхаарлыг хүний төвтэй аюулгүй байдлын үзэл баримтлалд чиглүүлэх шаардлагатай байна.

<sup>25</sup> Монгол улсын Хүүхэд хамгааллын тухай хууль, 6–р зүйлд “Боловсролын орчин дах хүүхэд хамгаалал” тусгай бүлэг, –УБ, 2016;

<sup>26</sup> Монгол улсын Хүүхэд хамгааллын тухай хууль, 4.1.1–р зүйл, –УБ, 2016;



## Ашигласан материал:

1. Япон улсын Үндэсний батлан хамгаалахын академийн багш нарын хамтарсан бүтээл, Аюулгүй байдлын тулгуур асуудлууд, 24-р тал, 2017;
2. Goodman M, Tagle D, Fitch D, Bailey W, Czelusniak J, Koop B, Benson P, Slightom J (1990). "Primate evolution at the DNA level and a classification of hominoids". J Mol Evol. 30 (3): 260–6. [PMID 2109087](#).
3. "Hominidae Classification". Animal Diversity Web @ UMich. Татаж авсан: 2006–09–25.
4. <https://mongoltoli.mn/>
5. Human development report, UNDP, 1994
6. For various definitions of Human Security, see Tadjbakhsh and Chenoy (2007).
7. The Human Development Index, used by the UNDP, is a composite measure of education, life expectancy, and per capita income, roughly corresponding to the basic rights to education, health, and standard of living.
9. Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын Үзэл Баримтлал
10. Towards a Fourth Pillar of Human Security: "Freedom from Hazard Impacts "Addressing Global Environmental Change, Environmental Stress and Natural Hazards
11. Human development report, UNDP, 1994
12. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Хүний аюулгүй байдал 4-р тал, –УБ, 2010;
13. UNDP, "Human development report 1990: Defining and measuring Human development", p.9
14. <http://www.president.mn>, УИХ-ын намрын чуулганы дээр Монгол улсны Ерөнхийлөгч Н. Энхбаярын хэлсэн үгнээс, 2005 оны 10-р сарын 3-ны өдөр.
15. НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн хүний хөгжлийн илтгэл, 1990;
16. Ж. Соёмбо, Хүний аюулгүй байдал, ху17, –УБ, 2021;
17. <https://dic.academic.ru/dic.nsf/emergency/>
18. Human development report. UNDP. 1994
19. Ж. Батдэлгэр, Доктор Б. Төртогтох, Х. Алтанхундага, Х. Жүгдэрнамжил (2022) Ялгаатай орчны хүүхэдтэй ажиллах арга зүй : 24 цагийн цэцэрлэгийн жишээн дээр, МУБИС
20. Б. Бямбасайхан Ph.DСоёл иргэншлийн аюулгүй байдал өсвөр насныхны төлөвшилд нөлөөлөх нь, УБ, 2024;
21. Кремененко, Ольга Дмитриевна, Аюулгүй боловсролын орчныг бүрдүүлэх хүчин зүйл болох ерөнхий боловсролын сургуулийн удирдагч багш нарын амьдралын стратегийн онцлог. 2006;
22. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, 14,18,19-р зүйл, –УБ, 1989;
23. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол Улсын хууль, 24-р тал, –УБ, 2016;
24. Монгол улсын Хүүхэд хамгааллын тухай хууль, 6-р зүйлд "Боловсролын орчин дах хүүхэд хамгаалал" тусгай бүлэг, –УБ, 2016;
25. Монгол улсын Хүүхэд хамгааллын тухай хууль, 4.1.1-р зүйл, –УБ, 2016;



## XIII–XIV ЗУУНЫ ҮЕИЙН МОНГОЛЫН СОЁЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН СУДАЛГААНЫ ТОВЧ ТОЙМ

**О.ИЧИННОРОВ** /УБХИС-ийн Суртал, хүмүүжлийн албаны дарга,  
докторант, дэд хурандаа

**Түлхүүр үг:** Эзэнт гүрэн, соёлын түүх, судалгаа

**Key words:** Empire, cultural history, research

### Оршил.

Монголын эрт, дундад үеийн соёлын түүх бичлэгийн судалгаа нь өнөөгийн түүх, соёлын судалгааны үндсэн суурь нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ түүхэн залгамж чанар, учир холбогдлын талаар өөр хоорондоо салшгүй холбогдоно.

Түүний дотор XIII–XIV зууны Монголын соёлын түүх бичлэгийн асуудлыг тусгайлан судалснаар тухайн цаг үеийн монголчуудын бичиг үсэг, соёл боловсрол, шашин шүтлэгийн түүхэн нөхцөл байдал, онцлог, давуу талыг танин мэдэх, судлан шинжлэх, үнэлэн дүгнэх боломжийг давхар олгох төдийгүй монголын түүх бичлэгийн уламжлал, шинэчлэлийн асуудлыг шинжлэх ухааны үндэстэй судлан шинжлэхэд чухал ач холбогдолтой юм.

Өнөөгийн түүх, соёлын судалгааны түвшинд авч үзвэл, XIII–XIV зууны Монголын соёлын түүх бичлэгийн асуудал нь хараахан бүрэн хэмжээнд судлагдаагүй учир цаашид түүх, архивын шинэлэг баримт материал болон эрдэмтэн судлаачдын үнэлэлт дүгнэлтийг цогцоор судлан шинжилж, судалгааны эргэлтэд оруулах хэрэгцээ шаардлага хэвээр байгаа нь энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийн үндэслэл болно.

### Үндсэн хэсэг:

Монгол Улсын албан ёсны түүхийн бүтээл болох “Бүгд найрамдах Монгол ард улсын түүх” хэмээх хамтын нэгэн боть бүтээлийг монгол, зөвлөлтийн түүхчид анх 1954 онд бичиж хэвлүүлсэн бөгөөд түүний агуулгад тусгасан соёлын түүхийн бүлэг, зүйлийг 1966 онд дахин засварлан хэвлүүлсэн “Бүгд найрамдах Монгол ард улсын түүх” хэмээх нэгэн боть бүтээлд нэлээд дэлгэрүүлэн бичсэний дотор “XIII–XIV зууны үеийн Монголын соёл” хэмээх 6 дугаар бүлгийг нэрт эрдэмтэн Ш.Бира анх удаа хөндөн судалсан нь чухамдаа энэхүү чиглэлийн судалгааны хөгжлийн шинэ үеийн эхлэлийг

тавьсан хэрэг байв. Зохиогч уг бүлэгтээ “XIII зууны үесээр феодалын харилцаа гүнзгийрэн хөгжиж ирэхийн хамтад монголчуудын соёлын хөгжилд шинэ өөрчлөлт хөдөлгөөн гарч эхэлжээ. Монголын нэгдсэн улс байгуулагдсан нь монголчуудын соёлыг хөгжүүлэх хэрэгт бүр ч хүчтэй түлхэц болжээ. Тархай бутархай байсан олон аймаг нэгдэл нь улс гэр тогтнох явцад соёл ахуйн талаар улам бүр ойртон адилшжээ”<sup>1</sup> гээд монголчуудын аж байдал ба хэв заншил, мэдлэг ухааны байдал, хууль зүйн мэдлэг, бичгийн боловсрол, уран зохиол, урлаг хот суурин газрын боловсрол” хэмээх зургаан зүйлд хуваан, тус бүрийн хөгжлийн дүр төрхийг Их Монгол Улс, Монголын Юань улсын түүхэнд холбогдох баримт материалд үндэслэн бодитой дүгнэжээ. Түүнчлэн зохиогч судалгаагаа гүнзгийрүүлэн “XIII–XVII зууны Монголын түүх” бичлэг” бүтээлдээ Монголын түүх бичлэгийн сэдвийг дөрвөн үед хуваан, өргөн хүрээнд үнэлэн дүгнэж, судалгааны эргэлтэд оруулсан нь өдгөө ч ач холбогдолтой хэвээр байна. Монголын нэрт эрдэмтэн Х.Пэрлээ “Монголын түүх бичлэг” бүтээлдээ Монголын хуучин түүх бичлэгийг судлах ажлын эхлэлийг тавьж, тэрхүү судалгаандаа Монголын эзэнт гүрний үеийн түүх бичлэгийг он цагийн дарааллын дагуу баримтлан тойм байдлаар нэгтгэн оруулсан нь хожмын эзэнт гүрний соёлын түүхийн судалгааны хөгжилд үнэтэй хувь нэмэр болжээ.

Монголын эзэнт гүрний соёлын түүх бичлэгт бөө, мөргөл, шашны асуудал агуулга, ач холбогдлоороо нягт уялдан хөгжиж ирсэн төдийгүй өөр хоорондоо салшгүй холбогдсон түүхэн үйл явц юм. Иймд нэрт эрдэмтэн Ч.Далай “Монголын бөөгийн товч түүх” бүтээлдээ эрт дундад үеийн бөө мөргөл, шүтээн түүний агуулга нь монголын эзэнт гүрний соёл, утга зохиолд гүнзгий нөлөөлж ирснийг баримтаар нотлон дүгнэсэн байна.

<sup>1</sup> БНМАУ–ын түүх. УБ., 1966. т. 138



Монголын эзэнт гүрний соёлын түүх бичлэгт академич Ш.Нацагдоржийн “Халхын түүх”, “Монголын феодализмын үндсэн замнал” зэрэг судалгааны суурь бүтээлүүд жинтэй хувь нэмэр оруулсан бөгөөд өгүүлэн буй үеийн монголчуудын мал аж ахуй, соёлын олон талт асуудлыг тусгайлан судалж, үнэ цэнтэй шинэлэг санал дүгнэлт дэвшүүлсэн байна. Түүнчлэн нэрт эрдэмтэн Д.Гонгорын “Халх товчоон” бүтээлд монголын эзэнт гүрний соёл түүхийн судалгааг түүхэн цаг хугацааны хувьд ХIY–ХYII зууны үеийн монголчуудын түүх, соёлын судалгааны түвшинд залгамж чанартай нэгтгэн судалж, томоохон хувь нэмэр оруулжээ.

Академич Н.Ишжамц “Монголын нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь” хэмээх томоохон бүтээлийнхээ “Их Монгол улсын соёл, шашин, зан заншил” хэмээх тусгай бүлэгт “Монголын нэгдсэн төр байгуулагдсаны дараа аймаг, ханлигуудын соёл нийлэн жигдэрч, нэгдмэл Монгол угсаатны соёл болж хөгжих замд оржээ. “Монгол орон зэргэлдээх... гадаад орнуудтай соёлоор идэвхитэй харилцаж, өндөр хөгжилтэй улс түмний соёлоос ихийг хүртэж өөрийн соёлыг баяжуулан хөгжүүлсээр ирсэн байна” гээд үндэсний бичиг үсэг, дуу хуур, бүжиг наадам, анагаах ухаан, хууль цааз, уран зохиол, хотын соёл хөгжиж байсны зэрэгцээ “Монголын нийгмийн үзэл суртлын гол тулгуур нь урьдын адил бөө мөргөл байж, бусад шашны хамт эзэнт гүрний төр засгийн эрх ашгийг хамгаалж байв”<sup>2</sup> гэж нэгтгэн дүгнэжээ. Энэ талаар академич Ч.Далай “Монголын түүх: Их Монгол Улс) бүтээлдээ дээрх дүгнэлтийг “Сүрхий чамбай дүгнэж бичсэн” хэмээн онцлоод “Гэвч зохиогч маань тухайн үеийн нийгмийн тогтолцооны байдлаас болж хэлэх гэснээ бас хэлээгүй дутуу орхисон буюу дотроо дургүй ч байлаа гэсэн зарим зүйлд арга буюу уламжилсан дүгнэлт хийсэн тал үзэгдэнэ”<sup>3</sup> гээд түүнд нэмэлт хийж “заримыг шинээр дүгнэн тайлбарлаж сэргээн бичлээ”<sup>4</sup> хэмээн өгүүлсэн буй. Энэ мэтээр академич Н.Ишжамц, Ч.Далай нар монгол судлаачдын тэр бүр тусгайлан судлаагүй хятад сурвалжийн мэдээ баримтыг судалгааны эргэлтэд оруулан, монголын эзэнт гүрний соёлын түүхийн судалгааг шинэ шатанд хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсаар

ирсэн байна.

Монгол Улсын албан түүхийг 2003 онд таван боть болгон шинэчлэн хэвлүүлсэн бөгөөд “Монгол улсын түүх” хэмээх уг зохиолын дэд ботид “ХII–ХIV зууны Монголын соёл” хэмээх бүлгийг өмнө өгүүлсэн зургаан зүйлд хуваан, мөн л Их Монгол Улс, Юань улсын хүрээнд авч бичжээ. Энэ үеэс эзэнт гүрний соёлын түүхийн судалгааг шинэ баримт сэлтээр баяжуулах, нэн ялангуяа газар зүйн болон эрдэс бодис олзворлох, ашиглах мэдлэгийн талаар шинжлэх ухааны үндэстэй үнэлэн дүгнэсний дотор “Монголын нууц товчоо”, “Цагаан түүх” зэрэг ХIII зууны сурвалжид “Ази, Европын олон орон, газар нутгийн нэр тэмдэглэгдсэнээс жишээ авч “тэр үеийн Монголчуудын газар зүйн мэдлэг дээгүүр байсныг гэрчилнэ”<sup>5</sup> хэмээн тэмдэглэсэн байна. Тухайлбал, “Монголын төмрийн дархны ажил мэдэгдэхүйц хөгжиж, ширэм, хүрэл цутгах дархны газар ажиллаж байсан... Хархорум хотын төмрийн үйлдвэрлэлийн төвшин өндөр байсныг тэндээс олдсон төмөр эдлэлийн технологийг задлан шинжилсний үр дүн харуулж байна”<sup>6</sup> хэмээн тэмдэглэжээ.

Монголын соёлын түүхийг тусгайлан судалсан бүтээл бол Ш.Бирагийн “БНМАУ–ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд” (УБ., 1977), “Монголын соёл” (Бээжин., 1992) хэмээх түүвэр, эмхэтгэлүүд юм. Эдгээрт нийтлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлүүд нь Монголын соёлын олон чухал асуудлыг тал бүрээс нь хөндөн өгүүлж, дундад эртний үеийн Монгол түмний соёлыг Төв Ази, дэлхийн соёл иргэншилтэй нягт холбон судалсанаараа онцлог бөгөөд ихээхэн ач холбогдолтой юм.

Сүүлийн үеийн монголын соёлын талаар туурвисан томоохон хамтын бүтээлд “Монголын соёлын түүх” (УБ., 1999) хэмээх 3 боть зохиол зүй ёсоор тооцогдохын зэрэгцээ “Оршихуйн аймаг” хэмээх тэргүүн боть, “Мэдлэгийн аймаг” хэмээх дэд боть, “Урлахуйн аймаг” хэмээх гутаар ботиос бүтсэн нийт 18 бүлгээс бүрдэж, Монголын эзэнт гүрний сэдвийн хувьд тухай тухайн бүлэг, зүйлд хуваагдан, сэдэвчлэгдэж, өөр өөрийн онцлог, давуу талыг судлан шинжилсэн байна.

Гэхдээ монголын эзэнт гүрний соёлын түүхийн асуудал нь ихээхэн сонирхолтой төдийгүй доктор Ж.Базарсүрэн уг судалгаандаа Их монгол улсаар цөм болгон авч үзэж, эзэнт

<sup>2</sup> Ишжамц Н. Монголын нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ., 1974. т.109–108

<sup>3</sup> Далай Ч. Их Монгол Улс (1206–1260) УБ., 2006. т. 207

<sup>4</sup> Далай Ч. Их Монгол Улс (1206–1260) УБ., 2006. т. 207

<sup>5</sup> “Монгол улсын түүх” Дэд боть. УБ., 2003. т. 217

<sup>6</sup> “Монгол улсын түүх” Дэд боть. УБ., 2003. т. 206



гүрний цэргийн соёлын талаар анхлан нэлээд дэлгэрэнгүй өгүүлсэн онцлогтой юм.

Нэрт түүхч Б.Балжиннямын “Монголчуудын бүрэн түүхийн товчоон” хэмээх гурван боть бүхий томоохон бүтээлийн тэргүүн ба дэд дэвтэрт Монголын эзэнт гүрний үеийн түүх, соёлын асуудал он дарааллын дагуу тусгагдан, олон тооны мэдээ сэлт, баримт материал, зураг хүснэгтийг цөөнгүй нэгтгэн оруулсан нь монголын түүх, нэн ялангуяа эзэнт гүрний соёлын түүхийн судалгааг он цаг, түүхэн үйл явдлаар нэхэн тодруулах, харьцуулан судлахад чухал гарын авлага болсоор байна.

Монголчуудын өнө эртний түүх, соёлын үнэт шастир болох “Монголын нууц товчоо” нь чухамдаа эзэнт гүрний соёлын түүх бичлэгийн үндэс суурь төдийгүй өнөөг хүртэлх олон зуун жилийн он цагийн уртад гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын анхаарлыг зүй ёсоор татсаар ирсэн билээ. Түүний дотор Нууц товчоонд өгүүлсэн монголчуудын нийгэм, улс төр, аж ахуй, цэргийн соёлын олон талт асуудлыг өргөн хүрээнд бүхий л талаас нь судлан шинжлэх шаардлага хэвээр оршихын сацуу түүх, угсаатны зүйн соёлын түүхэнд холбогдох баримт сэлтээр нэн баялаг агаад өнөө ч үнэ цэнтэй хэвээр буй.

Монголын эрдэмтэн, судлаачид Чингис хаан болон “Монголын нууц товчоо” судлалын үндсийг бүрдүүлэхэд бүхий л оюун билиг, үйл хэргээ зориулсан гавьяатай бөгөөд соёл судлалын бүхий л салбарын үүднээс шинжлэн олон арван бүтээл туурвин хэвлүүлсний дотор А.Амарын “Монголын товч түүх”, Ш.Нацагдоржийн “Чингис хааны цадиг”, “Хубилай сэцэн” зэрэг бүтээлүүд гол байр эзэлсээр ирсэн байна.

Монголын эзэнт гүрний соёлын түүх ба монгол хэл, уран зохиолын судалгаанд академич Ц.Дамдинсүрэнгийн бие даасан ба хамтран зохиосон “Монголын уран зохиолын тойм” гурван боть зохиолын тэргүүн дэвтэр, “Монголын уран зохиолын дээж зуун билиг оршив”, академич Д.Цэрэнсодномын “Монголын уран зохиол” нь томоохон байр эзэлсэн дорвитой бүтээлүүд болно.

Нэрт эрдэмтэн Л.Хүрэлбаатар “Монголын орчуулгын товчоон” зохиолдоо Монголын эзэнт гүрний үеийн монгол орчуулгын зарим тоймыг гарган тавьсан бол Б.Ренчин “Монгол бичгийн хэлний зүй” зохиолын удиртгалдаа

монгол бичгийн дурсгалын зүйл, үндэсний соёлын өв, түүнийг судлахын ач холбогдолыг цохон тэмдэглэсэн нь судалгаа, шинжилгээний шинэлэг бөгөөд онол, арга зүйн нэн чухал ач холбогдолтой юм.

Монголын нийгэм улс төр, түүх, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн сэдвээр Ч.Жүгдэрийн “Монголд феодализм тогтох үеийн нийгэм, улс төр, гүн ухааны сэтгэлгээ” зохиол хэвлэгдсэн бөгөөд түүнд Монголын эзэнт гүрний үеийн улс төр, гүн ухаан, цэргийн сэтгэлгээний талаар гүнзгий судалгаа хийж, олон шинэ содон санал, дүгнэлтүүдийг дэвшүүлэн тавьсан нь хойчийн судлаачдын суурь, гарын авлага болсоор байна.

Монголын угсаатны зүйчдийн судалгаа Монголын эзэнт гүрний үеийн соёлын судалгаанд чухал байр суурь эзэлсээр байдаг. С.Бадамхатангийн “Боржигон халх”, “Хөвсгөлийн дархад ястан”, Х.Нямбуугийн “Монголын бэлэгдэл”, “Монголын угсаатны зүй” зэрэг бүтээлүүдийн шинэлэг мэдээ дүгнэлтүүд нь өгүүлэн буй сэдэвтэй шууд буюу дам холбогддог билээ. Түүнчлэн түүх, урлаг судлаачдын туурвисан бүтээлүүд, тухайлбал, Н.Цүлтэмийн “Монголын урлаг”, Д.Майдарын “Монголын архитектур ба хот байгуулалт”, “Монголын түүх соёлын дурсгалт зүйлс” зэрэг бүтээлүүд нь Монголын эзэнт гүрний үеийн соёлын судалгаанд өөрсдийн өвөрмөц хувь нэмрийг оруулсан юм.

Өнөө үед дундад зууны Монголын соёлын судалгааг шинэ хандлага, арга зүйд үндэслэн хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж буйн дотор археологи, антроплогийн шинжлэх ухааны судалгааны чиглэл, үр дүн тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байна. Энэ хүрээнд эрдэмтэн Х.Лхагвасүрэнгийн хэвлүүлсэн “Монголын археологи” бүтээл, түүнд хавсаргасан “Монгол дахь түүхийн дурсгалт зүйлсийн ойллого” нь монгол түмний, тэр дундаас өгүүлэн буй үеийн соёлын судалгаанд чухал хувь нэмэр болсон юм. Зохиогч, XII–XIV зуунтай хамааралтай 200 орчим булш монгол нутгаас малтаад байгаагийн зэрэгцээ, 20 гаруй хот суурин, 10 гаруй бичээс үлэмж тооны хадны зураг илрүүлэн судлагдаж байна гэж тэмдэглэжээ. Эдгээр судалгаа нь эзэнт гүрний түүх бичлэгийн зангилаа асуудлуудыг тайлахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй юм. Уг бүтээлийн ойлгогод монгол нутгийн хөрснөө тэмдэглэгдсэн 5600 гаруй түүх, соёлын



дурсгалыг бүртгэж, аймаг хотоор жагсаасан нь тэдгээрийг судлах, арчлан хамгаалахад буянтай үйлс болж байна.

Сүүлийн жилүүдэд Монголын эзэнт гүрний соёлын түүхийн судалгаа нь багагүй орхигдож ирсэн нь тухайн асуудлыг дахин шинээр авч үзэж, шинжлэх ухааны үндэстэй судлан шинжилж, үнэлэн дүгнэх шаардлагыг буй болгосон юм. Иймд Монгол Улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс эрхлэн бүтээж 2006 онд хэвлүүлсэн “Монголын эзэнт гүрний үеийн түүхэнд холбогдох цуврал бүтээлүүдэд араб, перс хэл дээрх сүүлийн үеийн баримт сэлтийг өргөнөөр ашигласан онцлогтой”<sup>7</sup> бөгөөд Монголын эзэнт гүрний түүхийн судалгаанд томоохон хувь нэмэр оруулсан юм. Тухайлбал, Юань улсын үеийн соёлын бүлгийг доктор Д.Наран таван зүйлд хуваан авч үзсэнээс гадна Юань улсын судрын хятад хэвлэл болон монгол судлаачдын урьд өмнө үзэж ашиглаагүй хятад, англи сурвалж, судалгааны зохиолд тулгуурлан шинэ шинэ санаа дүгнэлт гаргажээ. Тэрбээр “Хубилай хааны хятадын сонгодог бичгийн хэлийг төрийн хэрэгт хэрэглэвэл соёлын хувьд хятадад захирагдсан хэрэг болно хэмээн үзэж, хятад сайд мэргэд хятадын сонгодог бичгийн хэлээр бичиг баримт үйлддэгийг болиулж, хятадын ард түмэнд ойлгомжтойгоор өдөр тутам хэрэглэдэг, нөгөө талаар монголчууд сурч, бичихэд хялбар байхуйц хэлээр хэрэг хөтлөхийг шаардаж байв. Улмаар аль нэг үндэсний хэлийг гол болголгүй монгол, хятад, төвд, түрэг, самгард зэрэг олон хэлний үг авиаг зөв тэмдэглэж чадах дөрвөлжин бичгийг зохиолгож, түүнийг төрийн бичиг болгохыг чармайсан... Хубилай хаан дайны хөлд сүйрсэн сургуулиудыг сэргээн байгуулж, олон үндэстэн угсаатны боловсролын тогтолцоог буй болгосон...” гээд Улсын хөвүүдийн, лалын шашинт үндэстний хөвүүдийн сургууль, тэдгээрийн үйл ажиллагааг тодотгон өгүүлжээ. Мөн монгол үндэсний онцлогтой, баялаг агуулгатай бүжиг, дуу, хөгжмийн зэмсэг хөгжиж, урлагийн шинэ төрөл үүссэнийг баримтаар нотлон бичиж, Юань улсын үед Хятад үндэстний урлаг шинэ агуулга хэлбэрээр баяжиж, одон орон, газар зүйн зэрэг шинжлэх ухаан хөгжиж байсан тухай нилээд дэлгэрэнгүй танилцуулсан ажээ.

<sup>7</sup> Далай Ч. “Монголын Юань улс” УБ., 2006, Анхбаяр Д. “Монголын Эл хаант улс” УБ., 2006, Энхчимэг Ц. “Монголын Цагаадайн улс. УБ., 2006.

Харин Монголын Цагаадайн улсын соёлын судалгаа хомс хэвээр байсаар ирсний дотор доктор Д.Анхбаяр “Монголын эл хаант улс” бүтээлдээ шашин, шинжлэх ухаан, урлаг утга зохиол, архитектурын 3 зүйл бүхий бүлэг гаргаж, тус улсын соёлын асуудлыг анх удаа нэгтгэн дүгнэх оролдлого хийсэн байна. Тэрээр бүтээлдээ: “Эл хаант улсын хаад шашинг тэгш үзэж байсан нь өргөн олны дэмжлэгийг хүлээж, улс орны тогтвортой хөгжих баталгаа болсон байна. Одон орны судлалын төв байгуулсан нь тухайн үеийн Ази, Европын эрдэмтдийн лаборатори болсон ажгуу... Анагаах ухааны мэдлэг, алхими, газар зүйн шинжлэх ухаан тус бүс нутагт урд өмнө байгаагүй өндөр төвшинд хөгжив”<sup>8</sup> хэмээн дүгнэжээ. Монголын хаад төрийн гарамгай зүтгэлтэн, байлдан дагуулагч төдийгүй шинжлэх ухааны мэдлэгээр гаргуу хүмүүс байсны жишээ нь Мөнх хаан өөрөө Евклидийн геометрийн хэд хэдэн теоремийн шийдлийг бодож олсон явдал байв.

Доктор С.Цолмон “Монголын Алтан ордон улс” бүтээлдээ энэхүү улсын соёлын хөгжлийн сэдэвт “гар урлал, хот суурины амьдрал, шашин шүтлэг” хэмээх гурван зүйл зориулж, Алтан ордон улсад алт, мөнгөний дарханы ажил, ангийн үс, арьс шир боловсруулалтын технологи, зоос, нэхмэлийн үйлдвэрлэл, ордгэр, хатад бүсгүйчүүдийн эрдэнийн гоёл чимэглэл, торгон эдлэл, шавар ба керамик эдлэл, төмөр боловсруулалт тэргүүлэн гар урлал дээд зэргээр хөгжиж байсныг баримтаар нотлон сийрүүлж, “худалдаа, гар үйлдвэрийн хөгжлийн үр дүнд Алтан ордон улсын хотууд цэцэглэн хөгжив”<sup>9</sup> гэсэнээс гадна “Өртөө нь Монголын эзэнт гүрний засаглалыг хэрэгжүүлэх, мэдээлэл, гадаад харилцаа, худалдааг хөгжүүлэх гол хэрэгсэл болсон төдийгүй өрнө, дорны ард түмэн бие биенээ танин мэдэх, соёл, шинжлэх ухааны ололт амжилт харилцан нэвтрэх гүүр болсон юм. Алтан ордон улс өртөөгөөр урьд хэзээ ч байгаагүйгээр мэдлэг мэдээллийг өргөн хэмжээгээр түгээн дэлгэрүүлсэн юм”<sup>10</sup> хэмээн дүгнэсэн байна.

Түүнчлэн гадаадын монголч эрдэмтэд монголын эзэнт гүрний үеийн соёлын хөгжил, түүхэн байдлын талаар өөрсдийн санал дүгнэлтийг дэвшүүлсэн нь цөөнгүй. Тэдгээрийн дотор Германы нэрт монголч эрдэмтэн

<sup>8</sup> Анхбаяр Д., “Монголын эл хаант улс”. УБ., 2006. т. 76

<sup>9</sup> Цолмон С. Монголын Алтан ордон улс. УБ., 2006. т. 117

<sup>10</sup> Цолмон С. Монголын Алтан ордон улс. УБ., 2006. т. 140



М.Правдин “Өртөө худалдааны замыг дагаж соёл, шинжлэх ухааны олон шинэ зүйл өрнө, дорнодод нэвтэрчээ. Хятад сампин, элдэв амтат халуун ногоо, чинжүү, цагаан гаа, шанцай тэргүүтний нутаг болох далайн орныг ч өрнийхөн таньж мэдэв. Энэтхэг мосул даавуу, эрээн бөс, сувд эрдэнийн чулуу европт өргөн тархжээ. Иранаас зэр зэвсэг, хивс, арьс ширэн эдлэл ирж байв. Ази тив урьд өмнө хэзээ ч байгаагүй зүйл бүрийн соёлын хослол болов. Византийн клуассоны паалан Хятадад хүрч, урлагийн шинэ төрөл бий болоход түлхэц өгчээ”<sup>11</sup> гэсэн нь чухамдаа монголын эзэнт гүрний үеийн соёлын хөгжлийн дүр төрх, хөгжлийн онцлог, давуу талыг олон талын судалгааны үр дүнд зүй ёсоор хүлээн зөвшөөрсөн хэрэг юм.

#### Дүгнэлт

Монголын эзэнт гүрний соёлын судалгаа, шинжилгээний ажил эрдэмтэн судлаачдын нөр их хичээл зүтгэлийн үр дүнд үндсэндээ 1950–иад оноос эхэлж, өнөөгийн судалгааны

зохих түвшинд хөгжин гүнзгийрсэн төдийгүй цаашдын түүх бичлэгийн шинэ хандлага, онол, арга зүйн үндэс суурь нэгэнтээ тавигджээ.

Монголын эрдэмтэн судлаачдын соёлын судалгааны үр дүн, зохиол бүтээлүүд дэлхийн эрдэмтдийн анхаарлыг улам бүр татах болсон нь тухайн судалгааны цар хүрээ олон улсын хэмжээнд өргөжин тэлэх, хамтын судалгаанд томоохон ахиц дэвшил гарах таатай нөхцөл боломжийг буй болгож байна.

Өнөөгийн Монголын эзэнт гүрэн болон түүний бүрэлдэхүүн улсуудын соёлын судалгаанд гадаад хэл (хятад, араб, перс г.м) дээрх сурвалж бичгийн мэдээ баримт нэн хомс төдийгүй цаашид уг чиглэлээр мэргэшсэн судлаачдыг сурган бэлтгэх, археологи, антропологийн судалгааны дурсгал, түүний үр дүнг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн судлаачдын хамтын ажиллагаа, бүтээлч үйл ажиллагааг өргөжүүлэх зэрэг шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

<sup>11</sup> Правдин М. Чингис хаан, түүний өв. УБ., 2005. т. 351

#### Ашигласан материал:

1. Анхбаяр Д. “Монголын Эл хаант улс” УБ., 2006
2. БНМАУ-ын түүх. УБ., 1966
3. Далай Ч. Их Монгол Улс (1206-1260) УБ., 2006
4. Далай Ч. “Монголын Юань улс” УБ., 2006
5. Ишжамц Н. “Монголын нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь” УБ., 1974
6. Монгол улсын түүх. Дэд боть. УБ., 2003
7. Правдин М. Чингис хаан, түүний өв. УБ., 2005
8. Цолмон С. Монголын Алтан ордон улс. УБ., 2006
9. Энхчимэг Ц “Монголын Цагаадайн улс. УБ., 2006



## СОЁЛ ИРГЭНШЛИЙН ТУХАЙ АСУУДАЛД

**С.БАЙГАЛМАА** /УБХИС-ийн АБДС-ийн НУТ-ийн багш, доктор (Ph.D)/

**Түлхүүр үг:** аюулгүй байдал, соёл, нөлөө, хөгжил

**Key words:** security, culture, effect, development

### Оршил

“Улс орны үндэсний аюулгүй байдал ба хөгжлийг хангах систем өргөн хүрээтэй асуудал юм. Өнөө үед аюулгүй байдлын болон хөгжлийн бодлогод аюулгүй байдлын суурь ойлголтыг тодруулах шаардлагыг нөхцөлдүүлсэн хүчин зүйлс оршсоор байна.”<sup>1</sup> Үндэсний аюулгүй байдалд хамаарах том асуудал бол соёл иргэншлийн асуудал юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ”, “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.” гэжээ. Мөн “... монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн” гэж заасан. Монгол Улсын Үндсэн Хуульд “хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж”<sup>2</sup> гэж тунхагласан юм.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй **нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно**”<sup>3</sup> гэжээ. Үүнээс үзэхэд бид нүүдлийн соёл иргэншил бүхий, түүнийг хадгалж хамгаалсан улс болохыг зорьсон нь тодорхой байна.

<sup>1</sup> Үржин.О, Орхончимэг.Х, Бат-Эрдэнэ.Д. Аюулгүй байдал судлалын системийн хандлага тогтортой хөгжлийн тулгуур үндэс болох нь. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал. №37 (47).УБ., 2024.т.5

<sup>2</sup> Монгол Улсын үндсэн хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

<sup>3</sup> “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211057&showType=1>

Тус өгүүлэлд соёл иргэншлийн асуудал нь цар хүрээ том бөгөөд түүний нөлөөллийн асуудлыг шинжлэхийн тулд үндсэн ойлголт болох соёл иргэншил, түүний онолын асуудлыг товч авч үзэхээр зорилоо.

Соёл иргэншил гэдэг үг нь франц хэлний иргэний civiltiy болон латин хэлний civitas гэсэн үгнээс гаралтай. Тухайн нийгмийн хөгжлийн хүрсэн түвшинг хэлэх бөгөөд энэ нь материаллаг болон оюуны соёлын түвшингээр тодорхойлогдоно.

Нийгмийн хөгжлийн хүрсэн түвшинг тодорхойлох Морганы онол, формацын онол, соёл иргэншлийн онол, өсөлтийн үе шатны онол, өрнөдийн орчин үеийн онол гэх мэт онолууд, Германы философич О.Шпенглер /1810–1836/, Английн түүхч, социологич Ж.А.Тойнби /1889–1975/ нарын зэрэг гол төлөөлөгчид бий. Соёл иргэншлийн онол нь нийгмийн материаллаг болон оюуны соёлын хүрсэн түвшинг тодорхойлохдоо ихэвчлэн байгалийн хүчин зүйлүүдийг харгалзан үзсэн байдаг.

Соёл иргэншлийн тухай ойлголт өмнө нь төрийн болон засаглалыг оролцуулан хууль, дэг журам гэсэн утгаар өргөн хэрэглэгдэж байсан боловч тэдгээрийн аль нь ч хөгжиж, өргөжиж буй шаардлагад бүрэн нийцэж чадахгүй болсон. Эмиль Бенвенистийн хэлснээр civiltiy гэсэн нэр томъёо нь нийгмийн хөгжлийн түвшнийг хангалттай утга илэрхийлж чадахгүй болсон бөгөөд чиглэл, залгамж чанарыг хоёуланг нь тодорхойлохын тулд соёл иргэншил гэж хамт нэрлэх ёстой гэсэн.

Франц хэл дээрх соёл иргэншлийн тухай анхны мэдэгдэж байгаа хэрэглээ нь өнөөгийн соёл иргэншилтэй холбоотой утгаас огт өөр утгыг илтгэж байсан. Хэсэг хугацааны турш хууль зүйн шинжлэх ухаанд ашигласан. 1743 оны Тгйvoux толь бичигт “хууль зүйн нэр томъёо” гэж тодорхойлсон байдаг. Судлаачид 1766 оноос өмнө хэвлэгдсэн франц хэл дээрх ямар ч бичвэрээс соёл иргэншил гэдэг үгийг олж чадаагүй байна. Ерөөс соёл иргэншлийг

нийгмийн хөгжлийн үйл явц, хөгжлийн төлөв байдлын аль алиныг нь илэрхийлэхэд ашиглаж байсан.

Соёл иргэншлийн тухай нэр томъёо XIX–XX зууны соёл иргэншлийн нарийвчилсан судалгаанд хэрэглэгдэж антропологи, угсаатны зүйн салбаруудын үндэс суурь болсон. Энэ нь аливаа үндэстнийг хамарсан нийгмийн хөгжлийн хүрсэн түвшнийг илтгэнэ. Соёл иргэншлийн харьцуулсан судалгааны төлөөлөгч болох Арнольд Тойнби соёл иргэншил хоорондын уялдаа холбоог илэрхийлэхийг оролдсон. Нийгмийн зохион байгуулалтын талаарх Тойнбигийн аргумент нь соёл иргэншлийн буюу иргэншсэн нийгмийн хөгжил дэвшилтэй холбоотой байсаар ирсэн. Р.Г.Коллингвуд соёл иргэншлийн дараах гурван талыг онцолсон. Үүнд: эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйг нэрлэсэн. Үүнээс, эдийн засаг нь баялгийг бүтээж нийгмийн хөгжил дэвшилд эргэлт гаргаж байгаагаар, нийгмийн тал нь хүн төрөлхтний нийгэмших чадварыг үнэлж байгаагаар тодорхойлогддог. Соёл иргэншлийн хүрсэн түвшинг илэрхийлэх гол үзүүлэлт бол хуульд захирагддаг нийгэм бөгөөд эрүүгийн эрх зүйгээр бус иргэний хуулиар хэрэглээ нь зохицуулагддаг гэж тодорхойлсон. Коллингвудын хувьд соёл иргэншил өөрөө хууль дээдлэх зарчмуудыг удирдан чиглүүлж, үйл ажиллагаагаа явуулдаг гэж үзсэн. Соёл иргэншлийн эдгээр гурван элементийг нэгтгэх юм бол соёл иргэншил ямар нэгэн хууль, үндсэн хуулийн тогтолцооны дагуу өөрийгөө зохион байгуулж, удирдах түвшинг илэрхийлдэг байна.

Дэлхийн янз бүрийн улс үндэстэн, тэдний янз бүрийн онцлогтой соёл иргэншлийг тайлбарлахын тулд Гегель соёл иргэншлийн хөгжилд газар зүйн орчны гүйцэтгэх үүргийг авч үзжээ. “Улс үндэстэн, бүс нутаг, тивүүдийн байгаль цаг агаар харилцан адилгүй, түүнийг даган тэдгээрийн үеийн үед эрхэлсээр ирсэн соёл иргэншил амьдрах арга, ёс өөр өөр. Байгаль нийгмийн түгээмэл шинж болон түүний амьдралд илрэн гарах нэгж шинжтэй үл давтагдах онцлог зэрэгтэй харьцуулахад ард олон, байгальтай холбогдох холбоо гадаад тал нь юм. Байгаль цаг агаараасаа болж ард түмэн, улс үндэстнүүдийн хэрэгцээ, зорилго өөр өөр түүнийг хангах бололцоо янз бүр”<sup>4</sup> гэжээ. Өөрөөр хэлбэл тэдний нийгмийн хөгжил, эрхэлж буй аж ахуй, амьдралын хэв маяг нь

<sup>4</sup> Хавх.Н.Соёл иргэншлийн онол.УБ.,2004.т.85–86

оршин буй газар нутгийн байгаль, цаг ууртай нягт холбоотой болох тухай бичжээ. Үүнтэй санал нэг байна.

XXI зуунд Мянганы хөгжлийн зорилтын үргэлжлэл болсон “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь соёл иргэншлийн хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулахад анхаарч байна. Техник технологийн хөгжил нь байгальд үзүүлэх хүний үйл ажиллагаанаас үүдсэн сөрөг нөлөөллийг улам л нэмэгдүүлж байна. Соёл иргэншлийн хөгжлийн арга замуудын талаар илүү оновчтой шийдэл, стратегийн шийдвэрүүдийн нэг бол өөрчлөлтийн эсрэг тэмцэх биш, харин удахгүй болох өөрчлөлтөд бэлтгэх явдал юм.”<sup>5</sup>

“Хүн төрөлхтний хувьсалд хязгаарлалтууд байдаг. Цаг хугацаа нь хөдөлгөөнтэй учир тодорхой орон зайд хувьсагчуудыг оруулах боломжтой.”<sup>6</sup>

“Соёл иргэншил гэдэг нь нийгмийн үйл явц ба түүний хүрэх түвшин хоёуланг нь илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл нийгмийн хөгжил, дэвшил соёл иргэншилтэй болох, эсвэл бүдүүлэг байдлаас соёл иргэншил рүү шилжих үйл явцыг дүрсэлдэг. Аливаа улсын нийгэм–улс төрийн зохион байгуулалт соёл иргэншлийн гол шалгуур гэж үзэж ирсэн. Соёл иргэншлийн хувьсагчуудаас томоохон үзүүлэлт болдог нь хотжилт, нийгмийн давхаргажилт, соёл, шинжлэх ухааны холбогдох дэвшлүүд юм.

Онолын хувьд цаг хугацаа өнгөрөх тусам алив юмсын хөгжилд ахиц дэвшил гарсаар байдаг. Ахиц дэвшил гаргах тусам нийгэм илүү соёлждог, хэдий чинээ соёлтой болох тусам соёл иргэншлийн хөгжил гүнзгийрдэг.”<sup>7</sup> гэжээ. Сэмюэл Хантингтон соёл иргэншлийг нэлээд товчхон дүгнэж сайн эсвэл муу гэх нь харьцангуй ойлголт гэсэн. Соёл иргэншил, орчин үеийн хэлбэр байдлаас эрс ялгаатайг Зигмунд Бауман дурдаад харанхуй талыг онцлон тэмдэглэсэн бол Холокост нь “орчин үеийн соёл

<sup>5</sup> Arutyunov. The Concept of Sustainable Development and Real Challenges of Civilization. Herald of the Russian Academy of Sciences. 2021.No:91.102–110

<sup>6</sup> Dynamics of Growth in a Finite World. D. L. Meadows, W. W. Behrens III, D. H. Meadows, R. F. Naill, J. Randers, E.K.O. Zahn. [https://scholar.google.com/scholar\\_lookup?title=Dynamics%20of%20Growth%20in%20a%20Finite%20World&publication\\_year=1973&author=Meadows%20D.%20L.&author=Meadows%20W.W.&author=Randers%20J.L.](https://scholar.google.com/scholar_lookup?title=Dynamics%20of%20Growth%20in%20a%20Finite%20World&publication_year=1973&author=Meadows%20D.%20L.&author=Meadows%20W.W.&author=Randers%20J.L.)

<sup>7</sup> Stark, R. How the West Won: The Neglected Story of the Triumph of Modernity. Wilmington, DE: Intercollegiate Studies Institute. 2014.



иргэншлийн парадигм” ба орчин үеийн байдлыг заавал үнэ цэнэтэй зүйл гэдгийг илтгэх албагүй. Энэ нь зөвхөн сайн талуудын зэрэгцээ зарим сул талууд, тэр ч байтугай “хар тал” байдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй”<sup>8</sup> гэсэн.

Дээрхийг дүгнэхэд соёл иргэншлийг илүү гүнзгий ойлгохын тулд, ялангуяа барууны улс төрийн сэтгэлгээний түүхэнд хэрхэн тэмдэглэгддэг, улмаар соёл иргэншил, хөгжил дэвшил, орчин үе зэрэг ойлголтуудын хоорондын билэг тэмдгийн учир холбогдол, мөн чанарыг илүү судлах хэрэгтэй. Энд соёл иргэншил ба хөгжил дэвшлийн хоорондын харилцааны бусад чухал хэмжигдэхүүнүүд,

тухайлбал соёл иргэншил ба хүн төрөлхтний туулж өнгөрүүлсэн амьдрах явц, соёл иргэншил ба хүрээлэн буй орчин эсвэл байгаль ертөнцийн хоорондын харилцааны шинж чанар зэргийг багтааж үзэх шаардлагатай болдог байна. Ерөөс соёл иргэншлийн тухай бичсэн судалгаануудаас харахад нийгмийн үйл явц ба түүний хүрэх түвшин хоёуланг нь илэрхийлдэг ойлголт гэдгийг дүгнэж хэлмээр байна. Өөрөөр хэлбэл нийгмийн хөгжил, дэвшил соёл иргэншилтэй болох, эсвэл бүдүүлэг байдлаас соёл иргэншил рүү шилжих үйл явцыг дүрсэлдэг. Аливаа улсын нийгэм-улс төрийн зохион байгуулалт соёл иргэншлийн гол шалгуур гэж үзэж иржээ.

<sup>8</sup> Alexander, J. C. *The Dark Side of Modernity*. Cambridge, UK, and Malden, MA: Polity. 2013.

#### Ашигласан материал:

1. Монгол Улсын үндсэн хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
2. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211057&showType=1>
3. Arutyunov. The Concept of Sustainable Development and Real Challenges of Civilization. Herald of the Russian Academy of Sciences. 2021.°91.102-110
4. Alexander, J. C. *The Dark Side of Modernity*. Cambridge, UK, and Malden, MA: Polity. 2013.
5. Dynamics of Growth in a Finite World. D. L. Meadows, W. W. Behrens III, D. H. Meadows, R. F. Naill, J. Randers, E. K. O. Zahn. [https://scholar.google.com/scholar\\_lookup?title=Dynamics%20of%20Growth%20in%20a%20Finite%20World&publication\\_year=1973&author=Meadows%2CD.%20L.&author=Meadows%2CD.%20H.&author=Randers%2CJ](https://scholar.google.com/scholar_lookup?title=Dynamics%20of%20Growth%20in%20a%20Finite%20World&publication_year=1973&author=Meadows%2CD.%20L.&author=Meadows%2CD.%20H.&author=Randers%2CJ).
6. Stark, R. *How the West Won: The Neglected Story of the Triumph of Modernity*. Wilmington, DE: Intercollegiate Studies Institute. 2014.
7. Хавх.Н.Соёл иргэншлийн онол.УБ.,2004.т.85-86
8. Үржин.О, Орхончимэг.Х, Бат-Эрдэнэ.Д. Аюулгүй байдал судлалын системийн хандлага тогтортой хөгжлийн тулгуур үндэс болох нь.Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал.°37 (47).УБ.,2024.т.5

